



Legum servi esse debemus, ut Liberi esse possimus

ХҮҮЛЬ ҮЙН ЭРТӨМ ШИНЖЛЭГЭ, СУЛАГАА, ОНОЛ, ПРАКТИКИЙН СЭТГҮҮЛ

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

- Хуулийн этгээд эрүүгийн гэмт хэргийн субъект болох нь: харьцуулсан эрх зүйн зарим асуудал
- Сонгуулийн компаниг ажил дахь зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн оролцоо
- Давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь
- Төрийн бус тэтгэврийн сангийн эрх зүйн зохицуулалт
- Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг ба иргэний хуулиар зохицуулсан үүргийн гүйцэтгэлээс үүссэн хэрэг маргааныг зааглан ялгах аргачлал боловсруулах нь
- Австрийн Үндсэн хуулийн шүүхийн тухай
- Ашиг сонирхлын зөрчлийн талаархи гадаад орнуудын эрх зүйн зохицуулалтыг бүтээлчээр ашиглая
- Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тухай
- Монгол Улс дахь эрүүдэн шүүхийн өнөөгийн байдал ба түүний шинэчлэл
- Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны аргачлал

Сэтгүүлийн зөвлөл

Сэтгүүлийн зөвлөлийн дарга

С.Сүхбаатар

Хууль зүйн доктор, дэд профессор

Гишүүд:

Б.Амарсанаа

Хууль зүйн доктор,

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн
тэнхимийн багш

Г.Банзрагч

Хууль зүйн доктор,

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Төр, захиргааны
эрх зүйн тэнхимийн багш

Д.Зүмбэрэлхам

Хууль зүйн доктор,

Төрийн албаны зөвлөлийн дарга

Ч.Энхбаатар

Хууль зүйн шинжлэх ухааны доктор,

Удирдлагын академийн Ерөнхий эрдмийн тэнхимийн
эрхлэгч

Ц.Эрдэнэболд

Хууль зүйн доктор

Дугаарыг эрхэлсэн:

С.Алтантуяа

Сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга

Эрхлэн гаргагч:



Хууль зүйн үндэсний хүрээлэн

Редакцийн хаяг:

Улаанбаатар-46, Чингэлтэй
дүүрэг,

Сүхбаатарын талбай-7

Утас: 315736, 99083007

Факс: 315736

Вэб сайт: www.legalinstitute.mn

И-мэйл хаяг: altantuya.s@legalinstitute.mn

Улсын бүртгэлийн дугаар: 279

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

Цуврал 31

2010 он, Арванхоёрдугаар сар

№4

АГУУЛГА

ХУУДАС

Эрдэм шинжилгээ, онол, арга зүй

Хуулийн этгээд эрүүгийн гэмт хэргийн
субъект болох нь: харьцуулсан эрх зүйн
зарим асуудал 5

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн
эрх зүйн тэнхимийн багш, Хууль зүйн доктор
Д.Баярсайхан

Сонгуулийн компанит ажил дахь зохион
байгуулалттай гэмт бүлэглэлийн оролцоо 13

ОХУ-ын Сонгуулийн эрх зүйн институтын
шинжээч, хууль зүйн доктор
Красинский Владислав Вячеславович

Давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь 29

ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн
секторын эрдэм шинжилгээний ажилтан,
докторант Г.Оюунболд

Төрийн бус тэтгэврийн сангийн эрх зүйн
зохицуулалт 36

Голомт банкны хууль зүйн зөвлөх, магистр
П.Өнөрмаа

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах
арга хэмжээний тухай 42

ИШПГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын
Ялтны сургалт, хүмүүжлийн хэлтсийн дарга,
хошууч, докторант Ц.Очгэрэл

Судалгааны тайлан

Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах
гэмт хэрэг ба үүргийн гүйцэтгэлээс үүссэн
хэрэг маргааныг зааглан ялгах аргачлал
боловсруулах судалгааны тайлан 52

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан

Үзэл бодол, эргэцүүлэл

Ашиг сонирхлын зөрчлийн талаархи гадаад орнуудын эрх зүйн зохицуулалтыг бүтээлчээр ашиглая	72
УИХ-ын тамгын газрын ажилтан, хууль зүйн доктор, профессор Л.Батжав	
Ашиг сонирхлын зөрчлийн нийгмийн ёс суртахуунаас үүдэлтэй шалтгаан	78
Улсын ерөнхий прокурорын туслах, Мэдээлэл дүн шинжилгээ, судалгааны төвийн захирал Г.Ганзориг	
Хорих анги ба гяндангийн практик ойлголт	81
Нийслэлийн прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, хууль цаазын итгэмжит зөвлөх Ц.Мөнхбат	
Австрийн Үндсэн хуулийн шүүхийн тухай	84
Үндсэн хуулийн цэцийн референт, магистр Ё.Өнөборгил	
Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх жуульд хэрэглэсэн “мөрдөн байцааж, хэрэг бүртгэх албаны дарга” нэр томъёог өөрчлөх талаар	89
ОХУ-ын ДЯЯ-ны Удирдлагын академийн адъюнкт, цагдаагийн дэд хурандаа Б.Одбаатар	
Гэр бүлийн эргэн тойронд	95
Цагдаагийн академийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, магистр, цагдаагийн дэслэгч О.Отгонтуяа	
Монгол Улсын Иргэний хуулийн зарчмын түүхэн хөгжил	102
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Р.Болормаа	
Монгол Улс дахь эрүүдэн шүүхийн өнөөгийн байдал ба түүний шинэчлэл	110
Магистр Г.Төмөрбаатар	
Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны аргачлал	115
Баян-Өлгий аймгийн Эрх зүйн тусалцааны төвийн өмгөөлөгч Т.Костёр	
Хууль зүйн албаны 100 жилийн ойд Мэдээлэл	121 123

CONTENTS

Article	PAGE
A Legal Entity as a Subject of a Criminal Crime: Some Issues on Comparative Law Bayarsaikhan.D, Ph.D, Lecturer of Department of Criminal Law, School of Law, National University of Mongolia	5
The Participation of Criminal Organizations in the Election Campaigns Krasinskii Vladislav Vyachaslavovich, Ph.D, Expert of Russian Public Institute of Electoral Law	13
To Prevent a Repeated Crime Oyunbold.G, Ph.D candidate, Researcher of Criminal Law and Criminology Sector, National Legal Institute	29
Legal Regulations on Private Pension Funds Unurmaa.P, LL.M, Legal Advisor of "Golomt" Bank	36
Measures to Secure Safety for Penalty Institutions Ochgerel.Ts, Ph.D candidate, Head Office of Enforcement of Court Decisions	42
Research Report	
To Elaborate a Method on to Separate Disputes Proceeded by Execution of Obligation Regulated by Civil Code and Appropriation of Property by Fraud Research Report by National Legal Institute	52
Notes	
Use of Legal Regulations of Foreign Countries on Conflict of Interests Constructively Batjav, Ph.D, Assistant of Secretariat of State Great Khural (Parliament) of Mongolia	72

Causes of Conflicts of Interests Stemming from Social Morality	78
Ganzorig.G, LLM, Head of Information, Analysis and Research Centre, General Prosecutor Office	
Practical Understanding of Prison and Jail	81
Munkhbat.Ts, Prosecutor of Metropolitan Prosecutors Office	
The Constitutional Court of Austria	84
Unuborgil.Yo, LLM, Assistant of Constitutional Tsets (Court) of Mongolia	
Issues on Changing the Term “Inquiry and Investigation Division” Used in the Law on Criminal Procedure of Mongolia	89
B.Odbaatar, Student of the Academy of Management, Ministry of Internal Affairs of Russian Federation	
Around the Family	95
Otgontuya.O, LLM, Lecturer of Department of Civil Law, Police Academy	
A Historical Development of Principles of the Civil Code of Mongolia	102
Bolormaa.G, LLM, Researcher of Civil and Economic Law Sector, National Legal Institute	
Current Status of Torture in Mongolia and its Reform	110
Tumurbaatar.G, LLM	
Method of Proceedings in Mediation	115
Kostyor.T, Attorney of Legal Aid Center, Bayan-Ulgii Aimag	
The 100th Anniversary of the Justice Sector Information	121
	123

ХУУЛИЙН ЭТГЭЭД ЭРҮҮГИЙН ГЭМТ ХЭРГИЙН СУБЪЕКТ БОЛОХ НЬ: ХАРЬЦУУЛСАН ЭРХ ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ*

Сүүлийн үед эрх зүйн харилцаанд оролцогч субьектийн хүрээ өргөжин тэлж, үүрэг хариуцлага нь өсөн нэмэгдэхийн хэрээр хуулийн этгээдийн ойлголтыг шинээр авч үзэх шаардлага гарч байна. Уг асуудалд зөвхөн иргэний эрх зүйн үүднээс хандах нь учир дутагдалтай төдийгүй зөвхөн шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох чадварыг хуулийн этгээдийн голлох шалгуур болгон авч үзсээр ирсэн нь өрөөсгөл бөгөөд судлаачдын хувьд шүүмжлэлтэй хандах сэдэв болоод байгаа билээ.

Хуулийн этгээдийг хувийн эрх зүйн төдийгүй нийтийн эрх зүйн талаас нь тэр тусмаа эрүүгийн эрх зүйн аспектаар судлан томьёолох нь онолын төдийгүй практикийн ач холбогдолтой.

Миний бие энэ хуралд “Хуулийн этгээд нь гэмт хэргийн субьект болох онцлог, үндэслэлийг харьцуулсан эрүүгийн эрх зүйн үүднээс тоймлон харуулахыг оролдож, зарим санал, бодлыг та бүхэнтэй хуваалцаж, өөрийн санааг нэмэрлэхийг зорьсон юм.

“Гэмт хэргийн субьект” ба “Хуулийн этгээд” гэсэн хоёр ойлголт хоорондоо салшгүй холбоотой. “Гэмт хэргийн субьект” гэдгийг гэмт хэргийн бүрэлдэхүүний нэг элемент гэхээсээ илүү эрүүгийн хариуцлага хүлээх чадвар бүхий этгээд гэж ойлгох явдал баруун Европ, АНУ-д ихэд дэлгэрсэн байдаг.¹

Гэмт хэргийн субьект нь гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр нотлогдсон бүхий л этгээдэд тэр тусмаа хувь хүн иргэн, албан тушаалтан төдийгүй байгууллага, төр, улсад ч хамааралтай асуудал гэдгийг хүлээн зөвшөөрөх хандлага бий болсон байна.²

“Хуулийн этгээд” (Латины “universitates” хамтран байгуулах, цогц бүрдэл) гэдэг нэр томьёоны анхны гарвал нь Ромын үүргийн эрх зүйн хэрэглээнд “Collegia”, “Sodalicia” зэрэг ойлголт нэвтэрч эхэлсэнтэй холбоотой тайлбарладаг. Өөрөөр хэлбэл, иргэний гүйлгээ, товар мөнгөний харилцаа анхлан бий болж эхлэх үед гэрээ хэлцлийг ганц нэгээрээ бус, цех, нөхөрлөл, баг, фонд зэрэг хэлбэрээр

“Хуулийн этгээдийн эрх зүйн байдал хариуцлага: харьцуулсан эрх зүйн асуудал” сэдэвт олон улсын бага хурлын илтгэл

¹ Simester A.P. Sullivan G.R. Criminal law. Theory and Doctrine. Oxford. Portland 2005. P.275 -282.

² Никифоров А.С. “Юридическое лицо как субъект преступления и уголовной ответственности”. М., 2002г. с.84.



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн багш, Хууль зүйн доктор Д.Баярсайхан

дамвуулж, эдгээр нь Ромын хуулиудад заасан эрх зүйт ёсны наад захын шаардлагыг хангаж, хууль ёсны хариуцлага хүлээх зайлшгүй нөхцөлөөр хангагдаж байжээ.³ Хэдийгээр хуулийн этгээд ихэнхдээ иргэний гүйлгээ иргэний эрх зүйн харилцааны хамгийн идэвхтэй субъект бөгөөд иргэний болон материаллаг хариуцлага хүлээх этгээд гэсэн утгаар өргөн хэрэглэгдэж ирсэн, одоо ч энэ нь хэвээр боловч XIX зууны эхэн үеэс эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ болж тусгагдах болсон юм.

Бүр анх 1670 оны Францын Ордананс, 1813 оны Боварын хууль цаазын бичиг зэрэг түүхэн эх сурвалжид корпораци, общин болон адил төстэй хуулийн этгээд гэмт хэрэгт холбогдсон нөхцөлд хүлээлгэх эрүүгийн болон хатуу чанд хариуцлага хүлээлгэх үндэслэлийг анхлан дэвшүүлсэн байдаг.⁴ Эх газрын системийн барууны чиглэлийн голлох орнууд болох Франц, Итали, Герман, Швед, Португали, Бельги, Австри зэрэг ихэнх орны анхны эрүүгийн хуулиудад “хуулийн этгээдийн гэмт хэргийн субъект болох үндэслэлийг үгүйсгэсэн буюу энэ талаарх институт шууд тусгагдаагүй XX зууны сүүлч хүртэл “явсан” байдаг. Тэгвэл Англи-Америкийн системийн орнуудад корпораци нь хуулийн этгээд болохын хувьд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, зарчмууд тухайн эрх зүйн эх сурвалжуудад тусгалаа олсоор иржээ.⁵ Жишээ нь: Англид XIX зууны дунд үеэс корпорацид эрүүгийн хариуцлага хүлээлгэх үзэл санааг хүлээн зөвшөөрөх болсон бол АНУ-д хуулийн этгээдэд эрүүгийн ял оногдуулах зайлшгүй үндэслэлийг 1909 оны АНУ-ын хувьд Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээр хүлээн зөвшөөрч томъёолж байжээ. Австралид 1921 онд анх уг асуудал эрүүгийн хууль тогтоомжид тусгагдаж байдаг.

Англи-Америкийн орнуудад хуулийн этгээд бүхий корпорациуд нь ихэвчлэн экологийн болон эдийн засгийн гэмт хэргийн субъект болох нь олонтоо бөгөөд эрүүгийн хариуцлагыг шүүхийн практикийн он удаан жил хэрэглэж ирсэнээр энэ нь олон улсын гэрээ, хэлэлцээрт хүртэл нөлөөлж, тусгагдаж ирснийг харж болно.⁶

Хуулийн этгээд гэмт хэрэг үйлдсэн буюу түүнд үйл ажиллагаа нь шууд холбогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлагыг хүлээлгэх, тэрчлэн ял завших боломжийг хязгаарлах үзэл санааг 1929 оны Бухарестийн Олон Улсын Конгрессийн зөвлөмжид тусгагдсан нь бий. Түүнчлэн 1946 оны Ньоренбергийн процесс дахь Олон улсын шүүхийн баримт бичгүүдэд “Аливаа төр, засгийн газар, улс нь хуулийн этгээд төдийгүй олон улсын гэмт хэргийн субъект байх үндэслэл, нөхцөлийг

³ Д.Баярсайхан. “Ромын эрх зүй”. УБ., 2000 он. 50-52 дахь тал.

⁴ Богородский С.О. “Очерк истории уголовного законодательства в Европе с начала XVIII-ого века” Т.1. Киев. с.24-26.

⁵ “International Encyclopedia of Comparative law”. vol. VI. N.Y.1987.

⁶ Кафтаников. А.А. “Юридическое лицо как субъект уголовной ответственности в законодательстве зарубежных стран”. М., 2004г. с.409-411.

томьёолсон нь хожмын түүхэнд шийдвэрлэх нөлөө үзүүлжээ. Европын зөвлөлийн 1979 оны гэмт хэргийн асуудлаарх Тусгай хорооны зөвлөмжид аливаа хуулийн этгээд экологийн гэмт хэргийн субъект болохыг онцлон дурьдаж, эрүүгийн ялаас ангид байж болохгүйг анхааруулсан байдаг.

Дээр дурьдсан үзэл санаа, үндэслэл НҮБ-ын 1996 оны Каирт болсон Гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх талаарх конвенц, Европын зөвлөлийн тусгай хорооны 88/18 тоот тогтоол зэрэг цөөнгүй бичиг баримтад тусгагдаж ирснийг тэмдэглэх нь зүйтэй. Ялангуяа бизнесийн төдийгүй төрийн бус байгууллага, үйлдвэр, аж ахуйн газрын буруутай ажиллагаа гэмт хэргийн үйлдэл болж хувирсан тохиолдолд иргэн, захиргааны арга хэмжээгээр хязгаарлагдахгүй, хүнд ноцтой хохирол учирсан үед зөвхөн компаний албан тушаалтныг эрүүгийн хариуцлагад татсанаар өнгөрч болохгүй бөгөөд тухайн байгууллагад нь ялыг мөн адил оноох ёстой гэсэн агуулга дээрх баримт бичгүүдэд тусгалаа олжээ.⁷

1990-ээд оноос эхлэн баруун Европын орнууд хуулийн этгээд гэмт хэргийн субъект болох үндэслэл, нөхцөлийг эрүүгийн хууль тогтоомждоо тусган шинэчлэн тогтоож иржээ. “1992 онд баталсан Францын Эрүүгийн хуулиар тус орны түүхэнд анх удаа төрөөс бусад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсон байна. Ингэхдээ нэгдүгээрт, хуулийн этгээдийн явцуу эрх ашгийн үүднээс гэмт хэрэг үйлдсэн, хоёрдугаарт, хуулийн этгээдийн удирдлагад ашигтай байдал олгоход чиглэгдсэн бол...эрүүгийн хариуцлага хүлээлгэх...”⁸ тухай заажээ.

Францын Эрүүгийн хуулийн 121 дүгээр зүйлийн 2-т “хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хувь хүн, албан тушаалтанд оногдуулах ялаар орлуулан тооцож болохгүй” гэж заасны дээр тухайн гэмт хэрэгт гүйцэтгэгч ба хамтран оролцогчийн гэмт үйлдлүүдийг ялган зааглаж хариуцлагыг хамтад нь хүлээлгэж болох тухай өгүүлсэн байдаг.⁹

АНУ-ын Техас муж улсын Эрүүгийн хуулийн 7 дугаар зүйлийн 22-т “Корпораци болон ассоциаци нь өөрсдөө ямар нэгэн давуу ашигтай байдал олж авахын тулд хамтарсан коллеги, зөвлөлөөрөө хэлэлцэж шийдвэрлэх замаар хуулийн этгээдийн ашиг сонирхлыг илүүд үзэж тодорхой хууль бус үйл ажиллагааг дэмжсэн, зөвлөсөн, гүйцэтгэсэн зэргээр фелони (хүнд гэмт хэрэг) үйлдсэн нь нотлогдвол эрүүгийн ял онооно”¹⁰ гэж заажээ.

Нидерландын Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлийн 2-т “Эрүүгийн арх зүйн зөрчил (гэмт хэрэг) гаргасан хуулийн этгээдэд эрүүгийн хэрэг

⁷ Кисельник А.Г. “Современное международное уголовное право”. М., Пресс., 2003. с.72-75.

⁸ С.Нарангэрэл. “Монгол Улсын эрүүгийн эрх зүй. Ерөнхий анги”. УБ., 1999 он. 378 дахь тал.

⁹ Уголовный Кодекс Франции СП. 6: Пресс., 2002г.

¹⁰ Уголовный Кодекс Техаса СП.6. Юридический Центр. Пресс. 2006г.

үүсгэх буюу эрүүгийн ял оноох, хуульд заасан эрүүгийн албадлагын арга хэмжээ авах боломж нээлттэй бөгөөд ингэхдээ:

1. Хуулийн этгээдэд өөрт нь;
2. Хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан буюу эрх бүхий субьектэд;
3. Хамтарсан хариуцлагын зэрэг хэлбэрээс сонгон хэрэглэж болно¹¹ гэж заажээ.

Исланд, Дани, Норвеги зэрэг оронд хэрвээ хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэгт тухайн байгууллагын ямар нэгэн албан тушаалтныг эрүүгийн хариуцлагад татах үндэслэл байхгүй нөхцөлд тэрхүү компани, корпорацид өөрт нь эрүүгийн ял хүлээлгэхээр зохицуулсан байх ажээ.

Хуулийн этгээд гэмт хэргийн субьект байх үндэслэл нь нэг талаас, эрүүгийн хуулиар хориглосон гэмт хэргийг тухайн хуулийн этгээд өөрийн нэрээр зориуд үйлдсэн нь ямар нэгэн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх нөхцөлийг үгүйсгэх байдал бий болсноор; нөгөө талаас, гэмт хэргийн үйлдэл нь тухайн байгууллагад ашигтай, давуу байдал бий болгоход шууд чиглэгдсэн буюу зарим тохиолдолд албан тушаалтны хүлээх ялтай давхардахгүйгээр хуулийн этгээд тусдаа эрүүгийн хариуцлага хүлээх шаардлага зайлшгүй бий болсон зэргээр тайлбарладаг.¹²

Францын чиглэлийн (Р.Мерль, А.Витю) хамтын хариуцлагын онолоор бол хуулийн этгээд нь эрүүгийн хариуцлагын субьект (гэмт хэргийн субьект) болохыг нөхцөлдүүлж буй шалтгаан, үндэслэл гэдэгт:

- Хуулийн этгээдэд ашигтай боловч бусдад хохирол, үр дагавар учруулсан байх;
- Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс хийгдсэн байх;
- Хуулийн этгээдийг төлөөлөх коллеги, зөвлөлийн хамтын шийдвэрээр уг үйлдлийг дэмжсэн ба санаачлан үйлдсэн байх;
- Удирдах буюу эрх бүхий албан тушаалтны гэмт үйлдэлтэй давхардахгүй буюу тусдаа бүрэлдэхүүнтэй байх зэргийг хамааруулдаг ажээ.¹³

Хуулийн этгээдийн төрөл олон янз төдийгүй статус, төлөөллийн болон хариуцлагын хэлбэр өөр өөр байдгаас хамаарч эрүүгийн ялын төрлүүд хоорондоо ялгаатай байдаг. Францад хуулийн этгээдийг статус, эх үүсвэрээр нь хувийн ба нийтийн гэж 2 үндсэн ангилалд авч үздэг ба нийтдээ 30 гаруй төрөл хэлбэртэй байхад, Америкт зорилгоор нь буюу ашиг олох (бизнесийн), тэрчлэн ашгийн бус (бизнесийн бус)

¹¹ Уголовный Кодекс Голландий СП.6. Юридический Центр. Пресс. 2000г.

¹² Rassat M.L. Droit penal. Paris .1987. p.338. Авенесов .О.Г. "Реформа уголовного права Франции" 1990г. с.29-30.

¹³ Conte P, Maistre du Cuamdon P. Droit penal general Paris 1998. p157.

гэж ялган ангилж тус тусад нь нийтдээ 20 шахам төрөл болгон авч үздэг байна.

Хуулийн этгээд нь гэмт хэргийн (эрүүгийн хариуцлагын) субъект байх нөхцөл хийгээд ял оногдуулах үндэслэлийг эрүүгийн хуулийн тодорхой заалт, институт болгон тогтоосон 35 орон байдгаас (бидний судалгаагаар) Франц (1992), АНУ, Финлянд (1995), Англи, Бельги (1999), Канад, Хятад (1997), Португали (2007), Швейцар (2003), Дани, Израил, Ирак, Ирланд, Исланд (1998), Австрали, Алжир (2004), Нидерланд (1976), Норвеги (1991), Шотланд (2001) зэрэг улсаас гадна постсоциалист орнуудаас: Польш (2002), Эстон (2003), Унгар (2001), Румын (2004), Хорват (2003), Словени (1999) зэрэг орон, түүнчлэн Африкийн орнуудаас ӨАБНУ, Этиоп, Того зэрэг орныг энд тухайлан дурьдаж болно.

Дээр дурьдсан орнуудын Эрүүгийн хууль болон эрүүгийн хууль тогтоомжид хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлагын институт шууд ба шууд бус байдлаар хуульчлан томъёологдсон байна.

Нийтлэг жишгийн түгээмэл хандлагаар¹⁴ авч үзвэл Хуулийн этгээдийн гэмт хэргийн төрлүүдэд:

- Хүмүүс дээр элдэв туршилт хийх;
- Хүний амь насанд санаатай ба болгоомжгүй халдах;
- Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг үйлдэх;
- Хууль бусаар мансууруулах бодис тараах;
- Хүн худалдаалах, наймаалах, хүний наймаанд зуучлах;
- Хүний хувийн амьдралд халдах;
- Компьютерийн сүлжээ, ашиглалт, аюулгүй байдалд халдах;
- Байлдааны бүлэглэл зохион байгуулах;
- Хуурамч мөнгөн тэмдэгт, үнэт цаас үйлдвэрлэх;
- Ажлын байранд хүний амь насанд аюултай байдал буй болгох;
- Хөдөлмөр, аюулгүй ажиллагааны журам зөрчих;
- Хууль ёсны зөвшөөрөлгүй, газарт, хууль бусаар барилга барих;
- Харилцагч байгууллагыг хууран мэхлэх замаар хууль бусаар гэрээ хэлцэл хийх;
- Бусдын болон бизнесийн нууц, нэр хүндэд халдах;
- Экологийн тэнцэл алдагдуулах, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулах;
- Мэдээлэл, холбооны шугам сүлжээг гэмтээх, хууль бусаар ашиглах;
- Төрийн нууцыг задруулах, үндэсний аюулгүй байдалд халдах;
- Хүнсний аюулгүй байдлын стандарт, нөхцөлийг зөрчих;
- Чанаргүй буюу стандарт бус бүтээгдэхүүн гаргаж бусдад хохирол учруулах гэх мэт.

¹⁴ Есаяев Г.А. "Основы сравнительного уголовного права". М., "Элит" 2007 с.97-104.

Хуулийн этгээдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын хувьд ихэнхдээ торгох, эрхийг хязгаарлах, үйл ажиллагааг нь зогсоох зэрэг ялыг хэрэглэдэг байна. Францын эрүүгийн хуульд заасан санхцаас үзэхэд:

1. Хувь хүн, албан тушаалтанд хүлээлгэх торгуулиас наад зах нь 5 дахин илүү төлбөр торгуулийг хуулийн этгээдэд оногдуулах;

2.5 жилээс дээш хорих ял шийтгүүлэхээр (минимум) гэмт хэрэгт хувь хүн албан тушаалтан биш харин тухайн байгууллага холбогдон ял эдлэх нөхцөлд уг хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах эрхийг зогсоох, хүчингүй болгох;

3.5 жил хүртэл ял шийтгүүлэхээр альтернатив гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн нөхцөлд үйл ажиллагааг нь хязгаарлах, тодорхой хугацаанд хориглох;

4. Гэмт хэргийн замаар олсон орлого, эд зүйлс бүтээгдэхүүнийг хураах гэх мэт. Түүнчлэн чек, хувьцаа гаргах эрхийг хязгаарлах, хориг тавих зэргээр шүүхийн хяналтад 5-аас дээшгүй жил цагдан хянах, хяналтад байлгах зэрэг ялын төрлийг тогтоосон байдаг. Францад гэмт хэргийн ангилалтаас хамаарч хуулийн этгээдэд 50.000-250 сая хүртэл еврогийн торгууль оногдуулдаг ба торгууль төлж чадахгүй хуулийн этгээдийг албадан татан буулгадаг.¹⁵

Бельги, Дани, Франц, Исланд зэрэг зарим оронд хувийн хуулийн этгээдээс гадна нийтийн эрх зүйн хуулийн этгээд болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага гэмт хэргийн субъект болдог практик бий. Харин Ирак, Хятад, Литва, Молдав, Норвеги, Эстони зэрэг оронд зөвхөн хувийн эрх зүйн хуулийн этгээд тэр тусмаа арилжааны компаниуд эрүүгийн хариуцлага хүлээх субъект болдгоороо онцлогтой.

Испани, Япон, Албани, Австри зэрэг оронд хуулийн этгээдийн гэмт хэргийн субъект байх шинжийг хуульчлаагүй (хүлээн зөвшөөрөөгүй) боловч тухайн хуулийн этгээдийн гэмт хэргийн үр дагаврыг компаний удирдах албан тушаалтан төлөөлөн хүлээх буюу зарим тохиолдолд эрүүгийн албадлагын (хөрөнгө хураах, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түтгэлзэх, хойшлуулах, хамгаалалт тогтоох, битүүмжлэх) арга хэмжээг (ял биш) хэрэглэдэг аж. Хуулийн этгээд гэмт хэргийн субъект байх бас нэг шалгуур онцлог нь уг хуулийн этгээд хууль ёсны дагуу үүсч байгуулагдсан байхын дээр эрүүгийн хууль тогтоомжид заасан нөхцөлүүдийг бүрэн хангасан байхад оршино.

Зүүн Европын зарим орон, Орос, Украин, Белорус, Казакстан болон Монголд хуулийн этгээд гэмт хэргийн субъект байх шинжийг үгүйсгэж ирсэн бөгөөд зөвхөн иргэний эрх зүйн хүрээнд, зарим тохиолдолд захиргааны эрх зүйн хувьд хариуцлага хүлээх (эрүүгийн бус) явдлыг зохицуулан тогтоож иржээ.

Сүүлийн 20 жилд постсоциалист орнуудад хуулийн этгээдэд

¹⁵ Харьцуулан эрх зүйн онол, практикийн орчин үеийн асуудал” сэдэвт Олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын материал. УБ., 2007 он. 84 дэх тал.

хүлээлгэх захиргааны хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх, зарим тохиолдолд хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын нөхцөл, боломжийг судалж тооцон, эрүүгийн хуульдаа нэмэлт, өөрчлөлт оруулах замаар эрх зүйн реформын шинжтэй зоримог өөрчлөлтүүд хийгдэж эхлээд байна. Жишээ нь, Унгар 2001 онд, Литва 2000 онд, Польш 2002 онд, Румын 2004 онд, Эстони 2001 онд, Словени 1999 онд тус тус өөрчлөлт, шинэчлэлтийг хийснээр эдгээр оронд хуулийн этгээдийг гэмт хэргийн субъект гэж тооцох болсон ба эрүүгийн хариуцлага хүлээлгэх орчин нөхцөл нэгэнт бүрджээ.

Зах зээлийн нийгмийн харилцаа бүрэн нэвтэрч, төлөвшөөгүй, тогтвортой хөгжлийн орчин бий болж чадаагүй оронд гэмт хэргийн шинэ төрлүүд далд хэлбэрээр оршиж, гэмт хэрэг үйлдэгч субъектийн хүрээ өргөжин, гэмт зан үйлийн сөрөг нөлөөллийг тогтоон барих эрүүгийн эрх зүйн үр ашигтай механизм бүрэлдэж амжаагүй байдгаас үүдэн албан тушаалтнууд төдийгүй хуулийн этгээд ял завших боломж бий болсоор байдаг ажээ.

Байгаль орчин (ус, агаар, газрын хөрс, ургамал) бохирдуулах, “мөнгө угаах”, үнийг хууль бусаар өсгөх, зах зээлийн орчинд шударгаар өрсөлдөх боломжийг хааж, дангаар ноёрхох, монополь тогтоох, хууль бусаар лиценз олгох, хуулиар зөвшөөрөөгүй нөхцөлд хууль бус аргаар барилга барих, газар эзэмших, татвараас зайлсхийх, хуурамч баталгаа баримт бүрдүүлж зээл авах, зээл төлөхөөс санаатай зайлсхийх, залилан мэхлэх замаар бусдыг төөрөгдүүлж гэрээ хэлцэл хийх, хууль бус, хуурамч баталгаа баримт гаргаж өгөх зэрэг олон гэмт хэргийн эзэн холбогдогч нь албан тушаалтан ба хуулийн этгээд хоёрын дунд эзэнгүйдэж, эрх зүйн хийдлийн негатив хамаарлаас болж ял завших, хариуцлагаас мултрах нөхцөл нь аяндаа бүрддэг байна. Дээрх байдал постсоциалист орнууд төдийгүй Монгол Улсын хувьд ч бодит зүйл болсныг үгүйсгэх аргагүй юм.

Тоймлон дүгнэсэн саналын хувьд

1. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, нөхцөлийг эрүүгийн хуульдаа эрх зүйн институт болгон томьёолж, эрүүгийн эрх зүйн зохицуулалттай болгосон гадаадын зарим орны туршлагыг сайтар гүнзгий судлах, энэ талаар төсөл хөтөлбөр боловсруулж, судалгааны болон ажлын хэсэг байгуулж ажиллан үр дүнг тооцох нь манай орны хувьд чухал ач холбогдолтой гэж үзэж байна;

2. Одоо үйлчилж буй Монгол Улсын эрүүгийн хуулийг өөрчлөн шинэчлэх реформын хүрээнд экологийн, эдийн засгийн зарим тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдсэн буюу түүнд холбогдсон хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага (торгох, үйл ажиллагааг зогсоох) хүлээлгэх үндэслэлийг шинээр томьёолсон заалтыг

эрүүгийн хуульд нэмж оруулах.;

3)Экологи, газар, санхүү, төсвийн болон аж ахуйн эсрэг гэмт хэргийн гаралт, илрүүлэлт болон шүүхээр шийдвэрлэгдсэн байдалд сүүлийн 20-25 жилийн байдлаар иж бүрэн тандалт, судалгаа хийж, хуулийн этгээдтэй холбогдсон захиргааны зөрчлийн болон гэмт хэргийн шинжтэй үйлдлийн шалтгаан нөхцөл, бүтэц, хандлагыг криминологи, эрүүгийн эрх зүйн талаас нь төслийн хэмжээнд судалж, дүгнэлт, санал боловсруулах;

4)Харьцуулсан эрүүгийн эрх зүй судлалыг дэмжих, хөгжүүлэх талаар дорвитой арга хэмжээ авах, энэ чиглэлийн ном, сэтгүүлийг хамтарч гаргах, тухайн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг идэвхжүүлэх нь зүйтэй юм.

Хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг боловсронгуй болгох хүрээнд хуулийн этгээд гэмт хэргийн субъект болох зайлшгүй үндэслэл, нөхцөлийг эрх зүйн тодорхой зохицуулалттай болгох, захиргааны зөрчлийн бүрэлдэхүүн хэмжээнээс хэтэрсэн зарим гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцож болох нөхцөлийг бодитойгоор судалж, эрүүгийн эрх зүйн чиглэлийн зоримог, шийдвэртэй өөрчлөлт хийх шаардлага бидний өмнө тулгарч байна.

СОНГУУЛИЙН КОМПАНИТ АЖИЛ ДАХЬ ЗОХИОН БАЙГУУЛАЛТТАЙ ГЭМТ БҮЛЭГЛЭЛИЙН ОРОЛЦОО

**ОХУ-ын Сонгуулийн эрх зүйн институтын шинжээч,
хууль зүйн доктор Красинский Владислав Вячеславович**

ОХУ-ын эдийн засаг дахь төрийн зохицуулах үүрэг мэдэгдэхүйц сулрах шатанд явагдсан эдийн засгийн харилцааны хөгжил, зах зээлийн харилцааг зохицуулах шаардлагатай эрх зүйн зохицуулалтгүй нөхцөл байдал, хууль бус арга, хэрэгсэл ашиглах замаар төрийн өмчийг өргөн хүрээгээр хувьчилж эхэлсэн зэрэг нийгэм, эдийн засаг, улс төрийн үйл явцууд зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлүүдийн (ЗБГБ) төлөөллийг эдийн засгийн харилцаанд үй олноор татан оролцуулах, үлэмж их хэмжээний аж ахуйн үйл ажиллагаанд гэмт бүлэглэлүүдийн хяналт аажмаар тогтоход хүрсэн.¹

Ашиг, орлогоо тогтмол өсгөж, үржүүлэх гэсэн гэмт бүлэглэлүүдийн санаа, зорилго, эрмэлзэл, оросын улс төрийн нөхцөл байдлаас шууд хамааралтай албан ёсны ба далд эдийн засгийн үйл ажиллагаа, гэмт хэрэгтнүүдийн хувийн аюулгүй байдал, ашиг сонирхолоо хангах гэсэн хүсэл, эрмэлзэл зэрэг нь эрүүгийн ертөнцийн нөлөө бүхий хүмүүс (толгойлогчид)-ийг өөрсдийн байр суурь, эрх мэдлээ хууль ёсны болгох, бэхжүүлэх, дээд түвшинд улс төрийн шийдвэр гаргахад идэвхтэй оролцох санаа зорилгыг бий болгосон.

Дээр дурдсан гэмт санаа, зорилго, ашиг сонирхолоо хэрэгжүүлэх таатай зам суваг нь ОХУ-д явагддаг сонгуулийн компани ажилд ЗБГБ өргөнөөр оролцох явдал юм.

ЗБГБ сонгуулийн кампанид ажилд оролцоходоо төрийн эрх мэдэл, засаглалыг гартаа авах, улмаар төрийн болон орон нутгийн сонгуульд байгууллагуудын зүгээс гэмт бүлэглэлийн хууль бус ашиг сонирхолд тогтмол үйлчлэх нөхцөл бүрдүүлэх алсын зорилго агуулдаг онцлогтой.

Уг зорилгодоо хүрэхийн тулд зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл нь хэд хэдэн хэтийн зорилтуудыг шийдвэрлэх шаардлагатай байдаг.

ЗБГБ сонгуулийн кампани ажилд оролцох хэтийн зорилтууд нь:

а. улс төрийн;

б. эдийн засгийн гэсэн хоёр төрөлтэй.

¹ Энэ ба цаашид зохион байгуулалттай гэмт бүлэг гэдэгт тогтвортой, эвлэлдэн нэгдсэн, шатлан захирах ёсны пирамид бүтэцтэй, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж зорилгоор байгуулагдсан гэмт байгууллагыг ойлгоно. Зохион байгуулагч, удирдагч, оролцогч болон гэмт бүлгийн бусад төлөөлөгчид хамтдаа гэмт хэргийн ертөнц (байгууллага) юм.

ЗБГБ-ийн төлөөний хүмүүсийг төрийн эрх мэдлийн болон орон нутгийн байгууллагад сонгохтой холбогдуулан ЗБГБ улс төрийн зорилтуудад дараахыг хамааруулбал зохино²:

- нутгийн захиргааны байгууллагын сонгуульд албан тушаалыг ЗБГБ ашиг, сонирхолд нийцүүлэн ашиглах зорилгоор тэдгээрийн албан тушаалын эрх мэдлийг олж авах;
- холбооны болон бүс нутгийн төрийн эрх мэдлийн байгууллагуудын бүтцэд ЗБГБ-ийн ашиг сонирхолд нийцсэн эрх зүйн хэм хэмжээний акт батлуулах, улс төр, захиргааны болон бусад албан ёсны шийдвэр гаргуулахад чиглэгдсэн “лобби” хийдэг парламентын болон бүс нутгийн төрийн дээд байгууллагад туслах бүлэг байгуулах;
- сонгуульд албан тушаалтнууд болон парламентын гишүүний халдашгүй дархан эрх ямба олж авах.

ЗБГБ-ын төлөөлөл болсон хүмүүсийг төрийн эрх мэдлийн болон орон нутгийн байгууллагад сонгогдохтой холбогдуулан ЗБГБ-ийн эдийн засгийн хэтийн зорилтуудад дараахыг зорилтуудыг хамааруулна:

- түүхий эд, үл хөдлөх хөрөнгө, бараа, үйлчилгээний зах зээлийг ЗБГБ ашиг сонирхолд нийцүүлэн хууль бусаар хуваах;
- ашиг, орлог ихтэй төсөв бүрдүүлэгч төрийн өмчит үйлдвэрийн газар, стратегийн ач холбогдолтой эдийн засгийн салбар (барилга, түлш эрчим хүч, уул уурхайн олборлох аж үйлдвэр, банк, зээл санхүүгийн байгууллагууд)-т хяналтаа тогтоох;
- хууль бусаар нэмэлт хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх (экспорт-импортын гүйлгээ, татвар, эрх, лиценз, зөвшөөрлийн үйл ажиллагаа, квот);
- хууль бусаар зээл авч ЗБГБ-ын ашиг, сонирхолд нийцүүлэн төсвийн хөрөнгийг зарцуулах.

ЗБГБ сонгуулийн кампанит ажилд оролцох цогц зорилтыг төрийн эрх мэдлийн төлөө сонгуулийн нөхцөлд тэмцэл явуулж буй эрүүгийн гэмт хэрэгтнүүдийн сонгосон арга, хэрэгслээр тодорхойлно.

ЗБГБ-ийн гишүүд сонгуульд бэлтгэх, хэрэгжүүлэх явцад улс төрийн тэмцэлд хүлээн зөвшөөрөгдсөн, хууль ёсны аргуудаас гадна дараахыг өвөрмөц аргуудыг ашигладаг:

- улс төрийн нам, тэдгээрийн бүс нутгийн салбар, газар, хэлтсийн удирдлага, сонгуулийн хорооны дарга, гишүүд, шүүгч, хууль сахиулах байгууллагуудын ажилтнууд, сэтгүүлчдийг хахуульдах (албан тушаалтан буюу зохион байгуулалттай гэмт бүлгийн

² Сонгуулийн журмаар байгуулагдах төрийн эрх мэдлийн болон орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад ОХУ-ын Ерөнхийлөгч, ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Дум, ОХУ-ын субъектуудын төрийн эрх мэдлийн хууль тогтоох байгууллагууд, орон нутгийн захиргааны төлөөллийн байгууллагын сонгуульд албан тушаалтнууд хамаарна. Одоог хүртэл гэмт хэргийн ертөнцийн төлөөлөл дундаас ОХУ-ын Ерөнхийлөгчийн албан тушаалд сонгогдох хүсэл, эрмэлзлийн талаарх мэдэл, мэдээлэл авагдаагүй байгааг онцлон тэмдэглэх шаарддагтай. Үүнийг харгалзан зохиогч ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд ЗБГБ оролцооны тухай авч үзээгүй. ХҮ

сонирхож буй объектуудыг хахуульдахад нийт гэмт хэрэг үйлдэж олсон орлогын 3/2-ыг зарцуулдаг болох нь практикаас харагдаж байна. ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын болон төрийн эрх мэдлийн хууль тогтоох байгууллагуудын гишүүдийг (депутат) хувь тэнцүүлэх буюу пропорциональ тогтолцоогоор сонгох аргыг нэвтрүүлж амьдралд хэрэгжүүлсэн ч нөхцөл байдлыг зарчмын хувьд огт өөрчилж чадаагүй. Урьд өмнө нь ЗБГБ-ын гишүүд өөрсдийн хяналтыг тогтоосон нутаг дэвсгэрт буюу нэг мандаттай, олон мандаттай тухайн тойргоос эсхүл улс төрийн намуудын жагсаалтад "гаргасан" суудлаас сонгогдож байсан бол одоо улс төрийн үйл явц дахь намын хээл хахуулийн эзлэх байр суурь, үүрэг үлэмж их хэмжээгээр өссөн);

- сонгогчдыг хахуульдах;
- намын ажилтнууд, сонгуулийн хорооны гишүүд, сэтгүүлч, шүүгчдэд элдэв дарамт шахалт үзүүлэх;
- үнэнч, чадварлаг албан тушаалтан, хууль сахиулах байгууллагуудын ажилтнуудыг (хэргийн) холбогдолд оруулан (компрометация) дарамтлах, эрхшээлдээ оруулах;
- сонгогчдыг нэр дэвшигчийн тээврийн хэрэгслээр сонгуулийн хэсгийн хорооны байруудад албадан хүргэж санал өгүүлэх;
- эд хөрөнгө устгах (байр сууц, тээврийн хэрэгсэл, иргэдийн хүлээн авах байр болон нэр дэвшигчдийн сонгуулийн штаб);
- улс төрийн өрсөлдөгчид болоод тэдгээрийн гэр бүлийн гишүүд, садан төрлийн хүмүүст хүч хэрэглэх (аллага үйлдэх хүртэл)³.

ЗБГБ-ийн сонгуулийн кампанит ажилд оролцох зорилтыг хэрэгжүүлэх нь эрүүгийн ертөнцийн төлөөлөл болсон хүмүүсийн зүгээс сонгуулийн нөхцөл дэх төрийн эрх мэдлийн төлөөх тэмцэлд ашиглаж буй аргаас зөвхөн хамааралтай бус бөгөөд үүнд зарим шийдвэрлэх хүчин зүйл нөлөөлнө. Дээр дурдсан зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг хөнгөвчлөх, хүндрэл, бэрхшээлтэй болгодог хүчин зүйлсийг тус тус ялгаж салгаж байх шаардлагатай.

Сонгуулийн кампанит ажилд оролцох зорилтыг хэрэгжүүлэх ажлыг хөнгөвчлөх, улс төр, эрх зүй, материал-техникийн, зохион байгуулалтын, үзэл суртлын хүчин зүйлс нь нэлээд ач холбогдолтой болохыг дурдаж болно.

Улс төр, эрх зүйн хүчин зүйлс нь улс орны төрийн тэргүүн, ОХУ-ын субъектуудын өндөр албан тушаалтнуудын алдаа, овоог төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын гэмт явдалд автах үйл явцтай тэмцэх хүсэл зориггүй байдлыг хослуулан хамааруулдаг. Эрүүгийн ертөнцөөс гаралтай этгээдүүд аль хэдийнээ

³ Тухайлбал, 2006 онд Приморск тойргийн Дальнегорск хотын Засаг Захиргааны Тэргүүний албан тушаалд нэр дэвшигчийн аллага. 2006 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн "Нэгдсэн Орос" намын Тэргүүлэгчдийн Ерөнхий Зөвлөлийн мэдэгдэл "Гэмт хэргэлтийг төрийн эрх мэдэлд гарахыг үл зөвшөөрнө!"

төрийн зарим эрх хэмжээ, нутгийн засаг захиргааны байгууллагуудын чиг үүргийг бодит амьдралд хэрэгжүүлээд эхэлсэн байна.⁴

ЗБГБ-ын гаралтай нэр дэвшигчид оросын ард түмний зарим нийгмийн бүлэг, бүлэглэлийн ашиг, сонирхолыг илэрхийлж, олон нийтийн зүгээс дэмжлэг авч чаддаг болсон байна.⁵ “Нийгмийн үзэл бодол” сангаас ОХУ-ын 44 субъектын хот суурин болон хөдөө, тосгоны ард иргэдийн дунд явуулсан Бүх нийтийн санал асуулгад оролцсон иргэд улс орон дахь эмх журмыг ЗБГБ-ээс гаралтай хүмүүс тогтоож чадна гэж үзсэн байна. Учир нь гэмт хэрэгнүүд илүү “дэг журамтай”, тэдгээрийн орчинд “эмх журам илүү зонхилдог” гэснээр тайлбарлажээ. Асуулгад оролцсон иргэдийн 2% нь эрүүгийн ертөнцийн төлөөлөл болсон хүмүүс үнэнч, шударга, амьдралын баялаг туршлагатай, ухаантай, өгсөн амлалтаа биелүүлж чаддаг (“тэд нар амьдралын нарийн, ширийнийг илүү сайн ойлгодог”, “улс төрчдийг бодвол тэд гол төлөв эмх журамтай байж чаддаг гэж хариулсан нь тохиолдлын зүйл биш юм.”).⁶

Улс төр, эрх зүйн хүчин зүйлсийн өөр нэг бүрэлдэхүүн хэсэг нь төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудад ЗБГБ-ийн төлөөлөл болсон хүмүүс сонгогдох болоход үүнээс урьдчилан сэргийлэх эрх зүйн хэм хэмжээний үр дүнтэй хязгаарлалт байхгүй байгаа явдал юм. Эрэн сурвалжлагдаж буй эсхүл мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж буй этгээдүүд сонгуульд нэр дэвшигчээр бүртгэгдэн сонгогдож болзошгүй байдаг. Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй сонгуулийн тухай хууль тогтоомжид сонгуульд нэр дэвшигч ЗБГБ-тэй холбоотой талаар гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан чухал ач холбогдолтой мэдээ, мэдээлэл цөөнгүй байгаа нь тухайн нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзах (нэр дэвшигчийн жагсаалтаас-цаашид НДЖ гэх), нэр дэвшигчийг жагсаалтаас хасах, нэр дэвшигчийн бүртгэлийг хүчингүй болгох эсхүл нэр дэвшигчийг бүртгэхийг хойшлуулах үндэслэл болохгүй гэж заасныг цохон тэмдэглэх нь чухал юм.⁷

⁴ Тухайлбал, “Далд шүүх эрх мэдэл”

⁵ Эрүүгийн гэмт ертөнцийн төлөөлөгчдөд сонгуулийн үеэр тогтвортой дэмжлэг үзүүлэх нийгмийн үндэс суурь нь гол төлөв үзрү өмнө нь нэг бус удаа ял шийтгүүлж байсан, мөрдөн байцаалтын шатанд шалгагдан хорих газруудад хоригдож буй этгээдүүд, тэдгээрийн хамь хамсаатан, залуучууд байдаг. Гэмт явдлыг өөгшүүлэх, дэмжихээ бэлэн иргэдийн гэмт хэргийн чадавхн нэлээд өндөр юм. Мэргэжилтэн, шинжээчдийн хийсэн тооцоо, судалгаагаар нийт 15-18 сая хүн ОХУ-ын засан хүмүүжүүлэх байгууллагуудаас дамжсан; далд гэмт хэрэг үйлдэгсдийн тоо 15 саяд хүрч байна; жил бүр ойролцоогоор 3 сая орчим гэмт хэрэг үйлдэгддэг; 5 сая орчим гэмт хэргийг албан ёсоор илрүүлээгүйд тооцогддог байна. Ингэхлээр 35-40 сая хүн (оросын нийт насанд хүрсэн иргэдийн бараг 3/1 болгон) гэмт хэрэгт холбогдолтой байна. (Криминология. Их, дээд сургуулиудад зоринусан сурах бичиг) В.Д. Малков хянан тохиолдуулсан. М.: ЗАО Юстцинформ, 2006. С. 421.

⁶ Петрова. А. “Криминал во власти-обычное явление?” //bd.fom.ru/report/map/projects/, мөн Труд. 2004.08.10. №148.

⁷ ОХУ-ын иргэдийн сонгуулийн эрхийн үндсэн баталгаа болон олон нийтийн санал асуулга (референдум)-д оролцох эрхийн тухай ОХУ-ын Холбооны хуулийн 38.24 дүгээр зүйл, 76 дугаар зүйл, ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын депутат(гишүүн)-ын сонгуулийн тухай хуулийн 44, 91-дүгээр зүйл, ОХУ-ын Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хуулийн 39, 84 дүгээр зүйл.

Сонгуулийн кампанит ажилд оролцох ЗБГБ-ийн зорилтыг хэрэгжүүлэхэд материал-техникийн хүчин зүйлс чухал үүрэг гүйцэтгэдэг. Нэг талаас, орон нутгийн болон бүс нутгийн төсвийн хомсдол, нөгөө талаас ЗБГБ үлэмж их хэмжээний материаллаг баялаг, эд хөрөнгөтэй байдал нь төрийн эрх мэдлийн байгууллагуудыг ЗБГБ-тэй хамтран ажиллах сэдэл төрүүлж, цаашид “эрүүгийн” ертөнцийхөөс эдийн засгийн хамааралтай болгоход нөлөөлж байна.

ЗБГБ мөнгө санхүүгийн хувь ямар нэгэн асуудалгүй байх, өөрсдийн эзэмшил, хяналтад аль хэдийнээ “хөлөө олсон” аж үйлдвэр, санхүүгийн байгууллагуудтай байх нь сонгуулийн кампанит ажлын гол явзэн тэтгэгч, санхүүжүүлэгчээр оролцож, шүүх, сонгуулийн хороо, хууль сахиулах байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагаанд хяналт тавих өргөн боломжийг бүрдүүлдэг. Сонгуульд бэлтгэх, явуулах явцад гэмт бүлэглэлийн ашиг, сонирхолыг илэрхийлэгч бүлэглэлүүд ард, иргэдийн нийгэм-хангамжийн ач холбогдолтой асуудлыг шийдвэрлэх бэлэн байдал, ур чадвараа олонтаа харуулж чаддаг. Тухайлбал, шинэ зам тавих, засаж, сайжруулах, Дэлхийн II дайнд оролцогч-дайчдад зориулсан дурсгалын хөшөө, самбар байгуулах, хүүхдийн тоглоомын талбай барих, улс орны эдийн засгийн хөтөлбөр, үндэсний төргүүлэх төслүүдийг хэрэгжүүлэхэд оролцохыг эрмэлздэг. Ингэснээр иргэдийн ялангуяа эмзэг, бүлгүүд ядуусын талархалыг хүлээж чаддаг.

Зохион байгуулалтын хүчин зүйлс бол гэмт бүлэг, бүлэглэлийн сонгуулийн кампанит ажилд оролцох зорилтыг амжилттай хэрэгжүүлэх явдалд тус дөхөм болдог. ЗБГБ-ээс гаралтай нэр дэвшигчдийн баг санхүүжилт сайтай байх, сонгууль зохион байгуулах мэргэжлийн, чадварлаг боловсон хүчнийг сонгох, элсүүлэх өргөн боломжтой байх, эмх цэгцтэй удирдлагын тогтолцоотой байх зэрэг нь зохион байгуулалтын хүчин зүйлсэд хамааралтай шинжүүд юм. Эмх цэгцтэй удирдлагын тогтолцооны шинжээс дурдвал дэвшүүлж буй зорилт бодитой, тодорхой байх, хүнд суртлыг багасгахад чиглэгдсэн байх, үүрэг даалгаварын хуваарилалт, хатуу захирагдах ёс, хяналттай байх, гүйцэтгэгчдийн харилцан хариуцлага өндөр байх зэрэг болно.⁸

Эрүүгийн ертөнцийн төлөөлөл болсон хүмүүс сонгуульд амжилт гаргахад үзэл суртлын хүчин зүйлс улам их ач холбогдолтой болж байна. Сонгуулийн практикаас харахад ОХУ-ын хэдэн мужийн ард иргэдийн нийгмийн ухамсарт сонгуульд албан тушаалд ЗБГБ-ийн төлөөлөлөөс төрийн эрх мэдлийн болон нутгийн захиргааны өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгогдсон эсхүл “эрүүгийн” ертөнцөөс гаралтай нэр дэвшигчдэд хүлцэнгүй байдал гаргах, өрөвдөх, тал

⁸ 2002 оны 4 дүгээр сард Омск хотын иргэдийн дунд явуулсан санал асуулгад оролцсон иргэдийн 23,3% нь эрүүгийн ертөнцийн төлөөлөл болсон хүмүүсийн сэтгэл татам шинжүүд дундаас ажил хэрэгч байдал, асуудал шийдвэрлэж ур чадварыг нэрлэсэн байна.

засах байдал ажиглагдах болсон. ОХУ-ын хэд хэдэн мужид эрүүгийн ертөнцийн төлөөлөл болсон хүмүүст иргэдийн зүгээс хүндлэл үзүүлдэг байна.⁹ Эрүүгийн ертөнцийн соёл, дэг жаяг (хүчирхийллийг тахин шүтэх, бусдын хөлс, хүчийг мөлжих явдал, нийгэмд харш хэм хэмжээ-зан үйл, мөрийтэй тоглоом, этгээд үг хэллэг (жаргон), бүдүүлэг хараал, хоч, шивээс, хулгайчдын этгээд хэлтэй дуу)-ийн шинж өдөр тутмын амьдралд нэвтрэн оросын нийгмийн тодорхой бүлэгт тогтмол мөрдөж байна.¹⁰ Гэмт хэргийн нөлөөллийг нийгэмд, ялангуяа, залуу үеийхний дунд нэмэгдүүлэхэд ЗБГБ идэвхтэй дэмжлэг үзүүлдэг. ЗБГБ-ийн эх үүсвэрээс санхүүжиж, түүний нөлөөн дор үйл ажиллагаа явуулдаг спортын дугуйлан, секц, клуб, чөлөөт цагаа өнгөрүүлэх төвүүд, шөнийн цэнгээний газрууд олонтоо тохиолддог. “Хулгайч”-дын сэтгэхүй холбооны төрийн эрх мэдлийн болон захиргааны байгууллагуудад хүртэл газар аваад байна.

Түүнчлэн ЗБГБ сонгуулийн кампанит ажилд оролцох зорилтуудыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг хүчин зүйлсийг тусгайлан авч үзэх нь зүйтэй. Үүнд:

- зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх ашиг сонирхол төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагуудын бодлоготой нийцэх;
- зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх талаар төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын удирдлага, албан тушаалтнуудын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээнд хүн амын зүгээс дэмжлэг үзүүлэх;
- эрүүгийн ертөнцийнхнийг төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад “шургалах” явдлыг гаргахгүй байх талаар хууль сахиулах байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн байгууллагуудын явуулж буй үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах;
- мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж, эрэн сурвалжлагдаж буй хүнд болон онц хүнд гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө урьд өмнө нь ял шийтгүүлж байсан этгээдүүдийг төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгоход эрх зүйн хязгаарлалт тогтоох замаар сонгуулийн тухай хуулийг боловсронгуй болгох;
- сонгуульт албан тушаалтнуудын халдашгүй дархан эрх, парламентын дархан эрх ямбын тоо хэмжээ, агуулгыг

⁹ Төрийн эрх мэдэлтнүүд ихэвчлэн өөрсдөө иргэдийн сэтгэл зүйд гэмт хэрэгтнүүдийг “хамгийг чалагч” хүмүүс гэдэг итгэл үнэмшлийг суулгадаг. Эрүүгийн гэмт хэрэгтнүүдээс буяны хандив хэлбэрээр дурталаа мөнгө авдаг төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад хэрхэн хандах вэ? Гэмт хэрэгтэн, эрүүгийн элементүүдээс өөрийгөө (иргэдийг биш!) хамгаалж чадахгүй байгаа төрийг хэрхэн хүндлэх вэ? Гэмт бүлэглэлүүдээс хараат төрийн эрх мэдэл нийгмийн амьдралын бүхий л салбарт гэмт хэргийн нөлөөллийг нэмэгдүүлэх шалтгаан болно.

¹⁰ Маликов Б.З. “Усиление криминала в сфере духовности общества и некоторые проблемы укрепления правопорядка” / Проблемы правовой культуры. Криминологическая ассоциация, 2002. Х. 7. Түүнчлэн Анисимов В.М. “Криминальная культура и нейтрализация” в ИУ России. Автореф. дис. д-ра. юрид. наук. М.: Академия управления МВД РФ, 1998. Х.3.

хязгаарлах.

Төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад эрүүгийн ертөнцийхний нэвтрэх, “шургалах” үйл явц хоёр үе шатаас бүрдэж байсан.

Зохион байгуулалттай гэмт явдлын улс төржих анхдагч үзэгдэл буюу 1995-1999 онуудад ЗБГБ-аас өөрсдийн нэр дэвшигчдийг төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгуулиар дэвшүүлэн, идэвхтэй хөхүүлэн дэмжиж байсан.¹¹ Энэхүү нөхцөл байдал нь 1999 оны сонгуулийн тухай хууль тогтоомжтой үндсэндээ холбоотой юм. Тус хуульд нэр дэвшигч эрүүгийн хариуцлагад татагдсан тухайгаа сонгуулийн хэсгийн хороонд заавал мэдээлэх шаардлагатай тухай эрх зүйн зохицуулалтгүй байжээ. 1999 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн “Сонгуулийн эрхийн үндсэн баталгаа ба бүх нийтийн санал хураалтад оролцох холбооны хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Холбооны хууль (№55-Ф8) хүчин төгөлдөр болсонтой холбогдуулж сонгуульт албан тушаалд нэр дэвшигч буй нэр дэвшигч шийтгүүлсэн ялын үр дагавар хүчингүй болоогүй эсхүл эдэлж дуусагүй ялаа ОХУ-ын Эрүүгийн хуулийн хэддүгээр зүйл заалт, ямар гэмт хэрэгт үндэслэн шийтгэгдсэн тухай нарийвчлан тусгах үүргийг бөхжүүлсэн байна. Мөн энэ тухай ЗХУ болон Холбоотон Бүгд Найрамдах Улсын эрүүгийн хууль тогтоомжид нийцүүлэн батлагдсан эрүүгийн хуулийн зүйл, заалт, гадаад улсын эрүүгийн хуулийн зүйл, заалтыг үндэслэн нэр дурдсан хууль тогтоомжийн дагуу ОХУ-ын хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуульд гэмт хэрэгт тооцогдох үйлдэл хийсний улмаас ял шийтгүүлсэн бол ялгүй болоогүй эсхүл эдлэж дуусаагүй ялаа заавал тусгах үүрэг хүлээнэ.

Гэмт явдлын улс төржих анхны үйл явц давамгайлсан нь эрүүгийн ертөнцийхний бүтэц өөрчлөгдсөнтэй холбоотой юм.

“Дархлагдсан хулгайч”-дын хажуугаар хулгайчдын зан үйл, уламжлал (үндэсний өшөөрхөл, дайсангал, улс төр, нийгмийн амьдралд оролцох хоригоос татгалзах, аллага үйлдэх, хууль сахигчдад халдах, гэмт хэргийн ертөнцийхний нэгдэл, хуримтлалаас татгалзах)-ыг¹² үл ойлгож, бүдүүлгээр зөрчдөг балмад эрүүгийн толгойлогч

11 Төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад гэмт хэргийн ертөнцийхнийг нэвтрүүлэх, шургуулах явдал гагцхүү сонгуулийн нөхцөлд хэрэгждэг бус гэдгийг ойлголцон тэмдэглэх шаардлагатай. Парламентын гишүүн, сонгуульд албан тушаалтан, тухайн холбооны, бүс нутгийн болон засаг захиргааны албан тушаалтан (зарим тохиолдолд тээгээрийн ойрын хүрээллийг урт хугацааны нууц хамтын ажиллагааг төрийн механизм болон нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх зорилгоор) нь эд материалын үндсэн дээр татан оролцуулах нь аль ч зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн тагнуул, сөрөх тагнуулын тэргүүлж зорилтуудын нэг юм. Гэхдээ авилгач-албан тушаалтан бүр зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн ашиг сонирхолыг төлөөлдөггүй бөгөөд зохион байгуулалттай гэмт явдалтай зүй ёсоор холбоотой байдаггүй гэдгийг харгалзан үзэх нь зүйтэй.

12 “Дархлагдсан хулгайч” гэдэгт гэмт хэргийн өргөн туршлагатай бөгөөд хулгайчдын зан үйл, уламжлалыг сахин биелүүлдэг гэмт ертөнцийн хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн, толгойлогчийг хэлнэ. Зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн тэргүүн, толгойлогч, оролцогчдын тодорхойлох

этгээдүүд (зэрлэг, балмад адгуусууд)-эрүүгийн ертөнцөд идэвхтэй үүрэг гүйцэтгэж байна. 1990-ээд онд дээрх хэсэг этгээдүүд төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгогдохын тулд ихэхээн идэвх, чармайлт гаргаж байсан.

Уг зорилгоодоо хүрсний дараа эрүүгийн ертөнцийн төлөөлөл болсон хүмүүс төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад өөрсдийн байр сууриа хууль ёсны болгож, санхүүгийн нөөц, эд хөрөнгийг хууль ёсоор эзэмших, захиран зарцуулах эрх олж авч улмаар төрийн байгууллагын чадавх, боломжийг гэмт үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, түүнийгээ хөхүүлэн тэтгэхэд өргөнөөр ашиглах болсон.

Гэмт хэрэгтнүүд төрийн эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагаанд оролцож эхлэх үед зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн үйл ажиллагаа ОХУ-ын зарим мужийн төрийн үйл ажиллагааны механизмтай холилдох, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудтай нэгдэн нийлэх, бие биедээ уусах үйл явц явагдсан.

ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын сонгуулийн пропорционал буюу хувь тэнцүүлэх аргаар зохион байгуулах тогтолцоонд шилжсэн, санал хураах өдөр хүнд, онц хүнд гэмт хэрэг, оногдуулсан ял нь хүчингүй болоогүй эсхүл түүнийгээ эдлэж дуусагүй этгээдийг төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгоход эрх зүйн хязгаарлал тогтоосон, сонгуульд оролцож буй улс төрийн намуудын санхүүжилтийг улам нарийн болгосон, сонгуулийн кампанид ажлыг санхүүжүүлэх журам зөрчсөн хуулийн этгээдийн хариуцлагыг чангатгасан, мөнгө угаасан хэрэгт холбогдолтой хэмээн сэжиглэгдсэн хэд хэдэн банк-санхүү, зээлийн байгууллагуудын лицензийг хураасан, төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад гэмт ертөнцийн төлөөлөл байлгах шаардлагагүй, ЗБГБ-ын ашиг сонирхолд үйлчлэх холбооны болон бүс нутгийн төрийн байгууллагын тогтолцоон дахь авлигад өртсөн удирдах болон гүйцэтгэх албан тушаалтнуудын төр, засаглалын эрх хэмжээг ашигласнаар гарах өндөр үр нөлөө зэрэг нь ЗБГБ-ын зүгээс өөрсдийн нэр дэвшигчдийг төрийн эрх мэдлийн байгууллагуудад зүтгүүлэх үр нөлөөтэй арга хэмжээнүүд нь арга, тактикаа өөрчлөхөд хүргэсэн.¹³

шинжүүдийг дараах номнуудаас харж болно: В.Г. Гриб "Зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх нь". Москва.: Инфра-М, 2001. 43-46 хуудас, В.Д. Малмын хянан тохиолдуулсан Криминологн /Их дээд сургуулиудад зориулсан гарын авлага Москва, ЗАО Юстшинформ, 2006. 395-396 хуудас.

¹³ - "ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын депутат(гишүүн)-ын сонгуулийн тухай хууль" /2005.05.18/№51-ФЗ;

- "ОХУ-ын сонгуулийн, бүх нийтийн санал асуулга (референдум)-ын тухай ОХУ-ын хууль тогтоомжийн акт болон бусад ОХУ-ын хууль тогтоомжийн актуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Холбооны хууль /2005.07.21/№93-ФЗ;

- "ОХУ-ын иргэдийн сонгуулийн эрхийн үндсэн баталгаа болон олон нийтийн санал асуулга (референдум)-д оролцох эрхийн тухай ОХУ-ын Холбооны хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай"

2006-2008 онд болж өрнөсөн бүс нутгийн болон орон нутгийн сонгуулийн статистик мэдээлэл нь зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн зүгээс сонгуулийн кампанит ажилд оролцох шинэлэг хандлага бий болсон тухай гэрчилнэ.

Нэгдүгээрт, өнөө үед сонгуульт албан тушаалд шууд нэр дэвшихээр саналаа өгч буй ЗБГБ-ын төлөөлөл болсон хүмүүсийн тоо, хэмжээ мэдэгдэхүйцээр буурсан. Одоогийн нөхцөлд эрүүгийн ертөнцийн толгойлогчид үнэхээр ирээдүйтэй нэр дэвшигчдэд сонгуулийн кампанит ажлыг нь санхүүжүүлэхэд оролцох санал тавих эсхүл төрийн эрх мэдлийн болон нутгийн захиргааны байгууллагуудад "гэрэлд цохиулаагүй", урьд өмнө нь ял шийтгэл эдэлж байгаагүй, ЗБГБ, тэдгээрийн хань, харилцаатай холбогдолтой болох нь олон нийтэд ил болж, нэр нь гараагүй өөрсдийн хүмүүсийг нэвтрүүлэхийн тулд урьдчилан бэлтгэж байна.

Хоёрдугаарт, хууль тогтоох байгууллагуудад сонгогдсон эрүүгийн ерөнцийн толгойлогч-депутатууд эсхүл сонгуульт албан тушаалтнууд байр суурь болон орлогын эх үүсвэрээ хууль ёсны болгосон байгаагаас үл хамааран хэн нь ч өөрсдийн хүчний бүлэглэл(зодооч, хамгаалагч) үүдээ татан буулгаагүй байна. Эдгээр бүтэц, бүрэлдэхүүн нь тогтсон ёсоор бол хувийн хамгаалалтын алба эсхүл аюулгүй байдлын албаны халхавчинд дор үйл ажиллагаа явуулдаг байна¹⁴. Тиймээс сонгууль зохион байгуулж явуулах явцад улс төрийн шийдвэр гаргахад нөлөөлөх, нөхцөл байдлыг тогтворгүйжүүлэх, ард түмэнд айдас төрүүлэхийн тулд гэмт бүлэглэлийхэнд сонгуулийн үйл явцад хүч хэрэглэх замаар нөлөөлөл үзүүлэх боломж хадгалагддаг. Түүнээс гадна, ОХУ-ын нутаг дэвсгэрт үйл ажиллагаагаа явуулж буй үндэсний гэмт бүлэглэлийн толгойлогчид ОХУ-ын мужуудад үүсдэг үндэстэн хоорондын мөргөлдөөний явцад цэрэг байлдааны нэгж, салбараа ашиглах бололцоотой байдаг.

Гуравдугаарт, сонгуулийн үйл явц дахь улс төрийн намуудын үүрэг, байр суурь нэмэгдэж байгааг харгалзан ЗБГБ-ын эрүүгийн тагнуул, сөрөх тагнуулын чухал ач холбогдолтой зорилт нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй улс төрийн намуудад (намуудын бүс нутгийн салбар нэгжүүдэд) хяналт тогтоох, намын салбар, нэгжүүдийг ашиглан өөрсдийн хүмүүсийг төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад зүтгүүлэх, цаашид шурглуулах явдал юм.

Дөрөвдүгээрт, ЗБГБ-ын төлөөлөл болсон хүмүүс сонгуулийн үеээр мөнгө угаадгаа больсон. Энэ нөхцөл байдалд ЗБГБ сонгуулийн кампанит ажлыг санхүүжүүлэх олон төрийн хууль ёсны үүсвэртэй болон "ОХУ-ын иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай" хууль

¹⁴ Бусдад хүч хэрэглэхэд ашиглагддаг этгээдийг (зодооч, тулаанч хамгаалагч г.м.) зарим тохиолдолд гэмт бүлэглэлийн хяналт дор үйл ажиллагаа эрхэлдэг жуулийн этгээдийн орон тоон дээр бүртгэн тэмжээ, этгээдэг

болсон, сонгуулийн санхүүжилттэй холбоотой журам зөрчснөөс хүлээх хуулийн хариуцлага чангарсан зэрэг бодит хүчин зүйлс нөлөөлсөн.

Сонгуулийн кампанит ажилд оролцох ЗБГБ-ын дээр дурдсан хандлагууд төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын сонгуулийн явцад оролцохыг хориглох хууль сахиулах байгууллагуудын тусгайлан чиглэгдсэн үйл ажиллагаанд бэрхшээл учруулдаг ба иймэрхүү үйл явцын нийгмийн аюулыг нэмэгдүүлдэг.

ЗБГБ-ын төлөөлөл болсон этгээдүүд төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгогдох нь нийгмийн аюул ихтэй ба уг аюулын илрэх хэлбэр нь янз бүр юм.¹⁵

Эдгээр этгээдүүд сонгуульт албан тушаалд томилогдох орлох нь гэмт хэрэгтнүүдийн хяналт дор буй далд эдийн засгийн чадавхийг гарцаагүй нэмэгдүүлэхийн шалтгаан болдог. Гэмт бүлэглэлүүд төсвийн хөрөнгийг хууль бусаар захиран зарцуулах, нөөц хөрөнгө, хөнгөлөлт, чөлөөлөлт хуваарлах эрхтэй болсноор ОХУ-ын мужуудын эдийн засагт тэргүүлэх байр суурь эзлэх боломжтой болдог.

ЗБГБ лоббидох аргаар эрх зүйн хэм хэмжээний акт батлах нь ард иргэдийн зүгээс төрийн эрх мэдлийн (нутгийн өөрөө удирдах ёсны) төлөөллийн байгууллагууд болон хууль тогтоогч (депутатууд)-ын батлан гаргаж буй хууль тогтоомжийн актуудад үл итгэх байдал үүсгэдэг.

Гэмт үйл ажиллагаа эрхлэх ба хууль тогтоох ажиллагааны гарал, үүсэл, угшил нь тас өөр тул хоорондоо нийцэх учиргүй юм. Нийгмийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг гэмт бүлэглэлийн ашиг сонирхолын үүднээс зохицуулах нь хүн амын өргөн давхаргын эрх зүйн ухамсарт өөрчилж болшгүй сэв, гажуудал үүсгэх үр дагавартай ба эрх зүйн нигилизм(нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн үнэт зүйлсийг бүхэлд нь үгүйсгэх үзэл)-ыг даамжруулдаг.

Гэмт хэрэгтнүүд төрийн засаглалын эрх мэдэл, сонгуульт албан тушаалтны эрх дарх, парламентын гишүүний халдашгүй эрх олж авах нь хууль тогтоох, зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх үйл хэрэгт асар их хор хөнөөл учруулдаг. Төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгогдсон эрүүгийн ертөнцөөс гаралтай этгээдүүд өөрсдийн өрсөлдөгчидтэйгээ тэмцэх, хууль сахиулах байгууллагуудын ажилтнууд, прокурор, шүүгчдэд хууль бусаар нөлөөлөхийн тулд засаглалын эрх мэдлээ үр өгөөжтэй ашиглахыг бүх талаар эрмэлзэж байдаг.

Халдашгүй эрх дарх, ямбатай гэмт ертөнцийн төлөөлөгчдийг хариуцлагад татах бэрхшээл, гэмт бүлэглэлийнхний зүгээс авлигад

¹⁵ Сонгуульд ялалт байгуулсан нэр дэвшигчид болон зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн санхүүжүүлсэн улс төрийн намуудаас гэмт хэрэгтнүүдэд төрөл бүрийн үйчилгээ үзүүлж зэрэг тохиоллууд дор дурдсан нийгмийн хор аюулын илрэх хэлбэрүүдэд хамаардаг.

өртсөн төрийн байгууллагын дарга, ажилтнууд, тэр дундаа, хууль сахмулах байгууллагуудын ажилтнуудад дэмжлэг үзүүлэх нь төрийн байгууллагын үнэгч ажилтнууд, ур чадвартай, мэргэшсэн боловсон хүчин, мэргэжилтгүүдийн урам зориг хугарах, улмаар ажлаа орхих, халагдахад хүргэдэг¹⁶.

Үүнийг харгалзан зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн зүгээс өөрсдийн нэр дэвшигчдийг төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгуулиар нэр дэвшүүлэхийн эсрэг олон нийт ба төрийн байгууллагуудын зүгээс тэмцэх төрийн нийтлэг (улс төрийн, эрх зүйн, зохион байгуулалт боловсон хүчний, мэдээлэл-ухуулгын) ба тусгай цогц арга хэмжээг хойшлуулашгүйгээр, төлөвлөгөө, үе шаттайгаар хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад ЗБГБ-аас гаралтай нэр дэвшигчдийг сонгуулиар нэр дэвшүүлэхийн эсрэг олон нийт ба төрийн байгууллагуудын зүгээс авч хэрэгжүүлэх тэмцлийн шинжтэй төрийн нийтлэг арга хэмжээ нь төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын гэмт хэрэгжих шалтаан нөхцлийг заавал арилгахад чиглэгдсэн байна.

Төрийн эрх мэдлийн байгууллагуудын гэмт хэрэгжих үйл явцтай тэмцэхэд олон нийтийн болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн оролцоо зайлшгүй шаардлагатай юм. Учир нь байр сууриа бэхжүүлсэн ЗБГБ-ын гаралтай нэр дэвшигчдийг төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад дэвшүүлэхийн эсрэг тэмцдэггүйгээс гадна иймэрхүү оролдлогыг өөрт олгогдсон төрийн эрх мэдлийн эрх хэмжээгээ (“захиргааны нөөц”)-г ашиглан зарим байдлаар дэмждэг байна.

ЗБГБ-ын зүгээс өөрсдийн нэр дэвшигчдийг төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгуулиар нэр дэвшүүлэхийн эсрэг олон нийт ба төрийн байгууллагуудын зүгээс тэмцэх төрийн нийтлэг улс төрийн арга хэмжээнд эрүүгийн ертөнцийхнийг улс төрийн амьдралд болон сонгоход оролцуулахгүй байх талаар Төрийн тэргүүн, ОХУ-ын мужуудын төрийн дээд албан

¹⁶ Байр сууриа хууль ёсны болгож бэхжүүлсэн гэмт ертөнцийн төлөөлөгчидтэй тэмцэх явдал нэмэгдгүй, үр дүнгүй гэдэг нь гүеэгийн ташаа ойлголт бөгөөд аюултай үзэл санаа юм. Иймэрхүү үл тоосон үзэл санаа, байр суурь ОХУ-ын субъектуудын төрийн дээд албан тушаалтан, хууль сахиулах байгууллагуудын удирдлагуудын эс үйлдэхгүйг олонтаа зөвтгөдөг ба ОХУ-ын нутаг дэвсгэрт зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн албан ёсны удирдлаган доорхи гэмт шинж бүхий төрийн бүс нутгийг бий болгох үр дагаварыг бүрдүүлдэг. Төрийн үйл ажиллагаа, практикт гаргасан улс төр-хууль зүйн алдааг зэвсэж байх шаардлагатай ба түүнтэй эвлэрэхгүй байх нь зүйтэй юм. Гэмт хэрэгтнүүд өнөө үед ямар ч албан тушаал хашиж байсан, түүний албан тушаалын нэр, нөлөө, хэрэгтэй-ашигтай харилцааны цар хүрээ, төрөөс авсан гавъяа шагналын тоо, хэмжээ нь ямагт тэдгээрийн үйлдсэн гэмт хэргийг зөвтгөх үндэслэл байж болохгүй. Хууль зүйн хариуцлага гаршаагүй байх нь бүх хүмүүст хамааралтай байх учиртай.

тушаалтан, сонгуулийн хороо, хууль сахиулах байгууллагуудын удирдлагуудын албан ёсны даалгавар, төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын гэмт хэрэгжих үйл явцтай тэмцэх холбооны болон бүс нутгийн хөтөлбөр, өөрөөр хэлбэл, холбооны болон бүс нутгийн сонгуулийн өмнөх улс төрийн намуудын “гэмт хэргийн эсрэг пакт” боловсруулах зэрэг арга хэмжээ багтана.¹⁷

Зохион байгуулалттай гэмт явдлыг саармагжуулахын тулд эхний ээлжинд төрийн ба бүс нутгийн өндөр албан тушаалтнуудын улс төрийн хүсэл зориг, түүнчлэн олон нийт, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, төрийн байгууллагуудын хамтарсан дэс дараатай, тууштай үйл ажиллагаа шаардлагатай юм.

Төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын гэмт хэрэгжих үйл явцтай тэмцэх эрх зүйн арга хэмжээнд нь орон даяар эрэн сурвалжлагдаж буй (федеральный розыск) болон хүнд эсхүл онц хүнд гэмт хэрэг үйлдсэнийхээ төлөө ял шийтгэлтэй (тэр дундаа ялаас чөлөөлөгдсөн, эдэлж дууссан ял) этгээдүүдэд төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгогдох эрх зүйн хязгаарлалт тогтоох замаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох үйл ажиллагаа нэгэн зэрэг хамаарна.

Холбооны сонгуулийн тухай хуулиудад хууль тогтоох байгууллага, сонгуульг албан тушаалд нэр дэвшиж буй нэр дэвшигчид эдэлсэн бүх ялаа (тэр дундаа ялаас чөлөөлсөн, эдэлж дууссан ял) заавал заах, түүнчлэн улс төрийн нам, сонгуулийн хороод бүх нэр дэвшигчдийн ял шийтгэгдсэн эсэхийг тус тус мэдээлэх үүрэгтэй болохыг тусгахыг санал болгосон байдаг.

Төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгогдсон гэмт хэргийн ертөнцийхний төлөөлөгчдийн хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох, хариуцлага татах, холбогдох материалуудыг бэлтгэх зорилгоор парламентын гишүүн (депутат) болон сонгуульг албан тушаалтны эрх хэмжээг түдгэлзүүлэх институтыг ашиглагдахыг санал болгодог. Үүнийг харгалзан “ОХУ-ын Холбооны Хурлын гишүүний эрх зүйн байдал болон ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын депутатын эрх зүйн байдлын тухай” 1999 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн (2007 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн нэмэлт, өөрчлөлттэй) Холбооны хуулийн 4 дүгээр зүйл (ОХУ-ын Холбооны Хурлын гишүүн, Холбооны Хурлын Төрийн Думын депутатын эрх хэмжээг түдгэлзүүлэх тухай)-д дараахь агуулгатай зүйлийг нэмэх нь зүйтэй:

¹⁷ Энэ төрлийн “Гэмт хэргийн эсрэг пакт”-тай холбоотой жишээ дурдахад 2006 оны 07 дугаар сарын 10-ны өдөр оросын “Единая Россия”, “ЛДПР”, “КПРФ”, “Российская партия пенсионеров”, “Российской коммунистической рабочей партия”, “Яблоко”, “Патриоты России”, Демократическая партия России”, “Родина” намуудын байгуулсан “Төрийн эрх мэдэл гэмт хэргэгчдийг үл оролцуулах тухай санамж бичиг”-ийг дурдаж болно.

1. Холбооны Хурлын гишүүн, ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын депутатын эрх хэмжээг дараахь тохиолдолд түдгэлзүүлнэ:

а) Холбооны Хурлын гишүүн болон ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын депутат нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан шийтгэл хүлээх хүнд ба онц хүнд гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хэрэг үүссэн;

б) Холбооны Хурлын гишүүн болон ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын депутат нь ОХУ-ын Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан шийтгэл хүлээх хэт даврагч, хүчирхийлийн шинжтэй гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хэрэг үүссэн;

в) Холбооны Хурлын гишүүн болон ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын депутатыг холбооны түвшинд эрэн сурвалжилж байгааг зарласан.

2. Холбооны Хурлын гишүүн, ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын депутатын эрх хэмжээг түдгэлзүүлэх тухай шийдвэрийн хэлбэр нь ОХУ-ын Холбооны Хурал, ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын гаргасан холбогдох тогтоол байна. Уг тогтоолд Холбооны Хурлын гишүүн, ОХУ-ын Холбооны Хурлын Төрийн Думын депутатын эрх хэмжээг түдгэлзүүлж буй огноог тусгана.

Дээрхтэй ижил төстэй парламентын гишүүн, сонгуульт албан тушаалтны эрх зүйн байдлыг тодорхойлж буй хэм хэмжээг ОХУ-ын субъектуудын хууль тогтоомжид мөн адил нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Гэмт хэрэгтнүүдтэй тэмцэх зохион байгуулалт-боловсон хүчний шинжтэй арга хэмжээ нь хоёр бүлэг арга хэмжээнүүдээс бүрдэнэ:

Эхний бүлэгт намын дотоод боловсон хүчний бодлого хамаарна. Тухайлбал, намын гишүүн нэр дэвшигчдийг шалгах, намын дотоод авилга, хээл хахуулийн баримт, фактыг илрүүлэх, цуглуулсан баримт материалаа хууль сахиулах байгууллагуудад хүргүүлэх, улс төрийн намын жагсаалтаас нэр дэвшиж буй намын гишүүдийг шалгах, хэт даврагч, хүчирхийллийн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг байгууллага, зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдтэй холбогдолтой болох нь тогтоогдсон этгээдүүдийг намын гишүүнчлэлээс хасах.

Дараагийн бүлэг арга хэмжээ нь төрийн байгууллагын бүх тогтолцоон дахь боловсон хүчний орон тоог бүрдүүлэхтэй холбоотой юм.

Саяхныг хүртэл төрийн эрх мэдлийн болон удирдлагын байгууллагуудын боловсон хүчний бодлого хангалтгүй гэж мэргэжлийн бэлтгэл, боловсрол багатай, сайтар шалгагдаагүй боловсон хүчнээр орон тоогоо бүрдүүлэх бодлого явуулахад чиглэгдэж байсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй.¹⁸

¹⁸ Юшкова Е.М. "Иргэд ба засаглал: криминологийн зарим тулгамдсан асуудал". // Гэмт явдал ба засаглал. Бага хурлын материал. ОХУ-ын Криминологийн Холбоо, Москва хот. 2000. С. 31.

ЗБГБ-ын зүгээс өөрсдийн нэр дэвшигчдийг төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгуулиар нэр дэвшүүлэхийн эсрэг тэмцэх явцад аль хэдийнээ байр сууриа олсон гэмт хэрэгтнүүд (гэмт ашигт сонирхолтой авилгад өртсөн албан тушаалтнууд)-ийн зүгээс зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлж буй тодорхой удирдлага, албан тушаалтнуудад үзүүлэх дарамт, шахалтыг урьдчилан тооцоолох шаардлагатай ба иймэрхүү төрлийн дарамт шахалтыг таслан зогсоох, саармагжуулах талаар урьдчилан хариу арга хэмжээ боловсруулсан байх, уг тэмцэлд оролцож буй төрийн албан тушаалтан, хууль сахиулах байгууллагуудын ажилтан, намын зүтгэлтэн, гишүүд, сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хангах зүй ёсны шаардлага гардаг.

Цагдаагийн байгууллага (ОВД), Холбооны аюулгүй байдлын алба, Хууль зүйн яам, Прокурорын байгууллага болон төрийн эрх мэдлийн бусад байгууллага гэмт хэрэгжих үйл явцтай тэмцэх чиглээр Холбооны тойргууд дахь ОХУ-ын Ерөнхийлөгчийн Бүрэн Эрхт төлөөлөгчийн ажлын албатай хамтын ажиллагааг хэрэгжүүлэхдээ гүйцэтгэх ажлын ач холбогдолтой мэдээлэл сэлт болзошгүй байдлаар гэмт хэрэгтнүүдэд задрахыг үгүйсгэхгүй байх хэрэгтэй. Үүнтэй холбогдуулан иймэрхүү мэдээлэл задрах явдлын эсрэг ажиллах сөрөг үр дагаварыг арилгах талаар арга хэмжээ авахыг харгалзан үзэх нь зүйтэй.

Зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн зүгээс өөрсдийн нэр дэвшигчдийг төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгуулиар нэр дэвшүүлэхийн эсрэг тэмцэх олон нийт болон төрийн байгууллагуудын мэдээлэл-сурталчилгааны арга хэмжээ нь иргэдийн нийгэм, эрх зүйн ухамсар, соёлыг дээшлүүлэхэд чиглэгдсэн байх ёстой.

Сонгуулийн хороо, хууль сахиулах байгууллагууд, Холбооны мужуудын төрийн байгууллагууд, залуу үеийнхний дунд урьдчилан сэргийлэх ажил явуулахад онцгой үүрэг, ач холбогдолтой болох нь харагдаж байна.

Оросын нийгэм, олон нийтийг нэгтгэх, зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа, гэмт хэргийн толгойлогч, тэдгээрийн улс төрийн амьдралд оролцож буй баримт, факт, төлөвлөгөө, төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгогдох оролдлогын талаар олон нийтийн дунд сөрөг сэтгэгдэл бий болгоход хэвлэл мэдээллийн хэрэгслийн байгууллагуудын үр нөлөөтэй үйл ажиллагаа онцгой чухал ач холбогдолтой.

Дээрх үйл явцын эсрэг тэмцэл явуулах тусгай арга хэмжээ нь төрийн нийтлэг цогц арга хэмжээний хамт үр өгөөжтэй байдаг. Тусгай арга хэмжээ нь ЗБГБ төлөвлөгөө, бүтэц, бүрэлдэхүүн, хууль бус ажиллагаагаа хэрэгжүүлэхэд гэмт бүлэглэлүүдэд туслалцаа, дэмжлэг

үзүүлж буй төрийн болон нутгийн захиргааны байгууллагын албан тушаалтан, сонгуулийн хууль бус санхүүжилтийн эх сурвалж, зам суваг, ОХУ-ын аюулгүй байдалд хор хохирол учруулахад чиглэгдсэн улс төрийн үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл цуглуулах зорилгоор ЗБГБ-ийн дунд ба удирдах шатны төлөөлөл болсон хүмүүс дундаас нууц мэдээлэгч бий болгох зэрэг арга хэмжээнээс бүрддэг.

Эрүүгийн ертөнцийн “халуун, эмзэг цэг, газруудад” ЗБГБ-ийн ашиг сонирхолд үйлчилж буй нэр дэвшигчдийн хань, харилцаа, улс төрийн намын зүтгэлтнүүд, төрийн ба нутгийн захиргааны байгууллагууд дахь авлига, хээл хахуулийн баримт, фактын талаар мэдээлэл цуглуулах талаар сонгуулийн хороодын гишүүд, хууль сахиулах байгууллагуудын ажилтнууд, улс төрийн нам, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах нь чухал ач холбогдолтой.

ЗБГБ-ийн толгойлогч, оролцогчдыг эрүүгийн хариуцлагад татахад шаардлагатай материал бүрдүүлэх зорилгоор зохион байгуулалттай гэмт үйл ажиллагааг дэс дараатай баримтжуулах нь тусгай арга хэмжээний нэг салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм

Өнөөгийн нөхцөлд ЗБГБ-ийн үйл ажиллагааг бүрэн хэмжээнд баримтжуулах ажил хангалттай түвшинд явагдахгүй байгааг тэмдэглэх хэрэгтэй.¹⁹ Одоогоор хууль сахиулах байгууллагуудын нийт ажилтнуудын 60-аас дээш хувь нь гэмт бүлэглэлийн гишүүдийн гэмт үйл ажиллагааны зөвхөн хэд хэдэн үйлдлүүд л эрүүгийн хэргийн материалд баримт болон үлддэг ба харин гэмт бүлэглэлийнхний өөрсдийх нь үйл ажиллагаа дэлгэрэнгүй байдлаар огт тусгагддаггүй гэж үзжээ.²⁰

Гүйцэтгэх ажлын шугамаар хууль бус ажиллагааг баримтжуулах ажиллагааны чухал нөхцөл нь уг ажиллагаанд татан оролцуулсан хууль сахиулах байгууллагын ажилтан, нууц эх сурвалжийн аюулгүй байдлыг бүх талаар хангах явдал юм.

ЗБГБ үйл ажиллагааг таслан зогсоох (үйлдэл дээр нь барих, баривчлах, гэмт бүлэглэлийн зохион байгуулагч, оролцогчдыг эрүүгийн хариуцлагад татах) асуудлыг эцсийн үр дүнгийн хувьд авч

¹⁹ Үүнтэй холбогдуулан ОХУ-ын Улсын Ерөнхий Прокурорын газар, Аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц ОХУ-ын бүх Холбооны субъектууд болон хилийн чанад дахь оросын бүх гэмт бүлэглэлийн хууль бус үйл ажиллагаа, төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад нэгтгэсэн гэмт бүлэглэлийнхний баримт, факт, төрийн эрх мэдлийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудад сонгогдсон ЗБГБ-ийн толгойлогч, оролцогчид, ОХУ-ын Эрүүгийн хуулийн 208-210 дугаар зүйлд зассан гэмт хэргийн бүрэлжлүүнтэй эрүүгийн хэргүүдийг мөрдөн байцаах ажиллагаа болон шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаархи мэдээ, мэдээллийг хуримтлуулан нэгтгэж, системчилдэг. Дүн шинжилгээний нэгдсэн төв байгуулах нь зүйтэй мэт төсөөлөгдөж байна. Уг төвийн удирдлагыг Төрийн тэргүүн болон төрийн өндөр албан тушаалтнуудад ОХУ дахь гэмт хэргийн болит нөхцөл байдал, ЗБГБ-ийн зүгээс ОХУ-ын аюулгүй байдалд учруулж буй аюул, замалжлалын талаар тогтмол мэдээлэл хийж байх үүрэг, хариуцлагатай болгох нь зүйтэй.

²⁰ См.: Гэмт ертөнц дэх гэмт явдал ба тэдгээрийн өөрчлөлт // Юшова Е.М., “Орос дахь гэмт явдал ба түүнтэй тэмцэх нь: бүс нутгийн асуудал” // ОХУ-ын Криминологийн Холбоо // Москва. 2003 он. с.21.

үзэж болно.

Улс дамнасан буюу хилийн чанадад өргөн харилцаатай зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн үйл ажиллагааг баримтжуулах нь ажлын тусгайлсан чиглэлд тооцогддог.

Баримтжуулалтын чанар, үр дүнг сайжруулах, гэмт явдалтай тэмцэх нэн тохиромжтой арга хэмжээнд бэлтгэх зорилгоор Интерпол, Хамтын нийгэмлэгийн орнуудын зохион байгуулалттай гэмт явдалтай тэмцэх үйл ажиллагааг удирдан зохицуулах товчоо, гадаад улсын тусгай алба, хууль сахиулах байгууллагуудтай мэдээлэл солилцох ажлыг хөгжүүлэх нь чухал ач холбогдолтой.

Сонгуулийн компанит ажилд дахь ЗБГБ-ийн оролцоо хууль ёсны иргэний нийгмийн улс төрийн үйл ажиллагаанд саад учруулах ёсгүй.

хууль зүйн үндэсний хүрээний
www.nli.gov.mn

ДАВТАН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЬ

Урьд ял шийтгэлтэй, тэр дундаа шоронгоос суллагдсан хүмүүсийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх асуудал нь криминологийн тусгай ангийн төдийгүй пенологийн судлагдахуун болоод байгаа өнөө үед энэ салбарын судлаач бид дэлхий нийтийн чиг хандлагатай хөл нийлүүлэн алхах хэрэгтэй байна. Дадал олсон, рецедив гэмт хэрэгтэн хэмээн тодорхойлж байсан цаг үе ард өнгөрч гэмт хэрэгтэн бие хүнийг судлах нь зайлшгүй болоод байгаа нь сүүлийн үед гараад байгаа онц ноцтой хэргүүдээс харагдаж байна.

Хорих болон баривчлах ял эдлээд суллагдсан хүмүүсийг нийгэмд хүлээн авах, ажлын байраар хангах, тусламж дэмжлэг үзүүлэх, амьдрах боломж, орчин нөхцөл сайн бүрдээгүй зэрэг байдлаас ял эдлээд дууссан болон өршөөл, уучлалаар суллагдсан хүмүүс давтан гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлэх, хорих газар дасан зохицох хандлага ажиглагдаж байна. Улсын хэмжээгээр 2007 онд 6149 хүн, 2008 онд 6282 хүн, 2009 онд 5069 хүн баривчлах болон хорих ял эдэлж байсан ба тэдний 42-48 хувь нь урьд өмнө ял шийтгэл эдэлж байсан хүмүүс байгаагаас¹ үзэхэд цаашид улам өсөх төлөвтэй байгаа нь илэрхий.

Хэдийгээр хүн гэмт хэрэг үйлдэж түүндээ тохирсон шийтгэл хүлээх ёстой авч хорих байгууллагаас жил бүр суллагдаж буй 2000 орчим хүнд туслалцаа, дэмжлэг дутаж байгаа нь төрийн байгууллагын үйл ажиллагааны болон эрх зүйн зохицуулалт байхгүйтэй холбоотой юм.

Өнөөдөр урьд ял шийтгэгдсэн, хорих ялаас суллагдсан, өршөөгдсөн хүмүүс давтан гэмт хэрэг үйлдэж, улс орны эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хүндрүүлж байна. Монгол Улсын нийт хүн ам, үйлдэгдэж бүртгэгдсэн гэмт хэрэг, түүнд холбогдогч, түүнээс урьд ял шийтгэгдсэн хүмүүсийн эзлэх хувь, хөдөлгөөнийг сүүлийн 10 жилээр дурьдвал 2000-2009 онд урьд нь шүүхээр ямар нэгэн хэлбэрээр ял шийтгэгдсэн 18117 хүн дахин гэмт хэрэг үйлджээ. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн нийт хүмүүсийн 9.8 хувийг эзэлж байна.²

Сүүлийн 3 жилийн хугацаанд урьд ял шийтгэгдсэн 4817 хүн, жилд дунджаар 1606 хүн давтан гэмт хэрэг үйлджээ. Эндээс үзэхэд сүүлийн арван жилд урьд шоронгоос суллагдсан хүмүүсийн дунджаар



ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан, докторант Г.Оюунболд

¹ ШШГЕГ-ын жилийн эцсийн тайлан.

² ЦЕГ-ын МДШТ-өөс гаргасан "Урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс давтан гэмт хэрэг үйлдсэн мэдээ" нээс.



хүрээгүйчүүдийн 411, 407 дугаар ангиас суллагдсан хүүхдүүд нэг их удалгүй эргээд шорондоо ордог эсвэл насанд хүрсэн хүмүүсийн хорих ангид дэглэм өгсөж хоригддог³, 50-70 хувь нь суллагдсанаас хойш 3 жилийн дотор дахин гэмт хэрэг үйлддэг байна. Хүүхдийн давтан гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан, нөхцөлийг судлан үзэхэд:

- Хорихоос суллагдаад очих газаргүй (орон гэргүй);
- Эцэг эх нь өрхийн өрлого байхгүй, амьдралын баталгаажих түвшингээс доогуур амьдралтай;
- Ажил, сургуульд орох гэхэд иргэний бичиг баримтгүй, сургууль завсардсан, мэргэжил боловсролгүй өөрөөр хэлбэл тэднийг нийгмийн зүгээс хүлээн авах ямар ч бэлтгэл хангагдаагүй байгаа⁴ нь давтан гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж байгаа нэг хүчин зүйл болж байна.

Хуулийн байгууллагын алба хаагч, шоронгоос суллагдсан хүмүүстэй бүлгийн ярилцлагын судалгаа хийх явцад давтан гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нь нийгэмд хэвийн амьдарч чадахгүй байгаатай холбоотой төдийгүй гэмт зан үйл төлөвшсөн, эргээд гэмт хэрэг үйлдэх орчиндоо очдог зэрэг нөхцөлтэй холбоотой юм. Энэ нь:

- Хулгайлах;
- Бусдын бие махбодид гэмтэл учруулах;
- Хүчиндэх;

³ "Хүүхдийн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл" судалгааны тайлангаас.. НҮБ-ын Хүүхдийн сан. 2006 он. 31 дэх тал.

⁴ Нийслэлийн цагдаагийн газрын Олон нийттэй харилцах хэлтсээс 2009 онд хийсэн "Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж буй гэмт хэргийн танилцуулга".

- Танхайрах;
- Дээрэмдэх;
- Хүнийг санаатай алах гэмт хэргүүдийг гол төлөв үйлдэж байгаас харагдана.⁵

Гэтэл давтан гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгааныг хуулийн байгууллагаас тавих хараа хяналт дутсантай холбон үзээд тэдэнд үзүүлэх туслалцаа, дэмжлэг байхгүйгээс дахин гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг анхаарч үзэхгүй байна. Бодит байдал дээр цагдаагийн байгууллагаас тавьж байгаа захиргааны хяналт нь сард нэг удаа дуудаж, бүртгэх хэлбэртэй байгаа ба цагдаагийн байгууллагын хэсгийн төлөөлөгч, байцаагчаас ч тэр хяналтад байгаа хүмүүсээс ч энэ арга хэмжээг тээршаасан байдалтай байдаг нь ажиглагдлаа.⁶

Иргэдийн санаа бодол: “Гэмт хэрэг үйлдэгдэхэд ямар ямар нөхцөл нөлөөлж байна гэж та үзэх вэ?” гэсэн асуулгад⁷ оролцсон иргэд үзэхдээ: ажилгүй байх, хийх ажилгүй, амар хялбар аргаар амьдрах гэсэн хүсэл, хүний зан байдал, авир араншин, ёс суртахууны доголдолтой холбон үзсэнээс гадна хориhoоc суллагдсан хүмүүст анхаарал тавих тогтолцоо бүрдээгүй, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө хангалтгүй байгаа зэргийг авч үзжээ. “Хүнийг шоронд суулгаснаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайн зохион байгуулах нь илүү үр дүнтэй байдаг гэсэн саналыг юу гэж үзэж байна вэ?” гэсэн асуулгаас үзэхэд шоронд хүмүүсийг байлгаж цээрлүүлэх нь үр дүнтэй, шоронд л хийчихвэл болно гэсэн *хандлага тал хувьд нь байхад* энэ нь буруу санал нийлэхгүй байгаа нь гэж үзсэн нь 35 орчим хувийг эзэлж байна.

Гэтэл шоронд ял эдэлж байгаа хүмүүсээс хориhoоc суллагдаж гарсны дараа учрах бэрхшээлүүдийн талаар судлахад⁸:

Үүнээс үзэхэд ял эдэлж буй ялтнуудын ихэнхи нь хориhoоc суллагдаад гарахад тэдэнд учрах бэрхшээл ихтэй, нэн ялангуяа тэднийг амьдралд хүлээн авах хэн нэгэнтэй үл ойлголцох байдал бий болно гэсэн айдастай байхад иргэд эсрэгээр шоронгоос суллагдсан хүмүүсийн талаар сөрөг төсөөлөл, хандлагатай байдаг нь ажиглагдлаа.

Түүнчлэн төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад ажилд орох иргэнээс бүх тохиолдолд ял шийтгэлийн тухай лавлагааг гаргуулж


⁵ 2000-2009 онд захиргааны хяналтанд байхдаа болон өршөөлийн хуулиар суллагдаад дахин гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн судалгааны дүн. ЦЕГ-ын Мэдээлэл дүн шинжилгээний төв. 2010 он.

⁶ Хэнтий аймаг, Багануур дүүргийн цагдаагийн хэлтсийн 12 хэсгийн байцаагч болон тус аймаг, дүүргийн хорих ангид ял эдэлж буй 20 хоригдол, захиргааны хяналтанд байгаа 40 хүмүүсийн дунд хийсэн ярилцлагын судалгаанаас. 2010 оны 8 дугаар сар. Суд.

⁷ ЦЕГ-ын МДШТ-өөс 2008 оны 12 дугаар сард улсын хэмжээнд “Гэмт явдлын нийтлэг шалтгаан нөхцөл, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах зорилгоор явуулсан социологийн судалгаа.

⁸ “Хорих ялын үр нөлөө”, ХЗҮХ-ийн ЭЗЗКС-ын 2008 онд хийсэн судалгаанаас.

авдаг болжээ. Иймээс ял шийтгүүлж байсан этгээд нийгэмд ажил,



албан тушаал эрхлэх ямар ч боломжгүй, ялгаварлан гадуурхагдах үндсэн нөхцөл болж байна. Эрүүгийн гэмт хэрэг нь санаатай болон болгоомжгүйгээр үйлдэгддэг, тухайн хүний хийсэн үйлдэл, эс үйлдэл нь гэмт хэрэг мөн эсэх нь үзэл бодлын үүднээс харьцангуй маргаантай тул ял шийтгүүлсэн хүмүүсийг бүх насаар нь харлуулан гадуурхах нь хүний эрхийн зарчимд нийцэхгүй юм.

Ажил хөдөлмөр эрхлэх, сонгон шалгаруулалтад орох, тендерт өрсөлдөх, гадаадад ажиллах, гэрээ хэлэлцээр хийх, аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, зээл авах, зарим сургуульд элсэн орох, бүхий л тохиолдолд цагдаагийн байгууллагаас ял шийтгэлийн лавлагаа авдаг журам үйлчилж байна. ЦЕГ-ын Мэдээлэл лавлагааны төв нь байнгын ачаалал дугаарлалттай болж, иргэдийн лавлагаа авах эрэлт, хэрэгцээ улам бүр өссөөр байна.⁹

Давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь

Дэлхий дахинд давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үндсэн хоёр хандлага байдаг бөгөөд үүний нэг нь нийгмийн хяналт буюу social control, нөгөө нь нийгмийн ажлын туслалцаа буюу rehabilitation of criminal offenders гэсэн хэлбэрүүд юм. Судлаачийн зүгээс санал болгож буй хувилбар нь 2 дахь хэсэг бөгөөд бидний уламжлалт хандлага болох гэмт хэрэгтнийг хянаж, цагдаж, бүртгэснээр давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил үр дүнд хүрэхгүй байгаа нь судалгааны дүнгээс харагдлаа.

Хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг нийгэмд дасан зохицоход нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ажил нь нийгмийн үйлчилгээний нэг төрөл бөгөөд¹⁰ үүнийг гадаадын зарим орны туршлагаас үзэхэд төрийн

⁹ ХЭҮК, "Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх илтгэл". 2009 он. 160 дахь тал.

¹⁰ Шоронгоос суллагдсан хүмүүсийг нийгэмшихэд нь туслалцаа дэмжлэг үзүүлэх ойлголтыг гадаадын зарим оронд нийтлэг байдлаар "resocialization эсвэл reintegration and rehabilitation of criminal offender" хэмээн томъёолдог бөгөөд тусгайлан институтууд энэхүү үйл ажиллагааг

аль нэг институтээр гүйцэтгүүлдэг байна.¹¹ Шоронгоос суллагдсан ялтныг нийгэмшүүлэх талаар дэлхийн улс орнуудад тогтсон хэд хэдэн хандлага байдаг. Үүнд:

1. *Social control* буюу нийгэм-захиргааны хяналт тогтоох гэсэн манай улсад байгаа загвар нь одоогийн постсоциалист зарим оронд байдаг. Казакстан, Киргизстан гэх мэт;

2. *Probation, Parol* буюу тусгайлсан алба, ажилтан хяналт тавьж, дэмжлэг үзүүлэн ажиллах. Энэ нь зарим тохиолдолд "bootcamp", "halfway house" гэсэн хэлбэр буюу түр амьдрах, туслалцаа авах, орогнох зэрэг орон байр хэлбэртэй байна. Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой орнуудад түгээмэл байдаг хэлбэр;¹²

3. *Imprisonment type: open and close* нь хорих ялын нээлттэй, хаалттай дэглэмийг нийгмийн ажлын үр дүнтэй хэлбэртэй хослуулан хэрэгжүүлэх систем буюу Ром, германы эрх зүйн тогтолцоотой зарим улс оронд бий. Тухайлбал: Герман, Эстони, Европын холбооны зарим улс багтана;

4. *Programm* буюу Тусгайлсан хөтөлбөр гарган ажиллах буюу шоронгоос суллагдсан хүмүүсийг нийгэмшүүлэх хөтөлбөр нь хууль эрх зүйн орчин харьцангуй сайн хөгжөөгүй улс орнуудад хэрэгждэг бөгөөд үүний нэг тод жишээ нь, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах улс юм.¹³ Энэ улс нь ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөрийг 2002 оноос олон улсын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүндээ хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудыг өргөнөөр татан оролцуулж, төрийн зарим чиг үүрийг гүйцэтгүүлж байгаа сайн туршлагыг нэвтрүүлжээ.

Судалгааны ажлын явцад Монгол Улсад "Хорих ялтныг нийгэмшүүлэх" хөтөлбөр гарсан сайшаалтай боловч үүний үр дүнг тооцох, ололттой талыг мэдэх бололцоогүй байна. Үүний учир нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны №198 тушаал, ИШПГЕГ-ын даргын 2009 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн №А/91 тушаалын хавсралтуудаар батлагдсан хөтөлбөр нь дөнгөж хэрэгжиж эхэлж байна. Хөтөлбөрийн хүрээнд зайлшгүй шийдвэрлэх асуудал нь:

1. Ял эдлэгсэдэд хүмүүжлийн нөлөө үзүүлэн төлөвшүүлэх;

2. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэн, хөдөлмөрийн дадал олгох;

3. Тэднийг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдтэй ойртуулах, эвлэрүүлэн зуучлах, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авах, ялтныг суллан гарахад

эрхлэн гүйцэтгэх үүрэгтэй байна.

¹¹ АНУ-д Halfway house нэртэй нэгж нь хорих ял эдлээд суллагдсан хүмүүсийг 120-180 өдөрт шаардлагатай бол түр байршуулах хэлбэрээр эргэн нийгэмшэхэд нь дэмжлэг үзүүлдэг бөгөөд хагас хяналттай үүндээ цагдаагийн байгууллагын тусалцааг авах хэлбэрээр хамтран ажилладаг.

¹² Тухайлбал, Англи улсад The rehabilitation of offender act (1974) гэсэн хууль үйлчилдэг бөгөөд түүнд заасан арга хэрэгслээр шоронд байгаа болон суллагдсан хүмүүст нийгмийн ажил, үйлчилгээ үзүүлэх хугацаа зэргийг зохицуулсан байдаг.

¹³ K.C. Goyer. "Incarcerating and rehabilitating offenders". 2002.

бэлтгэх шаардлагатай хэмээн үзэж энэ төлөвлөгөөг баталжээ.

Ийнхүү дээр дурдсан нөхцөл байдлыг харгалзан үзэж эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр ХЗДХЯ-ны Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих анги ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр батлан хэрэгжүүлж, хорих байгууллагын төрөл, дэглэмийг 2012 он гэхэд нээлттэй, хаалттай системд шилжүүлэх талаар хуулийн төсөл боловсруулан ажиллаж байгаа нь нэн сайшаалтай байна.

Цаашид төрийн зүгээс шоронгоос суллагдсан хүмүүст чиглэсэн бодлого боловсруулахдаа энэхүү хөтөлбөртэй зайлшгүй уялдуулах хэрэгтэй юм.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд шоронгоос суллагдсан хүмүүсийг нийгмийн ажил үйлчилгээнд зуучлах, туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин байхгүй, харин Цагдаагийн байгууллагын тухай болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулиудад шоронд байгаа болон шоронгоос суллагдсан хүмүүст тавих хяналтын талаар дэлгэрэнгүй зааж, тусгаж өгчээ. Практикт хуулийн байгууллагын үйл ажиллагаа тухайлбал, цагдаа, прокурорын байгууллагын хуулиар заасан дээрхи ажиллагаанд иргэд шүүмжлэлтэй хандаж, суллагдсан хүмүүст дарамт учруулдаг, алдсан дээр нь дахин түлхдэг, тэднийг нийгэмд хэвийн ажиллаж амьдрахад нь саад учруулж байгаа тухай баримттай дурдаж байна.

Зөвлөмж

ХЗХДЯ, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас 2009 онд боловсруулан, баталсан “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр”-т хичнээн хамрагдсан ч гэсэн хүн суллагдаад тодорхой дэмжлэг туслалцаа авч чадахгүй бол дээрхи хөтөлбөр ямар ч үр дүнгүй болох юм. Ийм учраас залгамж шинж чанартай, үр нөлөө бүхий хөтөлбөр боловсруулж, шоронгоос суллагдсан хүмүүст дэмжлэг туслалцаа үзүүлэх эрх зүйн орчин бий болгох шаардлагатай.

Үүний тулд Засгийн газраас хөтөлбөр батлан гаргаж цаашдаа тусгайлсан хууль боловсруулан хэрэгжүүлэх, эсвэл Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хорих байгууллагаас суллагдсан ялтныг ажил хөдөлмөрт зуучлах, нийгэмд ажиллаж амьдрахад дэмжлэг үзүүлэх талаар тодорхой заалтуудыг оруулах хэрэгтэй.

Судлаачийн хувьд “хөтөлбөр” гарган хэрэгжүүлж, шоронд байгаа болон шоронгоос суллагдах гэж байгаа, суллагдсан хүмүүсийг нийгмээс нь хөндийрүүлэхгүй байх, шоронд гэмт зан үйл, дадалд суралцуулахгүй байх, хэвийн ажиллаж амьдрахад нь туслалцаа

дэмжлэг үзүүлэх үндэсний хөтөлбөр гарган хэрэгжүүлэх бодлогын боломжит хувилбарыг дэвшүүлж байна. Энэхүү хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар явуулсаны дараагаар олсон ололт, амжилт, алдаа, дүгнэлтдээ үндэслэн хорих ялын нээлттэй, хаалттай дэглэмийг нийгмийн ажлын хэлбэртэй хослуулан хөгжүүлэх нь бодлогын гол цөм байх юм.

Энэхүү хөтөлбөрийн гол зорилго нь дараахь шинжийг агуулсан байвал зохино. Үүнд:

- Шоронд байгаа, суллагдах гэж байгаа, сулагдсан хүмүүст чиглэсэн байх. Эдгээр хүмүүст чиглэсэн ажил нь хоорондоо уялдаа холбоо бүхий бодит үр дүн гарахад үндэслэсэн байх ёстой;
- Хуулийн байгууллагуудын үйл ажиллагаанд хүндрэл учрахааргүй байх. Хууль, журам, заавруудыг өөрчлөлгүйгээр хэрэгжих боломжтой, өдөр тутмын үйл ажиллагаа, тухайлбал, өөр хоорондоо уялдаа холбоо бүхий процессыг тусгасан байх;
- Хэрэгжүүлэх арга зам тэр дундаа туслалцаа дэмжлэг үзүүлэх хэлбэрүүдийг зааж өгөх. Эдгээр хэлбэр нь хууль, тогтоомжид харшлахгүй байх, шоронгоос сулагдсан хүмүүст хүрэхүйц байх;
- Нийгмийн ажилтан голлох хэлбэртэй цагдаагийн байгууллагын туслалцаа бүхий үйл ажиллагаа нь давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үр дүнтэй нэг хэлбэр байж болохоор байна.

Судлаачийн санал болгож буй зөвлөмж нь цагдаагийн байгууллагын одоогийн үйл ажиллагаанд ихээхэн хамааралтай бөгөөд цаашид зөвхөн хэсгийн байцаагч, цагдаагийн анхан шатны нэгж энэ ажлыг дангаар хийх нь ажлын дарамт авчирдаг.

Хэсгийн байцаагч, төлөөлөгч нь өдөр тутмын үйл ажиллагаа болох хэрэг бүртгэх, хэв журам, захиргааны хяналт гэх мэтчилэн ажил дүгнэх олон үзүүлэлтэд түүртэж байгааг хуулийн байгууллагын удирдах албан тушаалтнууд бодитойгоор олж харах хэрэгтэй байна.

ТӨРИЙН БУС ТЭТГЭВРИЙН САНГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ



Голомт банкны хууль
зүйн зөвлөх, магистр
П.Өнөрмаа

I. Төрийн бус тэтгэврийн сангийн тухай ойлголт

Монголд "...нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн бөгөөд 60 нас хүрсэн даатгуулагч өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Харин 20-иос доошгүй жил шимтгэл төлсөн бөгөөд 55 нас хүрсэн эмэгтэй өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болох¹ ба энэхүү тэтгэврийн хэмжээ нь сарын дундаж хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 45 хувь байдаг".²

Төрөөс олгож буй³ тэтгэврийн зэрэгцээ ажилтанболонажиллолгогчбайгууллагахамтран хуримтлал бий болгож, хожим ажилтанг тэтгэвэрт гарсан хойно уг хуримтлалыг олгодог систем бас бий. Үүнийг ерөнхийд нь "Хувийн тэтгэврийн систем" гэдэг. Энэ нь төрийн "шууд" оролцоогүйгээр тэтгэврийн хуримтлалыг бий болгож, буцаан хуваарилах арга юм. Хоёр үндсэн төрөлтэй. Тэдгээрийг Англиар "Defined Benefit" ба "Defined Contribution" гэдэг. "Defined Contribution"⁴ дотроо олон төрлүүдтэй.⁵

ТБТС (Төрийн бус (хувийн) тэтгэврийн сан)-ийн гол зарчим нь ажилтан, ажил олгогч байгууллага хоёр харилцан тохиролцсон тодорхой хэмжээгээр мөнгөн хуримтлал цуглуулах, тэр хуримтлалыг хөрөнгө оруулалтын аргаар өгсөж/нэмэгдүүлж, нэгэнт бий болсон хуримтлалын мөнгийг ажилтанг тэтгэврийн насанд хүрч ажлаас гарсан⁶ тохиолдолд ажилтанд нэг удаа, эсхүл тодорхой хугацаанд, тогтоосон дүнгээр олгох явдал юм. ТБТС-ийн гол зорилго нь эцсийн дүнд тэтгэврийн нэмэлт орлогыг бий болгоход оршдог.

¹ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйл, 1994 он.

² Мөн хуулийн 5 дугаар зүйл.

³ 2010 оны 10 дугаар сарын 13-ны Өнөөдөр сонинд бичсэн "Тэтгэврийн сангийн мөнгө байгаа юу эрх баригчид аа" хэмээх нийтлэлд, "...Нийгмийн даатгалын сангийн мөнгийг бүхэлд нь Төрийн санд байршуулж, ямар ч хүү, хараа хяналтгүйгээр зарцуулан 2.1 триллионоор хэмжигдэх ерийн сүлжээ үүсгэсэн нь эрх баригчдад итгэх итгэлийг алдагдуулж байна... гэжээ.

⁴ Энэхүү нийтлэлд "Defined Contribution"-ы талаар голлон өгүүлэх болно.

⁵ Profit sharing plan, Money purchase plan, Employee stock ownership plan, A 401 (k) гэх мэт.

⁶ Их Британид зарим тохиолдолд ажлаас гарсан буюу өөр байгууллагад шилжсэн ч санд байгаа мөнгийг хэвээр үлдээн тэтгэвэрт гартал өсгөдөг байна. (<http://www.timesonline.co.uk/tol/money/pensions/article721744.ece> 2010-05-02).

Энэ систем гурван талын ач холбогдолтой. Нэгд, ажилтан тухайн байгууллагад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажилласнаар тэтгэврийн нэмэлт орлоготой болох, Хоёрт, байгууллагын хүний нөөцийн бодлогын хүрээнд туршлагатай сайн ажилтанг хадгалж үлдээх, ажилтнуудын ажлаас гарах тоог багасгах, шинэ ажилтанг давтан сургахтай холбоотой зардлыг бууруулах г.м, Гуравдугаарт, хүн амын насжилт байнга өсөн нэмэгдэж байгаа өнөө үед төрийн нийгмийн хамгаалал, тэтгэврийн талаарх үүргийг хөнгөвчлөх, төрийн тэтгэврийн үр ашиг муутай механизмын зардлыг бууруулах г.м олон талын ач холбогдолтой болохыг дэлхийн бусад орон хүлээн зөвшөөрсөн байна.⁷

Түүнчлэн энэ ойлголтыг “Deferred Salary” буюу “Хойшлуулсан цалин” гэж нэрлэдэг. Энэ системд:

- Ажилтны сар бүрийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын тодорхой хэсгийг ажилтны нэр дээр данс нээн байршуулах ба, ажил олгогч байгууллага мөн адил хэмжээний⁸ мөнгийг дансанд шилжүүлнэ;
- Уг хуримтлалыг хөрөнгө оруулалтын аргаар өсгөнө. Үүгээрээ хадгаламжаас ялгаатай;
- Мөн энэ мөнгийг байгууллагын үндсэн хөрөнгөнөөс тусад нь бүртгэдэг. Өөрөөр хэлбэл, байгууллага энэ мөнгийг үйл ажиллагаандаа зарцуулах эрхгүй;
- Харьцангуй урт хугацааны гэрээний шинжтэй;
- Нэгэнт бий болсон, (бас сар бүр цалингаас нэмэгдэн орж байгаа) хөрөнгийг бие даасан хараат бус “Fund Manager”, “Trust” г.м хөрөнгийн удирдлагын мэргэжлийн байгууллага, хувь хүнээр удирдуулж өсгөдөг. Хөрөнгийг удирдагч нь туршлагатай, эрх бүхий байгууллага, хувь хүн байдаг. Тэдэнтэй гэрээ байгуулдаг;
- Хөрөнгийг үнэт цаас, бонд, хувьцаа, хадгаламжийн сертификат, санхүүгийн бусад үүсмэл хэрэгслүүд, үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулах болон бусад арга замаар өсгөдөг. Хөрөнгө оруулалт бүр ашигтай байх боломжгүй бөгөөд зарим тохиолдолд алдагдал хүлээх ч үе гарна. Энэ эрсдэлийг ТВТС болон ажилтан хүлээнэ. Хамгийн бага алдагдал хүлээж ашиг олохын тулд туршлагатай хөрөнгө удирдагчийг олох хэрэгтэй ба хөрөнгө оруулалтын уян хатан, эрсдэлээс сэргийлсэн бодлоготой байх шаардлагатай⁹;
- Ажил олгогч буюу ажилтны санаачлагаар хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон тохиолдолд тодорхой торгуультайгаар, харин ажилтан хөдөлмөрийн чадвараа бүрэн алдах, тэтгэвэрт гарах наснаас өмнө/дараа нас барсан тохиолдолд ажилтанд хуримтлалыг

⁷ IOPS, “Principles of Private Pension Supervision”, 2006, p.1.

⁸ Зарим байгууллага ажилтны төлж буй хуимтлалыг хоёр дахин өсгөж, эсхүл ажилтны төлж буй хэмжээнээс бага хэмжээний хуримтлал хийдэг. Энэ хэмжээг гэрээгээр зохицуулах ба тухайн байгууллагын санхүүгийн чадвараас ихээхэн хамаардаг.

⁹ Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хөрөнгийн удирдагчид тавих олон хязгаарлалт байдаг. Жишээ нь, Макао-д Fund Manager-үүд сангийн хөрөнгөөр өөрийн компанийн хувьцааг худалдан авах, өөрт болон бусдад зээл олгох эрхгүй байдаг. (Makau, Act of Private Pension Funds).

бүрэн хэмжээгээр буцаан олгодог. Энэ нь уг систем бол богино хугацааны хөрөнгө оруулалт бус, урт хугацаанд хадгаламж бий болгох буюу нэмэлт тэтгэврийн орлого бүрдүүлэх зорилготой байдагтай холбоотой.

ТБТС-ийн ашиг алдагдал, үйл ажиллагааны талаарх мэдээллийг ажилтнуудад хамгийн багадаа жилд нэг удаа хүргэх ба энэ мэдээлэлд дор дурьдсан зүйлсийг тусгана. Үүнд:

- Ажилтан болон ажил олгогчийн сар бүрийн хуримтлалын дүн;
- Нэрийн дансан дахь хуримтлалд ногдох хөрөнгө оруулалтын өгөөж¹⁰ (алдагдал)-ийн хэмжээ;
- Тухайн жилийн дансанд хуримтлагдсан нийт дүн;
- Шаардлагатай бусад мэдээлэл.

ТБТС-ийн хөрөнгө оруулалт, эрсдлийн удирдлагын үйл ажиллагаанд төрөөс хяналт тавина.

II. Бусад орны практик

Анхны “Хувийн” тэтгэврийн сан 1800 оны сүүл үед Канад улсад¹¹ үүсч дараа нь 50-иад оны үед баруун европ, АНУ-д нэвтэрсэн байна. Тэдгээр нь сайн дурын гишүүнчлэл бүхий, хувийн компаниудын удирдлага дор үйл ажиллагаагаа явуулдаг байв.

80-аад оноос сайн дурын, хувийн тэтгэврийн сангуудын туршлагыг төрийн тэтгэврийн программуудтай хослуулан хэрэглэж эхэлсэн. Жишээ нь, “Чилийн Тэтгэврийн загвар”-ыг Аргентин, Уругвай зэрэг латин америкийн хэд хэдэн орон, мөн Швед, Итали г.м европын зарим оронд хэрэгжүүлсэн байдаг.¹²

90-ээд оноос Польш, Болгар, Словак, Балтын орнууд, ОХУ зэрэг оронд хувийн тэтгэврийн сангууд байгуулагдаж, нийт ажилтнуудын 3-10 хувийг хамарч эхэлсэн байна. 1992 онд ОХУ-д нийт 950 сан байсан бол 2000 онд 100 орчим болж цөөрчээ. 2002 оноос ОХУ-д иргэдэд нэрийн данс үүсгэн, тэтгэврийг түүнээс төлдөг тэтгэврийн шинэ систем бий болсон.¹³

Өнөө үед өндөр хөгжилтэй орнуудад энэ систем дунджаар ажилтнуудын 50 хүртэл хувийг хамрах болсон ба жишээ нь, Голландад 90%,¹⁴ АНУ, Германд ойролцоогоор ажилтнуудын 50%, баруун европын бусад орнонд 10-30% -ийг хамарчээ. ТБТС нь гишүүнчлэлийн

¹⁰ Тухайн жилд олох өгөөжийн доод хэмжээг гэрээнд урьдчилан тодорхойлох нь явиргай байдаг.

¹¹ OECD, “Description of Private Pension Systems”, 2008, p.65.

¹² С.Батхүлэг, “Төрийн бус тэтгэврийн сангийн тухай”, Судалгаа, 2009 он.

¹³ Мөн судалгаа.

¹⁴ OECD, “Description of Private Pension Systems”, 2008, p.73.

хувьд “Хаалттай” буюу ямар нэг групп компаниудын хүрээнд байгуулагдсан өөр бусад байгууллага элсэх боломжгүй, “Нээлттэй” буюу ТБТС-д хамрагдахыг хүссэн аль ч байгууллагыг элсүүлдэг гэсэн төрөлтэй байдаг. Ихэнх оронд ТБТС-ын үйл ажиллагааг хуульчилсан байдаг. Цөөн хэдийг дурьдвал АНУ,¹⁵ Унгар¹⁶, Литва, Макао¹⁷ юм. Ажил олгогчийн болон ажилтны цугларуулсан мөнгөн хэрэгсэл нь зөвхөн тэтгэврийн актив хэлбэрээр хэрэглэгдэх бөгөөд тэтгэврийн сангийн оролцогчийн (ажилтны) хөдлөшгүй өмч байна. Тэтгэврийн хуримтлалыг бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

ТБТС нь сайн дурын болон заавал оролцох гэсэн хоёр төрөлтэй байдаг. Зарим орон (Чили, Аргентин, Уругвай, Швед, Итали, Польш г.м)-д заавал оролцох хэлбэрийг хуульчилсан байдаг. Харин сайн дурын гишүүнчлэлийн хэлбэр нь илүү түгээмэл юм. (АНУ, баруун болон зүүн европын орнууд, Япон, Австрали г.м.).

Хувийн тэтгэврийн сангууд нь хөрөнгө оруулалтын маш хүчирхэг бүтцийг бий болгодог бөгөөд тэдгээр нь их хэмжээний санхүүгийн нөөцийг эзэмшиж, зах зээлийн эдийн засгийн хөгжилд ихээхэн нөлөө үзүүлж, хөрөнгийн болон үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалт хийж, том том төслүүдийг эзэлжүүлдэг/санхүүжүүлдэг байна. Жишээ нь, АНУ-д хөрөнгийн зах зээлд зарагдаж буй хувьцааны 25%-ийг хувийн тэтгэврийн сангуудын актив бүрдүүлдэг бөгөөд тэдний нийт хөрөнгө оруулалтын хэмжээ нь эдийн засагт оруулж буй төсвийн хөрөнгө оруулалтаас давдаг байна.¹⁸ Хувийн тэтгэврийн сангууд нь ажилтнуудын нэрийн дансанд цугларуулсан мөнгөн хөрөнгийг эргэлтэд оруулснаар түүнийг урт хугацааны туршид мөнгөний ханшны уналтаас хамгаалж, өсгөж чаддаг. Санхүүгийн хүчирхэг тоглогч болох тэтгэврийн сангууд нь хүмүүсийн ирээдүйнхээ өмнө хүлээх хариуцлагыг өндөрсгөж, тэдний эдийн засгийн идэвхийг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын мэдлэг, дадлыг бий болгодог¹⁹ тул ТБТС-уудад төрөөс татварын хөнгөлөлт үзүүлдэг. Австри, Бразил, Чили, Финлянд, Франц, Герман, Голланд, Турк, АНУ, Англи зэрэг улсад ажилтан болон ажил олгогчийн сар бүр төлж буй хуримтлалыг орлогын албан татвараас чөлөөлдөг бөгөөд ТБТС-ийн хөрөнгө оруулалтын өгөөжид татвар ногдуулдаггүй.²⁰ ТБТС-ийн хамгийн гол асуудал бол хуримтлалыг эрсдэлгүй буюу хамгийн бага эрсдэлтэй хөрөнгө оруулалтад ашиглах юм. Өөрөөр хэлбэл ТБТС-ийн гол эрсдэлүүд нь хөрөнгө оруулалт (хөрөнгө болон өр төлбөрийн зөрүү)-

¹⁵ Pension Protection Act (бие даасан бүлэг бий).

¹⁶ Act LXXXII of 1997 on Private Pensions and Private Pensions Funds.

¹⁷ Makau, Act of Private Pension Funds.

¹⁸ Мөн судалгаа.

¹⁹ ТБТС-ийн гишүүд тухайн жил хөрөнгө оруулалтын ямар төрлүүдийг сонгохоо өөрөө сонгодог. Тогтоосон хугацаанд шийдвэрээ гаргаж чадаагүй бол Сан сонгодог.

²⁰ OECD study “Private Pension System in Turkey”, 2003.

ын эрсдэл, инфляци, биометрик эрсдэл, төлбөрийн чадваргүй болох явдал байдаг.²¹

III. Монгол Улсын эрх зүйн орчны өнөөгийн байдал

Өнөөдөр Монгол Улс (МУ)-д ТБТС-ийн эрх зүй зохицуулалт бараг байхгүй гэж хэлж болохоор байна. Харин ИНЕГ, Голомт банк, Хасбанк, Вагнер Ази ХХК зэрэг компани ТБТС-ийн эхлэлийг хэдийн тавьжээ. Харамсалтай нь хууль, эрх зүйн зохицуулалт хангалтгүйгээс эдгээр сангуудын үйл ажиллагаа жинхэнэ утгаараа хэрэгжиж чадахгүй байна. ТБТС-ийн эрх зүйн статус МУ-ын Төрийн бус байгууллагын тухай хуулийн дагуу “Гишүүнчлэл бүхий, ашгийн төлөө бус байгууллага” байдлаар байгуулж болохоор байна.²² Харин ТБТС-ийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч ТББ-ын нийтлэг зохицуулалтаар зохицуулах боломжгүй байна. Санг байгуулах, татан буулгах асуудал, хөрөнгийн удирдлагын бодлого, сан, ажилтан, ажил олгогчийн эрх үүрэг, төрөөс сангийн үйл ажиллагаанд тавих хяналт, шаардлага гэх мэт асуудлуудыг энэ хуулиар зохицуулах боломжгүй юм. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан Хөрөнгө оруулалтын сан нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах, тодорхой дүрмийн сантай байх шинжээрээ ТБТС биш болохыг харуулж байна.

Татварын асуудал Ажилтан болон ажил олгогчийн төлж буй хуримтлалыг татвараас чөлөөлөх, хөнгөлөх, хөрөнгө оруулалтын ашиг, олгож буй тэтгэвэрт татвар ногдуулахгүй байх буюу тодорхой хэмжээнд чөлөөлөх механизмыг бусад оронд өргөн ашиглаж байгааг МУ-д нэвтрүүлэх, ингэснээр хувийн хэвшилүүдэд ТБТС байгуулах сэдлийг төрүүлэх, дэмжих шаардлагатай байна.

Хөрөнгийн менежмент буюу удирдлага, хяналт Одоогийн эрх зүйн зохицуулалтаас харахад Хөрөнгө оруулалтын сан²³, арилжааны банкууд хөрөнгийг удирдаж болохоор байна. Тухайлбал, Банкны тухай хуулийн 6.2 дугаар зүйлд зааснаар банк, түүний хараат болон охин компани Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэйгээр “итгэлцлийн үйлчилгээ”²⁴ явуулах эрхтэй байна. Өөрөөр хэлбэл ТБТС-ийн хөрөнгийг удирдаж болно гэсэн үг юм. Харин хөрөнгө оруулалтын бодлого,²⁵ түүнийг

²¹ OECD, “Evaluating the Design of Private Pension Plans: Costs and benefits of Risk-Sharing”, 2009.

²² 4.3 дугаар зүйл.

²³ МУ-д байхгүй.

²⁴ Trust гэж ойлгож байна.

²⁵ Жишээ нь: Литва улсад ТБТС-ийн хөрөнгөөр Хадгаламжийн сертификат авах бол түүний нийт хэмжээ сангийн хөрөнгийн 10%, төрийн өмчит орон нутгийн байгууллагаас гаргасан үнэт цаасны 30% -аас хэтрэхгүй байх, үл хөдлөх хөрөнгө худалдан авахгүй байхыг тус тус хуульчилсан байна. (Private Pension Fund Regulation In Lithuania, Lithuanian Banking, Insurance and Finance Institute) Филиппин улсад ТБТС-ийн үйл ажиллагааны зардлыг ашгийн

хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, шаардлага, ажилтнуудын эрх ашгийг хамгаалах зэрэг асуудлыг зохицуулах механизм үгүйлэгдэж байна.

Даатгалын асуудал Эрсдэлийг бууруулах, түүнээс сэргийлэхийн тулд ажилтан өөрөө тэтгэврээ даатгуулах эсхүл сан хөрөнгө, үйл ажиллагаагаа даатгуулах хэлбэр байдаг. Өнөөдрийн байдлаар "National Life", Бодь даатгал нар энэ төрлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан байна. Цаашдаа ТБТС-ийн хөрөнгийг заавал даатгах хэлбэрт шилжих нь зүйтэй болов уу. АНУ-д хувийн тэтгэврийн сангуудын эрсдэлийг төрийн оролцоотой "сан" даатгадаг²⁶. Зүүн өмнөд азийн хямралын үеэр Японы хувийн тэтгэврийн сангууд ихээхэн алдагдал хүлээсэн тул уг системийг дэмжих зорилгоор улсын төсвөөс ихээхэн хэмжээний хөрөнгийг гаргасан юм.²⁷

IV. Дүгнэлт ба асуулт "Бид юу хийх ёстой вэ?"

ТБТС-уудыг байгуулах, үйл ажиллагааг өргөжүүлэх нь нийгмийн бодит хэрэгцээ тул хууль эрх зүйн орчин, хөрс суурийг зөв бүрдүүлэх шаардлага зүй ёсоор гарч байна. Өөрөөр хэлбэл, ТБТС-ийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, дэлхий нийтийн чиг хандлагыг дагах нь зүйтэй. Энэ зорилгоор дор дурдсан асуудлыг шийдвэрлэх, ялангуяа шийдвэрлэх арга замуудыг сайтар тунгаах хэрэгтэй гэсэн дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

- ТБТС-ийн эрх зүйн статус, ТБТС-ийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох эсэх, сангийн удирдлага зохион байгуулалт, ажилтнуудын эрх ашгийг хамгаалах, санд элсэх, сангаас гарах асуудал;
- Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд тавих шаардлага (зайлшгүй байлгах нөөц, хязгаарлалтууд, эрсдэлээс сэргийлэх механизм);
- ТБТС-д заавал/сайн дураар хамрагдах эсэх (томоохон эсхүл жижиг компаниудын ялгаа);
- Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төрийн хяналт, мониторинг, НББ-ийн хяналт, хөндлөнгийн аудит;
- Эрсдэлийн удирдлага, даатгалын асуудал, төрөөс үзүүлэх татварын хөнгөлөлт зэрэг асуудлыг эхний ээлжинд шийдвэрлэх шаардлагатай юм.

10%-аас хэтрүүлжгүй байхыг үүрэг болгосон байдаг. (Supervisory Structure for Private Pension in the Philippines, By Dir. Emilio B. Aquino, OECD/INPRS Conference on Private Pensions in Asia, May 28-30, Hyderabad, India (2002))

²⁶ Pension Benefit Guaranty Corporation.

²⁷ С.Батхүлэг, "Төрийн бус тэтгэврийн сангийн тухай", Судалгаа, 2009 он.

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ



ШШГЕГ-ын Тогтоол
гүйцэтгэх газрын Ялтны
сургалт, хүмүүжлийн
хэлтсийн дарга, хошууч,
докторант Ц.Очгэрэл

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд заасан “...иргэний болон эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэх...” ажиллагаанаас хорих ял эдлүүлэх ажиллагаа буюу эрүүгийн ял эдлүүлэхээр тогтоосон шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагаа, түүний хэрэгжилтийг хангахад учирч буй бэрхшээл, эрх зүйн зохицуулалтын мөн чанар, тогтолцооны бодит зүй тогтол зэргийн талаар шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа, шинжилгээний ажлыг тогтмол явуулж, үр дүнг практикт зохистойгоор ашиглах нь энэхүү төрийн онцлог чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх зорилтыг хангахад чухал ач холбогдолтой.

Монгол Улс нийгэм, эдийн засгийн шинэ тогтолцоонд шилжиж буй сүүлийн жилүүдэд гэмт хэргийн тоон үзүүлэлт өсөхийн хамт гэмт үйлдлийн арга нарийсч илүү хор аюултай болж өөрчлөгдөж байгаа ба зохион байгуулалттай, нийгэм эдийн засаг, улс төр, бизнесийн салбар түүнчлэн эрүүгийн гэмт хэрэгтнүүдийг хамарсан шинэ өнгө аяс бүхий бүлэглэлүүд үүсч эрүүгийн гэмт хэргийн нөхцөл байдал хүндэрсээр байна.

Манай улсын эрүүгийн хууль тогтоомжийн онцлогоос шалтгаалж онц хүнд, хүнд, хүндэвтэр гэмт хэрэгт сэжиглэгдэн холбогдох байгууллагад шалгагдаж байгаа сэжигтэн, яллагадчийг цагдан хорьж шалгадаг, мөн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан дийлэнх гэмт хэрэг нь хорих ялын санцтай байдаг учир улс орны эрүүгийн нөхцөл байдал Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын (ШШГБ) харьяа хорих анги, баривчлах, цагдан хорих байрны (цаашид хорих анги гэх) дотоод нөхцөл байдалд тодорхой хэмжээгээр нөлөөлж байдаг. Өөрөөр хэлбэл, үйлдлийн арга хэлбэр, нийгэмд учруулсан хор уршгаар хүнд ноцтой хэргийн ихэнхи сэжигтэн цагдан хоригддог, улмаар гэмт үйлдэл нь шүүхийн шатанд хэлэлцэгдэн нотлогдсон тохиолдолд мөн дийлэнхихувь нь шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ял шийтгэгддэгээс улбаалан тухайн хоригдогч, ялтны хувийн байдал, гэмт санаа бодлын хэр хэмжээ, субъектив шинж нь хорих байгууллагын дотоод нөхцөл байдлыг хүндрүүлэх шууд хүчин

зүйлсийн нэг болж байдаг.

Хоригдогч, ялтын дундаас албан хаагчийн үүрэг гүйцэтгэлт, улмаар албаны үйл ажиллагаанд нөлөөлөхийг оролдох, өөртөө ашигтай шийдвэр гаргуулахыг эрмэлзэх, албан хаагчийг янз бүрийн аргаар эрхшээлдээ оруулахыг хичээх гэх мэт хорих анги, баривчлах цагдан хорих байрны өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах зорилго бүхий үйлдлийг байнгын буюу тасралтгүй шинжтэйгээр үйлдсээр байна. Түүнчлэн хоригдогчид нь хорих анги, баривчлах цагдан хорих байранд бусдын амь нас, эрүүл мэндийн эсрэг үйлдэж байгаа, мөн хорих ангиас харуул хамгаалалтын сул байдал эсхүл тухайн анги, албаны үйл ажиллагааны онцлог байдлыг ашиглан хамгаалалтын инженер техникийн хэрэгсэлийг эвдэх, зориулалтын саад, төхөөрөмжийг давж туулах замаар ганцаар болон бүлэглэн оргох гэмт хэрэг үйлдэгдсээр байна. Энэ нь хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрхэн үр дүнтэй зохион байгуулах зүй тогтлыг онолын үүднээс шат дараатай судлан, практик ач холбогдлыг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

Мөн өнөөдрийн байдлаар хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, бодит зүй тогтлыг бие даасан байдлаар шинжлэх ухааны үүднээс авч үзсэн бүтээл, судалгааны ажил тийм ч хангалттай бус байгаа нь энэ чиглэлээр судалгаа шинжилгээ явуулах бас нэгэн шалтгаан болж байна. Ер нь аливаа улс орны “Эрүүгийн бодлого буюу төрийн зүгээс гэмт явдлын өсөлтийг бууруулах, тогтворжуулах зорилтыг хангах оновчтой бодлого боловсруулж хэрэгжүүлэх замаар нийгмийг гэмт халдлагаас хамгаалах чиглэлээр явуулж буй идэвхтэй үйл ажиллагаа”-ны¹ салшгүй нэг хэсэг нь эрүүгийн ял эдлүүлэх ажиллагаа төдийгүй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төр нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт явдалтай хийх тэмцлийн чиглэлээр явуулж буй эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч нэг чухал субъект юм.

Түүнчлэн “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал”-ыг тухайлбал, түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг хамгаалах, тэдгээрт халдаж болзошгүй гэмт явдалтай тэмцэх, учирч болзошгүй хор уршгаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор төрөөс буюу төрийн эрх бүхий субъектууд нь Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд тус тусын чиглэлээр тодорхой чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тухайлбал: Монгол Улсын зэвсэгт хүчин нь улс орныг цэргийн хүчээр батлан хамгаалах үүрэг хүлээдэг бол, ТЕГ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг тагнуулын арга замаар хангах зорилгыг хэрэгжүүлж, ЦЕГ нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах замаар тус тус Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад тодорхой үүрэг

¹ Л.И.Беляева. “Эрүүгийн бодлого ба түүнийг дотоод хэргийн байгууллагуудаас хэрэгжүүлэх нь”. Москва, 2003, с.7.

хүлээдэг.

Тэгвэл ШШГБ төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлэгч субъект болохын хувьд эрүүгийн хэргийн талаархи шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх явцдаа эрүүгийн ялын зорилтыг хангах үүднээс гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгэгдсэн хүмүүсийг нийгмээс тусгаарлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан сэжигтэн яллагдагчийг хорих, хоригдогч, ялтны зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Түүнчлэн хорих анги, баривчлах, цагдан хорих байрны хэвийн үйл ажиллагааг хангах, хоригдогсдын болон ажилтан, албан хаагч, бусад хүмүүсийн (...хоригдогч ялтны ар гэрийнхэн, ШШГБ-ын анги, албадын бүс дотор ажиллаж буй хууль хяналтын, түүнчлэн төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагын ажилтнууд г.м) аюулгүй байдлыг хангах замаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бүрэлдхүүн хэсэг болсон нийгэм-төрийн байгууллын аюулгүй байдал, иргэдийн эрх, эрх чөлөө аюулгүй байдлыг хангахад тодорхой үүрэг гүйцэтгэж байна гэж үзэж болох юм.

Үүнээс үзвэл нэг талаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэгч субъект хэдий боловч нөгөө талаас Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу эрүүгийн ялын зорилгын хүрээнд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх түүнчлэн хорих анги, баривчлах, цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах замаар чиг үүргээ хэрэгжүүлдэг байгууллага юм.

Хорих ял эдлүүлэхээр гаргасан шүүхийн шийдвэрийг биелүүлэх явцад хорих ангийн дотоод нөхцөл байдлаас шалтгаалж түүний аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар нарийвчлан судлах шаардлагатай байдаг бол цагдан хорих баривчлах байрны хувьд одоогийн мөрдөгдөж буй хууль, эрх зүйн актуудын хүрээнд харуул хамгаалалтын үйл ажиллагаа нь мөн адил түвшинд зохион байгуулагддаг ба тэнд хяналт, харуул хамгаалалтыг тухайн объектын онцлог нөхцөл байдалтай уялдуулан оновчтой, нягт зохион байгуулах зайлшгүй шаардлага байна.

УИХ-аас 2002 онд “Эрх зүйн шинэтгэл”-н бодлогын явцад батлагдсан зарим хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд баривчлах, цагдан хорих байр нь ШШГБ-н харьяанд шилжин ирсэнээр баривчлах, цагдан хорих талаархи шүүхийн шийдвэрийг хэрхэн гүйцэтгэх, ямар шаардлага, стандарт хангасан нөхцөлд хорих, хяналт, харуул хамгаалалтыг яаж зохион байгуулах талаар ШШГБГ-аас шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүсээр ирсэн. 2002-2008 оны хугацаанд баривчлах, цагдан хорих байранд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил, дотоод нөхцөл байдлыг судалж үзвэл тэнд үйлдэгдэж буй гэмт хэргийн үйлдлийн арга хэлбэр нарийн, сайтар төлөвлөсөн,

гарах үр дагаварыг урьдаас тооцсон байхын зэрэгцээ хоригдогсдын сэтгэл зүйн өвөрмөц онцлог байдлаас шалтгаалан учруулж байгаа хор уршиг хүнд ноцтой шинжийг агуулж байна. Тухайлбал, хорих байрны албан хаагчийн болон бусад хоригдогсдын амь нас, эрүүл мэндэд халдсан ноцтой гэмт хэргүүд ч үйлдэгдэж байна.

Иймээс баривчлах, цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах асуудлыг тусад нь орхигдуулах бус ШШГБ-ын үйл ажиллагааны нэг онцлог чиглэл, чухал объектын хувьд хорих ангитай хамтатган нэг зарчмаар хандан тулгамдаж буй асуудлын талаар судлах нь зүйтэй гэж үзэж байна. Миний бие 2007 онд цагдан хорих байрны аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар магистрын судалгааны ажил хийсэн ба энэ чиглэлээр судалгааны ажил үргэлжилж байгаа.

Хорих ангийн аюулгүй байдлыг хангах тухай судлахын тулд юуны өмнө аюулгүй байдлыг хангах тухай ерөнхий ойлголт түүний мөн чанар, бодит ач холбогдлыг авч үзэх нь зүйтэй.

Аюулгүй байдлыг хангах гэдэг нь чухам ямар зүйлийн аюулгүй байдлыг хангах талаар авч үзэж байгаагаас шалтгаалан тодорхой хэмжүүрээр тодорхойлогдсон арга хэмжээнүүдийн нэгдлийн тухай ойлголт юм. Аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тодорхойлохын тулд дотоод агуулга, мөн чанарыг тогтоох олон хэмжүүрээр тухайн объектын шинж байдлыг тодорхойлохын зэрэгцээ нийгэм, эдийн засгийн буюу улс орны оршин тогтнохуйн болон хөгжлийн чухам ямар ач холбогдол, үнэ цэнэ агуулж байгааг харгалзан үздэг. Түүнчлэн аливаа зүйлийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тодорхойлох гол хүчин зүйлийн нэг нь түүнд нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлс бөгөөд чухам ямар аюул заналхийлэл нөлөөлж болзошгүй байгааг тогтоох явдал юм. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлыг хангах шаардлага, аюул заналхийллийн түвшин, эх сурвалжийг оновчтой тодорхойлох зайлшгүй шаардлагатай.

Аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нь тулгарч буй бодит шаардлага, түүний ач холбогдол, тухайн объектын онцлог зэргээс шалтгаалан хувь хүний, байгууллагын, улс орны тусгаар тогтнолын, мэдээллийн түүнчлэн тодорхой чиглэлт үйл ажиллагааны, эдийн засгийн, хөгжлийн, экологийн, соёлын, түүхийн ач холбогдол бүхий үнэт зүйлсийн аюулгүй байдлыг хангах гэх мэт маш олон төрөл зүйл байж болно. Эндээс тухайн хамгаалагдах шаардлагатай объектын аюулгүй байдал гэдгийг түүний бодит зүй тогтол, хэвийн оршин тогтнох, бусад мөн чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй тэрхүү гадаад, дотоод хүчин зүйлс буюу сөрөг нөлөөллөөс хамгаалах нөхцөл хангагдсан байдал буюу аюулгүй байдлыг хангах зорилго амжилттай хэрэгжсэн байдлыг хэлж болох юм.

Тэгэхээр ШШГБ нь Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль

эрх зүйн актуудыг удирдлага болгон өөрийн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа хорих ангийн аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар иж бүрнээр нь авч үзэхийн тулд дараах цогц ойлголтуудыг товч тодорхойлох шаардлагатай болж байна. Үүнд:

1. Хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний зорилго, зорилтыг тодорхойлох;
2. Хорих ангийн аюулгүй байдлыг хангахад нөлөөлж буй гадаад болон дотоод хүчин зүйлсийг тогтоох;
3. Хорих ангийн аюулгүй байдлыг хангах бүтэц;
4. Хорих ангийн аюулгүй байдлын тухай ойлголт түүний бүрэлдэхүүн, онцлог шинж;
5. Хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тогтолцоог тодорхойлж авч үзэх зэрэг асуудал багтаж байна.

Нэг. Хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний зорилго, зорилтыг дараах байдлаар авч үзвэл зохино

Үүнд: Зорилго нь хорих ял эдлүүлэх болон баривчлах, цагдан хорих талаархи шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагааг Монгол Улсын хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулах явцдаа хүний эрх, эрх чөлөөг хангах, улмаар хорих анги, баривчлах, цагдан хорих байрны хэвийн, аюулгүй ажиллагааны тогтолцоог бүрдүүлэх явдал юм. Энэхүү зорилгын хүрээнд дараахь гурван бүлэг зорилтыг хэрэгжүүлнэ.

1. Хорих ангийн хэвийн үйл ажиллагааг хангах

Энэхүү зорилт нь ШШГБ-ын хуулиар хүлээсэн үүрэг, чиглэлтэй салшгүй холбоотой юм. Өөрөөр хэлбэл ШШГБ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг нь хорих анги, баривчлах цагдан хорих байрны хэвийн ажиллагааг хангах явдал.

Хэвийн үйл ажиллагаа хангагдсан байдал гэдэгт юуны түрүүнд хоригдогч, ялгны зүгээс үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, ноцтой гэмт зорилго бүхий нуугдмал санаа, төлөвлөлтийг илрүүлэх арга хэмжээ үр дүнтэй хэрэгжсэн байхыг ойлгоно. Үүний зэрэгцээ хорих анги, баривчлах цагдан хорих байрны барилга байгууламж, хамгаалалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн байнгын найдвартай ажиллагаа; - санхүүгийн болон бусад материаллаг хангамж тасралтгүй хангагдсан байдал зэрэг нь хорих ангийн хэвийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсгүүд юм.

Мөн хорих ангийн хэвийн үйл ажиллагааг хангахад зайлшгүй анхаарвал зохих нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь ШШГБ-ын боловсон хүчний хангамж, ажилтан, албан хаагчдын мэргэжлийн ур чадвар,

анхан шатны болон давтан сургалт түүний үр дүн гэж үзэж байна. Түүнчлэн ИШГБ нь Монгол Улсын хууль тогтоомжид зааснаар “Төрийн нууц”-тай холбоотой чиг үүргийг хэрэгжүүлдэг “Төрийн тусгай алба” болохын хувьд байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь мөн хэвийн үйл ажиллагааг хангах зорилтын хүрээнд хэрэгжинэ.

2. Ажилтан, албан хаагчдын аюулгүй байдлыг хангах

Хорих ял эдлэж байгаа болон цагдан хоригдож буй хоригдогсод нь ямар нэг гэмт санаа бодлоо амжилттай хэрэгжүүлэх эсхүл нуун даалдах, өөрийн хань хамсаатантай холбоо тогтоох гэх мэт сөрөг үйлдлийнхээ явцад ажилтан, албан хаагчийн аюулгүй байдалд шууд болон шууд бусаар халдаж болзошгүй байдаг. Тухайлбал, эрхшээлдээ оруулахыг эрмэлзэх, айлган сүрдүүлэх, дарамтлах мөн амь нас, эрүүд мэндэд халдах гэх мэт. Иймээс хорих ангийн ажилтан, албан хаагчдын аюулгүй байдлыг хангах нь туйлын чухал зорилт юм.

Хэдийгээр ИШГБ-ын офицер ахлагчид нь албан үүрэг гүйцэтгэх явцдаа дүрэмт хувцас, зарим нөхцөлд зэвсэг, тусгай хэрэгслээр хангагддаг боловч албан хаагчдын аюулгүй байдлыг хангах арга хэмжээний хүрээнд үүрэг гүйцэтгэхээс бусад цаг хугацаанд, тухайлбал, олон нийтийн газарт, ажилд ирэх, буцах замд хэрхэн аюулгүй байдлыг хангах талаар зайлшгүй анхаарч үзэх нь зүйтэй.

3. Хоригдогч, ялтны болон бусад хүмүүсийн аюулгүй байдлыг хангах

Хоригдогч, ялтны зүгээс хамт хоригдогсдын амь нас, эрүүл мэндэд халдах, дарамтлах зэрэг гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсээр байгаа нь судалгаанаас харагдаж байна. Түүнчлэн эрүүгийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор эсхүл сэтгэл зүйн онцлог, бусад шалтгааны улмаас амиа хорлох, бие эрхтэндээ гэмтэл учруулах зэрэг ноцтой үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохын тулд хоригдогч, ялтны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Энд бусад хүмүүс гэдэгт оршил хэсэгт дурдсанчлан хорих ангийн бүс, байрлалд түр хугацаагаар нэвтэрч байгаа болон тодорхой ажил үүрэг гүйцэтгэж байгаа албан тушаалтан иргэдийг хамруулж ойлгох нь зүйтэй юм.

Хоёр. Хорих ангийн аюулгүй байдалд нөлөөлж буй гадаад дотоод хүчин зүйлс

Хорих ангийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлийг бусад

аюулгүй байдлын талаар бичигдсэн ном сурах бичиг, эрдэмтэн судлаачдын үзсэнчлэн эх сурвалж, шинж чанараар нь гадаад болон дотоод хэмээн нийтлэг байдлаар хуваан авч үзнэ. Хорих ангийн аюулгүй байдалд нөлөөлөх гадаад хүчин зүйлс гэдэгт дараах зүйлийг хамруулан ойлгоно. Үүнд:

1. Өхний бүлэг хүчин зүйлсэд аливаа улс орны нийгмийн хөгжлийн бодит зүй тогтол, эдийн засаг, санхүүгийн тогтвортой байдал, ард түмний амьжиргааны түвшин гэх мэт нийтлэг нөхцөлүүд хамаарна;

2. Мөн улс төрийн болон хууль, эрх зүйн тогтолцооны бүтэц, тэдгээрийг бүрдүүлэгч элементүүдийн зүй тогтол, амьдралд хэрэгжих бодит үр дүнтэй холбоотой нөлөөллийг гадаад хүчин зүйлд хамааруулж ойлгоно;

3. Улс орны эрүүгийн нөхцөл байдалтай холбогдсон хүчин зүйлс. Энд бид гэмт явлын бодит байдал түүний криминологи шинж болон нийгмийн амьдралд нөлөөлж буй нөлөөлөл, гэмт явдлын бүтэц, түүний өсөлт, бууралт, нийгэмд хор аюултай шинж чанарын өөрчлөлт гэх мэт зүйлийг хамааруулж ойлгож болно;

4. Байгаль, цаг уурын хүчин зүйлс. Өнөөгийн дэлхийн нийтийн өмнө тулгамдаж буй тэмдгээр асуудал нь байгаль, цаг уурын өөрчлөлт, түүнээс учирч болох хор уршгаас урьдчилан сэргийлэх явдал юм. Хорих анги нь байгал, цаг уурын гэнэтийн өөрчлөлт, түүнээс үүдэн гарах үр дагаврыг урьдчилан тооцох, ноцтой хор уршиг учрахаас урьдчилан сэргийлэх байнгын төлөвлөгөөт бэлэн байдалд байх шаардлагатай;

5. Хорих ангийн аюулгүй байдалд нөлөөлөх гадаад хүчин зүйлсэд зайлшгүй хамааруулвал зохих нэг зүйлс нь хорих ангийн албаны үйл ажиллагаа, албан тушаалтны үүрэг гүйцэтгэлтэд шууд ба шууд бусаар нөлөөдөх сонирхол бүхий объектив болон субъектив хандлага юм. Үүнд, гэмт хэрэг, зөрчил үйлдэж болзошгүй хоригдогч, ялтны хань хамсаатан, бүлэглэлүүд тэдгээрээс хэрэгжүүлж буй идэвхтэй үйлдэл санаархал юм.

Хорих ангийн аюулгүй байдалд нөлөөлөх дотоод хүчин зүйлсийн мөн чанарын талаар дээр аюулгүй байдлыг хангах арга хэмжээний талаар судлах шаардлагыг тодорхойлох явцад дурдсан хэдий ч бүрдүүлэгч хүчин зүйлийг авч үзье. Үүнд:

1. Хорих ангийн дотоод нөхцөл байдал;

2. Хоригдогч, ялтны зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлийн хор уршиг, аюул заналхийллын түвшин;

3. Хамгаалалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн хүрэлцээ, барилга байгууламжийн чанар;

4. Хорих ангийн удирдлага зохион байгуулалтын ажил, түүний үр дүн;

5. Аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий албан тушаалтны мэргэжлийн (эсхүл мэргэшлийн), ур чадвар, ажил үүрэг гүйцэтгэлт, албаны болон мэргэжлийн бэлтгэлийн түвшин.

Гурав. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах бүтэц

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлд заасан зарчим, 5 дугаар зүйлд заасан тогтолцоонд үндэслэн дараах бүтэцтэй байна. Үүнд:

(А) Хэрэгжүүлэгч субъектын хувьд:

1. Төв удирдлага буюу ИШПГЕГ;
2. Мэргэжлийн удирдлага буюу ТТГ;
3. Шууд удирдлага буюу хорих ангийн дарга;
4. Хорих ангийн харуул хамгаалалт эрхлэсэн дэд дарга, түүнчлэн цагдан хорих байрны дарга;
5. Хорих ангийн харуул хамгаалалтын үндсэн бүрэлдэхүүн;
6. Тодорхой тохиолдлуудад хорих ангийн нийт офицер ахлагч;

(Б) Техник хэрэгслийн хувьд:

1. Барилга байгууламж;
2. Галт зэвсэг, тусгай хэрэгсэл;
3. Хамгаалалтын тоног төхөөрөмж хэрэгслүүд;
4. Машин техник бусад тусгай зориулалтын техник;

(В) Үйл ажиллагааны хувьд:

1. Өдөр тутмын буюу төлөвлөгөөт үйл ажиллагаа;
2. Гэнэтийн буюу болзошгүй бүхий л тохиолдолд ажиллах шуурхай ажиллагааны төлөвлөгөөт үйл ажиллагаа;
3. Болзошгүй аюулыг урьдчилан тооцох, тэдгээрийг даван туулах зорилгоор эрх зүйн, удирдлага зохион байгуулалтын болон бусад арга замыг боловсруулах чиглэл бүхий судалгаа, шинжилгээний үйл ажиллагаа.

Дөрөв. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах тухай ойлголт

Хорих ангийн аюулгүй байдлыг түүний үйл ажиллагааны онцлог шинж, үндсэн зорилго, зорилттой уялдуулан: “Хорих ангийн аюулгүй байдал гэдэг нь хорих анги, баривчлах, цагдан хорих байрны хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлэх, улмаар хэвийн үйл ажиллагааг алдагдуулж, ноптой хор уршиг учруулж болзошгүй гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаалах зорилгоор эрх, үүрэг бүхий субъектүүдээс хэрэгжүүлж буй тасралтгүй шинж чанар бүхий арга хэмжээний погц, оновчтой бүтэц бүрдэх явдал” гэж тодорхойлж болох юм.

Тав. Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тогтолцоо, түүнийг зохион байгуулах зарчим

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг тодорхой дэс дараалал, харилцан бие биетэй зохицолдсон, нягт уялдаа холбоо бүхий цогц байдлаар хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү аюулгүй байдлыг хангах цогц арга хэмжээ буюу тогтолцоог зохион байгуулахдаа дараах үндсэн зарчмыг баримтлана. Үүнд:

1. Хорих ангийн аюулгүй байдлыг хангах зорилго, зорилтоо тодорхойлж, түүнд нийцсэн үйл ажиллагаа явуулах;
2. Аюулгүй байдалд хор уршиг учруулж болзошгүй аюул заналаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тэргүүлэх шинж чанартай хэрэгжүүлэх;
3. Хорих ангийн аюулгүй байдлыг хангах бүхий л цогц арга хэмжээ шуурхай, тасралтгүй шинж чанартай байх;
4. Хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд буюу инженер техникийн хэрэгсэл, бусад үйл ажиллагаанд шинжлэх ухаан, технологийн дэвшлийг нэвтрүүлэх;
5. Хорих ангийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны хүрээнд явагдаж байгаа арга хэмжээ, үйл ажиллагаа, хүч хэрэгслүүд нь хоорондоо нягт уялдаа холбоотой байх;
6. Хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээнүүд нь гадаад болон дотоод хүчин зүйлээс шалтгаалан уян хатан байх. Өөрөөр хэлбэл, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нь хорих ангийн онцлог нөхцөл байдлаас хамааралтай байх шаардлагатай юм.

Дэлхий нийтэд түгээмэл хэрэглэгдэж буй аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тогтолцоо түүнчлэн хорих ангийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн зарим судалгаа, онолын болон практик дүгнэлтэд тулгуурлан үзвэл хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ нь дараах тогтолцоотой байна. Үүнд:

1. Удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ;
2. Биечилсэн харуул хамгаалалтын арга хэмжээ;
3. Инженер техникийн арга хэмжээ;
4. Гүйцэтгэх ажлын арга хэмжээ зэрэг арга хэмжээнүүд багтана.

Хорих ангийн аюулгүй байдлыг хангах дээрхи арга хэмжээнүүд нь харилцан бие биенээ нөхөх, байнгын уялдаа холбоонд байх зарчмаар хэрэгжих бөгөөд аль нэг арга хэмжээг нөгөөгөөр орлуулж гүйцэтгэх эсвэл орхигдуулах нь хэвийн үйл ажиллагааг алдагдуулах, аюулгүй байдлыг хангах үндсэн зорилт хэрэгжихгүй байх нөхцөлийг бүрдүүлж болзошгүй. Энэ нь хоригдогч, ялтанд гэмт санаа бодол, үйлдлээ хэрэгжүүлэх, хорих ангийн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх боломж олгох, ноцтой гэмт хэрэг, зөрчлийг таслан зогсоох боломжгүй болох гэх мэт үр дагавар учруулж болзошгүй гэсэн үг юм. Тухайлбал, дээрхи арга хэмжээнүүдээс удирдлага, зохион

байгуулалтын арга хэмжээ нь бусад арга хэмжээнүүдийг хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх, хоорондын уялдаа холбоог хангах, эцсийн үр дүнг урьдчилан тооцох гэх мэт чиглэлээр удирдах, төлөвлөх чухал үүрэг гүйцэтгэдэг ба энэ нь аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тогтолцоог үр дүнтэй зохион байгуулахад үлэмж чухал ач холбогдолтой юм. Харин биечилсэн харуул хамгаалалтын буюу тодорхой албан тушаалтнаар дамжин хэрэгжих арга хэмжээ, инженер техникийн арга хэмжээнүүд нь харилцан бие биенийхээ сул талыг нөхөх замаар хамгаалалтын нягт бүрдлийг бүрдүүлэх боломжтой. Түүнчлэн ШШГБ-ын үйл ажиллагааны нэг чухал чиглэл болох Гүйцэтгэх ажлын арга хэмжээг амжилттай хэрэгжүүлэхгүйгээр хорих ангийн аюулгүй байдал бүрэн хангагдах, дээрхи тогтолцоо бодит утгаараа хэрэгжих ямар ч боломжгүй юм.

Дээрхи бүгдээс дүгнэж үзвэл хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг өндөр түвшинд зохион байгуулах нь ШШГБ-ын хуулиар хүлээсэн чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах болон бусад олон талын ач холбогдолтой болох нь харагдаж байна. Иймээс дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар энэхүү зорилгыг хангах нь зүйтэй юм. Үүнд:

1. Хорих ангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй хууль, эрх зүйн актууд, тэдгээрийн хэрэгжилтийг судлан эрх зүйн орчинг боловсронгуй болгох;
2. Дэлхий нийтийн жишнгт нийцүүлэн шинжлэх ухааны судалгааны үйл ажиллагааг өргөжүүлэн байнгын үйл ажиллагаатай эрдэм шинжилгээний бие даасан нэгжийг ШШГБ-ын дэргэд ажиллуулах;
3. Судалгаа шинжилгээний ажлын үр дүнд тулгуурлан “Хорих ангийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тогтолцоо”-г ШШГБ-ын харьяа нэгжүүдэд зөв, оновчтой хэрэгжүүлэх;
4. Урьдчилан сэргийлэх ажлыг цогцоор нь хэрэгжүүлэх;
5. Аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий албан тушаалтнуудын мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх, энэ чиглэлээр анхан болон давтан сургалтын шат дараалсан арга хэмжээ авах гэх мэт олон ажил зохиож болох юм.

Хэдийгээр өнөөдрийн байдлаар ШШГБ нь өмнөө тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлэн, алба нэгжүүдийн үйл ажиллагаа хэвийн зохион байгуулагдаж байгаа боловч энэхүү өгүүлэл нь судалгааны түвшинд, асуудал дэвшүүлсэн материал учир холбогдох санал, шүүмж нь судалгааны цаашдын үр дүнд тус дэм болох нь гарцаагүй. Иймд “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн редакцид өөрийн санал бодлоо хуваалцахыг хүсье.

**БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ЗАЛИЛАН МЭХЭЛЖ АВАХ БА
ҮҮРГИЙН ГҮЙЦЭТГЭЛЭЭС ҮҮССЭН ХЭРЭГ МАРГААНЫГ
ЗААГЛАН ЯЛГАХ АРГАЧЛАЛ БОЛОВСРУУЛАХ НЬ**

ХЗҮХ-ийн судалгааны тайлан

Удиртгал

Сүүлийн жилүүдэд төрөл хүрээ нь өргөжин үйлдэх арга нь улам нарийсч буй гэмт хэргүүдийн нэг нь залилан мэхлэх гэмт хэрэг бөгөөд хүний хэрэгцээ, шунал, цаг үеийн нөхцөл байдлыг болон тухайн этгээдийн сул талуудыг овжин ашиглаж үйлдэгддэг онцлогтой. Энэхүү гэмт хэргийн үйлдлийн нэг арга нь иргэний эрх зүйн зохицуулалтай гэрээ, түүний дотор гэрээг ашиглан үйлдэж байгаа нь энэ төрлийн иргэний хэрэг маргааныг залилан мэхлэх гэмт хэргээс ялган салгаж, зөв шийдвэрлэхэд зарим бэрхшээл учруулах болсон байна. Иргэд, хуулийн этгээдийн хооронд маргааныг гэмт хэрэг эсхүл иргэний хэргийн аль нь болохыг ялгаж зааглаж чадахгүй байгаа нь иргэний асуудлаар эрүүгийн хэрэг үүсгэх, эрүүгийн хэргийг иргэний маргаан гэж андуурч эрүүгийн хэрэг үүсгэхгүй байх, эрүүгийн хэрэг үүсгэсэн бол үндэслэлгүй гэх зэргээр буруу шийдвэр гаргаж маргаан тасрахгүй байна. Үүнээс гэмт этгээдүүд ял завших эсхүл иргэний харилцаанд оролцогч эрүүгийн хариуцлагад хууль бусаар татагдах тохиолдол цөөнгүй гарч шударга ёсны зарчимаас гажуудаж, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх болсон учраас залилан мэхлэх гэмт хэргийг иргэний эрх зүйн төсөөтэй харилцаанаас ялгах аргачлал боловсруулах шаардлагатай гэж үзсэн болно. Судалгааны тайлангийн бүтэц нь судалгааны зорилго, судалгаа хийсэн байдал, судалгааны дүн, санал, дүгнэлт гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдэж байгаа бөгөөд эхний хэсэгт судалгааг хэрхэн явуулсан тухай, судалгааны дүн хэмээх хэсэгт залилан мэхлэх гэмт хэрэг ба иргэний эрх зүйн хууран мэхэлж хийсэн хэлцэл, зээлийн гэрээ түүнтэй төстэй ижил төрлийн гэрээний ойлголт, ялгагдах онцлог, криминалистик шинж болон энэ асуудлаар Улсын дээд шүүхийн хийсэн тайлбар, дүн мэдээ, шүүхийн шийдвэр, шийтгэх тогтоолыг судлан оруулсан болно. Төгсгөл хэсэгт, дэвшүүлсэн санал, дүгнэлтийг бичлээ.

I бүлэг. Судалгааны зорилго, судалгаа хийсэн байдал

1.1. Судалгааны зорилго, зорилт

Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэрэг ба иргэний хуульд заасан гэрээнээс ялгагдах онцлог, мөн чанарыг судлан эдгээр харилцааг ялгах аргачлалыг боловсруулж, судалгааны үр дүнг холбогдох албан тушаалтан болон олон нийтэд танилцуулах зорилготой. Зорилт:

- Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэрэг ба иргэний хуульд заасан гэрээний эрх зүйн онол, түүний үндэслэлийг судлах;
- Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэрэг ба иргэний эрх зүйн хууран мэхэлж хийсэн хэлцэл, зээлийн гэрээ түүнтэй ижил төрлийн гэрээний төсөөтэй шинж болон ялгагдах онцлогийг судлах;
- Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэргийн криминалистик шинжийг судлах.

1.2. Судалгааны арга, хэлбэр

Судалгааны ажилд хувийн ашиг сонирхол бүхий субъектийн нөлөөллөөс ангид бие даасан байдлаар, шинжлэх ухааны арга зүйг баримтлан, судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах зарчмыг иш үндэс болгов. Судалгааг сэдвийн хүрээнд хууль зүйн эх сурвалж болох баримт бичгийн задлан шинжилгээ, тоон болон чанар (практикийн байдлыг газар дээр нь ажиглах, ярилцлага, асуулга, сурвалжлага)-ын аргаар явууллаа. Үүнд:

- Баримт бичгийн шинжилгээгээр Улсын дээд шүүхийн тайлбар болон эрүүгийн хэргийн 14 хавтаст хэрэг, мөн 2006, 2007, 2008, 2009 оны Нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн 1134 шүүхийн шийтгэх тогтоол болон шүүхийн шийдвэрээс өнөөгийн практик;
- Чанарын судалгаагаар зарим шүүгч, прокурор, мөрдөн байцаагч нартай ярилцлагын судалгаа хийсэн.

Судалгааны зорилго зорилтын хүрээнд дараахь ажлыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Нийслэлийн хэмжээнд 2006-2010 онд шалгаж шийдвэрлэсэн эрүү, иргэний хэрэг маргааны жагсаалт-судалгааг дүүргийн шүүх, цагдаагийн байгууллагын бүртгэл, мэдээ тайланг түшиглэн гаргаж дүн шинжилгээ хийв;
- Улсын дээд шүүхийн холбогдох тайлбар тогтоолд дүн шинжилгээ хийв;

- Судалгааны сэдвээр урьд туурвисан эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэлүүдийг судлав;
- Шүүх, прокурорын байгууллагын архивт хадгалж буй эрүү, иргэний хэрэг, маргааныг хянан шийдвэрлэсэн тогтоол, шийдвэр, хавтаст хэргийн материалыг түүвэрлэн судласан;
- Банк, санхүүгийн болон бусад байгууллагын үйл ажиллагаагаар халхавчлан бусдыг залилан мэхлэсэн үйлдлүүд, хонжворт сугалаа гаргах, зуучлах, мөнгийг нь өсгөж өгөхийг амлах зэргээр хүмүүсийн хялбар хөрөнгөжих сонирхол дээр нь “тоглож” бусдыг мэхэлсэн үйлдлийн тухай хэвлэл, мэдээллийн хэрэгслийн нийтлэл, зар мэдээг судлан дүгнэлт хийв.

II бүлэг. Судалгааны дүн

2.1. Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэрэг ба Иргэний хуулиар зохицуулсан цэргийн гүйцэтгэлээс цүссэн хэрэг маргааны ойлголт, онцлог

(А) Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэргийн тухай

Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэрэг (цаашид залилан мэхлэх гэмт хэрэг гэнэ) нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн бүлэгт хамаардаг. Залилан мэхлэх гэмт хэрэг нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн нийтлэг шинжийг агуулахаас гадна өөрийн гэсэн онцлогтой нь уг гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинжээр илэрдэг.¹ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлд “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” гэмт хэргийг тодорхойлсон эрүүгийн эрх зүйн дараахь гурван хэм хэмжээг хуульчилсан.²

Жич. Эрцүгийн хуульд 2008 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн өөрчлөн найруулгаар Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэрэгт “148.4. Энэ гэмт хэргийг онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.” гэсэн зохицуулалт нэмэгдсэн.

1. Бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 5-50 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар

¹ “Залилан мэхлэх гэмт хэрэг” сургалтын гарын авлага, Д.Адьяабазар, УБ, 2008 он, 31 дэх тал.

² Мөн тэнд

хүртэлх хугацаагаар баривчлах ял шийтгэнэ;

2. Энэ гэмт хэргийг давтан, бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ;

3. Энэ гэмт хэргийг урьд нь энэ хэрэгт болон хулгайлах, булаах, завших, дээрэмдэх гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, эсхүл онц аюултай гэмт хэрэгтэн, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, түүнчлэн энэ гэмт хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.³

Хууль тогтоогч дээрх зүйлийн I хэсэгт уг гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинжийг, II хэсэгт энэ гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүний шинжийг, III, IV хэсэгт дээрх I, II хэсгүүдэд заагдсан гэмт хэргийг онц хүндрүүлэх шинжийг зааж өгсөн байна.⁴ Энэ байдлаас үзэхэд бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг нь:

- Үндсэн бүрэлдэхүүн;
- Хүндрүүлэх бүрэлдэхүүн;
- Онц хүндрүүлэх бүрэлдэхүүн юм.⁵

Залилан мэхлэх гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинжид уг гэмт хэргийг өмчийн эсрэг бусад ялгагдах, залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэх хамгийн анхдагч ерөнхий объектив, субъектив шинжийг тодорхойлж өгсөн.⁶

Залилан мэхлэх гэмт хэргийн шинж нь хууран мэхлэх, итгэл эвдэх гэсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр илэрнэ. Хуурч мэхлэх гэдэг нь гэмт этгээд бусдын эд хөрөнгө болон түүнийг эзэмших эрхийг түүний эзэмшигч эсвэл хариуцан хамгаалж буй этгээдийн үгээр буюу үйлдлээр хуурч мэхлэн төөрөгдүүлж хохирогчийг сайн дураар эд хөрөнгөө шилжүүлэн өгөхөд хүргэж буй үйлдэл юм⁷. Итгэл эвдэх гэдэг нь найз нөхөд, танил тал, төрөл төрөгсдийн харилцааг ашиглан итгэлийг олж бусдын эд хөрөнгө түүнийг эзэмших эрхийг гэмт этгээд

³ Мөн тэнд.

⁴ Мөн тэнд.

⁵ Мөн тэнд.

⁶ Мөн тэнд.

⁷ "Криминалистикийн тактик" ред. Ж.Болдбаатар, УБ., 2001 он, 246 дахь тал.

олж авахыг хэлнэ⁸ гэж эрүүгийн эрх зүйн онолын номуудад дээрхтэй адил тайлбарласан байдаг.

Итгэл эвдэх гэдгийг мөн хохирогчийн итгэлийг эвдэх замаар залилан мэхлэх гэмт хэргийг гэмт хэрэгтэн хохирогчийн итгэлийг олж авсан тэдгээрийн хоорондын харилцааг урьдаас төлөвлөн үүсгэж, итгэл үнэмшлийн үндсэн дээр буй болсон өөрийн үүргээ гэмт хэрэгтэн үл биелүүлэх аргаар үйлддэг байна⁹. Жишээлбэл, түрээсээр авсан эд зүйлс, өмч хөрөнгийг эргүүлэн өгөхгүй байх, урьдчилгаа авсан хэр нь ажил үйлчилгээг бүрэн дуусгалгүй орхих, авсан өр, зээлээ эргүүлэн төлөхгүй байх зэрэг хамаарна.

Хуурч мэхлэх гэдэг нь бусдын өмчлөх эрхийг элдэв хуурамч аргаар төөрөгдүүлэх замаар эд хөрөнгө, эд юмсыг өөрөө өгөхөд хүргэж, түүний эд хөрөнгө, эд юмсыг эзэмших, ашиглах эрхийг хууль бусаар олж авах үйлдлийг хэлнэ.¹⁰ Жишээлбэл, гадаад орны виз гаргана, гадаад болон дотоодын сургуульд оруулах, байшин барилгыг өндөр үнээр зарж өгнө, ордер сольж өгнө, мөнгө өсгөж өгнө гэх мэт. Хуурч мэхлэх¹¹ гэдэг нь гэм буруутай этгээд эд хөрөнгийг хариуцагч буюу эзэмшигчийг үгээр буюу үйлдлээр үнэн байдлыг гуйвуулж буюу нуун дарагдуулж, төөрөгдүүлснээр уул эд хөрөнгийг авах эрхтэй гэж хууртагдсан этгээд эд хөрөнгийг сайн дураараа шилжүүлэн өгсөн байдлаар илэрнэ. Итгэлийг эвдэх¹² гэдэг нь гэм буруутай этгээд бусдын эд хөрөнгийг авахын тулд талуудын итгэлд үндэслэн тодорхой гэрээний харилцааг ашиглах буюу эд хөрөнгийг хариуцагч, эзэмшигч зохих баримт бичиг бүрдүүлэлгүй буюу тогтсон журмыг мөрдөлгүйгээр шилжүүлснийг ашиглан түүнийг өөрийн өмчлөлд шилжүүлэх үйлдлээр илэрнэ. Дээрх онолын ойлголт, тайлбаруудаас харахад хуурч мэхлэх гэдэг нь гэмт этгээд тухайн эд хөрөнгийг эзэмшигч, өмчлөгчийг үгээр буюу үйлдлээр хууран мэхэлж, төөрөгдүүлэн хууль бусаар эд хөрөнгийг өөрийн өмчлөлдөө шилжүүлэн завших үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. Харин итгэл эвдэх гэдэг нь тухайн гэмт санаагаа хэрэгжүүлэхийн тулд итгэлцлийн үндсэн дээр бий болдог харилцааг ашиглан итгэж хүлээлгэсэн үүргээ үл биелүүлэх аргаар эд хөрөнгийг өөрийн өмчлөлд оруулахыг хэлнэ гэж тайлбарлаж болохоор байна. Залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэгдэж буй байдлыг судалж үзэхэд хүмүүсийн шунал, хэрэгцээг ашиглан хуурамч амлалт өгөх, эсвэл биелэгдэх боломжгүй зүйлийг боломжтой мэтээр ойлгуулж мөн заавал төрийн байгууллагын эрх зүйн актаар шийдвэрлэх асуудлыг шийдвэрлэж өгч чадна гэж итгүүлэх үүндээ хуурамч албан бичиг, баримт ашиглах зэрэг үйлдэл

⁸ Мөн тэнд.

⁹ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, (албан бус), УБ., 2010 он. 374 дэх тал.

¹⁰ Мөн тэнд.

¹¹ Д.Адьяабазар, "Залилан мэхлэх гэмт хэрэг" сургалтын гарын авлага. УБ., 2008 он, 57 дахь тал.

¹² Мөн тэнд.

нь хууран мэхэлж байгаа үйлдэл, эс үйлдэхүйг итгэл эвдэх аргаар үйлдэгдэж байгаа нь ихэнхдээ иргэний эрх зүйн гэрээний харилцааг ашиглан зохих ёсоор гүйцэтгэх үүрэг, гэрээний нөгөө талд хүлээлгэсэн үүрэг, гэрээнд оролцогч этгээдийн баримтлах ёстой үүрэг зэргийг анхнаасаа биелүүлэхгүй гэсэн зорилготойгоор гэрээнд оролцон бусдын эд хөрөнгийг хууль бусаар өөрийн өмчлөлд шилжүүлэн авч байгаа үйлдлээр уг гэмт хэрэг үйлдэгдэж байна.

(Б) Иргэний хуулиар зохицуулсан цүргийн гүйцэтгэлээс цүссэн хэргийн тухай ойлголт

Иргэний эрх зүйн сурах бичиг, судлаачдын бүтээлээс үзвэл гэрээ болгон хэлцэл, хэлцэл болгон гэрээ биш. Хэлцэл нь нэг талын байж болдгоороо гэрээнээс ялгаатай ажээ. Иргэний хуулийн 39.1.Иргэний эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, шилжүүлэх, дуусгавар болгох зорилгоор хүсэл зоригоо илэрхийлсэн иргэн, хуулийн этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-г хэлцэл гэнэ. Хоёр буюу түүнээс дээш талууд ямар нэгэн зүйлийг хийхээр эсвэл хийхгүй байхаар тохиролцсон хуулийн хүчин төгөлдөр хэлэлцээрийг гэрээ гэнэ. Гэрээ нь аль аль талуудын сайн дурын үндсэн дээр, эрх тэгш, чөлөөтэй байгуулснаар хүсэл зориг, ашиг сонирхол нь хангагдаж, эрх үүрэг, үр дагавар үүсч байдаг.¹³ Иргэний хуулийн тусгай ангид бусдын өмчлөлд хөрөнгийг бүрмөсөн шилжүүлэхэд чиглэсэн үндсэн 4 төрлийн гэрээг, тухайлбал, худалдах-худалдан авах гэрээ, арилжаа, бэлэглэл, зээлийн гэрээг зохицуулсан байна.¹⁴ Зээлийн гэрээгээр зээлдэгч нь зээлдүүлэгчийн өмчлөлд мөнгө болон бусад төрлийн шинжээр тодорхойлогдох эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь үүнтэй ижил төрөл, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буцаан өгөх үүргийг хүлээж байдаг. Энэхүү гэрээ нь сүүлийн жилүүдэд манай улсад иргэний эрх зүйн салбарт хамгийн өргөн тархсан үзэгдэл болоод байна. Найз нөхөд, тавилын хүрээнд богино хугацаатай, хүүгүй зээл олгох тохиолдол маш бага хувийг эзлэх бол санхүүгийн эргэлтэд хамаарах зээл давамгайлж буйг харж болно. Тиймээс зээлийн эрх зүй нь өнөөдөр гол төлөв банкнаас олгох зээл, хадгаламжийн хөрөнгийн эргэлт, хадгаламж зээлийн хоршоодоос гишүүддээ зээл олгох явдал, аж үйлдвэрийн зээл, төр болон түүний нэгжийн зээл авах үйл ажиллагаа түлхүү байдаг.¹⁵ Зээлийн гэрээг объектийг нь харгалзан мөнгө зээлэх болон эд хөрөнгө зээлэх гэрээ, субъектийг нь харгалзан банк санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдээс зээлэх, бусад этгээдээс зээлэх хэмээн ангилж үзжээ. Өнөөгийн амьдралд мөнгө зээлэх гэрээ болон банк санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдээс зээлэх мөн иргэд хоорондын

¹³ Ц.Цолмон, "Гэрээний эрх зүй", УБ., 2009 он.

¹⁴ Б.Буянхшиг, "Иргэний эрх зүйн тусгай анги", УБ., 2010 он. 95 дахь тал.

¹⁵ Мөн тэнд, 160 дахь тал.

зээлийн гэрээ хамгийн их байдаг. Зээлийг эргүүлэн төлөх явдал нь зээлийн гэрээний хамгийн чухал үүрэг байдаг.¹⁶ Үүргийн харилцаанд оролцогч этгээд үүргээ зохих ёсоор шударгаар биелүүлэх нь иргэний эрх зүйн харилцаанд хамаарах шударга ёсны зарчим юм.

Иргэний эрх зүйд хууран мэхэлж хийсэн хэлцлийн хууран мэхлэх үйлдлийн зорилго нь ямар нэгэн төөрөгдлийг сэдэж бий болгох эсхүл бий болсон төөрөгдлийг хэвээр хадгалах явдал бөгөөд мэхлэгч этгээд бодит нөхцөл байдлын талаар ташаа зүйл баталж, үнэмшүүлэхийг эрмэлзэж нотлох гэж оролддог. Эдгээр үйлдэл нь дараахь гурван хэлбэрийн аль нэгийг хэрэглэдэг.

- Мэхлэгч этгээд үнэнд үл нийцэх зүйлийг үнэн хэмээн итгэж, үнэмшүүлэхийг оролддог;
- Мэхлэгч этгээд бодит үнэн, нөхцөл байдлыг далдалж, мушгин гуйвуулдаг;
- Мэхлэгч этгээд мэдээлэх үүргээ зөрчин бодит үнэн, нөхцөл байдлыг нуун дарагдуулахыг оролддог.

Хууран мэхлэгч этгээд хууран мэхлэх зорилго санаатайгаар үйлдлээ гүйцэтгэнэ, хэлцлийн нөгөө тал төөрөгдөхийг мэдэж, зорилгоо болгосон байх ёстой.¹⁷ Хууран мэхлэгч этгээд ашиг хонжоо олох, баяжих, эсхүл мэхлэгдсэн этгээдийн өмчид гэм хор учруулах зорилготой байсан эсэх нь хамаагүй учир нь хохирогчийн өмчийг бус харин хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөг хамгаалдагаараа залилангийн гэмт хэргээс ялгагдана. Хэлцэл нь хүсэл зоригийн илэрхийлэл байдаг учраас хэлцэлд оролцогч талуудын хүсэл зоригийн илэрхийллийг хамгаалдаг. Зөвхөн тухайн хэлцлийг хийх гэж хууран мэхэлдэгээрээ ялгаатай. Мөн Иргэний хуулийн 56.1.1-ийн хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцлийн нарийн ялгааг гаргах шаардлагатай. Нийтийн болон гуравдагч этгээдийн эсрэг зан суртахууны хэм хэмжээг зөрчсөн субъектив хүчин зүйл талуудад байх ёстой. Ямар нэг хэлцэл объектив бодит байдлаар зан суртахууны хэм хэмжээг хараахан зөрчиж, үйлдэгдээгүй боловч түүний зорилго, шалтгаан нь зан суртахууны зөрчилд хүргэж болно.¹⁸ Энэ нь залилан мэхлэх гэмт хэргийн хуурч мэхлэх үйлдэлтэй ижил төстэй боловч гол ялгаа нь зорилго шалтгаан нь зан суртахууны хэм хэмжээг зөрчсөн байдгаараа харин залилан мэхлэх гэмт хэрэг уг зан суртахууны хэмжээг зөрчсөн байдаг. Жишээ нь, хэт өндөр хүүтэй зээл олгох, их дээд сургуульд шалгалтгүй оруулж өгөх, виз гаргаж өгнө гэх мэт гэрээ, хэлцэл байгуулах нь гэмт хэрэг мөн. Залилан мэхлэх гэмт хэргийн субъектив шинж нь хууран мэхлэх, итгэл эвдэх үйлдлээс өмнө гэмт санаа бодол

¹⁶ Мөн тэнд, 166 дахь тал.

¹⁷ Иргэний хуулийн тайлбар, (албан бус), УБ., 2006 он, 222 дахь тал.

¹⁸ Мөн тэнд, 184 дэх тал.

үүссэн байдаг бөгөөд бусдын өмчийг ашиглан шамшигдуулах гэсэн санаа зорилготой байдгаараа иргэний зээлийн гэрээнээс ялгаатай.

2.2. Ялгагдах онцлог

Хууль зөрчсөн буюу нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан хэлцэл хийх нь өөрөө залилан мэхлэх гэмт хэрэг болно. Хуурч мэхэлсэн хэлцэл нь тухайн хэлцлийг хийхийн тулд хэлцэлд оролдогч нөгөө талаа хууран мэхлэсэн байдаг ингэснээр тухайн хэлцлийн гол зүйлийн нэг болох эд хөрөнгийн шударга бус эзэмшигч болдгоороо залилан мэхлэх гэмт хэргээс ялгаатай. Учир нь залилан мэхлэх гэмт хэрэг нь тухайн эд хөрөнгийн завшиж ашиглан шамшигдуулсан байдаг бол иргэний эрх зүйд тухайн эд хөрөнгийн шударга бус эзэмшигч болдог онцлогтой. Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.1. “Өмчлөгч хөрөнгөө бусдын хууль бус эзэмшлээс шаардах эрхтэй байдаг, шударга бус эзэмшигч гэдэг нь тухайн эд хөрөнгийг хууль бусаар эзэмшиж байгаа түүнийг эзэмших эрхтэй эсэх нь тодорхой бус байгаа этгээдийг шударга бус эзэмшигч” гэж хэлж болно. Эндээс харахад иргэний эрх зүйн харилцаанд шударга бус эзэмшигч байх бол залилан мэхлэх гэмт хэрэгт тухайн эд хөрөнгийг хуурч мэхлэх, итгэл эвдэх замаар өөрийн мэдэлд оруулан завшиж, ашиглан шамшигдуулсан залилагч гэсэн субъект байдаг. Эдгээр субьектийн субьектив санаа зорилго нь их ялгаатай байдаг. Залилан мэхлэгч этгээд нь анхнаасаа уг эд хөрөнгийг өөрийн мэдэлд авахаар санаархсан уг эд хөрөнгийг эргэж хэзээ ч өгөхгүй гэсэн санаа бодол төрж түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд урьдчилан төлөвлөж гүйцэтгэсэн байдгаараа ялгаатай. Гэхдээ зарим тохиолдолд анхлан иргэний эрх зүйн зээлийн гэрээний харилцаа байсан боловч гэрээгээр хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтаглаж залилан мэхлэх гэмт санаа үүсч болдог. Тэгэхээр залилан мэхлэх гэмт хэргийн субьектив санааг анхлан үүссэн гэмт санаа, үүсмэл гэмт санаа гэж ангилж болохоор байна. Анхаарах зүйл нь бизнесийн үйл ажиллагаа болон ямар нэгэн шалтгаанаар үндсэн зээлээ төлж чадахгүй нөхцөл байдал үүсч болно энэ болгоныг залилан мэхлэх гэмт хэргийн үүсмэл санаа гэж үзэж болохгүй, үүнийг хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад тогтоох шаардлагатай. Өөрөөр хэлбэл, итгэл эвдэх явдал нь шууд итгэл эвдэх, эсхүл үйл ажиллагааныхаа явцад итгэл эвдэх байдлаар илэрдэг. Үүргээ зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй болсон гэдгээ нөгөө талдаа мэдэгдэж зээлийн гэрээний хугацааг сунгах эсвэл барьцаа хөрөнгийг зарж борлуулах талаар зөвшөөрөл өгсөн гэх мэт нь өөрөө гэрээний чөлөөт байдлын зарчим юм.

2.3. Криминалистик шинж

Залилан мэхлэх гэмт хэргийг мөрдөн байцаах ажиллагаа нь бусад гэмт хэргийг мөрдөхөөс ялгагдах онцлог шинжтэй байдаг.¹⁹ Энэ нь:²⁰

1. Тухайн гэмт хэргийн хохирогч, гэмт этгээд хоёр тодорхой хугацаанд бие биетэйгээ харьцдагаас хохирогч гэмт этгээдийн талаар ямар нэг хэмжээний мэдээлэл өгч чаддаг;

2. Уг гэмт хэрэг үйлдэгч бусад гэмт хэрэг үйлдэгчдээс ялгагддаг өөрөөр хэлбэл гэмт этгээд овжин авхаалжтай байж бусдыг өөртөө татаж, өөрийн талаар тааламжтай сэтгэгдэл төрүүлж чаддаг. Залилан мэхлэгч ер нь бол ов живтэй, сэтгэн бодох хөгжил өндөртэй, хүмүүсийг өөртөө татах чадвар сайтай, жүжиглэх авьяастай, гэмт санаагаа хэрэгжүүлэхийн тулд ямарч байдлыг чадварлагаар ашигладаг этгээд байна;²¹

3. Гэмт этгээд хохирогчид итгэл төрүүлэхийн тулд ямар нэг бичиг баримт үзүүлэх, баталгаа гаргаж өгдөг зэрэг нь мөрдөн байцаалтыг тодорхой зүгт чиглүүлж өгдөг ач холбогдолтой.

Эндээс дүгнэн харахад мөрдөн байцаалтын шатанд доорх зүйлсийг зайлшгүй шалгах хэрэгтэй:

- Гэмт этгээдүүд өөрсдийгөө уг гэмт хэргийг үйлдсэн гэдгийг нууцлах зорилгоор байгууллага, иргэдийн санхүүгийн бичиг баримтуудыг хуурамчаар үйлдэх;

- Иргэд, байгууллагын гэсэн бичиг баримт, иргэний үнэмлэхийг ашиглах;

- Тухайн гэмт хэргийн талаар ямар ч мэдлэг, ойлголтгүй хүмүүсийг хөлсөлж, гэмт үйлдэлдээ ашиглах;

- Интернэтээр тухайн байгууллага, иргэдийн талаар мэдээлэл авч гэмт үйлдэлдээ ашиглах;

- Урьд нь ажиллаж байсан байгууллага, аж ахуйн нэгжээс олж авсан мэдээллээ залилангийн гэмт үйлдэлдээ ашиглах гэх мэт олон аргыг хэрэглэж залилан мэхлэх гэмт хэрэг үйлддэг байна.

Мөрдөн байцаалтын ажлыг төлөвлөхдөө эрүүгийн хэрэг үүсгэсэн үндэслэл нь хохирогчийн гомдол байсан бол түүнийг болон харсан хүнийг байцаах, гэмт хэргийн зэвсэг, хэрэгсэлд үзлэг хийх, хуурамч хэлцэлд экспертиз хийлгэх зэрэг ажиллагаа төлөвлөгөөнд тусгагдана.²² Мөрдөн байцаалтын анхны ажиллагаагаар гэм буруутай этгээдийн үйлдэл, хохирогч хэрхэн хуурч мэхлэгдсэнийг тогтоох шаардлагатай.²³ Хэрэв хохирогчид хуурамч хэлцэл, эд зүйл-мөнгө буюу эд юмс, хуурамч үнэт зүйлс гэх мэт байгаа түүнд үзлэг хийж

¹⁹ "Криминалистикийн тактик", ред. Ж.Болдбаатар, УБ., 2001 он, 248 дахь тал.

²⁰ Мөн тэнд

²¹ "Криминалистик" Ж.Хурцгэрэл, УБ, 2004 он, 349 дэх тал

²² Ж.Хурцгэрэл, "Криминалистик", УБ., 2004 он, 351 дэх тал.

²³ Мөн тэнд.

экспертиз хийлэгэнэ.²⁴ Энэ гэмт хэргийг мөрдөхөд гэмт хэрэг үйлдэгдсэн арга, хохирогчийн оролцоо, гэмт хэрэг гарахад нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг илрүүлэн тогтооход онцгой анхаарах хэрэгтэй.

Залилан мэхлэх гэмт хэргийн субъектив гол шинж буюу гэмт этгээдээс гаргаж буй санаа зоригийг хөдөлбөргүй тогтоох нь онцгой чухал. Энэ байдлыг тогтоохдоо ялангуяа хохирогчийн итгэл үнэмшлийг олж авсан арга, гэмт этгээдийн амласан, болзол болгосон зүйл, ажил үйлчилгээ нь бодит байдал дээр биелэгдэх, хэрэгжих боломжтой эсэх, тохиолдлын чанартай бэрхшээл тулгарсан нь үнэн эсэх, уг этгээд урьд нь тухайн төрлийн болон өөр төрлийн гэмт хэрэг үйлдэж байсан эсэхийг тогтоох шаардлагатай.²⁵

2.4. Залилангийн гэмт хэрэг, иргэний эрх зүйн гэрээний маргааны гаралтын байдал

Шүүх, прокурор болон цагдаагийн байгууллагын тайлан мэдээнээс үзвэл энэ төрлийн хэрэг маргаан нэлээд элбэг тохиолддог байна.

№	Он	Хэргийн тоо (Нийслэлийн хамжаан)	Илрүүлэлт	Учирсан хохирол	Хохирол нөхөн төлүүлэлт
1.	2005	403	94.79%	7568.5 сая төгрөг	288.5 сая төгрөг
2.	2006	424	97.2%	8530.6 сая төгрөг	490.7 сая
3.	2007	569	92.9%	3247025.91 төгрөг	319901.91 төгрөг
4.	2008	656	92.7%	8.8 тэрбум	1.1 тэрбум
5.	2009	640	91.5%	13 тэрбум	6.9 тэрбум

Жил болгон залилан мэхлэх гэмт хэрэг өсөж түүний хэрээр уг гэмт хэргийн улмаас учирсан хохирол ихсэж байгаа нь дээрх статистик мэдээнээс харагдаж байна.

Залилан мэхлэх гэмт хэрэг жил ирэх тусам үйлддэг арга нь улам нарийсч, нууц далд хэлбэртэй болж байна. Тухайлбал, урьдаас төлөвлөж иргэний эрх зүйн харилцааг ашиглан гэрээ, хэлцэл хийх замаар халхавчилж залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэж байгаа нь тухайн төрлийн хэргийг хянан шийдвэрлэхэд тодорхой төвөгтэй бэрхшээлийг буй болгож байна. Учир нь хэргийн заргыг иргэний журмаар шүүхээр хянан шийдвэрлэхэд ихээхэн хугацаа шаардагдаж хохирлоо нөхөн төлүүлэхэд цаг хугацаа алдаж байгаа мэт нэхэмжлэгч талд санагдвал тухайн иргэний эрх зүйн маргааныг гэрээгээр халхавчилсан залилан гэсэн зүйл болгон эрүүгийн журмаар шалгуулах сонирхол төрдөг байна.

Нийслэл, дүүргийн шүүхийн шийтгэх тогтоол, магадлалаас үзвэл бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэргийг дараахь арга хэлбэрээр их төлөв үйлдсэн байна. Үүнд:

²⁴ Мөн тэнд.

²⁵ "Криминалистикийн тактик", ред. Ж.Болдбаатар, УБ., 2001 он, 252 дахь тал.

- хуурамч бичиг баримт ашиглан банк, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоо, хувь хүмүүсээс мөнгийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар залилан авах;
- барьцаа хөрөнгийг зохиомлоор бий болгож зээл авах;
- гэмт этгээд өөрийгөө хадгаламж, зээлийн хоршоо ажиллуулдаг, зээлийн байр чөлөөлдөг, богино хугацаанд ашигтай бизнес хийнэ гэх зэргээр итгүүлэн, өндөр хүү, шагнал амлаж иргэдийн өмчлөх эрх болон бэлэн мөнгийг залилан авах;
- иргэдтэй орон сууцны захиалгын гэрээ байгуулж, мөнгийг урьдчилан аваад гэмт этгээд иргэдийн итгэл эвдэн мөнгийг өөр зориулалтаар ашиглаж үрэгдүүлэх;
- хуурамч алт гэдгийг мэдсээр байж бусдад их хэмжээгээр худалдах;
- визний ангилал өөрчлөх, визний сунгалт хийх, оршин суух зөвшөөрөл олгох болон Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны №02 дугаартай тэмдэг зэргийг ашиглах зорилгоор хуурамчаар үйлдэж улмаар гадаадын иргэний гадаад паспортад (уг дардаснуудыг) дарж өгөх;
- Ажилд болон сургуульд зуучлах.

Эдгээрээс зээлийн гэрээг ашиглан үйлдсэн залилан мэхлэх гэмт хэрэг, зээлээр худалдах, худалдан авах гэрээ, мөн виз²⁶ гаргахаар амлаж залилан мэхлэсэн гэмт хэрэг эзэлж байна.

Зээлийн гэрээ болон зээлээр худалдан, худалдах авах гэрээг ашиглан үйлдсэн залилан мэхлэх гэмт хэргийг шийдвэрлэсэн шийтгэх тогтоолд анализ хийвэл:

Сонгинохайрхан дүүргийн шүүх 2007 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн 132 дугаар шийтгэх тогтоолоор Х.С нь бусадтай бүлэглэн бусдын эд хөрөнгийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсан гэмт хэрэгт буруутайд тооцож Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.2 дахь хэсэгт зааснаар Х.С-ийг 2 жил 6 сар шийтгэсэн боловч шүүхийн шийтгэх тогтоол гарахын өмнө Х.С нь иргэдийг залилан мэхлэж, нийт 30 орчим сая төгрөгийн хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн болох нь шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа тогтоогдсон байдаг. Х.С нь банкнаас зээл авахдаа хуурамч үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ бүрдүүлэн хуурамч барьцаа болгон зээл авсан үйлдэлд нь шийтгэх тогтоол гарсан боловч тогтоол гарахын өмнө олон иргэдээс зээлийн гэрээ ашиглан залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн байдаг. Энэ хэргийн хувьд гэмт этгээдийн субъектив санаа зорилгоос нь бусдын эд хөрөнгийг хууль бусаар өөрийн мэдэлдээ авч завшиж үрэгдүүлсэн үйлдлүүд нь залилан мэхлэх гэмт хэргийн шинжийг агуулж байна.

²⁶ 2009 оны 1 дүгээр сард Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамнаас гаргасан "Гадаадад ажиллах хүч гаргах" тусгай зөвшөөрлийн эрх авсан нийтдээ 17 компаниас зөвхөн нэг компани нь БНСУ-д ажиллах хүч гаргах эрхтэй, бусад 16 компани нь Япон улсад ажиллах хүч гаргах эрхтэй юм байна. Харин Европ болон дээрхээс бусад улсад одоогийн байдлаар ажиллах хүч гаргахаар эрх авсан хуулийн этгээд алга байна.

Чингэлтэй дүүргийн шүүхийн 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 217 дугаар шийтгэх тогтоолоор: "... Д.Э нь бүлэглэн 2004 оны 12 дугаар сарын 21-ний өдөр, 2005 оны 2 сарын 7-ны өдрүүдэд шунахайн сэдэлтээр өөрийн ажиллаж байсан Х банкны Чингэлтэй дүүрэг дэх салбараас гурван удаагийн үйлдлээр 55 сая төгрөгийг орон сууц өмчлөх эрхийн хуурамч бичиг баримт барьцаалан хуурч мэхлэх аргаар залилан мэхлэж авсан хэрэгт холбогджээ. Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлийн 148.4 дэх хэсэгт зааснаар 5 жил 1 сар хорих ял шийтгэж..." шийдвэрлэжээ. Харин давж заалдах шатны шүүх ялтан, тэдгээрийн өмгөөлөгчдийн гаргасан гомдлыг үндэслэн 2009 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 742 дугаар магадлалаар шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт шүүх ял шийтгэснийг хүчингүй болгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж шийдвэрлэжээ. Хэрэгт авалдсан 2004 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 40 дүгээр шийтгэх тогтоолоос үзвэл орон сууцны өмчлөх эрхийн гэрчилгээ болон өмчлөх эрхтэй холбоотой эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн лавлагааг хуурамчаар бүрдүүлж түүнийгээ ашиглан банкнаас зээл нэрээр хууран мэхлэж, мөнгө авдаг байсан ба үүнийг давж заалдах шатны шүүх аяхааралгүй ямар үндэслэлээр гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзсэнээ тайлбарлаагүй банкны барьцаанд тавьж байгаа үл хөдлөх хөрөнгө нь өөрөө бодитойгоор байхгүй, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээ нь хуурамчаар үйлдэгдсэн, тухайн үл хөдлөх эд хөрөнгөд үүрэг ногдуулсан эсэхийг нотолсон баримт болох эрхийн улсын бүртгэлийн лавлагаа хуурамч байхад иргэний хэрэг болгож байгаа нь ойлгомжгүй байна.

Иргэний эрх зүйн харилцааны банк санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдтэй зээлийн гэрээ байгуулсан боловч өөрийн хүлээсэн үүргээ биелүүлэхээс татгалзан хамтран үүрэг гүйцэтгэгчийнхээ итгэлийг эвдсэн үйлдэл нь иргэний журмаар хянан шийдвэрлэвэл зохих иргэний маргаан болохыг ялгалгүй шийдвэрлэсэн хэргийн нэг нь: "Ц.Б нь бусадтай хамтран өмнө нь банкны барьцаанд тавьсан орон сууцны барьцаанд тавьсан гэдгээ нуун далдалж, барьцаанд тавиагүй гэж хохирогч Ж.С.-д итгүүлэн уг байрны үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээг барьцаалсан зээлийн гэрээ байгууллаа гэж хууран мэхлэж түүнээс 18,900,000 төгрөгийг залилан мэхлэж авсан гэх хэргийг Орхон аймаг дахь Сум дундын шүүхийн шүүхийн 2009 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 134 дүгээр цагаатгах тогтоолоор гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй бөгөөд иргэний хэрэг байна гэсэн үндэслэлгүй дүгнэлт хийж, хэрэгсэхгүй болгон, түүнийг цагаатгаж, давж заалдах шатны шүүх уг цагаатгах тогтоолыг хэвээр үлдээсэн" нь Ц.Б-гийн үйлдлийг ялгалгүй шийдсэн байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн дээрх залилан мэхлэх хэргийн объектив талын үйлдлийн арга, хэлбэр, бусад шинж:

1. Банк болон банк бус санхүүгийн байгууллагатай эд хөрөнгийн хуурамч барьцаа бүрдүүлэн иргэд зээлийн гэрээ байгуулдаг. Энэ үл хөдлөх хөрөнгийн лавлагааг Улсын Бүртгэлийн Ерөнхий Газраас сайтар лавлахгүйгээр тухайн зээлдэгчээр өөрөөр нь тухайн лавлагааг хийлгэснээр банк болон банк бус санхүүгийн байгууллага гэмт этгээдэд залилуулсаар байна;

2. Банк болон банк бус санхүүгийн байгууллагатай харилцдаг байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтнуудад цалингийн зээлийн гэрээ байгуулсныг харилцагчийн санхүүгийн ажилтнууд хуурамчаар өөр хэсэг ажилтан болгож зээлд хамруулах замаар “мөнгө иддэг” байна. Хуурамч зээлдэгч нар авсан мөнгөнөөсөө тодорхой хувийг нягтлан бодогчид өгч үлдсэн мөнгөө өөрөө аван ор сураггүй алга болдог байна;

3. Зээлээ санхүүгийн байдлаас болж түр төлж чадахгүй болонгуут нөгөө тал нь шууд цагдаад ханддаг. Мөн аж ахуйн нэгж зээлээ төлж чадахгүй санхүүгийн хямралд орох үе байдаг бас дампуурах тохиолдол гардаг. Гэхдээ хуурамчаар дампуурах, санхүүгийн хямралд ордог. Энэ 2 тохиолдлыг яг ижил гэж ойлгон залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэж байгаа нь иргэд болон аж ахуйн нэгжийг хохироож байна;

4. Гадаадын компаниуд МУ-ын иргэдийг залилсан олонр хэрэг байна. Солонгосын хөрөнгө оруулалттай ХХК нь МУ-ын нэгэн ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж хувь нийлүүлэн ажиллахаар тохиролцжээ. Гэвч солонгосын компани өөрийн ажлыг хийж гүйцэтгэлгүй сураггүй алга болонгуут монголын компани шүүхэд ханджээ. Шүүх дээр солонгосын компани бид хохирлыг төлнө, эвлэрье гээд хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэжээ. Тэгээд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулах гэтэл бүх хөрөнгийг нь солонгосын өөр компани шүүхийн шийдвэрээр өмчлөгч нь болсон байдаг байна. Хялбаршуулоан журмаар хэрэг хянан шийдвэрлэхээс өмнө солонгосын компани өөр дүүрэг дээр өөрийн өмчийн хөрөнгөөрөө өөр солонгосын компанид учруулсан гэх хохирлоо барагдуулах шийдвэр гаргуулсан байдаг байна. Тухайн хэргийг судлан үзэхэд бүх юм гэрээний дагуу мэт боловч яг үнэндээ залилан мэхлэж ашиг олдог;

5. Интернетээр залилах, сүүлийн үед интернет ашиглан бусдыг хууран мэхэлж мөнгө олох арга, сүлжээний бизнес дэлгэрчээ. Энэ нь эхлээд элсүүлсэн хүмүүсдээ амласан амлалтаа биелүүлж байгаад хүмүүс итгээд их мөнгө оруулангуут гэнэт ор сураггүй алга болдог хэргүүд ихээр үйлдэгдэж байна. Дэлхийн улс орнуудад төлбөр авах замаар тухайн сүлжээний гишүүнчлэлд элсүүлэх буюу “Пирамид” хэлбэртэй сүлжээний бизнесийг хориглосон байдаг. Монгол Улсын “Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хууль”-ийн 4.1.-д энэ талаар зохицуулсан байдаг ба сүлжээний бизнесийн үйл ажиллагаа явуулахыг хориглосон байдаг ч ийм үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд байсаар байна.

Иргэний хэргийг шүүхээр шийдвэрлэж байхад хэрэг маргааны явц удаашралтай байх юм бол залилангийн гэмт хэрэг болгон шалгуулдаг хууль бус жишиг тогтоод байгаа талаар дээр дурьдсан билээ. Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэх эрх бүхий субъект прокурорын шатанд энэ үйл явц их тохиолдож байна. Учир нь мөрдөн байцаалтын шатанд учирсан хохирлыг нөхөн төлүүлдэг тухай өмнө өгүүлсэн ба энэ нь буруу жишиг талаар доктор, профессор Д.Зүмбэрэлхам “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй дэх гэм буруугүйн презумпци”²⁷ номондоо “гэм буруу нь эцэслэн шийдвэрлэгдээгүй байхад сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр хохирогчид учирсан хохирлыг нөхөн төлүүлж байгаа, үүнийгээ хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажлын үзүүлэлт болгож дүгнэдэг зэрэг гэм буруугүйн презумпцийн зарчимд харш практик тогтсон байна. Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч нь хохирогчийн нэхэмжлэлийг сайн дурын үндсэн дээр барагдуулах хүсэлт тавьснаас бусад тохиолдолд шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол гараагүй байхад хохирлыг тэднээр албадан төлүүлэх нь хууль бус юм” гэж тайлбарласан байдаг.

Иргэний хэргийн оролцогч нь шинэ нөхцөл байдал илэрсэн тухай хүсэлтээ хэргийг шийдвэрлэсэн тухайн шатны шүүхэд хэргийг хянах болсон үндэслэл байгааг мэдсэнээс хойш 30 хоногийн дотор гаргахаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан байна. Шийдвэртээ иргэний хэргийн оролцогчийн хүсэлтээр шинэ нөхцөл байдал илэрсний улмаас шүүх хянаж хүсэлтийг хангасан тохиолдолд оролцогч нарын гомдлоор эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэнэ. Хүчин төгөлдөр шийдвэртэй иргэний хэргийг шинэ нөхцөл байдлын улмаас гэсэн үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэж зэрэгцүүлэн шалгаж болохгүй.

Энэ талаар Улсын Ерөнхий прокурорын газраас чиглэл өгсөн байдаг. “Сүүлийн үед иргэний журмаар шийдвэрлэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийдвэртэй хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн шалгах тохиолдол цөөнгүй гарч байна. Иргэний хэргийн оролцогч нь шинэ нөхцөл байдал илэрсэн тухай хүсэлтээ хэргийг эцэслэн шийдвэрлэсэн тухайн шатны шүүхэд хэргийг хянах болсон үндэслэл байгааг мэдсэнээс хойш 30 хоногийн дотор гаргахаар иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заажээ.

Хүчин төгөлдөр шийдвэртэй иргэний хэргийн оролцогчийн хүсэлтээр шинэ нөхцөл байдал илэрсний улмаас шүүх хянаж хүсэлтийг хангасан тохиолдолд оролцогч нарын гомдлоор эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэж байх нь зүйтэй гэж үзнэ. Иймд хүчин төгөлдөр шийдвэртэй иргэний хэргийг шинэ нөхцөл байдлын улмаас гэсэн үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэн зэрэгцүүлэн шалгаж

²⁷ Уг номын 149 дэх талаас дэлгэрэнгүй харна уу.

болохгүйг анхаарах нь зүйтэй²⁸” гэж чиглэл өгчээ.

Чингэлтэй, Сүхбаатар дүцргийн шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэргийн 420 шийдвэрийг уншиж судлахад шийдвэрийн дийлэнх хувь нь

“Иргэд хоорондоо, иргэд, аж ахуйн нэгж банк болон ББСВ-тай зээлийн гэрээ байгуулан зээл авдаг. Эдгээр зээлийн гэрээ нь хуулийн дагуу барьцаа хөрөнгө нь зээлдэгчийн өөрийн өмчлөлийн хөрөнгө болох нь хангалттай нотлох баримтаар нотлогдож байвал иргэний хэрэг болон иргэний шүүхээр хянан шийдвэрлэгдсэн байна.

Иргэд хоорондын зээлийн гэрээ нь хуульд заасан гэрээний шаардлагыг биелүүлсэн бол, мөн амаар хэлцэл хийсэн тохиолдолд зээлдэгч зээл авснаа хүлээн зөвшөөрсөн, тэр нь нотлогдсон тохиолдолд иргэний журмаар хянан шийдвэрлэгдэж байна.

Дээрх хэргүүдэд дүгнэлт хийхэд гэрээний 2 тал, мөн гуравдагч этгээдтэй холбоотой зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбоотой нэхэмжлэлийг шууд иргэний журмаар хянан шийдвэрлэдэг харин олон холбогдогчтой мөн зээлдэгчийн барьцаа хөрөнгө өөрийн өмч мөн болох нь тодорхойгүй, аж ахуйн нэгж үүргээ гүйцэтгэж чадахгүй болох өөрөөр хэлбэл дампуурах, гэнэтийн хүчин зүйлсийн улмаас төлбөр төлж чадахгүй болсон тохиолдолд мөн иргэд хоорондын амаар хэлцэл хийсэн нь нотлогдохгүй байвал эрүүгийн хэрэг гэж үзэн хэргийг шилжүүлдэг байна. Энэ тохиолдолд хэрэгт авагдсан нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитой үнэлэх шаардлагатай.

Тухайлбал: Чингэлтэй дүүргийн шүүхийн 2008 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 537 дугаар шийдвэр, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн 2008 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 401 дүгээр магадлалтай, Ж.Т, Л.В-ын нэхэмжлэлтэй, Н.Ц-д холбогдох 6.911.300 төгрөг гаргуулах тухай иргэний хэргийг Улсын Дээд шүүх 2008 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр хэлэлцээд 391 тоот тогтоолоор давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

Анхан шатны шүүхийн шийдвэр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 116 дугаар зүйлийн 116.2-т заасан үндэслэл бүхий болж, зохигчдын хооронд байгуулагдсан гэрээний харилцаанаас үүссэн маргааныг үндэслэлтэй зөв шийдвэрлэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчөөгүй байна.

Харин давж заалдах шатны шүүх Иргэний хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1 дэх хэсэгт заасан үндэслэл тогтоогдохгүй гэж үзсэн нь үндэслэл муутай дүгнэлт болсон байна.

Зохигчдын хооронд 2003 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр байгуулагдсан зээлийн гэрээний ард 2004 оны 2 сарын 15-нд нэхэмжлэгч Л.В хариуцагч Н.Ц-д 4.000.000 төгрөгийг 2 сарын хугацаатай, 6 хувийн хүүтэй зээлсэн талаарх үйл баримтыг анхан

²⁸ УЕПГ 2009 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 1467 дугаар тушаал.

шатны шүүх үнэлэлдээ Иргэний хуулийн 281 дүгээр зүйлийн 281.1 дэх хэсэгт заасны дагуу зээлийн гэрээний харилцаа үүссэн гэж үзсэн. Энэхүү баримтад хариуцагч Н.Ц гарын үсэг зурж зөвшөөрсөн болох нь Шүүхийн шинжилгээний үндэсний төвийн Криминалистикийн хэлтэсийн шинжээчийн 2006 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 717, 2006 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 3031/3 тоот дүгнэлтүүдээр тогтоогдсоны дээр зээлдэгч энэ зээлийн гэрээний үүргийн дагуу 2004 оны 5 дугаар сарын 15-ны өдөр 240.000 төгрөг төлөгдсөн, үйл баримтын талаар маргаагүй байна.

Иймд зохигчдын хооронд зээлийн харилцаа огт үүсээгүй гэж үзэх үндэслэлгүй бөгөөд энэ талаар давж заалдах шатны шүүх дүгнэлт хийгээгүй, зөвхөн тухайн баримтыг үйлдсэн гэх өдөр буюу 2004 оны 2 дугаар сарын 15-ны өдөр хариуцагч Н.Ц нь Монгол Улсад байгаагүй болох нь Хил хамгаалах ерөнхий газрын 2008 оны 4 дүгээр сарын 21-ны өдрийн 1-6/1150 тоот албан бичгээр нотлогдсон гэж үзэж, Л.Б-оос хариуцагч Н.Ц мөнгө зээлээгүй гэсэн дүгнэлтийг хийсэн нь ойлгомжгүй болжээ.

Энэхүү шүүхийн дүгнэлтийн гол үндэслэл болсон дээрх албан тоотын хавсралт нь тухайн албан бичгийн хавсралт мөн болохыг нотолсон байгууллагын тэмдэглэгээгүй, нөгөөтэйгүүр зохигчдын үйлдсэн гэх баримтыг 2004 оны 2 дугаар сарын 15-ны өдөр хийснийг нотолсон баримт ч хэрэгт авагдаагүй байна.

Зээлдэгч зээл авсан тухайгаа нотолсон баримтыг хэдийд ч хийж болох бөгөөд огноог үнэн зөвөөр бичихгүй байх нь энэ нь үйл баримтын зөвхөн нэг хэсгийг тодорхойлохоос талуудын хооронд зээл авсан, аваагүй асуудлыг бүрэн үгүйсгэх баримтын хэмжээнд дүгнэхэд учир дутагдалтай болохыг шүүх анхаараагүй байна.

Иргэний хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2-д зааснаар “Хугацааг зайлшгүй бий болох үйл явдлаар тодорхойлж болно” гэсэн заалтыг давж заалдах шатны шүүх буруу тайлбарлан хэрэглэж, энэ хэргийн хүрээнд зөвхөн цаг хугацааг үйл явдлыг үгүйсгэх баримт болгосон дулимаг дүгнэлтийг хийжээ.

Хариуцагч Н.Ц шүүхэд гаргасан тайлбартаа Л.Б-оос мөнгө зээлсэн үйл баримтыг бүрэн үгүйсгээгүй, өөрийн ах Н.Ч-г зээл авахад зуучилсан гэсэн тайлбар өгч мэтгэлцсэний дээр түүний ах Н.Ч нь шүүх хуралдаанд гэрчээр оролцоходоо Л.Б-оос 4.000.000 төгрөг зээлсэн, энэ хэлцлийн талаар бичиг баримт үйлдээгүй гэдгийг ч хүлээн зөвшөөрсөн, гэрч Р.Э энэ асуудал үнэн болохыг нотлон гэрчилсэн байхад давж заалдах шатны шүүх орхисон байна.”

Зээлийн гэрээнээс үүдэлтэй маргааныг хянан шийдвэрлэхдээ анхаарах зүйлсийн талаар Улсын дээд шүүхээс зөвлөмж гаргасан байдаг. Үүнд:

- Нэхэмжлэлийн шаардлагыг зөв тодорхойлох, шаардлагын агуулгыг түүний үндэслэлтэй зөв уялдуулж үзэх шаардлагатай;

Зээлдэгчийн үүрэг биелүүлэх гэрээний хугацааг зөв тодорхойлох. Жишээ нь: Иргэний хуулийн 222 дугаар зүйлийн 222.5-д “хэтэрсэн хугацаанд тохирсон хүү” гэж тодорхойлогдсон ойлголтыг “тохирсон хүү” гэж буруу тайлбарлан хэрэглэсэн жишиг байна.

Хэтэрсэн хугацаанд тохирсон хүү заавал банкны хүү тооцдог журамд нийцсэн байх шаардлагагүйгээс гадна нэхэмжлэгчийн уг шаардлагыг хариуцагч няцаагаагүй тохиолдолд шүүх уг хүүгийн хэмжээг банкны журамд нийцүүлэх үүрэггүй болно. Нөгөө талаар нэхэмжлэгч хэтэрсэн хугацааны хүүг гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувьд дүйцүүлэн нэхэмжилсэн нь түүний эрх хэмжээний асуудал бөгөөд ийнхүү шаардах нь хууль зөрчөөгүй болно;²⁹

• Зээлийн болон барьцааны гэрээний хүчин төгөлдөр эсэхэд мөн дүгнэлт хийх шаардлагатай. Иргэний хуулийн 175 дугаар зүйлийн 175.1 “... ипотекийн зүйл болох үл хөдлөх эд хөрөнгийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан худалдана” өөрөөр хэлбэл, барьцааны гэрээ хүчин төгөлдөр эсэхэд шүүх дүгнэлт хийж, барьцааны эд хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай шийдвэр гарах ёстой;

• Үүрэг гүйцэтгэгч барьцаагаар хангагдсан үүргийг буюу гэрээнд заасны дагуу гүйцэтгээгүй бол барьцаалагч тэргүүн ээлжинд барьцааны зүйлээс шаардлага хангуулах эрх буюу үл хөдлөх хөрөнгийн барьцааны эрх үүссэнээр үүргийн гүйцэтгэлийг шаардах давуу эрх бий болдог байна.

Дээрх зөвлөмж нь Иргэний хуульд заасны дагуу зээлийн гэрээ болох нь хангалттай нотлогдож байгаа тохиолдолд мөн түүнийг шийдвэрлэх явцад үүсч болох бэрхшээлийг хэрхэн зохицуулах талаар гаргасан.

Шүүхийн шийдвэрийг уншиж судлах явцад шийдвэрийн үндэслэх хэсэгт ямар учраас зээлийн гэрээ, барьцааны гэрээ гэж үзсэн, ямар хүсэл зоригийн үндсэн дээр гэрээ гэж үзэж байгаагаа үндэслэх хэсэгтээ бичдэггүй нь “яагаад” гэсэн асуултыг байнга дагуулдаг учир дутагдалтай байна.

Эрүүгийн хуулийн 148 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах” гэмт хэргийг Иргэний эрх зүйн гэрээний харилцаанаас үүссэн маргаанаас ялгаж, зөв зүйлчлэхэд анхаарах зарим асуудлын талаар³⁰ тайлбарласан Улсын дээд шүүхийн тогтоол зарим нарийн ялгааг сайн гаргаж чадаагүй, чухам юуг гэрээгээр халхавчилсан залилан гэж үзээд нэрлээд байгаа нь тодорхойгүй. Зээлээ төлж чадахгүй эрсдэл үүссэн бүхэн гэрээгээр халхавчилсан залилан биш. Иргэний эрх зүйд өөр хэлцлийг халхавчлах зорилгоор хийсэн хэлцлийн халхавчилсан хэлцэл нь хүчин төгөлдөр бус харин

²⁹ Улсын дээд шүүхийн мэдээлэл. 2009 он, №2.

³⁰ “Улсын дээд шүүхийн тогтоолын эмхтгэл”. УБ., 2008 он, 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 51 дүгээр тогтоол.

даад хэлцэл нь хүчин төгөлдөр байдаг. Залилан мэхлэх гэмт хэргийг үйлдэхдээ иргэний эрх зүйн гэрээг ашиглан үйлддэг.

III бүлэг. Дүгнэлт, санал

Хуурч мэхлэх буюу итгэл эвдэх үйлдэл нь залилан мэхлэх гэмт хэргийн объектив тал бөгөөд тухайн гэмт хэргийн үндсэн шинжийн нэг болно.

Хохирогч ирээдүйд эд зүйлс, өмч хөрөнгөөрөө хохирохыг үл ухааран тэдгээрийг гэмт хэрэгтэнд сайн дураар шилжүүлдэг онцлогтой. Гэм буруутай этгээдээс хохирогчийг өөрийн эд хөрөнгөө сайн дураар өөрт нь шилжүүлэн өгөхөд хүргэсэн хуурч мэхлэх арга нь хуурамч бичиг баримт үйлдэх, иргэний эрх зүйн харилцаагаар халхавчилсан дүр үзүүлсэн гэрээ хэлцэл хийж хохирогчдын эд зүйлс, өмч хөрөнгийг өөрийн болгож авах эсвэл хохирогч итгэж үнэмшин өөрөө өмчөө шилжүүлэн өгөх нь залилан мэхлэх гэмт хэрэгт ашигладаг нэгэн арга юм.

Бусдын эд хөрөнгийг залилан мэхлэж авах гэмт хэрэг ба Иргэний хуулиар зохицуулсан цэргийн гүйцэтгэлээс цүссэн хэрэг маргаанаас ялгах нь:

Залилан мэхлэх гэмт хэргийг үйлдэхдээ иргэний эрх зүйн харилцааны зээлийн гэрээг ашиглан уг гэмт хэргийг үйлдэж байна. Гэхдээ залилан мэхлэх гэмт хэргийн объектив талын 1 шинж болох хуурч мэхлэх үйлдлийг иргэний хуулийн 59 дүгээр зүйлийн Хууран мэхэлж хийсэн хэлцлээс ялгаж харах шаардлагатай.

• Хууран мэхэлж хийсэн хэлцлийн үр дүнд эд хөрөнгийг хууран мэхлэгч этгээд өөртөө шилжүүлэн авсан тохиолдолд шударга бус эзэмшигч болдог. Хууль ёсны эзэмшигч нь шударга бус эзэмшигчээс Иргэний хуулийн 106 дугаар зүйлийн 106.1.-т заасны дагуу өөрийн өмчлөлийн зүйлээ шаардах эрхтэй байдаг. Харин гэм буруу нь эцэслэн шийдвэрлэгдээгүй байхад мөрдөн байцаалтын шатанд хохирлыг нөхөн төлүүлж байгаа нь гэм буруугүйн презумпцийн зарчимд карш хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны практик тогтсон байдаг. Энэ нь иргэний эрх зүйн маргааныг гэрээгээр халхавчилсан залилан гэж заргыг эрүүгийн журмаар хянан шийдвэрлүүлж хохирлыг албадан төлүүлэх гэсэн сонирхлын улмаас иргэний эрх зүйн маргааныг залилан мэхлэх гэмт хэрэг болгон шийдвэрлэж байна. Ингэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас гэсэн үндэслэлийн дагуу иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эрүүгийн хэрэг давхар үүсгэн шалгах хууль бус жишиг байгаа нь залилан мэхлэх

гэмт хэрэг болон иргэний эрх зүйн гэрээ, хэлцлийг өөрсдийн хүссэн эрх зүйн харилцаандаа хувиргаж байгаа нь энэ төрлийн гэмт хэргийг адилтгаж байгаа гол шалтгаан мөн;

• Улсын дээд шүүхийн тайлбарт буй “гэрээгээр халхавчилсан залилан” нь залилан мэхлэх гэмт хэргийг үйлдэхдээ гэрээний төрлийг ашиглаж үйлдэж байгаа аргыг тодотгож өгчээ. Гэрээний харилцаа нь 2 талын итгэлцэл байдаг. Итгэлцлийг алдаж, итгэл эвдсэн үйлдэл нь залилан мэхлэх гэмт хэрэг болохгүй. Учир нь зохих ёсоор гүйцэтгэх үүргээ хэрхэн биелүүлж байгаа болон түүнд хандаж байгаа хандлагаас шалтгаална. Тухайлбал, гэрээ анхнаасаа биелэгдэх боломжгүй, зээлийг буцааж төлөх бодит баталгаагүй, барьцааны хөрөнгөгүй, хөрөнгө нь эрхийн зөрчилтэй, тухайн эд хөрөнгийг барьцаалах бүрэн эрхгүй этгээд барьцаалсан, хуурамч бичиг, баримт ашиглан гэрээг байгуулсан үүнийг гэрээний нэг тал мэдсээр байж санаатайгаар нуун далдалж бусдын эд хөрөнгийг завшиж ашиглан хууль бусаар захиран зарцуулах эрх үүсгэдэг. Гэрээний үүргийн биелэлтийг үүрэг гүйцэтгэгч анхнаасаа биелүүлж чадахгүй, хангах боломжгүй байдлыг санаатайгаар нуун дарагдуулсан үүнийг гэрээний нөгөө тал мэдээгүй буюу мэдэх боломжгүй байдаг нь залилан мэхлэх гэмт хэрэг болно. Иргэний эрх зүйн хууран мэхэлж хийсэн хэлцэл нь тухайн гэрээ, хэлцлийг хийхдээ бодит байдлыг гуйвуулан тухайн этгээдийг төөрөгдүүлэн хэлцэл хийх эрх чөлөөг нь хязгаарладгаараа залилан мэхлэх гэмт хэргээс ялгаатай. Жишээ нь, санал бодол, үзэмж, байр суурь, зар сурталчилгаа, гоёж чимсэн магтаал эсхүл нийтлэг ариа, хэллэг орно. Өөрөөр хэлбэл мэхлэгдсэн этгээд хэлцлийн талаар төөрөгдсөн байдаг. Зээлийн гэрээ, зээлээр худалдах худалдан авах гэрээ, барьцааны гэрээний хувьд хуульд заасан зохих журмын дагуу байгуулагдсанаар үүргийн эрх зүйн харилцаа үүснэ. Үүрэг гүйцэтгэгч гэрээний үүргээ санаатай болон болгоомжгүй хэлбэрээр зөрчсөн тохиолдолд хуульд заасан хариуцлагын, өөрөөр хэлбэл, шаардах эрхийн хэмжээг нэмэгдүүлэх болон түүнийг хязгаарлах эсэхээ талууд чөлөөтэй тохиролцож болно.³¹ Энэ нь гэрээний чөлөөт байдлын зарчимтай холбоотой. Үүргээ биелүүлэх боломжгүй болох тохиолдол бүрийг анхаарах ёстой. Энд гэрээний ердийн эрсдэл, гэрээ байгуулагдсанаас хойш нөхцөл байдал ноцтой өөрчлөгдсөн, эсхүл энэ нөхцөл байдлын талаарх талуудын төсөөлөл буруу ташаа болох нь илэрхий болсон, үүрэг гүйцэтгэх хугацаа хэтрэх зэрэг нь үүрэг гүйцэтгэхэд учирсан нөхцөл гэж иргэний эрх зүйд үзэж үүнийг улмаас учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх үүсдэг онцлогтой;

• Залилан мэхлэх гэмт хэргийн гол онцлог нь гэмт этгээд бусдын эзэмшилд байгаа эд хөрөнгийг өөрийн мэдэлд авч, анхнаасаа эргэж хэзээ ч өгөхгүй гэсэн санаа бодол төрсөн байдаг боловч мөн гэрээгээр

³¹ “Иргэний хуулийн тайлбар”. Албан бус тайлбар. УБ., 2006 он, 846 дахь тал.

хүлээсэн үүрэг нь биелэгдэх боломжгүй болмогц түүгээр шалтгаглаж бусдын эд хөрөнгө, эсхүл түүнийг өмчлөх эрхийг бүгдийг буюу заримыг шилжүүлэхгүй байх гэмт санаа зорилго төрж, үүнийгээ хэрэгжүүлэхийн тулд эзэмшигч, өмчлөгчийг төөрөгдүүлэх замаар хуурч мэхлэх, итгэл эвдэх, тодорхой үйлдэл хийсэн нь хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны явцад тогтоогдвол залилан мэхлэх гэмт хэрэг гэж үзэж эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ³² гэж тайлбарласан байдаг. Доктор Д.Адьяасүрэн өөрийн бүтээлдээ залилан мэхлэх гэмт хэргийг иргэний эрх зүйн төстэй харилцаанаас ялгахад үйлдлийн арга биш субъектив санаа зорилгоор ялгаатай гэж үзсэн байдаг.

Санал, зөвлөмж

- Залилангийн хэргийг шалгахдаа иргэний эрх зүйн харилцаанаас үүссэн маргаан уу эсвэл залилан мэхлэх гэмт хэрэг үү гэдгийг тогтоохдоо эрх зүйн харилцаагаа зөв тогтоох шаардлагатай;
- Харилцаанд оролцогчдын санаа, зорилго, хүсэл зоригийг зөв тогтоох ёстой;
- Хэрэгт авагдсан нотлох баримтыг үнэлж шалгах шаардлагатай;
- Залилан мэхлэх гэмт хэргийг үйлдэхдээ ашигласан иргэний эрх зүйн гэрээ, хэлцлийг, иргэний эрх зүйн зээлийн гэрээ болон түүнтэй төстэй гэрээний харилцаа, хууран мэхэлж хийсэн хэлцлийг байгуулахдаа хандсан субъектив санаа зорилго, сэдэлтийг нарийн тогтоох ёстой;
- Гэрээний харилцааны гол анхаарах зүйлс нь гэрээ байгуулах үе шат, түүнийг байгуулах үеийн гэрээний талуудын үйлдэл, үйл явц буюу объектив байдалд үнэлэл дүгнэлт өгөх ёстой;
- Залилан мэхлэх гэмт хэргийг үйлдэхдээ гэрээ ашиглан үйлдсэн болохыг хэрэгт авагдсан нотлох баримтаар шалгах хэрэгтэй.
- Анхаарах зүйлс: Ихэнх зээлийн гэрээг банк болон санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдтэй байгуулж байгаа учраас энэ тал дээр анхаарч ажиллаж зөв үнэлэлт өгөх шаардлагатай.

³² Улсын Дээд шүүхийн 51 дүгээр тогтоолын 7 дугаар хэсэг.

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ГАДААД ОРНУУДЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БҮТЭЭЛЧЭЭР АШИГЛАЯ



УИХ-ын тамгын газрын
ажилтан, хууль зүйн
доктор, профессор
Л.Батжав

Авлигатай тэмцэх үйл хэрэг нь нийгмийн олон талт харилцааг хамарсан иж бүрэн цогц арга хэмжээ бөгөөд үүний нэг салшгүй хэсэг нь төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх явдал юм. Энэ үзэл санааг манай улсын нийгэм, улс төрийн бүхий л хүрээнд бүрэн дүүрэн ойлгож, хүлээн зөвшөөрч байгааг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Ашиг сонирхлын зөрчлөөс болж эдийн засаг, үндэсний аюулгүй байдал, шүүн таслах ажиллагааны эсрэг болон бусад олон төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлдэгддэг учраас ашиг сонирхлын зөрчлийг зөвхөн авлигатай холбож үзэх нь учир дутагдалтай

байна. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд Авлигатай тэмцэх газраас гадна Эрүүгийн цагдаагийн газрын Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Тагнуулын ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Мөрдөн байцаах алба, татварын болон төрийн бусад байгууллага идэвхи санаачилгатай оролцох ёстой. Асуудал ийм өргөн утгаар тавигдаж байгааг үндэслэн төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхлыг нийтийн ашиг сонирхолд захируулах нийгмийн бодит шаардлага урган гарч байна. Энэ шаардлагын үүднээс Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаад багагүй хугацаа өнгөрч байгаа боловч чимээ сураг алга л байна. Энэ хуулийн төсөлтэй холбогдуулж гадаад орнуудад тухайн асуудлыг зохицуулдаг зарим хууль тогтоомжоос танилцуулах нь зүйтэй болов уу гэж үзлээ.

Аливаа өндөр зэрэглэлийн албан тушаалтан, төрийн албан хаагчийн ашиг сонирхлын зөрчлийг шийдвэрлэх асуудал дэлхийн бүх улсад нэн чухалд тооцогдож байна. Энэ асуудлыг шийдвэрлэх үндсэн зорилт нь төрийн удирдлагын үр нөлөөг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн ашиг сонирхлын зөрчлийг арилгах явдал мөн боловч хэрэгжиж байгаа байдал, гарч байгаа үр дүн нь улс орон бүрт өөр өөр байна.

Нэг. НҮБ-ын хууль тогтоомжийн талаар

1. НҮБ-ын дүрмийн 101 дүгээр зүйлд төрийн захиргаа ба удирдлагын дараахь гурван тулгуур зарчмыг тунхагласан байдаг. Нэгдүгээрт, тууштай шударга байх зарчим. Ардчилсан нийгэмд төрийн алба

нийтийн итгэл дээр оршдог гэсэн зүй тогтол үйлчилдэг. Төр, засаг ард түмний итгэлийг олж авахын тулд төрийн албан хаагчдын ярьсан, хэлсэн зүйл нь хийж, бүтээж байгаа зүйлээс зөрөхгүй байх ёстой. Нөгөө талаар, төр дэвшүүлсэн зорилтоо бодитой хэрэгжүүлэхээс гадна элдэв шалтаг, шалтгаан тоочиж зорилтоосоо ухрах явдал гаргахгүйг хатуу цээрлэх ёстой. Хоёрдугаарт, төрийн байгууллагын үйл ажиллагаа ил тод, тунгалаг байх зарчим. Төрийн албан хаагчийн хариуцлагыг шаардлагын хэмжээнд байлгах үндсэн арга бол түүнийг томилох, ажиллуулах үйл явц, мөн түүний шийдвэр гаргах, үүрэг даалгавар биелүүлэх зэрэг бүхий л үйл ажиллагааг нийтэд ил тод байлгах явдал юм. Үүний тулд төрийн байгууллагуудад нийтэд нээлттэй байх зарчим үйлчилнэ. Гуравдугаарт, төрийн байгууллага үйл ажиллагаагаа нийтийн өмнө нээлттэй тайлагнаж, үр дүнгийнх нь төлөө хариуцлага хүлээх зарчим. Төрийн бүх шатны байгууллага болон албан хаагчид өөрийн ажлын үр дүнг ард түмнээр үнэлүүлэн дүгнүүлж, олон нийтийн хяналтын дор ажиллах ёстой. Энэ зарчим амьдралд хэрэгжсэнээр төр, засаг тууштай шударга байж чадаж байгаа эсэх нь тодорно. Энэ гурван зарчмыг олон улс оронд төрийн захиргаа, удирдлагын тулгуур зарчим гэж үзэж Үндсэн хууль болон бусад хуульдаа тунхаглан заасан байдаг.

2. НҮБ-ын Ерөнхий Ассамблей 1996 онд "Нийгэм, төрийн албан тушаалтны ёс зүйн олон улсын хууль"-ийг баталж мөрдүүлсэн байна. Уг хуульд зааснаар төрийн албан хаагч нь ашиг сонирхлын зөрчилд өртөхгүйн тулд хэрхэн яаж ажиллах талаар тодорхой заасан байна. Үүнд:

1. Төрийн албан тушаалтнууд өөрийн чиг үүргээ биелүүлэх, түүний дотор олон нийттэй анхааралтай, шударга алагчлахгүй харилцах ёстой. Тэд аливаа этгээд болон бүлэг этгээдэд хууль бус дарамт шахалтыг ямар нэгэн хэлбэрээр үзүүлэхгүй байх, ямар нэгэн этгээд, бүлэг этгээдийн эсрэг хандахдаа ялгаварлан гадуурахгүй байх буюу өөрт олгогдсон эрх мэдэл, бүрэн эрхээ өөр бусад байдлаар хэтрүүлэхийг хориглоно;

2. Төрийн албан хаагч албан тушаалаа өөрийн ба гэр бүлийнхээ тусын тулд хувийн ашиг хонжоо, санхүүгийн орлого олох зорилгоор ашиглах ёсгүй. Тэд өөрсдийн албан тушаал, томилгоо, эрх үүрэгт үл нийцэх аливаа гэрээ хэлцэлд оролцох, ямар нэгэн албан тушаал давхар эрхлэх, үүрэг гүйцэтгэхээс татгалзахын зэрэгцээ санхүү, арилжаа наймаа болон түүнтэй төстэй ашиг сонирхол тэдэнд байх учиргүй;

3. Албан тушаал ямар нэгэн байдлаар албан хаагчийг хариуцлагажуулна. Төрийн албан хаагч төрийн хууль, захиргааны дүрэм, журмын дагуу ажил хэрэг, арилжаа наймаа, санхүүгийнхээ ашиг сонирхол, эсвэл ашиг сонирхлын зөрчилд хүргэж болзошгүй санхүүгийн ашиг олох зорилго бүхий үйл ажиллагааныхаа тухай мэдээлдэг. Түүний албан үүргийн болон

хувийн ашиг сонирхлын хооронд зөрчил үүсч болзошгүй, эсвэл тийм санал ирсэн тохиолдолд ашиг сонирхлын зөрчлийг багасгах буюу арилгахын тулд зохих дүрэм, журмын дагуу зохицон ажиллах шаардлага гарна;

4. Төрийн албан хаагч хэзээ ч төрийн сан хөмрөг, өмч, үйлчилгээ ба албан үүргээ гүйцэтгэх болон гүйцэтгэсний үр дүнд олж авсан мэдээллийг өөрийн үүрэгтэй холбоогүй үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд ашиглаж болохгүй;

5. Төрийн албан хаагч албан тушаалаасаа халагдсаны дараа урьдах албан тушаалаа хортойгоор ашиглахгүй байхын тулд хууль, захиргааны дүрэм, зааврын дагуу ажиллах ёстой;

6. Төрийн албан хаагч эрхэлж буй албан тушаалынхаа дагуу хууль, дүрэм, зааврыг үндэслэн хувийн болон боломжоороо гэр бүлийнхээ (эхнэр, нөхөр) хөрөнгө, орлого, зээлийн тухай мэдээлэх үүрэгтэй;

7. Төрийн албан хаагч хүлээсэн үүргээ биелүүлэх, албан тушаалаа хэрэгжүүлэх, эсвэл шийдвэр гаргахад нөлөөлөхүйц ямар ч бэлэг дурсгал, анхаарал татсан бусад эд зүйлийг шууд ба шууд бус аргаар авах, үйлчилгээ хийлгэхээс татгалзана.

3. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанаар баталсан “НҮБ-ын Авлигын эсрэг конвенци”-д ашиг сонирхлын зөрчилд хаалт тавих (хориглох, хязгаарлах гэх мэт) асуудлыг илүү тодорхой тусгасан байдаг. Энэ нь зөвхөн албан тушаалтан, төрийн албан хаагчид төдийгүй уг конвенцид нэгдсэн оролцогч улс бүрт хамааралтай ажээ. Тус конвенцид зааснаар:

1. Оролцогч улс бүр өөрсдийн хууль тогтоомжийн үндсэн зарчмын дагуу төрийн албыг тунгалаг байлгах тогтолцоог бүрдүүлж, дэмжин бэхжүүлэхийг эрмэлзэж, ашиг сонирхлын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх ёстой;

2. Оролцогч улс бүр өөрийн орны хууль тогтоомжийн үндсэн зарчмын дагуу албан тушаалтнууд албан үүрэгт нь харшилж, ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй албан бус үйл ажиллагаа, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалт, орлого, томоохон бэлэг дурсгалын зүйл, ашгийнхаа тухай мэдүүлгийг зохих байгууллагуудад өгч байх талаар үүрэг амлалт авахуйц тогтолцоо, арга хэмжээг хэрэгжүүлэхийг эрмэлзэх хэрэгтэй;

3. Оролцогч улс орон бүр өөрийн хууль тогтоомжийн дагуу тухайн зүйл ангиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн төрийн албан тушаалтанд сахилгын болон бусад арга хэмжээ авах боломжийг авч үзэх хэрэгтэй.

Монгол Улс 2005 онд НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид нэгдэн орсноор уг конвенциэр хүлээсэн үүргээ шударгаар сайн биелүүлэх ёстой бөгөөд тус конвенци нь манай улсын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилж байгаа билээ. Энэ конвенцид: “Улс орны авлигатай тэмцэх бодлого, үйл ажиллагаа нь хууль дээдлэх, төрийн удирдлагыг

ээв зохистой явуулах, тууштай шударга, ил тод, хариуцлагатай байх зарчмууд дээр тулгуурлах ёстой” гэж заасан байдаг. Монгол Улс НҮБ-ын Авлигын эсрэг конвенцийн зарим зүйл, заалтад дурдсанаар нэгд, нийгмийн оролцоог дэмжсэн, хуулийг дээдлэх ёс, төрийн үйл хэрэг болон төрийн өмчийг зохистой удирдаж хөтлөх, шударга байх, ил тод байх, хариуцлага хүлээх зарчмуудыг илэрхийлсэн үр нөлөөтэй, уялдаатай авлигын эсрэг бодлого боловсруулж хэрэгжүүлэх ёстой. Хоёрт, төрийн албан тушаалтныг ажилд авах, сонгон шалгаруулах, алба хаах, албан тушаал дэвших, чөлөөлөхөд ил тод байх, эрх ашгийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэхэд дөхөм болох тогтолцоог бий болгох, бэхжүүлэх үүрэг хүлээлгэсэн. Гуравт, төрийн албан тушаалтан өөрийнх нь чиг үүргийн хувьд эрх ашгийн зөрчил үүсгэж болох албан үүргээс гадуурх үйл ажиллагаа, ажил эрхлэлт, хөрөнгө оруулалт, эд хөрөнгө, чинээлэг бэлэг буюу давуу талыг холбогдох байгууллагад тайлагнаж байх систем болон арга хэмжээг тогтоох ёстой. Дөрөвт, төрийн байгууллагыг төлөөлж бараа, үйлчилгээ худалдан авахад оролцож байгаа төрийн албан хаагч тухайн үйл ажиллагаатай холбоотой ашиг сонирхлоо мэдээлэх, энэ мэдээллийг шалгах зэрэг асуудлыг зохицуулсан байна. Тавд, ашиг сонирхлын зөрчил гаргахгүй байх үүднээс төрийн албан тушаалтан этгээдийг шаардлагатай гэж үзвэл тодорхой хугацаанд мэргэжлийн чиглэлээр нь, эсвэл түүнийг огцорсон буюу тэтгэвэрт гарсны дараа хувийн хэвшилд ажиллахад хориг тавих шаардлагатай. Эдгээрийг манай улс хууль тогтоомждоо тусгах, биелүүлж ажиллах үүрэг хүлээсэн байдаг.

Хоёр. Европын Холбооны хууль тогтоомжийн талаар

Европын холбоо 2000 онд “Нийгэм, төрийн албан тушаалтны ёс зүйн загвар хууль”-ийг батлан мөрдүүлжээ. Энэ хууль нь албан хаагчдын ашиг сонирхлын болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үүнтэй холбогдож үүссэн асуудлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлийг таслан зогсооход чиглэгдсэн байна. Ашиг сонирхлын зөрчил төрийн албан хаагч албан тушаалын эрх мэдлээ бодитойгоор, чин сэтгэлээсээ шударгаар биелүүлэхэд сөргөөр нөлөөлөх, эсвэл нөлөөлж болзошгүй хувийн ашиг сонирхолтой байгаа тохиолдолд үүсдэг. Төрийн албан хаагчийн хувийн ашиг сонирхол нь өөртөө болон гэр бүл, төрөл төрөгсөд, найз нөхөд, ойр дотныхондоо болон ажил хэргийн ба улс төрийн талаар харилцаатай этгээд, байгууллагад ашигтай байхад оршдог. Мөн түүнчлэн ашиг сонирхлын зөрчилд төрийн албан хаагчийн бүх төрлийн зээл хамаарагддаг болохыг тус тус онцлон тэмдэглэсэн байна. Ашиг сонирхлын зөрчлийн талаар, уг зөрчилд орсноо мэдсэн төрийн албан хаагч нөхцөл байдлыг харгалзан үзээд хэрхэх ёстойг зааж дараахь чиглэл өгсөн байна. Тухайлбал:

• Ашиг сонирхлын зөрчил бодит зүйл болсныг онцгой анхаарах;

- Ашиг сонирхлын зөрчил гаргуулахгүй байх арга хэмжээ авах;
- Ашиг сонирхлын зөрчил болсон нь мэдэгдсэн тохиолдолд дээд шатны даргадаа мэдэгдэх;
- Ашиг сонирхлын зөрчлөөс бий болох ашгаас татгалзах, эсвэл түүнд орсон нөхцөл байдлаас гарахыг шаардсан эцсийн шийдвэрт захирагдах;
- Хэрвээ шаардлагатай бол төрийн албан хаагч ашиг сонирхлын зөрчил байгаа үгүй эсэхийг мэдэгдэх.

Үүнээс гадна захиргааны байгууллагын төрийн албаны шинэ албан тушаалд нэр дэвшиж байгаа хүн тухайн албан тушаалд томилогдохын өмнө өөрийн ашиг сонирхлын зөрчлийн асуудлыг зохицуулсан байх ёстой. Хэрвээ төрийн албан хаагчийн албан тушаал хувийнх нь ашиг сонирхлыг хөндөж байвал хуулийн дагуу албан тушаалд томилогдох, томилогдоод хэсэг хугацаа өнгөрсний дараа нөхцөл байдал өөрчлөгдсөн үед дээрх ашиг сонирхлын шинж байдал, цар хүрээ хэрхэн өөрчлөгдсөн тухайгаа мэдэгдэх үүрэгтэй.

Мөн түүнчлэн төрийн албан хаагчид албаны үүргээ гүйцэтгэхэд нь зохицохгүй, эсвэл өөрт нь хор хохирол учруулахуйц ажил хөдөлмөр эрхлэх, үйл ажиллагаа явуулах, өөр албан тушаалд ажиллахыг хориглодог. Төрийн албан хаагчийн ямар нэгэн үйл ажиллагаа төрийн албатай зохицож байгаа эсэх нь тодорхойгүй үед шууд захирах даргынхаа санал бодлыг сонсох ёстой. Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг харгалзан үзэж, үйл ажиллагааныхаа зарим төрлийг хэрэгжүүлэх, төрийн албаны бус ямар нэгэн албан тушаалд ажиллахын өмнө төрийн албан хаагч энэ тухай төрийн албаны ажил олгогчдоо мэдээлж, түүнтэй тохиролцох үүрэгтэй. Төрийн албан хаагч өөрийн албаны болон төрийн албан хаагчийн хувьд оногдсон үүргээ гүйцэтгэхэд хор хохирол учруулж болзошгүй намын гишүүнчлэл, аливаа нэг байгууллагад харьяалагддаг асуудлаа хуульд заасан шаардлагын дагуу шийдвэрлэх ёстойг зохицуулсан байна.

Төрийн албан хаагч улс төрийн буюу олон нийтийн үйл ажиллагаанд оролцоходоо хэрхэн ажиллах талаар ч дээрх хуульд заасан байна. Үүнд:

1. Төрийн албан хаагч Үндсэн хуулиар олгогдсон үндсэн эрхээ хэрэгжүүлж улс төрийн үйл ажиллагаанд болон олон нийтийн дунд зохиож байгаа энэ чиглэлийн ярилцлага, мэтгэлцээнд оролцоходоо энэ хүн өөрийн хариуцсан ажил, оногдсон үүргээ үнэнч шударгаар биелүүлэх чадвартай юм уу, үгүй юу гэсэн эргэлзээнд иргэдийг, эсвэл ажил олгогчийг оруулахгүй байх ёстой;
2. Төрийн албан хаагч албан тушаалын үүргээ биелүүлэхдээ ямар нэгэн улс төрийн зорилгод үйлчлэх ёсгүй;
3. Төрийн албан хаагч улс төрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ төрийн зарим албан хаагчдад хамааралтай, хуульд заасан хязгаарлалтыг чанд сахин биелүүлэх үүрэгтэй.

Энэ бүхнээс үзэхэд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулсан гадаад орнуудын хууль тогтоомж хангалттай байгаа төдийгүй НҮБ-ын гишүүн орны хувьд Монгол Улс тус байгууллагын дүрэм, баталж мөрдүүлсэн хуульд өөрийн орны хууль тогтоомжийн үзэл санааг нийцүүлэх, байхгүй зарим хуулийг яаралтай баталж гаргах замаар дэлхий нийтийн жишигтэй хөл нийцүүлэн урагш хөгжих ёстой.

Төрийн алба мөн чанараараа орших гол нөхцөл бол ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх явдал мөн. Гэтэл манай улсын хувьд эсрэгээр нь болох гээд байна гэхэд нэг их буруудахгүй болов уу. Тухайлбал, эрх бүхий байгууллагын шийдвэр, аливаа албан тушаалын томилгооны цаана тодорхой хувь хүн, хэсэг бүлэг хүмүүсийн ашиг сонирхол ямагт сүүдэр мэт дагалдах болсон нь нууц биш ээ. Тэр ашиг сонирхол нь тухайн эзэндээ хэмжээлшгүй их ач тусаа өгч, харин нийтийн ашиг сонирхлыг тэр хэмжээгээр зөрчих төдийгүй улсын эрх ашигт үлэмж хохирол учруулсаар байна. Үүний нэг гол илрэл нь хууль тогтоомж батлахад тодордог. Тухайлбал, Үндсэн хууль зөрчсөн хууль батлах явдал одоо бараг ердийн үзэгдэл болох гээд байгааг зориуд тэмдэглэх хэрэгтэй. Жишээ нь, хувь хүн, хэсэг бүлэг хүмүүс, улс төрийн намын явцуу ашиг сонирхлыг хамгаалсан хууль гаргаснаар төр нь ашиг сонирхлын зөрчлийг өөгшүүлэн газар авахуулах эх суурь болж байна. Аливаа хууль бол хууль ёсны хамгаалалтад байх ёстой хувь хүн, хамт олон, байгууллага, аж ахуйн нэгжийн эрхийн нийлбэр цогц байх ёстой.

Алийн болгон хэн нэгний, хэсэг бүлгийн эрх ашгийг хамгаалсан хууль гаргах вэ, эрхэм төрийн түшээд ээ. Та бүгдийн сэтгэлд ёс зүй, ёс суртахуун гэж байдаг бол, шударга ажиллах, шударга байх чин эрмэлзлэл байдаг бол эх орныхоо хөгжилд, ард түмнийхээ амьдралд нэн хэрэгтэй, зайлшгүй шаардлагатай, монгол хөрсөн дээр боловсорч хэрэгжих урт настай, хэнд ч хоёрдмол ойлголт өгөхөөргүй боловсронгуй хууль гаргаж хэрэгжүүлмээр байна, биелэлтэд нь тавих хяналтыг тогтмолжуулмаар байна, улсынхаа хуулийг хүндэлж хэрэглэдэггүй, тоож биелүүлдэггүй албан тушаалтанд эрх мэдэл, эд хөрөнгийг нь харгалзахгүйгээр хариуцлага тооцож сурмаар байна.

Энэ арга хэмжээг хэрэгжүүлэхэд Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль батлан гаргах нь чухал болно. Тиймээс нэгдүгээрт, дээрх хуулийг яаралтай хэлэлцэн баталж мөрдүүлэх нь нийтийн эрх ашигт нийцэх болно. Хоёрдугаарт, төрийн өндөр албан тушаалтнууд хэн нэгний юмуу, хэсэг бүлгийн эрх ашигт үйлчилж олон түмний дунд авлига, хээл хахуульд өртдөг гэсэн хардлагад хамрагдаж муу нэр зүүмээргүй байх нь илүү чухал мэт санагдана.

Ашиг сонирхлын зөрчлөөс аль болох ангид байхын тулд аль ч зэрэг зиндааны төрийн албан хаагч, удирдах ажилтан шударга төвшин байцгаая, шударга ажиллаж амьдарцгаая гэсэн хатуу шаардлагыг тавихаас өөр аргагүй болоод байна.

АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН НИЙГМИЙН ЁС СУРТАХУУНААС ҮҮДЭЛТЭЙ ШАЛТГААН



Улсын ерөнхий
прокурорын туслах,
Мэдээлэл дүн
шинжилгээ, судалгааны
төвийн захирал
Г.Ганзориг

Ашиг сонирхлын зөрчлийн тоо хэмжээ, чанар (зэрэглэл)-ын үзүүлэлт, түүний нийгэмд учруулж байгаа хор аюулын байдал нь төрийн захиргааны байгууллагын удирдах ажилтан, албан хаагч болон жирийн иргэдийн ёс суртахуун, хүний мөсийг илэрхийлэх чухал хэмжүүр болно. Тиймээс ашиг сонирхлын зөрчлийн шалтгааныг нийгмийн ёс суртахууны байдал, үнэлэмжээс хайх хэрэгтэй.

1. Манай ард түмэн олон зуун, олон мянган жилийн турш төрөө дээдлэн шүтэж, төрийн албыг хүндэтгэн хамгаалж ирсэн баялаг уламжлал, зан заншлын өндөр соёлтой. Хэрвээ энэхүү уламжлал, зан заншил, ёс зүйн хэм хэмжээ, үнэлэмжийн эерэг чиг баримжаа алдагдах юм бол нийгэм

бүхэлдээ ёс суртахууны доройтолд орох аюултай. Мөн түүнчлэн улс орны эдийн засгийн амьдрал, эрх зүйн зохицуулалт, улс төрийн бодлого хэзээ ч нийгмийн ёс суртахуунаас ангид байгаагүй тул эдгээр асуудлыг цогцоор нь судлах шаардлагатай байна. Нөгөө талаар дээр үеэс төрөө хүндлэн дээдэлж ирсний нэг баталгаа бол хот, хөдөөгүй, хөгшин залуугүй, “Төрийн минь сүлд өршөө” гэж залбирч, мөнх хөх тэнгэртээ цайныхаа дээжийг өргөдөг байсан. Гэтэл сүүлийн үед энэ хүндэтгэл алдагдах аюул нүүрлээд байна. Яагаад гэвэл УИХ-ын чуулганы үеэр эрхэм түшээдийн гаргаж байгаа ааш араншин, харилцааны соёлгүй байдал, сайд, дарга нарын албан тушаалын төлөөх тэмцэл, хий хоосон амлалт, өөрийгөө дөвийлгөсөн бардамнал олон түмний дургүйцлийг төрүүлж, төрдөө итгэх итгэлийг алдагдуулж байна. Дээрээ суудлаа олохгүй бол доороо гүйдлээ олохгүй гэгчээр ёс суртахууны хэм хэмжээ, хүний мөс чанарыг дээд түвшинд юуны өмнө төлөвшүүлэх шаардлагатай байна. Ийм төлөвшил байхгүйгээс ашиг сонирхлын зөрчил дээрээс эхэлж үндэслээд байгааг шударгаар хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Ургаж байгаа, ургахаар тэмүүлж байгаа ашиг сонирхлын зөрчлийн үндсийг нийгмийн бусад давхаргад хаван орж бэхжихээс нь өмнө, тал тал тийш салаалж нийтийг хамрахаас нь өмнө тайрч багасгах, таслан хаях шаардлагатай байна.

2. Хувь хүн, төрийн захиргааны байгууллагын удирдах ажилтан, албан хаагчийн ёс суртахуун, хүний мөс нь нийгмийн

баялгийг өсгөн арвижуулах, шударгаар хуваарилах, улс орны хөгжлийг урагшлуулах асуудалд ихээхэн нөлөө үзүүлнэ. Эдийн засаг нь өргөн утгаараа хүн амын амьжиргааны хэрэгцээг хангах зорилтыг хэрэгжүүлдэг. Гэтэл хэсэг бүлэг хүмүүс үндэслэлгүй баяжих, иргэдийн олонхи нь ядууралд орох зэргээр эдийн засгийн хөгжилд гажуудал үүсч, ёс суртахуунгүй үзэгдлийг улам тэтгэн даамжруулах нөхцөлийг бүрдүүлж байна. Нийгмийн хүрээнд хүмүүсийн тэгш бус байдал, амар хялбар аргаар ажил бүтээх, хөрөнгө хуримтлуулах хүсэл тэмүүлэл хүний эрх, ашиг сонирхлыг төдийгүй манай төрийн албаны ёс зүйг бүдүүлгээр зөрчиж байна.

Удирдах ажилтан, төрийн албан хаагчийн ёс суртахууны талаар философийн ухааны доктор, ахмад дипломатч, сэхээтэн, судлаач Д.Өлзийсайхан “Үнэн” сонин (2008.08.29, □170)-д нийтлүүлсэн “Удирдлагын сэхээтэн: бодол, эргэцүүлэл” өгүүлэлдээ: “Нийгэм, ард түмнийхээ өмнө онцгой үүргийг хүлээсэн субъект бол удирдлагын сэхээтэн бөлгөө. Эх орон, ард түмний хувь заяа өөдрөг сайн сайхан байх нь тэдний оюун, арга ухаан, хүнлэг, соёлч, шударга, үнэнч, зарчимч төрх, даруу зан төлөв гээд олон сайхан шинж чанараас шууд хамаардаг ажээ. Удирдах ажил, албан тушаалд томилохдоо нэгд, боловсролын диплом, хоёрт, ёс суртахууны шинж байдлыг харгалздаг. Тэгвэл одоо гадаадын зарим оронд хоёрдахь нь буюу ёс суртахууны шинж чанар өндөр байх ёстойг тэргүүн шалгуур болгон авч үздэг болсон тухай олон улсын эрдэмтэд бичжээ. Энэ нь сэхээтний ёс суртахуун ямагт цэвэр, ариун байх ёстойн чухлыг нийгмийн практик өгүүлж буй хэрэг билээ. Бодох ёстой л зүйл” гээд цааш нь ийнхүү сэхээтэн нь “Нийгэмд тодорхой байр суурь эзэлсэн, нарийн төвөгтэй, хүнд хэцүү оюуны хөдөлмөрийг давамгайлан эрхэлдэг, дотоод соёл, ёс суртахууны өндөр шинж чанарыг эзэмшсэн хэсэг бүлэг хүмүүс” гэж тодорхойлсон байна. Зах зээлийн ороо бусгаа энэхүү цаг үед удирдах ажилтан (удирдлагын сэхээтэн), төрийн албан хаагч (сэхээтэн)-ийн бүтэц бүрэлдэхүүнд ч, хүн чанарын үзүүлэлтэд ч багагүй өөрчлөлт гарч, тэр хэмжээгээр олон түмнээс шүүмжлэл хүлээх нь нэмэгдсээр байна. Тухайлбал, эрх мэдэлтэн, дарга, түшмэлүүдийн дунд шаталсан захиран тушаах ёс, явцуу хүрээ газар авч, өгөө аваа, хээл хахууль байх ёстой юм шиг ердийн, хэвийн үзэгдэл мэт болж, нийгмийн амьдралын хүрээг хамарсан том сүлжээ үүсгэснээр ард түмний бухимдлыг төрүүлж, нийгмийн ядуурлыг гааруулах болов. Ингэснээр дээдсийн хүрээллийнхнээс сэхээтэнд зайлшгүй байвал зохих ёс суртахууны болон ажил хэрэгч, зарчимч, шударга, хүнлэг ёсны зэрэг аль эерэг шинж чанар улам бүдгэрэн холдож байна.” гэж харамсан бичсэнийг анхаарахгүй өнгөрч болохгүй. Энэ нь яван явсаар газар авч хүмүүсийн ёс суртахууныг нэлэнхүйд нь доройтуулах аюултай

тул шат шатандаа хянуур нямбай ажиллах шаардлагатай байна;

3. Эрх зүйн зохицуулалт боловсронгуй бусаас шалтгаалж иргэн ч, төрийн албан хаагч ч ёс суртахууны хэм хэмжээг зөрчиж, хүний мөс чанараа алдах тохиолдол хоёр байдлаар гардаг нь ажиглагдсан. Нэгдүгээрт, мөрдөж байгаа эрх зүйн актаа зөрчиж байна. Яагаад гэвэл эмнэлэг, барилга, соёл, боловсрол, халамж, нийгмийн хамгаалал гээд төрийн үйлчилгээтэй холбоотойгоор яам, агентлагийн сайд, дарга нарын баталж мөрдүүлсэн дүрэм, журам, заавар зэрэг нийтлэг хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актууд шат дамжлага олонтой, хэт их чирэгдэлтэй байгаа нь хүмүүст түүнийг тойрч гарах хялбар арга замыг хайх, олон саад давааг алгасч товчлохыг урьтал болгодог зуршил тогтоогоод байна. Хоёрдугаарт, хамтран ажиллах, харилцан туслахтай холбогдсон баримт бичиг боловсруулах, эсвэл ажил, үйлчилгээ эрхлэх эрх авахын тулд хууль тогтоомж зөрчих явдал гаргадаг. Тухайлбал, гэрээ, контракт байгуулахдаа давуу эрх, ялимгүй илүү байдал өөртөө бий болгох, зарим нэг нь тендерт өрсөлдөх явцдаа ялж дийлэхийн тулд хууль бус арга хэрэглэх зэргээр мөн л ашиг сонирхлын зөрчилд хутгалдаж эхэлдэг байна. Энэ нь өнгөц харахад аргагүйн эрхэнд хийж байгаа мэт харагдавч үнэн хэрэг дээрээ олдсон боломжийг далимдуулан ашиглах муу аргад суралцахаар бэлтгэж байгаа, зарим нь бэлтгэлээ дуусгаад үндсэн ангид нь дэвшин орж суралцаж байгаа гэсэн үг юм. Тиймээс иргэдийн хувьд ч, төрийн албан хаагчийн хувьд ч иймэрхүү өө сэв, давхардал, хийдлийг ашиглаж чадахгүйгээр хууль тогтоомжийг нягт нямбай, илүү дутуу ойлголт өгөхөөргүй, хэрэглэж мөрдөхөд товч тодорхой, улам боловсронгуй болгохыг өнөөгийн цаг үе нэхэл хатуутай шаардаж байна.

ХОРИХ АНГИ БА ГЯНДАНГИЙН ТАЛААРХИ ПРАКТИК ОЙЛГОЛТ

Хуулийн зүйл анги хэсэг бүрийг амьдралд хэрэглэж чаддаг хүнийг хуульч гэх нь олонтаа. Тэгвэл уг хууль нь өөрөө хоёрдмол санаагүй, нэг мөр ойлгогдохоор, хоорондоо утгын зөрчилдөөнгүй байх ёстой. Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хорих анги болон гяндангийн талаархи заалт, тэдгээрийг практикт хэрэгжүүлж буй процессыг харьцуулан судлахад анхаарал татсан зүйл цөөнгүй байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн Ерөнхий ангийн 52 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг энэ хуульд заасан хугацаагаар эрх чөлөөг нь хязгаарлаж, нийгмээс тусгаарлан хорих анги, гянданд байлгахыг хорих ял гэнэ” гэж тодорхойлсныг үзэхэд хорих ял шийтгүүлдсэн этгээдийг хоёр өөр газар буюу хорих анги, гяндан хэмээх тусдаа объектод хорих ялыг эдлүүлж болохоор заажээ.

Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 105 дугаар зүйлд: “Хорих байгууллага нь баривчлах байр, насанд хүрээгүйчүүдийн болон насанд хүрэгсдийн хорих анги, гяндан (цаашид “хорих анги” гэх) тэдгээртэй адил дэглэм бүхий байгууллагаас бүрдэнэ” гэсэн нь гяндан Эрүүгийн хуульд заасан хорих ангитай яг ижил утгыг агуулсан байгаа нь цаашид гарах сөрөг үр дагаврыг бий болгосон байна. Тухайлбал: гянданг хорих ангийн нэг адил болгож ангийн дугаар олгож (405 дугаар анги г.м) нэрлэсэн, түүнд ял эдэлж байгаа ялтныг хорих ангийн “гяндангийн дэглэм”-ийн ялтан гэх, хорих ангийн ялтанд холбогдох шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхтэй холбогдсон ажиллагаанд гяндангийн ялтнуудыг хамруулж буй зэрэг нь хорих анги ба гяндангийн мөн чанарын агуулга алдагдаж зөвхөн ялтан ял эдлэх нөхцөлөөр хоорондоо ялгагдах төдий болсон байна.

Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон болон 18 насанд хүрсэний дараа онц хүнд гэмт хэрэгт 15 жилээс дээш хугацаагаар хорих ял шийтгүүлсэн эрэгтэй ялтны хорих ялын заримыг гянданд эдлүүлэхээр шүүх тогтоосон эсхүл цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн



Нийслэлийн прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, хууль цаазын итгэмжит зөвлөх, докторант Ц.Мөнхбат

амийг Монгол Улсын Ерөнхийлөгч уучилсан тохиолдолд 30 жилийн хугацаагаар гянданд хорих ялаар сольсон ялтан “гяндан”-д ногдсон ялаа эдэлж дуусгах учиртай гэсэн санааг дэвшүүлж байна.

Хууль тогтоогчид зөвхөн хорих ангийн дотоод журмыг чанд сахиж Эрүүгийн хуульд заасан, оногдуулсан ялын зохих хувийг эдэлсэн, засарч хүмүүжсэнээ зан байдлаараа харуулж, гэмт хэрэг үйлдсэний улмаас бусдад учруулсан хохирлоо нөхөн төлсөн, гэм хорыг арилгасан, эсхүл ялынхаа талаас доошгүй хувийг эдэлж сахилгын зөрчил гаргаагүй хөдөлмөрлөх үүргээ амжилттай биелүүлж урамшуулагдаж байсан ялтныг ял эдлэхээс хугацааны өмнө тэнсэн суллах буюу дэглэм бууруулж болохыг хуульчилсан байна.

Харин шүүхийн шийтгэх тогтоолд заасан хорих ялын заримыг болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар уучлагдсан 30 жилийн хугацаагаар гянданд хорих ял эдэлж байгаа ялтныг гяндангийн хугацаанаас өмнө дэглэм бууруулах тухай аль ч хуульд заагаагүй байхад эдлэх ялын талаас илүү хувийг эдэлсэн, эрүүл мэндийн байдал зэргийг үндэслэл болгож гаргасан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага болон Прокурорын санал, тодорхойлолт, дүгнэлтийн дагуу шүүх шийдвэрлэж байгаа нь бүрэн зөв үндэслэлтэй гэж үзэхэд эргэлзээтэй байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 335 дугаар зүйлийн 335.1 дэх хэсэгт заасан гянданд хорих ялын зохих дэглэмийг хорих ангид эдлүүлэхээр шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын саналыг үндэслэж гаргасан прокурорын дүгнэлтийн дагуу шүүгч захирамж гаргаж шийдвэрлэх тухай заалтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар нэгдсэн ойлголт байхгүй, ял эдэлж буй байгууллага юуг үндэслэж санал гаргах нь тодорхойгүй, энэ талаар Улсын дээд шүүхийн холбогдох тайлбар гараагүй зэрэг “цоорхой”-г ашиглан хорих ангийн онцгой, чанга дэглэмд ял эдэлж байгаа ялтны дэглэм бууруулах асуудалтай адилтгаж төсөөтэй байдлаар шийдвэр гаргаж байгааг зогсоох цаг болсон байна. Энэ асуудлыг цэгцэлж тодорхой шийдвэр гаргал гяндангийн ялтныг шүүхийн шийтгэх тогтоолд заасан хугацаанаас өмнө хорих ангид ялыг эдлүүлэхээр сольж буй байдлыг түдгэлзүүлэх нь зүйтэй юм.

Монгол Улсад цаазаар авах ялыг гүйцэтгэхээс татгалзах, улмаар халах санал санаачлага өргөх хүрээнд гарч улмаар тухайн ялтан этгээдийг цаазаар авахаас илүүтэйгээр зөвхөн гянданд тогтоосон хугацаанд “Яс” байлгаж хорих ялыг эдлүүлэх нь хангалттай цээрлэл болох тухай ярьж байгаа өнөө үед бодит байдалд гяндангийн ялтныг хорих ангийн ялтан адил хугацаанаас өмнө “дэглэм бууруулж” шийдвэрлэж байгаа нь үндэслэлгүй юм. Ганц жишээ дурьдахад 2009 онд 14 ялтныг гяндангаас хугацаанаас өмнө өөр хорих ангид ялыг

адлүүлэхээр сольсон байна. Энэ нь хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байгааг харуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 110 дугаар зүйлд “Насанд хүрээгүй ялтан 18 нас хүрмэгц ялыг нь эдлүүлэхээр насанд хүрэгсдийн хорих ангид шилжүүлэх асуудлыг хорих ангийн тодорхойлолтыг үндэслэн шүүх шийдвэрлэнэ” гэж заасан нь ач холбогдлоо алдаагүй холбогдох асуудлыг ямар нэг маргаангүй шийдвэрлэж байна. Үүнээс санаа авч “Шүүхийн шийтгэх тогтоолд заасан гянданд эдлэх хорих ялын хугацаа дуусмагц уг ялтныг зохих дэглэмийн хорих ангид шилжүүлэх асуудлыг хорих ангийн тодорхойлолтын дагуу гаргасан прокурорын дүгнэлтийг үндэслэж шүүх шийдвэрлэнэ” гэж ЭБШ хуулийн 335 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж найруулах нь зөв юм. Түүнчлэн энэ зүйл ангид гянданд хорих ялыг зохих дэглэмийн хорих ангид эдлүүлэхээр солих тухай саналыг шүүх хэрэгсэхгүй болгосон тухай захирамж гарсан өдрөөс хойш 1 жилийн дотор уг асуудлыг шүүх дахин авч хэлэлцэхгүй гэсэн заалт нь хүний эрхийг ноцтой зөрчсөн нэг хэлбэр гэж үзэж болохоор байна. Учир нь хорих ангийн санал тодорхойлолт, прокурорын дүгнэлтийг шүүх үндэслэлгүй гэж үзэж хэрэгсэхгүй болгосон нь гянданд хорих ял эдэлж байгаа ялтны буруу биш харин эрх бүхий албан тушаалтны хариуцлагагүй ажиллагаатай холбоотой байхад шүүх нэг жилийн хугацаа зааж дахиж хэлэлцэхгүй гэсэн нь өрөөсгөл, бодит амьдралд нийцэхгүй байна.

Иймд дээрх асуудлыг нэг мөр журамлахад юуны өмнө:

1. Улсын дээд шүүхээс Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 335 дугаар зүйлыг тайлбарлах;
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, прокурор, шүүх нь хууль хэрэгжүүлэх талаар нэг мөр ойлголттой болох;
3. Гянданг хорих ангийн нэгэн адил нэрлэхгүй байх;
4. Гяндангийн ялтныг шүүхийн шийтгэх тогтоолд заасан гянданд байх хугацааг дуусмагц зохих дэглэмийн хорих ангид ялыг нь сольж эдлүүлэх;
5. Холбогдох хуулиудад энэ талаар тодорхой нэмэлт, өөрчлөлт оруулах замаар хуулийн хийдлийг арилгах нь үр дүнгээ өгнө гэсэн санал дэвшүүлж байна.

АВСТРИЙН ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ТУХАЙ

Үндсэн хуулийн цэцийн референт, магистр Е.Өнөборгил

Австрийн Үндсэн хуулийн шүүхийн эхлэлийг 1867 онд байгуулагдсан Эзэнт гүрний шүүх тавьсан гэж үздэг. Тэгээд 1919 оноос Үндсэн хуулийн шүүх нэртэй болж Үндсэн хуулийн хяналтын байгууллагын эхийг тавьсан анхны шүүх юм.

Австрийн Үндсэн хуулийн шүүхийн шүүгчдийг Холбооны Засгийн газар, Үндэсний зөвлөл (парламент) эсвэл Холбооны зөвлөлийн саналыг үндэслэн Ерөнхийлөгч томилдог. Хэдийгээр энэ томилгоо нь улс төрийн шийдвэр байж болох боловч шүүгчид бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлснээр тэд хараат бус үйл ажиллагаа явуулах бөгөөд улс төрийн аль нэг чиг шугамыг дагадаггүй.

Үндсэн хуулийн шүүхийн 14 гишүүн (түүнчлэн 6 орлогч гишүүн) нь хуулийн сургууль төгссөн, мэргэжлийн өндөр туршлагатай байх ёстой бөгөөд шүүгч, их дээд сургуулийн багш, өмгөөлөгч зэрэг хуулийн нарийн мэргэшлийн хүмүүс байдаг. Шүүгчид нь 70 нас хүртлээ уг албан тушаалыг хашиж болдог. Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрээс бусад ямар ч шийдвэрээр тэдгээрийг албан тушаалаас нь огцруулж болдоггүй.

Үндсэн хуулийн шүүхийн Бүгд хуралдаанаас шүүхийн шийдвэр гаргадаг бөгөөд Бүгд хуралдаан нь шүүхийн Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч ба 12 шүүгчээс бүрддэг. Түүнээс гадна орлогч шүүгч гэж байх бөгөөд тэдгээр нь байнгын гишүүд сонирхолын зөрчилдөөнтэй байх, өвчтэй зэрэг тохиолдолд тэдгээрийг орлоно.

14 шүүгч жилд 4 удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд нэмэлт хуралдаан хийж болдог. Хууль, эрх зүйн үүднээс шийдвэр гаргахад хялбар, ойлгомжтой асуудлыг 4 шүүгч, нэг даргалагчтайгаар Бага хуралдаан гэж нэрлэдэг хуралдаанаар шийдвэрлэнэ. Бусад асуудлыг Бүгд хуралдаанаар шийдвэрлэнэ.

Үндсэн хуулийн шүүх 80 гаруй албан хаагчтай. Шүүгч бүр хоёроос гурван туслахтай. Ерөнхий нарийн бичгийн дарга, судлаачдын хэсэг, менежер, хэрэг бүртгэгч нар нь шүүхэд ирж буй хэргийг бүртгэх, холбогдох хүмүүст илгээх, хэргийн материал бэлтгэх зэрэг өдөр тутмын асуудлыг хариуцна. Үндсэн хуулийн шүүх нь жилд 3000 орчим шинэ хэрэг хэлэлцдэг бөгөөд жилд гаргаж буй шийдвэрийн тоо жилээс жилд нэмэгдсээр байна.

Үндсэн хуулийн шүүхийн хэргийн харьяалал

Холбооны Үндсэн хуульд Үндсэн хуулийн шүүхийн хэргийн

харъяалалыг дараахь байдлаар тодорхойлсон байдаг.

- Энгийн шүүхээр шийдвэрлэх боломжгүй, захиргааны байгууллага шийдвэр гаргаж гүйцэтгэх боломжгүй Холбоо болон муж улсууд, район, нэгдэл, нэгдлийн зөвлөлд хандан гаргасан бүх хөрөнгө-эрх зүйн холбогдолтой шаардлагыг Үндсэн хуулийн шүүх авч хэлэлцэх бөгөөд үүнд дараах маргаан хамаарна.

1. Шүүх болон захиргааны байгууллага хоорондын маргаан;
 2. Захиргааны хэргийн шүүх болон бусад шүүх хоорондын ялангуяа Захиргааны хэргийн шүүх ба Үндсэн хуулийн шүүх хоорондын, энгийн болон бусад шүүх хоорондын маргаан;
 3. Муж хоорондын болон муж улс, холбоо хоорондын маргаан.
- Холбооны засгийн газар эсвэл муж улсын засгийн газрын шаардлагаар тухайн хууль эрх зүйн акт эсвэл гүйцэтгэх засаглалын акт холбооны эсвэл муж улсын эрх мэдэлд хамаарах эсэхийг тогтооно.

ҮХШ Холбоо болон муж улсуудын байгууллагуудын тогтоол Үндсэн хууль зөрчиж байгаа эсэхийг шүүхийн нэхэмжлэлээр хянан шийдвэрлэнэ. Мөн Үндсэн хуулийн шүүхээр эрх зүйн маргаан хянан шийдвэрлэхэд уг тогтоолыг хэрэглэхээр болвол өөрт өгөгдсөн үүргийн дагуу шүүх өөрийн санаачлагаар хянан шийдвэрлэнэ. Мөн өргөдөл өгсөн иргэний эрх энэхүү тогтоолоос үүдэн шүүхийн шийдвэр, тодорхой тусгай тогтоол гараагүй ч гэсэн зөрчигдөж байгаа гэж үзвэл иргэний өргөдлөөр уг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

ҮХШ Холбоо болон муж улсуудын байгууллагуудын хууль Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг Захиргааны хэргийн шүүх, Дээд шүүхийн болон хоёрдахь шатны шүүхийн хувьд хэргийг хянасан шүүхийн нэхэмжлэлээр хянан шийдвэрлэнэ. Мөн Үндсэн хуулийн шүүхээр эрх зүйн маргаан хянан шийдвэрлэхэд уг хуулийг хэрэглэхээр бол өөрт өгөгдсөн үүргийн дагуу шүүх өөрийн санаачлагаар хянан шийдвэрлэнэ. Мөн өргөдөл өгсөн иргэний эрх энэхүү тогтоолоос үүдэн шүүхийн шийдвэр болон тодорхой тусгай тогтоол гараагүй ч гэсэн зөрчигдөж байгаа гэж үзвэл иргэний өргөдлөөр уг асуудлыг хэлэлцэнэ.

Улсын гэрээ эрх зүйн чадамжтай эсэх тухай хэргийг хэлэлцэнэ. Хэрвээ улсын гэрээ хууль зөрчсөн, Үндсэн хууль зөрчсөн гэж тогтоогдвол Үндсэн хуулийн шүүх энэхүү гэрээг цаашид хэрэглэхийг хугацаа заагаагүй бол шүүхийн шийдвэрийг хэвлэгдэн гарсан өдрөөс эхлэн түүнийг хэрэгжүүлэгч байгууллагууд биелүүлэх ёсгүй. Улсын гэрээний хувьд энэ хугацаа 2 жилээс хэтрэх ёсгүй.

ҮХШ дараахь хэргийг хянан шийдвэрлэнэ:

- Холбооны Ерөнхийлөгчийн сонгууль, нийтийн төлөөлөгчдийн газрын сонгууль, Европарламент, мэргэжлийн төлөөлөгчдийн

хууль ёсны удирдах дээд байгууллагуудын сонгуулийг эсэргүүцсэн хэрэг;

• Муж улсуудын засгийн газрын болон тойрог, нэгдлүүдийн гүйцэтгэх засаглалын сонгуулийг эсэргүүцсэн хэрэг;

• Гишүүдийн нийтийн төлөөллийн байгууллагын өргөдлөөр өөрийн гишүүдийн дотроос нэг гишүүний мандатыг цуцлах;

• Австри Улсаас Европын парламентад суугаа 11-ээс доошгүй гишүүдийн өргөдлөөр нэг гишүүний мандатыг цуцлах;

• Хууль ёсны мэргэжлийн төлөөллийн байгууллагуудын удирдах бүрэлдэхүүний өргөдлөөр нэг гишүүний мандатыг цуцлах.

Үндсэн хуулиар Холбоо болон муж улсын дээд байгууллагын хариуцах асуудлын хүрээнд албан тушаалтан хариуцлага алдан хууль зөрчсөнд буруутгагдсан хэргийг хянана: Үүнд:

• Холбооны Улсын Ерөнхийлөгч Холбооны Үндсэн хуулийг зөрчсөн бол-Холбооны хурлын шийдвэрээр;

• Холбооны Засгийн газрын гишүүд болон түүнтэй адилтгах хариуцлагатан хууль зөрчсөн бол-Үндэсний зөвлөлийн шийдвэрээр;

• Зөвлөлийн төлөөлөгчид Холбооны хууль тогтоомжид хамаарах асуудлаар хууль зөрчсөн бол-Үндэсний зөвлөлийн шийдвэрээр, мөн муж улсын хууль тогтоомжид хамаарах асуудлаар хууль зөрчсөн бол -Ландстагийн шийдвэрээр;

• Муж Улсын Засгийн газрын гишүүн мөн түүнтэй адилтгах хариуцлагатан хууль зөрчсөн бол- Ландстагийн шийдвэрээр;

• Муж Улсын Засаг дарга, түүний орлогч, Засгийн газрын гишүүд хууль зөрчсөн болон шууд бус холбооны удирдлагын асуудлаарх Холбооны тогтоол, мөн асуудлаарх Муж Улсын Засаг даргын зааврыг биелүүлээгүй бол-Холбооны Засгийн газрын шийдвэрээр

• Вена хотын байгууллагууд холбооны зорилтуудыг гүйцэтгэх өөрийн эрх мэдлийн хүрээнд хууль зөрчсөн бол-Холбооны Засгийн газрын шийдвэрээр;

• Муж Улсуудын Засаг дарга нар 14 дүгээр зүйлийн 8 дугаар мөрөнд заасан зааврыг биелүүлээгүй бол Холбооны Засгийн газрын шийдвэрээр;

• Муж Улсуудын сургуулийн зөвлөлийн Ерөнхийлөгч Холбооны тогтоол болон бусад хууль тогтоомжийг биелүүлээгүй бол-Холбооны Засгийн газрын шийдвэрээр;

• Муж Улсуудын Засгийн газрын гишүүд 11 дүгээр зүйлийн 1, 11 дүгээр зүйлийн 9 дэх мөрд тусгасан асуудлаар Холбооны хуулийг зөрчих, тогтоолыг биелүүлээгүй буюу саад тотгор учруулсан бол.

Хэрвээ Үндсэн хуулийн шүүх буруутайг нь тогтоовол эдгээр албан тушаалтныг огцруулж, хүндрүүлэх шалтгаантай бол улс төрийн эрхийг нь түр хугацаагаар хасна.

Холбогдох (ҮХ-ийн 142 дугаар зүйлд заасан) албан тушаалтан эрүүгийн гэмт хэрэгт холбогдохоор үйл ажиллагаа явуулсан бол Үндсэн хуулийн шүүх хэргийг хянана.

Үндсэн хуулийн шүүх захиргааны байгууллагын шийдвэр, эсвэл Үндсэн хуулийн эсрэг хууль, хууль бус тогтоол, тэгш бус гэрээг хэрэглэсний улмаас Үндсэн хуулиар олгогдсон эрх нь зөрчигдсөн гэж үзэж өргөдөл өгсөн иргэний гомдлыг авч хэлэлцэнэ.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээ зөрчигдөж байна гэж үзсэн хэргийг Холбооны тусгай хуулийн заалтын дагуу Үндсэн хуулийн шүүх авч хэлэлцэнэ.

Өргөдөл хүлээн авснаас маргаан хянан шийдвэрлэх хүртэлх ажиллагаа ямар дэгийн дагуу явагддаг тухай

Ирж буй өргөдөл ҮХШ-ийн ажлын албанд бүртгэгдэнэ. Ихэнхдээ өргөдөл шуудангаар ирдэг. Зарим нь өмгөөлөгчөөрөө дамжуулан ирүүлдэг. Бүх өргөдлийг Ерөнхий нарийн бичгийн дарга хүлээн авна. Тэрээр хүлээн авсан өргөдлийн үндсэн үзүүлэлтүүдийг компьютерийн дотоод сүлжээнд оруулна. Ерөнхий нарийн бичгийн дарга бэлтгэсэн файлаа ҮХШ-ийн Ерөнхийлөгчид өгч хэргийн талаар мэдээлэн, өөрийн саналыг “Байнгын илтгэгч” гишүүнд хэлж, энэ мөчөөс хэргийг тэр хариуцна. Ерөнхийлөгч шинэ хэрэг дээр ажиллах шүүгчийн нэрийг хэрэг дээр бичиж өгнө. Ерөнхийлөгч ийм шийдвэр гаргахдаа өөрийн үзэмжээр хуваарилна. Гэхдээ тэрээр хэргийг хуваарилахдаа шүүгчийн нарийн мэргэшлийг харгалзан үздэг. Үүний дараа хэргийн гол агуулга анхаарлын төвд орж ирдэг. Байнгын илтгэгч юуны өмнө өргөдлийн өгөгдлүүд зөв эсэхийг шалгана. Ялангуяа Үндсэн хуулийн харъяалан шийдвэрлэх асуудал мөн эсэх, өргөдөл эрх зүйн хяналтаар орох шаардлагатай эсэхийг шалгана.

Зарим өргөдөл гаргагч урьд өмнө нь ҮХШ-ээр хэлэлцэгдээд шийдвэрлэгдсэн асуудлаар өргөдөл гаргадаг. Ийм өргөдөлд холбогдох тайлбарыг хийж, хэлэлцэхээс татгалзах тухай шийдвэр гаргаж өгдөг. Мөн өргөдөлд дэвшүүлсэн асуудал нь Үндсэн хуулийн харъяалалын бус асуудал байвал татгалзах шийдвэр гаргадаг.

Хэргийг урьдчилан хянаж буй шүүгчийн бодлоор хэргийг хэлэлцэхэд бэлэн гэж үзэх юм бол хэлэлцүүлгийн төслийг бэлдэн холбогдох бусад хавсралтын хамт шүүгчдэд илгээнэ. Шүүгчийн туслахууд санал бэлтгэхэд туслана. Хэргийг бэлтгэсэн материалуудад үндэслэн хуралдааны үеэр хэлэлцэнэ. 14 шүүгч жилд 4 удаа хуралдаж (яаралтай хэргээр мөн хуралддаг) төслийг хэлэлцэн санал хурааж шийдвэр гаргадаг. ҮХШ-ийн хуралдааныг олон нийтэд нээлттэй хийдэггүй. Шүүгчид эхлээд төслөө бэлдээд энэхүү шийдвэрийг гаргах болсон шалтгааныг зааж өгнө. Ерөнхийлөгч хэлэлцүүлэг эхэлснийг

мэдэгдэж хуралдааныг нээнэ. Хэлэлцүүлгийн үед орсон нэмэлт, өөрчлөлт болон засварыг хийгээд шийдвэрийн төсөл дээр санал хураана. Төсөл олонхийн санал авч чадахгүй бол хэлэлцүүлгийн явцад гарсан саналуудыг тусгасан шийдвэрийн шинэ төслийг бэлдэнэ. Энэ тохиолдолд өөр шүүгч төслийг бэлдэнэ. Олонхийн саналыг авсан шийдвэрийн төслөөр эцсийн шийдвэр гаргана. Хэрвээ хэрэг ээдрээтэй байх аваас хэлэлцүүлэг хэдэн чуулган дамжин хэлэлцэгддэг.

Хэрвээ урьдчилсан хяналтын явцад бүх асуултад хариулт авах боломжгүй бол эсвэл хэрэг эрх зүйн болон улс төрийн чухал ач холбогдолтой бол хуралдааныг нээлттэй хийж болно. Хуралдааны үед талууд шүүгчдийн тавьсан асуултад хариулна. Энэ хэрэгт холбоотой хүмүүс хуралдааны танхимд байх ёстой. Хуралдааныг Шүүхийн Ерөнхийлөгч удирдан явуулна. Нэг хэргийг нэг хуралдаанаар шийдвэрлэн эцсийн шийдвэр гаргах боломжгүй тохиолдол гардаг. Тухайлбал, шүүгч нэг хуулийг хэрэглэх гэтэл тэр хууль нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн байх юм бол Шүүхийн хуралдааныг зогсоон хуулийн маргаантай заалт дээр анхаарлаа хандуулна. Үүний улмаас хуралдаан сунжирдаг. Хэлэлцэж байгаа асуудлаар Люксембург дэх Европын шүүхийн шийдвэрийг ч хүлээх хэрэг гардаг.

Бүгд хуралдаанаар шийдвэрийн төслийг баталсаны дараа хэргийг хаана. Олонхийн саналыг бэлтгэсэн шүүгч Бүгд хуралдаан дээр тохирсон шийдвэрийн эцсийн хувилбарыг бичнэ. Шүүхийн Ерөнхийлөгч эцэслэн нягтлан шалгана. Шаардлагатай тохиолдолд тэр Илтгэгч шүүгчийн зөвшөөрөлтэйгээр зарим зүйлийг тодруулж болно. Онцгой тохиолдолд тэр Бүгд хуралдаантай дахин зөвшилцөж болно. Ерөнхийлөгч гарын үсгээ зурснаар шийдвэр эцсийн хэлбэрт ордог. Туслахууд шийдвэрийн текстийг анхааралтай уншиж “чанарын шалгалт” хийнэ. Үүний дараа ҮХШ-ийн шийдвэрийг хэвлэн хуралдааны талуудад илгээнэ. Иргэдэд холбогдолтой чухал шийдвэрүүдийг Хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлүүдээр дамжуулан мэдээлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЭБШХ-Д ХЭРЭГЛЭСЭН “МӨРДӨН БАЙЦААХ, ХЭРЭГ БҮРТГЭХ АЛБАНЫ ДАРГА” НЭР ТОМЪЁОГ ӨӨРЧЛӨХ АСУУДАЛ

“Мөрдөн байцаах албаны даргын эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавих эрх”сэдвээр судалгааны ажлыг явуулж байна.

Эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаанд дахь мөрдөн байцаах албаны даргын хяналт тавих эрхийг шинжлэх ухааны үндэстэй судлахын тулдЭБША-ны энэ оролцогчийг Монгол Улсын ЭБШХ-д хэзээ анх тусгасан,хуульд мөрдөн байцаах албаны даргагэж томъёолсон нь оновчтой эсэхийг бусад орны ЭБШХ-иар энэхүү эрх бүхий оролцогчийг нэрлэсэн нэр томъёо, түүний хуулиар олгогдсон эрх хэмжээтэйхарьцуулж эрх зүйн орчинг тал бүрээс нь үндэслэлтэй судлахгүй бол боломжгүй юм.

Иймд диссертацийн судалгааны ажлын хүрээнд бид одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын ЭБШХ болон өмнө нь үйлчилж байсан ЭБШХуулиуд,бусад эрх зүйн акт,түүнчлэн мөрдөн байцаах албаны дарга түүний эрх хэмжээг зохицуулж байгаа бусад орны ЭБШХ-ийн зохих зүйл, заалтыг харьцуулан судалсан.

Бидний үзэж байгаагаар цогц судалгааны үр дүнгээр хуульд хэрэглэсэн нэр томъёо оновчгүй, бүтэц агуулгын хувьд ч хуульд байх найруулгын болоод техникийн шаардлага хангахгүй байгаад шүүмжлэлтэй хандаж нэр томъёог оновчтой болгон бусад орны жишигт хүргэх,өөрчлөх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

1. Мөрдөн байцаах албаны даргын эрх зүйн орчинг хуулиар бий болгосон анхны эрх зүйн акт нь БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1968 оны 01 сарын 25-ны өдрийн 13 тоот «БНМАУ-ын ЭБШХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай» зарлиг юм. Уг зарлигаартухайн үед үйлчилж байсан 1963 оны БНМАУ-ын ЭБШХ-д «Мөрдөн байцаах хэлтсийн дарга-НАХЯ-ны харьяа байгууллагын мөрдөн байцаах хэлтэс, тасгийн дарга, тэдгээрийн орлогчид» гэсэн агуулгатай «6а»-г 34дүгээр зүйлд, 127¹ дүгээр зүйл«Мөрдөн байцаах хэлтсийн даргын эрх хэмжээ» гэсэн нэмэлтүүдийг тусгаснаар БША-



ОХУ-ын ДЯА-ны
Удирдлагын академийн
адъюнкт,цагдаагийн дэд
хурандаа Б.Одбаатар

ны энэ оролцогч хуульд анх тусгалаа олж эрх хэмжээг нь хуульчилж өгсөн байна.

1992 онд Монгол Улс ардчилсан шинэ Үндсэн хуулиа баталжшинэ тогтолцоот нийгэмд шилжин орсноор зарим гол гол хуульд томоохон нэмэлт, өөрчлөлт орж мөннэлээд хууль шинээр батлан гаргасны нэг нь Монгол Улсын УИХ-аас 1994 оны 3 дугаар сарын 28-ны өдөр батласан «Монгол Улсын ЭБШХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай» хууль юм. Энэ хуулиар Монгол Улсын ЭБШХ-ийн 34.7 дугаар зүйлд «Мөрдөн байцаах албаны дарга-мөрдөн байцаах газар, хэлтэс, тасгийн дарга, тэдгээрийн орлогчид», 127 дугаар зүйл «Мөрдөн байцаах албаны даргын эрх хэмжээ» гэж тус тус өөрчлөн найруулсан байна.

Хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, ардчилал шинэчлэлийн зарчмыг тууштай хэрэгжүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгоход чиглэсэн олон талт ажлын хүрээнд тулгуур хуулиудыг шинээр дахин боловсруулахбагцад Монгол Улсын ЭБШХ хамрагдсанаар УИХ-аас 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөрМонгол Улсын ЭБШХ-ийг шинээр батлан гаргасан ньодоо хүчин төгөлдөр үйлчилжбайгаа хууль юм. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д «Мөрдөн байцаах албаны дарга гэж мөрдөн байцаалт явуулах байгууллагын мөрдөн байцаах газар, хэлтэс, тасгийн дарга, түүний орлогчийг», 29 дүгээр зүйлд «Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны даргын эрх хэмжээ»¹ гэж түүний нэр томъёо, БША-нд оролцох эрх зүйн орчинг бүрдүүлж өгсөн байна.

2. Судалгааны ажил онолын үндэстэй, бодитой, тал бүрийнбайх үүднээс хуульд хэрэглэсэн нэр томъёоноос эхэлье. Үүнийг задлаж авч үзвэл “дарга”, “мөрдөн байцаах алба” гэсэн хоёр хэсгээс бүрдэж байна.Үгсийн тайлбар тольд:

- **дарга**-ямар нэгэн зүйлийг удирдаж, эрхлэж байгаа албан тушаалтан этгээд² гэж тайлбарласан байна.

Зарим орны ЭБШХ-д энэ оролцогчид “удирдагч” гэсэн томъёогхэрэглэжээ. Тухайлбал, ОХУ-ын ЭБШХ-д “удирдагч” гэж томъёолон хуулийн 5 дугаар зүйлийн 38¹ хэсэгт «Мөрдөн байцаах байгууллагын удирдагч-харьяа мөрдөн байцаах нэгжийг тэргүүлж байгаа албан тушаалтан, мөн түүний орлогч»³ гэж тусгасан байна. ОХУ-ын ЭБШХ-д өмнө нь “Мөрдөн байцаах хэлтсийн дарга” гэж байсныг 2007 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн №87-ФЗ-ОХУ-ын ЭБШХ-д болон ОХУ-ын Прокурорын байгууллагын тухай хуульд

¹ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль.Нэмэлт, өөрчлөлтүүд.<http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?viewid=26835#>

² С.И. Ожегов. Орос хэлний үгийн тайлбар толь бичиг (профессор Л.И. Скворцовын удирдлага дор дахин боловсруулж нэмэлт, өөрчлөлт оруулсан 26 дахь хэвлэл.) орос хэл дээр-Москва: “Оникс”, Энхтайван боловсрол” хэвлэлийн газар, 2006г. с.736.

³ Оросын Холбооны Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. (орос хэл дээр.-Москва: “Омега-И” хэвлэлийн газар, 2009г. с.207.

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай жуулиардаргыг-удирдагч; хэлтсийг-байгууллага гэсэн нэр томъёогоор тус тус сольсон байна.

Киргиз улсын ЭБШХ-д мөн “удирдагч” гэсэн нэр томъёо хэрэглэн хуулийн 37 дугаар зүйлдмөрдөн байцаах нэгжийн удирдагчийн эрх хэмжээг тодорхойлон өгчээ.⁴ Тэгвэл “удирдагч” гэж хэн бэ? Үгсийн тайлбар тольд:

- **удирдагч**—хэн нэгнийг болон ямар нэгэн зүйлийг удирдаж байгаа этгээд⁵ гэж тайлбарласан байна. Дарга, удирдагч хоёр үгийгхарьцуулбал;
- **дарга**—ямар нэгэн зүйлийг удирдаж эрхэлж буй албан тушаалтан этгээд;
- **удирдагч**—ямар нэгэн зүйл, хүнийг удирдаж байгаа этгээд буюу нэг нь албан тушаалтан нөгөө нь зүгээр этгээд байна.

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлд⁶ зааснаар төрийн тусгай удирдах албан тушаалтныг “дарга” гэж нэрлэсэн бөгөөд мөрдөн байцаах газар, хэлтэс, тасгийн дарга нь төрийн тусгай албан тушаалтны ангилалд багтах тул Монгол Улсын ЭБШХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “дарга” гэж томъёолсон нь үгийнхээ тайлбарт нийцэж байгаа тул зөв тодорхойлсон гэж бид үзэж байна.

3. Одоо “алба” гэдэг үгийн тайлбарыг авч үзье. Үгийн тайлбар толь бичигт:

- **алба**:...1. Алба хаагчийн ажил, хичээл мөн түүнчлэн түүний ажлын байр. (*Ажилд орох. Төрийн алба. Ажлаас ирэх*), 2. Цэргийн үүргээ биелүүлэх, 3. *Юуны болон ямар албаны*. Ямар нэгэн ажлын мэргэжлийн хэсэг, (*Холбооны алба. Цаг уурын алба. Эмнэлгийн албаны ахмад г.м*)...гэж тайлбарлажээ.

Энэ тайлбарт зааснаар “алба” гэж ямар нэгэн байгууллагын нэр биш ажил, ямар нэгэн ажлын мэргэжлийн хэсэг, цэргийн үүрэгтний ажил байхаар тайлбарлагдсан байна.

Судалгаанаас үзэхэд “алба” гэж нэр томъёог Монгол Улсын ЭБШХ-д “Мөрдөн байцаах алба” гэдэгт хэрэглэснээс өөр улс хуульдаа хэрэглээгүй байна.

4. Бусад орны ЭБШХ-д ямар нэг томъёог хэрэглэсэн байна вэ? гэдгийг судалбал: “мөрдөн байцаах хэлтэс”, “мөрдөн байцаах нэгж”

⁴ Бүгд Найрамдах Кыргызстан улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн шинжлэх ухааны тайлбар. орос хэл дээр—Бишкек, 2008г. с.704.

⁵ С.И. Ожегов. Орос хэлний үгийн тайлбар толь бичиг (профессор Л.И. Скворцовын удирдлага дор дахин боловсруулж нэмэлт өөрчлөлт оруулсан 26 дахь хэвлэл). Орос хэл дээр. Москва: “Оникс”, Энхтайван боловсрол хэвлэлийн газар, 2008, с.736.

⁶ Монгол Улсын Төрийн албаны тухай хууль. / <http://www.legalinfo.mn/insys/lawmain.php?ylawid=6>

гэсэн нэр томъёонуудыг хэрэглэсэн байна. Тухайлбал:

Беларусь улсын ЭБШХ-ийн 6 дугаар зүйлийн 15 дахь хэсэгт «Мөрдөн байцаах нэгжийн дарга–Урьдчилсан мөрдөн байцаалтын асуудал эрхэлж байгаа урьдчилсан мөрдөн байцаах төв газрын дарга, урьдчилсан мөрдөн байцаалтын дарга, мөрдөн байцаах газрын дарга, мөрдөн байцаах хэлтэс, тасгийн дарга тэдгээрийн орлогчид⁷» гэж «мөрдөн байцаах нэгжийн дарга» гэдгээр тусгажээ.

Таджикистан улсын ЭБШХ-ийн 6 дугаар зүйлд «Мөрдөн байцаах нэгжийн дарга–өөрийн эрх, эрх мэдлийн хүрээнд газар, хэлтэс болон бусад мөрдөн байцаах нэгжийг удирдаж байгаа албан тушаалтан⁸», Казакстан улсын ЭБШХ-ийн 63 дугаар зүйл «Мөрдөн байцаах хэлтсийн дарга»¹ дүгээр хэсэг «Мөрдөн байцаах хэлтсийн дарга–өөрийн эрх мэдлийн хүрээнд урьдчилсан мөрдөн байцаалт болон шүүхийн өмнөх ажиллагааг хэрэгжүүлж байгаа байгууллагын мөрдөн байцаах нэгжийн дарга түүний орлогч⁹» гэж тус тус тодорхойлжээ.

Тэгвэл хуульд хэрэглэсэн “байгууллага”, “хэлтэс”, “нэгж” гэж юу вэ? аль нь оночтой вэ? гэсэн асуулт урган гарч ирнэ. Мөн үгийн тайлбар толийг сөхөн харвал:

• *байгууллага*–1.Тодорхойчиг үүрэг, бүрэн эрх бүхий хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн этгээд;¹⁰

• *хэлтэс*–Ямар нэгэн байгууллагын бүтцэд орж байгаа нэгж байгууллага¹¹;

• *нэгж*–1. том хэмжээний бүрэлдэхүүнд багтаж байгаа ямар нэгэн хэсэг бүлэг; 2. Цэргийн том нэгтгэлийн бүрэлдэхүүнд байгаа цэргийн нэгж¹² гэж тус тус тайлбарласан байна.Эндээс дүгнэхэд, байгууллага–төрийн болон нийгмийн байгууламж;хэлтэс–байгууллагын бүтцийн бүрдлийн нэг хэсэг; нэгж–бүтцийн хамгийн бага хэсэг байна.

Бидний хийсэн судалгааны дүгнэлтээр бүтцийн шинж чанар болоод нэр томъёоны тайлбараар эдгээрийн дотроос хамгийн оновчтой нь мөрдөн байцаах байгууллагын бүтцэд хэлтэс гэж нэр томъёог хэрэглэх нь зүйтэй гэж дүгнэж байна.Учир нь хэлтэс нь байгууллагын бүтцэд багтаж түүний бүрдлийн нэг хэсэг болж байна.

5. Монгол Улсын ЭБШХ-ийн 27 дугаар зүйлд зааснаар мөрдөн

⁷ Бүгд Найрамдах Беларусь улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль.Орос хэл дээр. Санкт-Петербург: "Пресс хууль зүйн төв" хэвлэлийн газар, 2001г.

⁸ Бүгд Найрамдах Тажикистан улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль.Орос хэл дээр. Душанбе, 2009г.

⁹ Бүгд Найрамдах Казакстан улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. Орос хэл дээр. Астана, 2008г.

¹⁰ С.Нарангэрэл. "Эрх зүйн эх толь бичиг" нэмж засварласан хоёрдахь хэвлэл. УБ., 2008 он, 53 дахь тал.

¹¹ Мөн тэнд 53 дахь тал.

¹² С.И. Ожегов.Орос хэлний үгийн тайлбар толь бичиг. (профессор Л.И. Скворцовын удирдлага дор дахин боловсруулж нэмэлт өөрчлөлт оруулсан 26 дахь хэвлэл). Орос хэл дээр. Москва: "Оникс", Энхтайван боловсрол" хэвлэлийн газар. 2008г; с.736.

байцаалт явуулах байгууллагууд:

- Тагнуулын ерөнхий газрын мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагч Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын эсрэг болон Тагнуулын байгууллага өөрсдөө илрүүлсэн Эрүүгийн хуулийн 175(Эд зүйлийг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлэх) дугаар зүйлд заасан гэмт хэрэгт;
- Прокурорын байгууллагын дэргэдэх мөрдөн байцаах албаны мөрдөн байцаагч цагдаагийн байгууллагын ажилтан, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн үйлдсэн хүндэтгэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт;
- Авилгалтай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагч Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан албан тушаалын хэрэгт;
- Цагдаагийн байгууллагын мөрдөн байцаагч Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан үндэсний аюулгүй байдлын эсрэг болон албан тушаалын гэмт хэргээс бусад хүндэтгэр, хүнд, онц хүнд гэмт хэрэгт мөрдөн байцаалт явуулж байна.(Цагдаагийн байгууллагын бүтцэд Улсын мөрдөн байцаах газар түүний харьяа төв орон нутгын мөрдөн байцаах хэлтэс, тасгууд багтдаг.)

Эдгээрээс прокурор болон тагнуулын байгууллагын мөрдөн байцаах албанаас бусад байгууллагын бүтцэд мөрдөн байцаах хэлтэсбайгаа нь нэр томъёоны болоод бүтцийн хувьд оновчтой байна.

6. Монгол Улсын ЭБШХ-ийн 29 дүгээр зүйлд “Хэрэг бүртгэх байгууллага, мөрдөн байцаах албаны даргын эрх хэмжээ” гэжнэг зүйлээр БША-ны хоёр өөр оролцогчид тэнцүү эрх хэмжээ олгосон байна. Монгол Улсын ЭБШХ-ийн 177 дугаар зүйлийн 177.1, 178 дугаар зүйлийн 178.1-д зааснаар хэрэг бүртгэгч нь Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хөнгөн гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагааг 21 хоногийн хугацаатай явуулах ба нэмэлт ажиллагаа хийх зайлшгүй шаардлага гарвал ЭШБХ-ийн 178 дугаар зүйлийн 178.2-д зааснаар прокурор энэ хугацааг 15 хоногоор сунгадаг. Хөнгөн гэмт хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байгаа байгууллагын дарга хүндэтгэр, хүнд, онц хүнд гэмт хэргүүдэд мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа мөрдөн байцаах албаны даргатай хуулиар олгогдсон тэнцүү эрх хэмжээтэй байж болох уу? гэсэн зарчмын асуудал гарч ирж байна. ЭБША-нд оролцож байгаа хэлбэр, эзлэх байр суурь, эрх хэмжээний хувьд яагаад ч нэг зүйлээр зохицуулж тэнцүү эрх хэмжээтэй байж болохгүй хоёр өөр оролцогч. Нөгөө талаар судалгаагаар ямар ч орны ЭБШХ-д энэ хоёр оролцогчийн эрх хэмжээг нэг зүйлээр зохицуулаагүй байна. Бидний үзэж байгаагаар хуулийн бүтэц, агуулга, техникийн талаасаа ч алдаатай байна.

7. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны дарга хуулиар олгогдсон

тэнцүү эрх хэмжээтэй байгаа шалтгаан нь Монгол Улсын ЭБШХ-ын 28 дугаар зүйлийн 28.2-д хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн эрх хэмжээг мөн л нэг зүйлд зааж зохицуулсанд оршиж байна.

Өмнө нь Монгол Улсын ЭБШХ-ийн 177 дугаар зүйлийн 177.1-д “Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан хөнгөн, хүндэвтэр хэрэгт хэрэг бүртгэгч энэ хуульд заасан харьяалалын дагуу хэрэг бүртгэлт явуулна” гэснийг 2007 оны 8 дугаар сарын 09-ны өдрийн хуулиар хүндэвтэр гэснийг хассанаар хэрэг бүртгэгч хөнгөн гэмт хэрэгт бүртгэлтийг 21 хоногийн хугацаатай явуулж байгаа. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуульд заасан хүндэвтэр хэргүүд мөрдөн байцаалтад шилжиж мөрдөн байцаагч хүндэвтэр, хүнд, онц хүнд хэрэгт мөрдөн байцаалт явуулж байна. Хуулийн энэ өөрчлөлтөөр хэрэг бүртгэх байгууллагын ажлын ачаалал үлэмж хэмжээгээр багасч, бүтэц орон тооны нэлээд хувь нь мөрдөн байцаах албанд шилжсэн. Үүнтэй уялдуулан ажлын ачаалал тэнцүүлэх, бүтэц орон тоог жигдрүүлэх үүднээс нийслэлийн Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн цагдаагийн хэлтэст мөрдөн байцаах 2 тасаг ажиллаж байна.

Мөн хуульд заасан үндэслэл журмын дагуу яллагдагчид цагдан хорих ТСАХ хэрэглэх, яллагдагчаар татахгэх мэт мөрдөн байцаалтын ажиллагааны эрх хэмжээг хэрэг бүртгэгч мөрдөн байцаагчтай тэнцүү эдлэхээр ЭБШХ-ийн 28 дугаар зүйлийн 28.2.4, мөн зүйлийн 28.2.6-д тусгасан нынэг зүйлд тусгаж болохгүй байгаа нь харагдаж байна.

Иймд судалгааны үр дүнг үндэслэн хуулийн заалтыг оновчтой болгох зорилгоор мөрдөн байцаах албаны дарга түүний эрх хэмжээтэй холбоотой Монгол Улсын ЭБШХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.4, мөн хуулийн 29 дүгээр зүйлийг дараах байдлаар өөрчлөн найруулах ёстой гэж үзэж байна.

1. 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Мөрдөн байцаах албаны дарга” гэж мөрдөн байцаалт явуулах байгууллагын мөрдөн байцаах газар, хэлтэс, тасгийн дарга, түүний орлогч гэснийг “Мөрдөн байцаах хэлтсийн дарга-мөрдөн байцаалт явуулах байгууллагын мөрдөн байцаах газар, хэлтэс, тасгийн дарга, түүний орлогчийг” гэж;

2. 29 дүгээр зүйлд “Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах албаны даргын эрх хэмжээ” гэснийг “Мөрдөн байцаах хэлтсийн даргын эрх хэмжээ” гэж өөрчлөх;

Хэрэг бүртгэх байгууллагын дарга, хэрэг бүртгэгчийн эрх хэмжээг хуулиар тусад нь зохицуулах шаардлагатай байна. Ингэснээр хуулийн нэр томъёог зөв хэрэглэж, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, бусад оры жишигт хүргэх байгаа чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

ГЭР БҮЛИЙН ЭРГЭН ТОЙРОНД

**“Эрх чөлөөг шударга ёсны төлөө,
өөр нэг эрх чөлөөний төлөө
хязгаарлаж болдог” Ж.Вольф**



Цагдаагийн академийн
Иргэний эрх зүйн
тэнхимийн багш,
цагдаагийн дэслэгч,
магистр О.Отгонтуяа

Нийгэмд гэр бүлийн хүчирхийллийн талаар янз бүрийн байр суурь, хандлага байгаа ба үүнийг өөр өөрсдийн үзэл бодлоор тайлбарлаж байна. Энэхүү өгүүллийг бичихдээ холбогдох хууль тогтоомжид судалгаа, шинжилгээ хийж, хууль зүйн үүднээс тайлбарлахыг зорилоо.

Гэр бүлийн хүчирхийлэл, түүний эрх зүйн зохицуулалтын талаар төрөөс тодорхой бодлого, хөтөлбөр, эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар багагүй ажлыг хийж гүйцэтгэсэн билээ. Үүнд:

- Жил бүрийн 5 дугаар сарын 15-ны өдрийг Гэр бүлийн өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлж байхаар шийдвэрлэсэн;
- 2004 оныг Гэр бүлийн жил болгон зарласан;
- 2003 онд “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого” хөтөлбөр;
- 2005 онд “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах” Үндэсний хөтөлбөр;
- 2007 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх” Үндэсний хөтөлбөр;
- 2004 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль;
- 2006 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” Улсын дээд шүүхийн тогтоол.

Улсын Их Хурлын 2003 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын зорилгыг хэрэгжүүлэхийн тулд “... гэр бүлийн гишүүнийг хүчирхийлэх, эрхийг нь зөрчих явдлыг тууштай бууруулах эрх зүй, зан үйлийн зэрэг орчин бүрдүүлэх ...” зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж байна.

Улсын Их Хурлаас Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 2004 оны 5 дугаар сарын 13-ны өдөр 5 бүлэг, 20 зүйлтэйгээр баталсан болон Улсын дээд шүүхээс 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 47

дугаар тогтоолоор Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарласан нь нийгмийн сөрөг үзэгдэл болох гэр бүлийн хүчирхийлэл, түүнтэй тэмцэхэд төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хохирогчдын аюулгүй байдлыг хангах, тэдний зөрчигдсөн эрхийг сэргээн хамгаалах, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай (ГБХТТХ) хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т “гэр бүлийн хүчирхийлэл” гэж Гэр бүлийн тухай хуульд¹ заасан гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, гэрлэлтээ хуульд заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй боловч хамтын амьдралтай байгаа хүмүүс², түүнчлэн Гэр бүлийн тухай хуульд заасны дагуу хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлсний, эсхүл асран хамгаалагч, харгалзан дэмжигч тогтоосны үр дүнд тухайн иргэний асрамжид байгаа этгээд аль нэг этгээд нөгөө этгээдийн эрх, эрх чөлөөг зөрчиж гэм хор учруулсан, эсхүл Учруулахаар заналхийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ гэж хуульчилсан байна.

Гэвч тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй байвал захиргааны зөрчил гэж үзэж болох боловч Захиргааны хариуцлагын тухай хуульд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн этгээдэд ямар төрлийн хариуцлага хүлээлгэх талаар хуульчилж өгөөгүй байгаа нь зөрчил гаргасан этгээдэд захиргааны шийтгэл ногдуулахгүй явсаар байх уу? эсвэл... гэсэн асуултыг нэхсээр...

Уг хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2009 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар 52 маргааныг шийдвэрлэсэн байна. Үүний 26 шийдвэр нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д заасан “тусдаа амьдрахыг даалгах” эрх хязгаарлах арга хэмжээ авчээ.

“Тусдаа амьдрахыг даалгах гэдэг” нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн болон үйлдэж болзошгүй этгээдийг хүчирхийлэл үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор, хүчирхийлэл үйлдэх бололцоо, нөхцөл, шалтгаан арилах хүртэлх хугацаанд хохирогчтой хамт нэг гэрт амьдрахгүй байхыг шүүхээс үүрэг болгохыг хэлдэг боловч нэг гэрт амьдардаг, өөр амьдрах байргүй хүчирхийлэл үйлдэгчийг хаана байлгах нь тодорхой бус байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 129

¹ Гэр бүлийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхтгэл, 1999 он, №8.

² Хамтран амьдрагсдын эрхийг хамгаалсан цорын ганц хууль гэж хэлж болохуйц байна.

дүгээр зүйлийн 129.1.3-т “гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах” урьдчилсан арга хэмжээ авч болно гэж заасан. Гэвч хүчирхийлэл үйлдэгч болон гэрлэгчдийг захирамжид заасан хугацаанд тусдаа амьдарч байгаа эсэхийг ямар процедураар, хэн хэрэгжүүлэх эсэх нь тодорхой бус, учир дутагдалтай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч хяналт тавих уу, тухайн дүүргийн харьяа цагдаагийн байгууллагын ажилтан хяналт тавих уу гэдэг нь тодорхой бус байна.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн хэргийн 39 буюу 75 хувьд нь хүчирхийлэл үйлдэгч архи хэрэглэдэг гэсэн судалгаа гарсан нь хүчирхийлэгч ихэнх тохиолдолд согтууруулах зүйл хэрэглэсэн үедээ хүчирхийлэл үйлддэг нь харагдаж байна.

Хүчирхийлэл үйлдэгчийн 42 хэрэг буюу 80.8 хувь урьд нь гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэний улмаас ямар нэгэн шийтгэл хүлээж байсан байна.

**Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн
дагуу хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарласан шүүхийн
шийдвэрт дүн шинжилгээ хийсэн судалгаа**

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дагуу шийдвэрлэсэн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд	Судалж үзэхэд
Нэхэмжлэлийг хэн гаргасан тухай асуудлаар нарийвчлан судлахад	• Хохирогч - 34 хэрэг буюу 65.3 хувь; • Итгэмжлэгдсэн төлөөлөгч -15 хэрэг буюу 28.9 хувь; • Цагдаагийн ажилтан - 3 хэрэг буюу 5.8 хувь.

Хохирогч, хүчирхийлэл үйлдэгчийн талаарх мэдээлэл дээр нас, хүйс, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдлыг нарийвчлан гаргасан байдал	Хохирогчийн нас: • 26-35 (12 хэрэг буюу 23 хувь); • 36-45 (16 хэрэг буюу 30.8 хувь). (24 шийдвэрт хохирогчийн насыг тусгаагүй байна.) Хүчирхийлэл үйлдэгчийн нас: • 18-25 (5 хэрэг буюу 9.7 хувь); • 26-35 (6 хэрэг буюу 11.5 хувь); • 36-45 (18 хэрэг буюу 34.6 хувь); • 45- түүнээс дээш (7 хэрэг буюу 13.4 хувь). (16 шийдвэр буюу 30.8 хувьд нь хүчирхийлэл үйлдэгчийн насыг тодорхой тусгаагүй байна.) Хохирогчийн хүйс: • Эм (52 хэрэг буюу 100 хувь). Хохирогчийн хөдөлмөр эрхлэлтийн байдал • Ажилтай (16 хэрэг буюу 30.8 хувь); • Ажилгүй (31 хэрэг буюу 59.7 хувь); (5 шийдвэрт хохирогчийн хөдөлмөр эрхлэлтийн талаар дурдаагүй байна.) Хүчирхийлэл үйлдэгчийн хөдөлмөр эрхлэлтийн байдал: • Ажилтай (23 хэрэг буюу 44.2 хувь); • Ажилгүй (17 хэрэг буюу 32.6 хувь); (12 шийдвэр буюу 23 хувьд нь хөдөлмөр эрхлэлтийн байдлыг дурдаагүй байна.) Хохирогчийн боловсролын байдал • Дээд (24 хэрэг буюу 46.1 хувь). (28 шийдвэр буюу 53.8 хувьд нь хохирогчийн боловсролын байдлын дурдаагүй байна.) Хүчирхийлэл үйлдэгчийн боловсролын байдал: • Дээд (11 хэрэг буюу 21.1 хувь); • Бүрэн дунд (18 хэрэг буюу 34.6 хувь); • Тусгай дунд (7 хэрэг буюу 13.4 хувь). (16 шийдвэр буюу 88.8 хувь нь хүчирхийлэл үйлдэгчийн боловсролын байдлын дурдаагүй байна.)
Хүчирхийллийн хэлбэрийг авч үзвэл	• Бие мах бодын хэлбэр- 23 хэрэг буюу 44.2; • Сэтгэл санааны хэлбэр-52 хэрэг буюу 100 хувь; • Эдийн засгийн хэлбэр- 11 хэрэг буюу 21.1 хувь. (Давхардаж байдалар) Хүчирхийлэл үйлдэгч архи хэрэглэдэг эсэх: • Тийм - 39 хэрэг буюу 75 хувь; • Үгүй - 13 хэрэг буюу 25 хувь.

Хүчирхийлэл үйлдэгчийн ял шийтгэлийн байдал	Хүчирхийлэл үйлдэгч өмнө гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэний улмаас ямар нэгэн шийтгэл хүлээж байсан эсэх: • Тийм -42 хэрэг буюу 80.8 хувь; • Үгүй - 10 хэрэг буюу 19.2 хувь .
Ямар төрлийн эрх хязгаарлах арга хэмжээ авсан эсэх	Эрхийг хязгаарлах арга хэмжээний төрөл: • Тусдаа амьдархыг даалгах -(26 хэрэг буюу 61.1 хувь); • Хамгаалах байранд, эсхүл хцүхэд асран хцмцүжцүлэх эсхүл халамжийн байгууллагад байгаа хохирогчтой уулзах болон уулзахаар оролдохыг хориглох- (12 хэрэг буюу 44.4 хувь); • Хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг хориглох-(14 хэрэг буюу 16.6 хувь); • Асрамжиндаа байгаа насанд хцрээгүй хцнтэй харилцахыг түр хориглох- (3 хэрэг буюу 16.6 хувь) (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлахдаа тцүний хүчирхийллийн шинж, үр дагавар нөхцөл байдал, хүчирхийлэл үйлдэгчийн зан төлөв зэргийг харгалзан эрх хязгаарлах арга хэмжээг дангаар нь буюу давхардуулан авсан байна. Тухайлбал, зан үйлд нөлөөлөх сургалтанд хамруулах, тусдаа амьдрахыг даалгах зэрэг арга хэмжээг давхардуулан авсан байна.)

ГБХТГХ-ийн 8 дугаар зүйлийн нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллагын бүрэн эрхэд “хууль хамгаалах байгууллагуудтай хамтран ажиллаж ...”, мөн хуулийн 9 дүгээр зүйлд заасан Цагдаагийн байгууллагын үүргийн дагуу цагдаагийн албан хаагч нь холбогдох хуульд заасны дагуу хүчирхийлэл үйлдэгчийг албадан саатуулах, баривчилж байна.

Үүнтэй холбоотойгоор 2007 оны 1 дүгээр сарын 10-ны өдрөөс 2007 оны 2 дугаар сарын 8^а-ны өдөр хүртэл албадан саатуулах, баривчлах төвд 1982 хүн баривчлагдсанаас 414 хүн нь гэртээ агсам тавьж гэр бүлийн гишүүдийн амгалан тайван байдлыг алдагдуулсан байна. Баривчлагдсан хүмүүсийн насны хязгаар 19-58 насны хооронд, эрхэлсэн тодорхой ажилгүй, эрэгтэй хүмүүс байна. 2007 оны 8 дугаар сарын 20-ны өдрөөс 2007 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн хооронд 2970 хүн саатуулагдсаны 206 хүн нь гэртээ агсам тавьж, хэрүүл өдөөн гэр бүлийн гишүүдээ зодож танхайрсан байна. Эдгээр саатуулагдсан хүний 99.6 хувь нь эрэгтэй хүн байна. 7 буюу 3.3 хувь нь хөдөлмөр эрхэлдэг ба саатуулагдсан хүмүүсийн насны байдал нь 19-67 насны

³ Судлаачийн зүгээс тухайн цаг үеийг сонгон авсан.

хүмүүс байна. Мөн Цагдаагийн ерөнхий газрын харьяа Хүүхдийн хаяг тогтоох газарт 2004-2008 оны эхний 4 сарын байдлаар хараа хяналтгүй тэнэж яваа хүүхдийн тоо 1254 байгааг хүйсээр авч үзвэл:

- Эрэгтэй-1005 (80.1 хувь);
- Эмэгтэй-249 (19.9 хувь).

Тус төвд 2004-2008 оны эхний 4 сарын байдлаар 4483 хүүхэд хүлээн авч үйлчилсэн байна. Хүүхдүүдээс тэнэх болсон шалтгаан юу болох талаар тус төвийн ажилтнууд тандахад нийт хүүхдийн 37 нь аав зоддог, 47 нь хойт эцэг зоддог, 144 хүүхэд өөрөө тэнэдэг гэж хариулсан байгаа нь нэг өнцгөөс харахад хүүхдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртүүлж байгаа болон өргөж болзошгүй нөхцөлд байлгаж байна гэж дүгнэж болохоор байна. Хаяг тогтоох төвд ирсэн хүүхдүүдийн насны байдлыг авч үзвэл 3-7 насны 39 хүүхэд, 10 настай 55 хүүхэд, 12 настай 36 хүүхэд байна. Цагдаагийн ерөнхий газрын харьяа Хүүхдийн хаяг тогтоох төвийн ажилтнуудтай уулзаж санал солилцоход өөрсдийн болоод хүүхдийн өмнө тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар ярьснаас:

- Ирж буй хүүхдүүдийн ихэнх нь эцэг, эх нь салсан, эсвэл хойд эцэг, хойт эхтэйгээ амьдардаг. Гэр бүлийн гишүүд нь зодож дарамталдаг байна. Тиймээс гэр бүлийн гишүүд тэр дундаа эцэг, эхийн үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээх хариуцлагыг нарийн тодорхой зааж өгөх;
- Ирж буй хүүхдийн ихэнх нь арьс өнгөний болон бэлгийн замын өвчтэй ирдэг. Манай байгууллагын нэг хүүхдийн эмчилгээний зардал сард 25.000 төгрөг зарцуулах норм байдаг. Энэ нормыг нэмэх хэрэгтэй учир нь хүүхэд гадны аливаа хүчин зүйлсээс болоод өвдсөн, эмчилгээ шаардлагатай тохиолдолд нэг хүүхэд зарцуулах норм нь дууссан гээд эмчлэхгүй байх уу гэдэг асуудал гарч ирнэ. Тиймээс төсвийг зах зээлийн өнөөгийн байдалд тохируулан тооцдог болгох.

Эдгээрээс дүгнэхэд:

1. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд гэр бүлийн хүчирхийлэл гэдгийг ... эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй үйлдэл, эс үйлдэхүй гэж томьёолсон нь захиргааны зөрчил гэж үзэж болохоор байна. Гэхдээ Захиргааны хариуцлагын тухай хуульд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрсөн этгээдэд ямар төрлийн хариуцлага хүлээлгэх талаар нэг мөр хуульчилж өгөөгүй байна. Тиймээс шийтгэлийн хэлбэрийг хэн, хэрхэн ногдуулах талаар хуульчлах нь зүйтэй болов уу;

2. Гэр бүл нь нийгмийн анхдагч нэгж бөгөөд түүний хүрээнд гарч буй аливаа хүчирхийлэл нь ахуйн хүрээнд далд, шууд болон дамжмал байдлаар үйлдэгддэг, хохирогч нь хүчирхийлэгчтэй гол төлөв

хамт амьдардаг зэрэг шалтгааны улмаас хохирогч нь хүчирхийлэл үйлдэгчийг нуун дарагдуулан Үндсэн хуульд заасан суурь эрх, эрх чөлөөгөө хязгаарлуулдаг. Иймд аливаа хүчирхийллээс үүдэн гарах гэм хорын хохирлыг хэрхэн, яаж бодитойгоор үнэлэн тогтоох талаар аргачлал Иргэний холбогдох хууль тогтоомжид хуульчлах шаардлагатай байна;

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 129 дүгээр зүйлд шүүгч шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн холбогдолтой хэрэг маргааныг шийдвэрлэхдээ насанд хүрээгүй хүүхэд болон хөдөлмөрийн чадваргүй эцэг, эхийг тэжээн тэтгүүлэх, насанд хүрээгүй хүүхдийг эцэг, эхийн хэн нэг дээр байлгах, гэрлэгчдийг тусдаа амьдрахыг даалгах, гэрлэгч хэн нэгийг тэжээн тэтгүүлэх, орон сууц болон хамтран өмчлөх дундын өмч, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, захиран зарцуулахыг хориглох, шүүхийн зардлын зохих хувийг урьдчилгаа болгон төлүүлэх, зохигчийг эвлэрэх талаар хугацаа заах гэсэн арга хэмжээг урьдчилан авахаар захирамж гаргаж болно гэж заасан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг тусдаа амьдрахыг даалгах, хамгаалах байранд, хүүхэд асран хүмүүжүүлэх, эсхүл нийгмийн халамжийн байгууллагад байгаа хохирогчтой уулзах болон уулзахаар оролдохыг хориглох, хамтран өмчлөх дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахыг хориглох, асрамжиндаа байгаа насанд хүрээгүй хүнтэй харилцахыг түр хориглох, зан үйлд нөлөөлөх албадан сургалтад хамруулах, шаардлагатай гэж үзвэл согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг хууль тогтоомжийн дагуу захиргааны журмаар албадан эмчилгээ хийлгэх, эсхүл албадан хөдөлмөрлүүлэх гэсэн арга хэмжээг авахаар хуульчилж өгсөн.

Хүчирхийлэл үйлдэгч болон гэрлэгчдийг захирамжид заасан хугацаанд тусдаа амьдарч байгаа эсэхийг ямар процедураар, хэн хэрэгжүүлэх эсэх нь (Шүүхийн шийдвэр гүйцэтгэгч хяналт тавих уу, тухайн дүүргийн харьяа цагдаагийн байгууллагын ажилтан хяналт тавих уу гэдэг) нь тодорхой бус байна. Тиймээс ямар процедураар, хэн хэрэгжүүлэхийг нарийвчлан тусгаж өгөх;

4. Хохирогчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Гэр бүлийн хүчирхийллийн тухай хуульд заасны дагуу шүүхээс хүчирхийлэл үйлдэгчийн эрхийг хязгаарлах арга хэмжээ болох “тусдаа амьдрахыг даалгах” арга хэмжээ оногдуулахдаа тус хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2-т заасан “хохирогчтой уулзах болон уулзахаар оролдохыг хориглох” эрх хязгаарлах арга хэмжээг хамтатган авч байх.

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ХУУЛИЙН ЗАРЧМЫН ТҮҮХЭН ХӨГЖИЛ



ХЗҮХ-ийн Иргэн,
эдийн засгийн эрх
зүйн секторын эрдэм
шинжилгээний ажилтан
Д.Болормаа

Монгол Улсын Иргэний хуулийн зарчмын түүхэн хөгжлийг авч үзэхийн өмнө Монголын Иргэний хуулиуд батлагдан гарахад нөлөөлсөн хүчин зүйлийн талаар авч үзэхийг зорьсон бөгөөд хууль цаазын сэтгэлгээний талаар авч үзэхийг хичээв.

Эрх зүйн сэтгэлгээ эрт дээр үеэс бүр XII-XIII зууны үеэс хөгжиж ирснийг түүхэн эх сурвалжууд гэрчилнэ. Шинэ үеийн эрх зүйн сэтгэлгээ хэрхэн хөгжиж ирснийг тухайн үеийн түүхэн эх сурвалжуудад дүн шинжилгээ хийх замаар тодорхойлж болох¹ талаар профессор Д.Наранчимэг үзсэн байхад доктор, профессор Н.Лүндэндорж аливаа түүхэн үеийн үзэл, эрх зүйн сэтгэлгээг судлан үзэхдээ тухайн үеийн хууль цаазын дурсгалт бичгүүдийн эх сурвалж чухал үүрэгтэй байдаг² гэжээ.

Монголчуудын эрх зүйн үзэл сэтгэлгээ, нүүдэлчдийн иргэншил соёл дунд үүсэн бүрэлдэж, он цагийн уртыг туулж, түүхийн нугачаанд баларч, бүдгэрч, тодорсоор өдий хүрчээ. Нүүдэлчдийн төр ёсны түүхэн хувь зохиол ч ийм л дүр төрхтэй байхаас гадна өөр аргагүй байсан бизээ. Гэвч монгол үндэстэн өдгөө туурга тусгаар улс гүрэн хэвээр оршиж, төр ёсыг хэрэгжүүлж ирсэн нь эрх зүйн соёл сэтгэлгээний баялаг түүхийг үлдээж ирсэн гэдгийн хангалттай нотолгоо юм.³

Мөн Монголчуудын эрх зүйн сэтгэлгээний уламжлал, шинэчлэл, хөгжлийн динамикийг тодорхойлоход түүний дотоод хөгжил, хувьсал, дэвшил, өөрчлөлтийг шалгуур болгож түүхийн үеүдийг тодорхойлох явдал чухал юм. Ингэхдээ тухайн үеийн нийгмийн харилцааг зохицуулж байсан аливаа хэм хэмжээний эх сурвалжийг гол шалгуур болгох нь онол, арга зүйн хувьд чухал юм. Энэ талаар Монголын судлаачдын хийсэн судалгаа нь төр, эрх зүйн түүхэн уламжлалыг түүхийн ерөнхий үечлэлийн дагуу авч үзэх явдал нэлээд түгээмэл байдаг байна. Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан нарын хамтран бичсэн

¹ "Монгол Улс дахь эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй судлалын хөгжил". УБ., 2004 он. "Монгол Улсын иргэний хууль тогтоомж ба эрх зүйн шинэтгэл". Д.Наранчимэг, Д.Аюуш нар, 120 дахь тал.

² Н.Лүндэндорж. "Төр эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага". УБ., 2002 он. 215 дахь тал.

³ Н.Лүндэндорж. "Төр эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага". УБ., 2002 он. 190 дэх тал.

“Төр, эрх зүйн түүхэн уламжлал” бүтээлд 1911 оноос хойшхи үеийг Шинэ үеийн төр, эрх зүй (XX зууны 20-иод оноос 90 он хүртэл), түүний дараах үеийг Монголын шинэхэн үеийн төр эрх зүй (1990-ээд он) хэмээн ангилан хуваасан байна. Энэ үечлэлийг нэлээд ерөнхий үечлэл болсон байна хэмээн зарим эрдэмтэн дүгнэжээ.⁴

Харин Академич С.Нарангэрэл монголын эрх зүйн түүхэн хөгжлийг эрх зүйн эх сурвалжийн төрөлжүүлэлт, тогтолцооны онцлогийг шалгуур болгож, Монголын нэгдсэн үндэстний эрх зүйн тогтолцоо бүрэлдсэн үе, Хууль зүйлийн бичгүүдийг төрөлжүүлсэн үе, орчин үеийн эрх зүйн тогтолцоо бүрэлдсэн үе гэж ангилсан. Эдгээр үечлэл, ангиллууд ихэвчлэн он цаг, түүх, төрийн байгууллын шинж чанарыг шалгуур болгож, хууль цаазын сэтгэлгээний хувьсал өөрчлөлтийг харгалзахаасаа илүү эрх зүйн оршин тогтнож байсан институтуудыг гол үндэс, тулгуур болгож авч үзсэн байна гээд доктор Н.Лүндэндорж монголын эрх зүйн түүхэн хөгжлийг институтын түвшинд хууль цаазын сэтгэлгээний шинж, чанарыг шалгуур болгон 1911 оноос хойшхи үеийг Өрнийн эрх зүйн соёл, сэтгэлгээ нэвтэрсэн үе, Социалист эрх зүйн сэтгэлгээний үе, Орчин үеийн эрх зүйн сэтгэлгээний үе хэмээн ангилан авч үзсэн байна.

Шинэ Монгол Улсын хууль, эрх зүйд өрнийн эрх зүйн соёлжингүй ололтуудыг нэвтрүүлэх ажил нэлээд гүнзгийрсэн. Энэ талаар Академич С.Нарангэрэл “Үндсэн хуудийн, иргэний хуулийн төслийг боловсруулахад дан ганц улсын бус, Европын олон улс орнуудын хууль, эрх зүйг харгалзан үзэхийн чухлыг онцолж байсан гэжээ”.⁵

1920-иод оны эхэн үед монголын эрх зүйн сэтгэлгээнд өрнийн нөлөө нэлээд олон талаар нээлттэй нөлөөлсөн үе гэж хэлж болно. Ардын хувьсгал ялж, Монголын тусгаар тогтнол эргэлт буцалтгүй болж, шинэ монголын хууль цаазын тогтолцоог бүрдүүлэхэд хөгжингүй орнуудын эрх зүйн тогтолцоо, онол, сэтгэлгээний ололтоос ашиглах шаардлага байгаа гэдгийг монголын тухайн үеийн сэхээтэн, улс төрчид ухаарч байсан.⁶

Монгол Ардын нам, засаг төр улс орны эдийн засаг, ард түмний амьдралыг дээшлүүлэхийн тулд юуны өмнө 1922 онд Эдийн засгийн бодлого боловсруулах комисс байгуулж, тэдний боловсруулсан төслийг 1923 онд Засгийн газрын хурлаар баталжээ. Уг баримт бичигт: мал аж ахуйг хөгжүүлж, малын гаралтай түүхий эд боловсруулах, газар тариалан, зам тээвэр, гүүр, холбоог үүсгэх, үндэсний мөнгөн тэмдэгт гаргах, санхүү, мөнгөний бүртгэлийн систем бий болгох зэрэг олон чухал асуудлыг тусгасан байна. Тухайн үед өмчийн улсын, хувийн,

⁴ Мөн тэнд. 192 дахь тал.

⁵ Н.Лүндэндорж. “Төр эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага”. УБ., 2002 он. 227 дахь тал.

⁶ Н.Лүндэндорж. “Төр эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага”. УБ., 2002 он. 226 дахь тал.

хамтын гэсэн төрөлтэй⁷ байв.

Иргэний хуулиудыг Монгол Улсын Үндсэн хуулиуд өөрчлөгдөн шинэчлэгдэхэд түүнд нийцүүлэн батлан мөрдсөн. 1922 онд ОХУ-ын Иргэний хууль батлагдан гарсан нь манай улсад Иргэний хууль батлагдан гарах гол эх сурвалж болсон ба тухайн үед Зөвлөлтийн хуульч, мэргэжилтэн П.В. Всесвятский Шүүх Яаманд уригдан ирж уг хуулийг зохиох комиссын гишүүн төдийгүй гардан боловсруулалцан хүн юм.⁸

Монгол Улсын анхны Үндсэн хууль 1924 онд батлагдсаны дараа мөн анхны Иргэний хуулийг 1926-1929 онд хэсэгчлэн боловсруулж, тухай бүр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн нийт 10 бүлэг, 217 зүйл бүхий хуулийг батлан мөрдүүлсэн нь анхны төрөлжсөн хууль болсон байна.

Нөлөөлсөн улс төр, хууль зүй, зан заншил болон зарим гадаад улсын Иргэний хуулийн үзэл санаа, бүтэц загвар эх сурвалж болсон байна.⁹

Улсын буюу ард түмний өмчийн эрх зүйн харилцааны объектод газар, хөрсөн доорх баялаг, үйлдвэр, аж ахуйн газар хамаарч байсан бөгөөд төр түүнийг худалдаж, бэлэглэхгүйгээр зөвхөн ашиглаж, захиран зарцуулж, зохион байгуулах эрхтэй байв. Хувийн өмчийн харилцааны зүйлд мал, бусад эд хөрөнгө байсан, түүний өмчлөгчид нь баян язгууртан, дунд зэргийн ба бүр ядуу гэсэн ялгавартай байсан.¹⁰

Мэдээж шинээр хамгийн анх удаа баталсан Иргэний хуулийн ач холбогдол нь иргэний эрх зүйн харилцааг хуульчлан тогтоосноос гадна иргэдийн өмчлөх, өв өвлөх гэх мэт харилцааг зохицуулсны дээр уламжлалт зан заншлын дэвшилтэт хэм хэмжээг өвлөн авсан МУ-ын Иргэний эрх зүйн сэтгэлгээний түүхэнд чухал алхам болсон нь гарцаагүй юм.

Дараагийн буюу 2 дахь Иргэний хуулийг 1940 онд хуралдсан 8 дугаар Их Хурлаас баталсан БНМАУ-ын Үндсэн хууль нь Монголын эдийн засаг, нийгмийн харилцаанд гарсан гүн гүнзгий өөрчлөлтийг тусгаж, хувьсгалын ардчилсан шатнаас социалист байгууллын үр үндсийг хөгжүүлэн бэхжүүлэх шинэ үед шилжин орсныг батлан тунхагласан нь үүнээс өмнө мөрдөж байсан Иргэний хуулийг өөрчлөн шинэчлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлага гарсан гэж үзэж болно. Үүнээс хойш 12 жилийн дараа Иргэний хуулийг 1952 онд батлан гаргасан нь одоогийн мөрдөгдөж байгаа Иргэний хуультай төстэй болсон хэмээн эрдэмтэн, судлаачид дүгнэсэн байдаг.

1952 оны Иргэний хуулийг БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1952 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн 38 дугаар зарлигаар Иргэний

⁷ Т.Мөнхжаргал. "Монгол Улсын иргэний цаазын товчоон". УБ., 2006 он. 173 дахь тал.

⁸ Т.Мөнхжаргал. "БНМАУ-ын аж ахуйн эрх зүй. УБ., 1990 он. 79 дэх тал.

⁹ Т.Мөнхжаргал. "Монгол Улсын иргэний цаазын товчоон". УБ., 2006 он. 175 дахь тал.

¹⁰ Т.Мөнхжаргал. "Монгол Улсын иргэний цаазын товчоон". УБ., 2006 он. 174 дэх тал.

шинэ хуулийг батлан гаргажээ. Энэхүү хуулийг батлахад 1926 оны Иргэний хууль, 1940 оны Үндсэн хуулийн үзэл баримтлал, бусад эрх зүйн акт, гадаад орны эрх зүйн актууд хууль зүйн эх сурвалж болсон байна. 1926 оны Иргэний хуультай харьцуулахад боловсронгуй болсон байдаг.

Хуульд өмчийн эрхийн талаар заахдаа нэгд, улсын өмч, хоёрт, хоршооллын ба бусад олон нийтийн өмч, гуравт, ард иргэдийн амины өмч байна гэжээ. Улсын өмчид ямар ч хөрөнгө байж болохоор зохицуулжээ.

3 дахь удаагийн шинэчлэгдэн батлагдан гарсан Иргэний хууль мөн л 1960 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалд шууд нийцүүлэн гаргасан гэж үзэх үндэстэй. 1963 оны 2 дугаар сарын 9-нд БНМАУ-ын Ардын Их Хурлын тогтоолоор “БНМАУ-ын Иргэний хууль”-ийг баталж, мөн оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоожээ.

1963 оны Иргэний хууль урьдах хуультай харьцуулбал бүлэг, зүйлийн бүтэц, систем, дотоод зохион байгуулалт, эрэмбэ дараалал ихэд боловсронгуй болсон бөгөөд үүний язгуур үндэс нь улс орны гадаад, дотоод нөхцөл байдал хийгээд эрх зүйн эх сурвалжууд байсанд оршино.¹¹

Тухайн үед өмчийн төрлийг социалист өмч, амины өмч гэж ялгадаг байсан. Социалист өмч нь улсын өмч (бүх ард түмний хөрөнгө), хоршооллын өмч (хөдөө аж ахуйн нэгдэл, хоршооллын бусад байгууллагын өмч), үйлдвэрчний эвлэл, олон нийтийн бусад өмчөөс бүрддэг байв.¹²

4 дэх удаагийн Иргэний хуулийг 1980-аад оны сүүлч, 90-ээд оны эхээр социалист систем задарч, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоог халж, нийгмийн чиг баримжаат зах зээлийн эдийн засгийг хэвшүүлэх зорилгыг өмнөө тавьсан улс орнуудын нэгэн адил Монгол Улсын эдийн засгийн гүн гүнзгий өөрчлөлтийг 1990-ээд оноос хойш хийж эхэлсэн.

Тус орны эдийн засаг-нийгмийн хөгжилд гарсан өөрчлөлт, шинж байдлыг дүгнэвэл эдийн засгийн салбарт капитализмын урсгал хөгжлийг (хувийн өмчит малчин ардын жижиг татварын аж ахуй, жижиг худалдаачид, гар урчууд зэрэг) төрийн удирдлагад захируулах оролдлого хийж тус секторыг хүчтэй болгож, хэдийгээр ардын аж ахуйтныг хохироох замаар боловч эдийн засгийн хөгжлийг цаашид хангах хуримтлалыг ямар нэгэн хэмжээгээр буй болгосон нь томоохон ололт байв.

Манай улсад урьд нь огт байгаагүй, үйлдвэр аж ахуйн салбарууд болон соёл, боловсрол, эрүүлийг хамгаалах мөн тэрчлэн дайны

¹¹ Мөн тэнд, 188 дахь тал.

¹² Мөн тэнд.

жилүүдэд ихэд өссөн батлан хамгаалахын зардал мал аж ахуйгаас авах албан татвар, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг улсаас хямд үнээр авах (экспорт, импортын зөрүүгээс) хөрөнгийн төвлөрөл бий болж байсан.

1940-өөд оны сүүл үеийн БНМАУ-ын эдийн засгийн бүтцэд бэлчээрийн мал аж ахуй үндсэн салбар нь байсан. Аж үйлдвэр, уул уурхай, тээвэр холбоо, барилга зэрэг бусад салбар шинээр хөгжиж байсан боловч улс ардын аж ахуйн бүтцэд тэдгээрийн эзлэх хувь бага байсан. Эдийн засгийг өмчийн харилцааны үүднээс нь авч үзвэл хувийн, хоршооллын, улсын гэсэн гурван үндсэн өмч оршиж байв. Гэвч өмчийн эдгээр хэлбэрийн өмчийн шинж чанар нь нам, төрийн үндсэн баримт бичгүүд түүх нийгэм судлалын бүтээлүүдэд тодорхойлогдсоноос үнэн хэрэгтээ арай өөр байдалтай байжээ.

Малчин ардууд малаа хэлбэрийн хувьд өмчлөх эрхтэй, хувийн өмчтөний категорид үнэн хэрэгтээ мал өсгөх шахуу даалгавар төлөвлөгөө бүтээгдэхүүнээ улсад хатуу үнээр тушаах явдлыг төрөөс хуульчлан тогтоосон, дотоод зах зээл хумигдаж, дотоод зах зээлд ганц оронтой харилцах (өрсөлдөөнгүй учраас худалдаа гэж хэлэхэд хэцүү) болж, таваарын үйлдвэрлэл явуулах бодомжгүй болсон зэрэг нь малчдын хувийн өмчтөний шинжийг алдагдуулж өмчийнхөө бүрэн эзэн байх эрх туйлын хязгаарлагдмал улсын албат, хамжлагын байдалтай болгож, өмч хөрөнгөө арвижуулах бус харин түүнээс салах эрмэлзэлтэй болгожээ.

Иргэний хуулиуд дахь зарчмуудын талаар авч үзвэл

Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын Их Хурлын 2002 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр батлан гаргасан Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт. Иргэний хууль тогтоомж нь:

- иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш;
- бие даасан байдал;
- өмчийн халдашгүй байдал;
- гэрээний эрх чөлөө;
- хувийн хэрэгт хөндлөнгөөс оролцохгүй байх;
- иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр хэрэгжүүлэх;
- зөрчигдсөн эрхийг сэргээлгэх;
- шүүхээр хамгаалуулах зарчимд үндэслэнэ хэмээн тодорхойлон заасан байна.

Одоо мөрдөгдөж буй Иргэний хуулийн адил зарчмыг тодорхой зааж өгөөгүй ч 1926 оны Иргэний хуульд 3 дугаар зүйлд “Аливаа асрамжлан хамгаалах хэргийг гүйцэтгэхээр томилогдсон хүмүүс

асрамжлан хамгаалах тэрхүү хүмүүс ба хөрөнгө зэргийг сайнаар асрамжлан хамгаалахаас гадна тэдний өмнөөс төлөөлөн аливаа хэргийг гүйцэтгэж байваас зохимой. Мөн хуулийн 6 дугаар зүйлд “Аливаа асрамжлан хамгаалах хүмүүс буюу тэдний хөрөнгө хогшил бүхий газрын ардын шүүх таслах газартаа мэдүүлэн батлуулваас зохимой”. Мөн 10 дугаар зүйлд “Асрамжлан хамгаалах хүмүүсийг томилохдоо эр эм ялгалгүй итгэмж бүхий бөгөөд чадвартай хүмүүсийг сонгон томилвоос зохимой”.

103 дугаар зүйлд “Аливаа хамтын хөрөнгийг зохих этгээдэд тус тусад нь хуваарилан авахад завсартаа хэлэлцэж, тусгай гэрээ байгуулвал зохих албаны газраа гэрчлүүлэх буюу хэрэв өөрсдөө эвээр хэлэлцэн үл тохирох аваас харьяат шүүх таслах газраа мэдүүлж шийтгүүлбээс зохимой” гэсэн нь зөрчигдсөн эрхийг сэргээлгэх зарчим, тэгш эрхийн зарчим, шүүхээр хамгаалуулах зарчим гэж үзэж болохоор байна.

Харин тус хуулийн Долдугаар бүлгийн Хоёрдугаар анги нь Аливаа эд юмсыг барьцаалуулан өгөх ба авахдаа байгуулах гэрээ бичгийн тухай заасан нь гэрээний эрх чөлөөний зарчим юм.

Найм, аравдугаар бүлэг нь Аливаа иргэний хэргийн учраа харилцан эдлэх ба хүлээх эрх, үүргийн тухай заасан нь тэгш эрхийн зарчимтай нийцэж байна гэж дүгнэж болохоор байна.

Харин Монгол Улсын хоёр дахь Иргэний хууль болох 1952 оны хуулийн Хоёрдугаар бүлгийн 4-т эрхийн субьектын талаар тусгасан ба Бүгд найрамдах Монгол Ард Улсын аж ахуйг хөгжүүлэх ба хөдөлмөрчдийн аж байдлыг сайжруулах зорилгуудын үүднээс шүүхээр эрхээ хязгаарлуулаагүй бүх иргэдэд тэдгээрийн эрэгтэй, эмэгтэй, арьс өнгө, үндэстэн, шашин шүтлэгийг ялгалгүйгээр эрхийг эдлүүлнэ. Өөрөөр хэлбэл, хуулиар хориогүй ажил ба мэргэжлүүдийг чөлөөтэйгээр сонгон авах иргэний гүйлгээнээс хасагдаагүй эд хөрөнгөнүүдийг өөртөө олж авах ба бусдад шилжүүлэх зэрэг иргэний эрх, үүргүүдийг эдэлнэ.

Мөн хуулийн хоёрдугаар бүлгийн 5-д: Хуульд тусгай зааснаас бусад шалтгаанаар хэн ч атугай иргэний эрхээ хязгаарлуулсан буюу хасагдсан байж болохгүй гэсэн нь эрх тэгш байх зарчмыг агуулсан байна.

Энэ хуульд гэрээний эрх чөлөөний талаар урьдны хуулиас дэлгэрэнгүй зохицуулсан нь гэрээний эрх чөлөөний зарчмын илрэл гэж үзэж болохоор байна. Тухайлбал, арилжааны гэрээ, эд хөрөнгийг хөлслөх, орон сууц хөлслөх тухай, ажлыг гүйцэтгэхээр хэлэлцэн авах тухай буюу ажлын гэрээ, контрактац гэрээний тухай, зээлийн гэрээ, батлан даах гэрээ, даалгаврын тухай, итгэмжлэл, комисс, хадгалалт, даатгалын гэрээний талаар тусгасан байна.

1963 оны Иргэний хуулийн 7 дугаар зүйлд Иргэдийн эдэлбэл зохих

иргэний эрхийн талаар тусгасан. БНМАУ-ын иргэд нь аминыхаа өмчид эд хөрөнгө, малтай байх; орон сууц бусад эд хөрөнгө ашиглан, хэрэглэх; оршин суух газар, эрхлэн хийх ажлаа сонгон авах; нээлт, шинэ бүтээл, оновчтой санал гаргах; шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийн талаар зохиогчийн эрх эдлэх; эд хөрөнгө өвлөх, гэрээслэх, мөн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус иргэний бусад эрхийг хууль ёсоор эдэлнэ.

Мөн өмчийн халдашгүй эрхийн болон гэрээний эрх чөлөөний талаар тухайлбал, худалдах-худалдан авах гэрээ, бэлтгэлийн (бэлтгэн нийлүүлэх) гэрээ, эд хөрөнгө хөлслөх, түрээслэх, орон сууц хөлслөх гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, тээвэрлэлтийн гэрээ, даатгалын гэрээ, зээлийн гэрээ, даалгаврын гэрээ, комиссын худалдааны гэрээ, хадгалалтын гэрээ, арилжааны гэрээ, эд хөрөнгө үнэ төлбөргүй хэрэглэх гэрээ зэрэг гэрээний талаарх заалт байх бөгөөд тус бүрт нь гэрээний эрх чөлөөний талаар тусгажээ. Өмчийн халдашгүй байдлын талаар мөн тусгасан байна.

МУ-ын 4 дэх Иргэний хууль 1994 оны 11 дүтээр сарын 1-ний өдөр батлагдсан. Одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Иргэний хуульд заасан зарчмуудыг энэхүү хуульд тусгаагүй. Харин 1992 онд батлагдсан шинэ Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 3-т Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

... 3) хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө хэмээн иргэд хувийн өмчтэй байж болох талаар хуульчилсан нь өмчийн халдашгүй байдлын зарчмын үндэс нь болсон. 1994 оны Иргэний хуулийн 10 дугаар бүлэгт Иргэний хувийн өмчийн талаар тусгасан. Мөн өмчлөх эрхийн баталгааны талаар 153 дугаар зүйлд заасан.

Уг хуульд нийтийн гэрээ, гэрээ заавал байгуулах, урьдчилсан гэрээ, эвлэрийн гэрээ, гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээ, нэрлэгдээгүй гэрээ, гуравдагч этгээдэд ашигтай гэрээ, гэрээг өөрчлөх ба цуцлах талаар хуульчлагдсан байна. Мөн тус хуульд бэлэглэл, хандивын гэрээ, худалдах-худалдан авах гэрээ, бэлтгэн нийлүүлэх гэрээ, арилжааны гэрээ, эрчим хүч, бусад нөөцөөр хангах гэрээ, зээл, эд хөрөнгө хөлслөх, орон сууц хөлслөх, эд хөрөнгө түрээслэх, эд хөрөнгө үнэ төлбөргүй ашиглах, оюуны үнэт зүйл ашиглах гэрээний талаар тусгасан. Мөн ажил гүйцэтгэх, төсөл зохиох ажил гүйцэтгэх, судалгаа, шинжилгээний ба туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэх гэрээ, зохиол бүтээл туурвих ажил гүйцэтгэх гэрээний талаар хуульчлан

уг харилцаануудыг зохицуулж байсан бол хөдөлмөрлөх эрхийн талаар хөдөлмөрийн гэрээг Иргэний хуульд тусгасан байсныг шинээр Хөдөлмөрийн хууль батлагдан гарснаар хүчингүй болсон.

Мөн тээвэрлэлтийн гэрээ, даалгавар, зуучлал, комисс, хадгалалт, асран тэтгэх, даатгал, мөнгөн хадгаламжийн гэрээ, хамтран ажиллах гэрээний талаар тусгаж тус бүрт нь гэрээний эрх чөлөөний талаар хуульчилсан байна.

Мөн 1994 оны хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: Монгол Улсын иргэд нь хуульд зааснаар эд юмс, оюуны үнэт зүйлийг өмчлөх, хэлцэл хийх, зохиогчийн эрх эдлэх, эд хөрөнгө, эрх өвлөх, гэрээслэх, хуулийн этгээд байгуулах, хуулийн этгээд байгуулахгүйгээр аж ахуй эрхлэх, оршин суух газар, эрхлэн хийх ажил, мэргэжлээ сонгон авах, хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа явуулах, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины бусад эрх эдэлнэ. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт Иргэний эрх зүйн эрхийн чадвар буюу иргэний эрх эдлэх, үүрэгтэй байх чадварыг Монгол Улсын иргэд тэгш эдэлнэ хэмээн тэгш эрхийн зарчмыг хуульчилсан байна.

Дээрхээс үзэхэд Монгол Улсын Иргэний хууль 1926 оноос одоог хүртэл 80 гаруй жилийн хугацаанд 5 удаа шинэчлэн боловсруулж ирсэн бөгөөд хууль бүр тухайн үеийн нийгмийн хэрэгцээ, шаардлагаар гарсан нь мэдээж. Эдгээр хууль манай улсын нийгэм, эдийн засаг, оюун санаа, шашин, зан үйлийн хөгжил өөрчлөлтийн бодит өөрчлөлтийг харуулсан чухал баримт, эрдэм шинжилгээ, судалгааны болон иргэн, эдийн засаг, аж ахуйн харилцааг зохицуулж ирсэн чухал баримт, эх сурвалжууд юм.

Иргэний эрх зүйн “зарчим” нь 2002 оны шинэ Иргэний хуульд тусгайлан тусгагдсан байна. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хуулиудад ямарваа нэгэн байдлаар тусгагдаж байсан талаар дээр өгүүлсэн билээ.

х х х х х

ЗАЛРУУЛГА

“Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2009 оны №3-т хэвлэгдсэн “Хууль бус донор ба хүний наймаа” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүлэлд Улаанбаатар Буян ХХК-ийн талаар дурдагдсан мэдээлэл нь цахим эх сурвалжаас авагдсан бөгөөд мэдээлэл нь бодит байдалд нийцэхгүй, үндэслэлгүй ташаа мэдээлэл болох нь тогтоогдсон тул энэхүү мэдээллийг өөрийн өгүүлэлдээ ашиглан тус байгууллагаар үйлчлүүлсэн талийгаачдын төрөл, төрөгсдийн сэтгэл зүй, итгэл үнэмшилд эргэлзээ төрүүлж “Улаанбаатар Буян” ХХК-ийн нэр хүндэд халдсандаа судлаач С.Гантулга миний бие чин сэтгэлээсээ хүлцэл өчье.

МОНГОЛ УЛС ДАХЬ ЭРҮҮДЭН ШҮҮХИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ БА ТҮҮНИЙ ШИНЭЧЛЭЛ

Магистр Г.Төмөрбаатар

I

Сэжигтэн, яллагдагч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх,
түүнчлэн өөрийн гэм буруугүйг болон хэргийн бусад
байдлыг нотлох үүрэг хүлээхгүй¹

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг НҮБ-ын конвенцид Монгол Улс 2000 оны 11 дүгээр сарын 2-ны өдөр нэгдэн орсон ба энэхүү конвенцид заасан эрүү шүүлтийн талаархи нэр томъёо, түүнтэй тэмцэх үр дүнтэй арга механизмыг дотоодын хууль тогтоомжид өөрчлөлт оруулах замаар нийцүүлэх ажил хийгдэж байгаа хэдий ч эхлэл төдий, эрүү шүүлттэй тэмцэхэд хууль, эрх зүйн орчин болон албан хаагчдын сэтгэлгээний шинэчлэлт хангалттай бүрдсэн гэж үзэхэд учир дутагдалтай.

Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж буй бүхий л илрэл, хэлбэрүүдийг эрүүгийн хууль тогтоомжид хуульчлан тогтоох, мөн дээрх үйлдлийг хийж буй субъектүүдийг зөв тогтоож өгөх асуудал чухлаар тавигдаж байгаа бөгөөд иргэд, эрх бүхий албан тушаалтнуудын *сэтгэлгээнд* эрс шинэчлэл хийх нь нэн тэргүүний тулгамдсан зүйл болоод байна.

Эрүүдэн шүүх гэдгийг та юу гэж ойлгодог вэ?

“Эрүүдэн шүүх гэж хэн нэг хүн буюу гурав дахь этгээдээс мэдээ сэлт, мэдүүлэг авах, тухайн хүн буюу гурав дахь этгээдийн үйлдсэн буюу сөрдөгдсөн хэрэгт шийтгэх, айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх, аливаа байдлаар алагчилах зорилгоор төрийн албан тушаалтан, албаны үүрэг гүйцэтгэж буй бусад хүний өдөөн хатгалт, ил, далд зөвшөөрлөөр тухайн хүн буюу гурав дахь этгээдийн бие махбодь, сэтгэл санааг хүчтэй шаналган зовоох аливаа санаатай үйлдлийг хэлнэ.”² гэж заасан байдаг.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь

¹ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль. 2002 он. 35, 36 дугаар зүйл.

² Эрүүдэн шүүхийн эсрэг конвенцийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг.

хэсэгт “...хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандаж нэр төрийг нь доромжилж болохгүй”, Монгол Улсын ЭВШХ-ийн 35, 36 дугаар зүйлийн 35.3, 36.4-т “Сэжигтэн, яллагдагч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөх, түүнчлэн өөрийн гэм буруугүйг болон хэргийн бусад байдлыг нотлох үүрэг хүлээхгүй”, мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т “Эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжлон харьцаж болохгүй” хэмээн тус тус хуульчилсан.

Гэтэл манай Тагнуул, Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтнууд “Хэргийг нь хүлээлгэ!”, “Өөрөө хэргээ хүлээсэн юм уу?” гэх мэт асуултыг эрх бүхий субъектэд тавьдаг. Энэ асуулт нь дээрх хуулийн заалтыг зөрчиж байгаа зүйл бөгөөд “хэргийг нь өөрөөр нь хүлээлгэсэн” баримт бичиг нь ЭВШХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.4-т зааснаар “нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх талаар хуульд заасан журмыг баримтлаагүй буюу зөрчсөн бол эдгээр нь нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй” юм.

Сэжигтэн, яллагдагч өөрийн гэм бурууг хүлээсэн нь гагцхүү хэрэгт байгаа бусад нотлох баримтаар батлагдвал яллах үндэслэл болдог бөгөөд дан ганц хэргээ хүлээсэн баримт нь нотолгооны чанараа алдана. Мөн Прокурорын байгууллагын зарим хяналтын прокурор хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулсан хэргийн материалтай танилцаад цугларсан бусад нотлох баримтыг анхаарахгүй “Өөрөө хэргээ хүлээсэн байдал”-д нь чухал ач холбогдол өгдөг буруу сэтгэлгээ өнөөг хүртэл байсаар байна.

Хэрэв сэжигтэн, яллагдагч өөрөө хэргээ хүлээсэн бол яллах дүгнэлтийг зоригтой үйлддэг, хэргээ хүлээгээгүй, хүлээлгэхгүйгээр бусад нотлох баримтаар эрүүгийн хэргийг нотолсон бол эрүүгийн хэргийг мөрдөн байцаалтад буцаадаг (мэдүүлгийн зөрүүг арилгах гэм мэт), хэргийн хугацааг сунгаж, шалгагдаж буй этгээдэд хүндрэл учруулдаг зэрэг сөрөг үзэгдэл буюу “Сэтгэлгээний хоцрогдол” оршсоор байгаа юм.

II

“...сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг яллах ба цагаатгах, эрүүгийн харуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоох үүрэгтэй”³

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх болон Гүйцэтгэх ажлын тухай хуулийн дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтнууд аливаа гэмт хэргийг илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг эрэн сурвалжлах, гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тодруулахдаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг яллах ба цагаатгах, эрүүгийн

³ Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлийн 16.1

хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоох үүрэг хүлээдэг.

Гэтэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтнуудын ажлын ачаалал их, урамшууллын систем, ажил дүгнэх тогтолцоо нь зөв биш байгаагаас үүдэн эрүү шүүлт явуулах нөхцөл бүрдээд байгаа юм.

2008 оны 02 дугаар сард Шинжлэх ухааны академийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгээс хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтнуудын дунд явуулсан судалгаанаас үзэхэд оролцогчдын 52.7% нь “Ажлын ачаалал, дарамт их, цалин хөлс бага, урамшуулалын систем буруу”⁴ гэсэн хариуг өгсөн байна. Энэ нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтнууд хэргийг шалгахдаа цагаатгах болон буруутгах, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх ба хүндрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоолгүйгээр сэжиглэж буй этгээдийг гэмт хэрэг үйлдсэн, хамтран оролцсон эсэхийг харгалзахгүйгээр хэрэг хүлээлгэхийг урьтал болгодог, гэрч, хохирогч болон бусад оролцогчдоос (хэрэгт авагдсан баримтад нийцүүлж) хэргийн нөхцөл байдалд тохируулж мэдүүлэг (тайлбар) гаргуулахыг оролдох, тэднийг мэдүүлгээ өөрчлөхийг шаардах, худал гэрчлүүлэх, мэдүүлгийн зөрүүг гаргах нэрээр олон дахин байцаах зэрэг оролдлого гардаг.

Мөн хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтнуудын ажлыг дүгнэх систем буруугаас эрүү шүүлт явагддаг. Өөрөөр хэлбэл, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтнууд аливаа гэмт явдлыг гүйцэтгэх ажлын шугамаар болон байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд үйл ажиллагаа явуулж яллах, буруутгах баримт сэлт цуглуулж холбогдох албадад шилжүүлбэл тэр нь ажлын үр дүн гэж үздэг. Гэтэл хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтнууд гэмт явдалыг гүйцэтгэх ажлын шугамаар болон байцаан шийтгэх ажиллагааны хүрээнд үйлдэл, эс үйлдлийг шалгаад тухайн сэжигтэн уг хэрэгт хамааралгүй болохыг нь тогтоогоод, холбогдох арга хэмжээг авбал ажлын үзүүлэлт буурдаг, ямар нэгэн хардлага, сөрдлөгэд өртдөг (сэжигтэн этгээдтэй хуйвалдсан, хахууль авсан, хэрэг замхаруулсан гэх мэт). Хардлага, сөрдлөгэд өртөж, ажлын үзүүлэлтээ буруулж байхаар ямар нэгэн аргаар хэргээ дуусгаад дараагийн шатны байгууллага, албанд шилжүүлээ гэсэн байдлаар асуудалд ханддаг.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 193 дугаар зүйлийн 193.1.24-т зааснаар хяналтын прокурор бүрэн эрхийнхээ хүрээнд “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллагын захиргаанаас хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны талаар гаргасан тушаал, шийдвэр хуульд нийцэж байгаа эсэхийг хянах, зөрчсөн тушаал шийдвэрт эсэргүүцэл бичих” эрхтэй байдаг.

⁴ Эрүү шүүлттэй тэмцэх нь зөвлөлдөх уулзалт. 2008 он. 103-р тал.

Гэтэл өнөөдрийн байдлаар хяналтын зарим нэг прокурор дээрх хууль зөрчсөн тушаал, шийдвэрийг мэдсээр атлаа төлөвлөгөөний дагуу тухайн байгууллагад очиж хэргээ зөв бүртгэж байгаа эсэх, эд мөрийн баримтын өрөө нь ямар байна гэх мэт бусад асуудалд ач холбогдол өгдөг сөрөг үзэгдэл буюу “Сэтгэлгээний хоцрогдол” оршисоор байна.

Эцэст нь дүгнэхэд

ЭБША-ны болон хойшлуулашгүй ажиллагааны хүрээнд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж хэрэг илрүүлэхийг урьтал болгодог хууль бус ажиллагаа гарсаар байгаа гэдгийг хэлэх хэрэгтэй.

Хэргийг өөрөөр нь хүлээлгэ (Вишинскийн онол) хэмээн үүрэг өгдөг, мэдүүлэг, тайлбар хүчээр авдаг, аливаа хэрэг шалгах асуудалд хувийн сонирхолоор хөндлөнгөөс оролцдог зэрэг нь Эрүү шүүлтийн нэг хэлбэр бөгөөд ажил дүгнэх систем, ажлын хэт их ачаалал, үндэслэлгүй хардлага, сэрдлэг нь эрүү шүүлт явуулах үндэс суурь мөн.

Эрүүдэн шүүх хэлбэрээр сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр хэрэг хүлээлгэхийг урьтал болгодог энэхүү сэтгэлгээнд шинэчлэл хийх шаардлагатай байгаа ба, “Сэтгэлгээний шинэчлэл” гэдэг нь сэтгэхүйг өөрчлөх үйл явц бөгөөд сэтгэлгээний шинэчлэл хийж чадах юм бол ямар ч салбарт ажил урагштай, хүнд сурталгүй явагдах болно. Үүний тулд:

- Эрүүдэн шүүхийн эсрэг соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах;
- Эрх бүхий албан тушаалтнуудыг мэргэжлийн сургалтанд хамруулах;
- Сэжигтнээр өөрөөр нь хэрэг хүлээлгэж мэдүүлэг, тайлбар авдаг асуудлыг таслан зогсоох (бусад нотлох баримтаар хэргийг нотлож хэвших);
- Шалгаж буй аливаа асуудалд хувийн сонирхолоор хөндлөнгөөс оролцох, шалгах асуудалд саад учруулдагыг зогсоох (мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхээс бусад байдлаар);
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, гүйцэтгэх ажилтнуудын ажил дүгнэх системийг өөрчлөх (ур чадвар, авъяас хэрхэн гаргаж шалгасан гэх мэтээр нь үнэлэх);
- Ажлын хэт ачааллыг зохистой байдлаар тэнцвэржүүлэх;
- Ямар нэгэн баримт сэлт, шалгаж тогтоосон зүйлгүйгээр хардаж, сөрдөх асуудлыг таслан зогсоох (үндэслэл бүхий баримт бичиг, материалд тулгуурлаж байх) зэрэг зүйлийг нэн тэргүүнд хийх нь зүй болов уу.

Эдгээр зүйлийг нэн тэргүүнд хийж хэрэгжүүлснээр эрүүдэн шүүхийн тухай болон түүний хор уршиг, тэмцэх асуудлын талаар

нэгдсэн ойлголттой болох, иргэд тухайн байгууллагын талаар зөв ойлголттой болох, эрх бүхий албан тушаалтан эрүүдэн шүүх, бусдад хүнд гэмтэл учруулах гэх мэт гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, ажлын үнэлгээг зөв дүгнэж, ажлын ачааллыг зохистой байдлаар тэнцвэржүүлж, шалгах асуудалд хувийн сонирхолоор хөндлөнгөөс оролцохгүй, үндэслэлгүйгээр хардаж сэрдэхгүй байснаар албан хаагчид гэмт явдлыг шалгахдаа ур чадвар, авъяас гаргахад оюун ухаанаа илүү их дайчлах, мэргэжлийн ур чадвар дээшлэх, удирдлагад итгэх итгэл нь нэмэгдэх, ажлын бүтээмж сайжрах гэх мэт сайн талтай хэмээн үзэж байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАХ АЖИЛЛАГААНЫ АРГАЧЛАЛ

Зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш гэр бүлийн хүчирхийлэл өргөн дэлгэрч сэтгэл зовоосон хурц асуудлын нэг болоод байна. Иймээс цаашид хазаарлан барьж хүчирхийлэлийг таслан зогсоохын тулд хууль хамгаалах байгууллагын ажилтан бүр сэтгэл, зүтгэл гарган ажиллах ёстой гэж бодож байна. Гэр бүл амгалан бол улс, орон амгалан, улс, орон амгалан бол дэлхий дахинд энх тайван оршин тогтнох нөхцөл бүрдэх болно.

Эрх зүйн туслалцааны төвийн дүрмийн 2.1.3-д заасан эвлэрүүлэн зуучлах ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд миний бие доорх арга барилаар ажиллаж байна. Үүнд:

Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчтэй их л элэгсэг дотно ярилцаж түүний хаягыг тэмдэглэж авсаны дараа гэр бүлийн хүчирхийлэлд хэзээнээс хэрхэн яаж өртсөн тухай маш дэлгэрэнгүй яриулж тодорхой ойлголттой болж аваад цаашид хэрхэх талаар зөвлөгөө өгч, хүчирхийлэл үйлдэгчийн хаягыг авна.

Хүчирхийлэл үйлдэгч этгээдийг төрөл садан, эцэг-эхийн аль нэгээр юмуу утсаар, утасгүй бол багийн засаг даргаар дамжуулж дуудан ерөөндөө ирүүлж, мэндлэж товчхон танилцсаны дараа гэр бүлийн хүчирхийллийг яагаад хийх болсоныг, түүнд ямар хүчин зүйл нөлөөлснийг тус тус асууж яриулаад тодруулах зүйлсийг асууна.

Түүний өчиг гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчийхтэй тохирч байгаа эсэхийг шалгаж хэрэв зөрүүтэй байвал хоёуланг байлцуулж байж ярилцан буруу, зөвийг нь тунгаана. Хэрэв тохирч байвал нөлөөлсөн нөхцөл байдлыг арилгах системтэй ажил зохионо. Өөрөөр хэлбэл, хадмуудаас нь болж тэд муудалцдаг бол тэдэнтэй ажиллаж бурууг нь ухааруулж болиулах, өөр хүнтэй холбоотой асуудал гарч ирвэл түүнийг таслан зосоох гэх мэт ажил зохионо. Эрхэлсэн ажил төрөлгүйгээс болж гиюурч архидаг согтуурч хүчирхийлэл үйлддэг бол ажилд оруулах асуудлыг сайтар хөөцөлдөж бүтээх арга хэмжээ авах гэх мэт.

Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч, хүчирхийлэлд өртөгч хоёрыг байлцуулан хүчирхийллийн хор уршгийн талаар нэг бүрчлэн ярьж жигшүүлэх, ойлгуулж мэдрүүлэх арга хэмжээ авна. Үүнд: гэр бүлийн хүчирхийлэлд өртөгчийн өөртөө итгэх итгэлгүй болох, ганцаардмал болох, үргэлж сэтгэлийн дарамтад уйтгар гунигт автан сэтгэл гутралд



Баян-Өлгий
аймгийн Эрх зүйн
туслалцааны төвийн
өмгөөлөгч Т.Костёр

орох (депресс), амьдрах итгэлгүй болох, өөрийгөө бусдаас дутуу үнэлэх, үр зулбах, дутуу төрөх, хүсээгүй жирэмслэх, байнга айдас дунд амьдардаг болохоор ой ухаан нь муудаж сэтгэцийн өөрчлөлтэй болох түүнээс улбаалаад эрүүл мэнд нь муудаж төрөл бүрийн хоргүй болон хортой хавдар өвчинөөр өвчлөх, зодуулсанаас болж бие махбодид хавдсан, хөхөрсөн, шалбарсан, зулгарсан гэмтэл үүсэх, яс хугарах, цуурах, тархи хөдлөх, түлэгдэх, байнга стресст орсоноор ихэвчлэн бие махбодийн зовиурыг үүсгэдэг бөгөөд энэ нь толгой өвдөх, зүрх дэлсэх, зүрхний шигдээс, даралт ихсэх, дархлал буурах, элэг, ходоод муудан шархлаа үүсэх, хямрах, хоолны шингэц муудах, хоолонд дургүй болох, дотор муухайрах, цусны эргэлт муудах, нойр муудах, сэрвэлзэх, гар, хөл салганах, амархан ядрах зэрэг хамрын ханиаднаас эхлээд элдвийн өвчинд баригдаж нэрвэгдэхээс гадна хүчирхийлэл үйлдэгчийн гарт амь насаа алдах, өндрөөс унах, өөрийгөө буудах, хутгалах, дүүжлэх зэргээр амь насаа егүүтгэхээс гадна хүүхдийн хүмүүжилд ч асар их хор хохиролтойг сайтар тайлбарлан таниулах хэрэгтэй байдаг. Ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл дунд өссөн хүүхэд уур уцаартай болдог, дураараа аашлах, зарим нь аймхай хулчгар, хэт ноомой халширамтгай болдог, айдас хүйдсээс болж шөнө хар дарж унтаж амарч чаддаггүй, гэрийн даалгавар хичээлээ хийж чадалгүй сурлага муудах, найз, нөхдөөс ичиж зовох, амар заяа үзүүлээгүйгээс болж орон гэртээ тогтохгүй тэнүүлч болж үл бүтэх хүмүүстэй нийлж хэрэг зөрчилд холбогдох, сэтгэл санаагаар унаж, янз бүрийн өвчинд нэрвэгдэх, айж сандарсанаас болж зөв боловсон хооллож чадалгүй өлсөж, цангах, гэрээс хөөгдөхдөө хагас дутуу хувцасласнаас болж бээрч дааран хатгаа өвчин тусах, гар, хөлөө хөлдөөх, заримдаа хүчирхийлэлийн явцад зодуулж бэртэж гэмтэх, амь насаа ч алдаж болзошгүй. Хүчирхийлэл дунд өссөн хүүхэд томрохоороо өөрөө хүчирхийлэл үйлдэх магадлал 75-80%-тай байдгийг эрдэмтэд тогтоосон байна гэдгийг ой тойнд нь ортол ойлгуулах хэрэгтэй байдаг. Та хоёр зохисгүй үйлдлээ эцэслэж чадалгүй даамжруулан гэрлэлтээ цуцлуулах юм бол хүүхэд өнчирхөөс гадна хүүхдийн хүмүүжилд асар их хор хохирол учруулж худ уургийн холбоотой болсон 2 талын бүх хамаатан садангуудаа хооронд нь дайсагнуулан зөвхөн өөрсдөө биш 2 талын эцэг-эх, ах дүү нараа сэтгэл санааны болон эдийн засгийн дарамт шахалтад оруулна гэдгээ сайтар бодож тунгаах хэрэгтэйг зөвлөнө.

Түүнчлэн тэдэнд казах болон монголчуудын ёс заншилд гэрийн хүмүүжил асар их ач холбогдолтой байсныг, энэ нь бүхэл бүтэн ардын сурган хүмүүжүүлэх ухаан болохыг, гэрийн ёсыг эх хүн хариуцаж, эцэг нь хянаж бататгадаг уламжлалтайг, өвөг дээдсийн гэр бүлээ хэрхэн зөв авч явсан, үр хүүхдээ хэрхэн зөв боловсон

хүмүүжүүлж гарыг нь ганзганд хөлийг нь дөрөөнд хүргэсэн тухай, тэдний зан заншил, ёс зүйн асуудал болон бурхан багшийн сургааль, айдвар, шашины гэр бүлийн хүмүүжилтэй холбоотой зүйл заалт болон гэр бүл, иргэн, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжуудаас тайлбарлан таниулж ёс заншил, бурханы ном судар, хуулиа дээдлэн үр хүүхдийнхээ цаашдын хувь заяаг бодолцож бие биеэ уучлан эвлэрч сайн сайхан амьдрахыг зөвлөнө.

Мөн тэдэнд уурлаж цухалдахыг тэвчиж, биеэ барьж сурах, өчүүхэн төдий ч муу юм хийхгүй байх (эргээд өөрт чинь зовлон болно) атаа жетөө, атгаг хорон санаанаас хол байх, шударга ариун үйлс, бие биедээ тусархаг сайхан сэтгэлтэй байх нь чухал гэдгийг сайтар ойлгуулна.

Тэр ч байтугай бидний хүрээлэн байгаа орчины бүр тодруулвал аливаа юмс үзэгдлийн гэр бүлийн амьдралд үзүүлэх нөлөөг ч сайтар тайлбарлан таниулах нь ашигтай байдаг. Тэгж байж хүн ухаарч алдаж эндэж байгаагаа зөвөөр ойлгох чадвартай болдог.

Гэр бүлийн хүчирхийлэл, хэрүүл маргааныг багасгаж амар тайван амьдрахын тулд гэрт цэцэг тарих нь ашигтайгаас гадна ямар нэгэн муу юм бага тохиолдохыг эрдэмтэд нотолсон байна. Айл гэрийн харьцааны соёлыг хамгийн түрүүн цэцэг л мэдэрдэг юм байна лээ. Тухайн гэр бүлд хэрүүл тэмцэл гарвал ургаж байгаа цэцэг өөрийн эрхгүй гулдайж эхэлдэг юм байна. Үүнийг орчин үед шинжлэх ухаан нотолжээ. Хэрэв гэр бүлийн хос үүнийг мэдэрч бидний харьцаа муудаж хэрүүл маань хүчирхийлэл болох шахсан байна гэдэгт зарчмын дүгнэлт хийж хоорондоо эвлэрч найрсаг харьцаатай болж эхэлвэл нөгөө цэцэг хуучин хэвэндээ орж өнгө засдаг. Цэцгийг гэрлэгчид хайрлан хамгаалж усалж байх нь хэн хэнд ч ач тустай. Учир нь цэцэг бол харааж чаддаг, ерөөж ч чаддаг юм. Өөрөөр хэлвэл цэцэг өөртөө сайн, муу хандсан хүнд заавал хариу барьдаг юм байна. Таньд гомдсон цэцэг тан руу хор цацаж дөнгөнө. Тэр бодис нь таныг ууртай, муухай ааштай болгох, архинд оруулах гэх зэргээр үйлчилгээгээ үзүүлдэг гэдгийг ч мартаж болохгүй юм. Магадгүй та хоёрын эв найрамдалтай сайн сайхан амьдарч байгааг танайд орж ирсэн зэвүүн сэтгэлтэй, хар энергитэй хүн хараад атаархаж нүдний хор, биеийн муу энерги, хэл амаа мэдэгдэлгүй тусгавал та нарын цаашдын амьдралд муу үр дагавар үүсэхээс гадна үүнээс болж салж сарнихад ч хүрч болзошгүй юм. Ийм зохисгүй явдлаас та нарыг зөвхөн кактус л аварна. Өөрөөр хэлвэл, тэр хүний муу энерги, нүдний хор тусах гээд байсан хэл ам, муу муухай бүхнийг кактусын өргөс нь биедээ шингээж аваад та нарыг хамгаалдаг юм.

Кактус гэгч гадна талдаа өргөстэй энэ ургамал хэрүүл, маргааныг багасгаж айл гэрт амар тайван байдал авчирдаг тул ихэнх оронд түүнийг гэртээ ургуулдаг байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд

кактус чухал үүрэг гүйцэтгэдэг тул Хятад зэрэг зарим орон цэцэглэх үеэр 5 жилд нэг удаа кактусын баяр гэж тэмдэглэж ирсэн заншилтай. Кактус аливаа муу энергийг өөртөө шингээж гэр дотор сайхан уур амьсгал бий болгодог ч түүнийг эрэгтэй хүн гомдоовол архианд дуртай болгодог бодис цацдаг юм байна лээ. Шимтэглэй (герань) бол хэрүүл шуугианд их дургүй цэцэг тул хүмүүсийг муудалцаж, хэрэлдэхээр тайвшруулах бодис ялгаруулж эхэлдэг юм гэнэ.

Бид усыг зөвхөн ундаалах, өдөр тутам хир угаах, талбай услах, хоол унда хийхэд хэргэлдэг. Тэгвэл ус ч гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэхэд асар их ач холбогдолтой юм. Ус нь гэр бүлийн хосыг жаргааж ч чаддаг, зовоож ч чаддаг юм байна. Товчхон хэлэхэд ус хүний биед шингэсэн муу энергийг гадагшлуулж арилгах авьдастай. Хүн усанд ороход миний бие, оюун ухаанд байгаа бүх муу муухай юмыг ус татаж авч байна гэж бодох хэрэгтэй. Тэгвэл таны хүсэл биелж бие, сэтгэл санаа чинь ариусах тавилантай. Бүр болохгүй бол ваннтай усанд далайн давс хийж уусгаад ороход хангалттай. Түүнчлэн ус бол хүчтэй хамгаалагч элемент. Таны сэтгэл санаанд гутрал байвал шүршүүрт орж ус гоожуулаад дор нь хэсэг хугацаагаар зогсвол сэтгэл санаа чинь өөдрөг болж тайвширна. Гэр бүлийн хоёр эв зүйгээ ололгүй гэр бүлийн хүчирхийлэл гарч эхэлвэл тэд хамтдаа гол руу хэд хэдэн удаа алхаж очоод буцвал хоорондын харьцаа эрс сайжирч хуучин хэвэндээ ордог юм. Австрали зэрэг оронд гэрлэлтээ цуцлуулахаар шүүхэд ирсэн хосыг завиар далайгаар тодорхой хугацаагаар аялуулдаг нь ч үүнтэй холбоотой байх. Манай өвөг дээдэс голын эрэг дээр орилж хашгирч муу муухай юм ярьж болохгүй, баяр жаргалыг авч оддог юм гэдгийг ч залуус анхааралдаа авах нь өлзийтэй. Ийнхүү олон зүйлийг тал талаас нь тайлбарлаж өгөх нь чухал ач холбогдолтой. Учир нь зарим хос үүнийг мэдэхгүй байгаагаас болж амьдралдаа том алдаа гаргадаг тал байна.

Хэрэвтэд хэлэлцэн тохиролцвол гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчээр цаашид хэрхэн засрах талаар дэлгэрэнгүй баталгаа гаргуулан авч түүний биелэлтэд тодорхой хугацаагаар хяналт тавьж биечлэн уулзан ярилцаж хамаатан садан, хүчирхийлэлд өртөгчөөс лавлан үүрэг, даалгавар өгч ажиллана. Хэрэв засрал авсан бол цаашид бас сургамж болгох үүднээс хоёуланг дуудан ирүүлж “Ариун гэр бүлийн тангараг” гэгчийг өргүүлэн гарын үсэг зуруулж нэг хувийг нь гардуулж гэр бүлийн амьдралд нь амжилт хүсэж, өнөр өтгөн аз жаргалтай айл болохыг ерөөдөг. Монгол хэл мэддэггүй хүмүүст уг тангарагыг казах хэл дээр хөрвүүлэн өргүүлнэ.

Гэрлэгсэд хоорондоо тохиролцоонд хүрч чадахгүй бол гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчийн эцэг, эх юмуу үгийг нь сонсож хүндлэх ёстой нэр хүндтэй хүн болох ураг овгийн ахлагчтай нь уулзан ярилцаж тэр

хүний туслалцааг авч холбогдох хүмүүсийг урьж ирүүлэн гэр бүлийн зөвлөгөөн хийнэ. Энэхүү зөвлөгөөнийг тэд болж өгвөл ажлын бус цагаар хийж өгөхийг хүсдэг тул зөвшөөрөхөөс өөр аргагүй. Учир нь гэр бүлийн хувийн асуудал нууц байх ёстой шүү дээ. Зөвлөгөөнийг нээж хэлэлцэх гэж байгаа асуудлын талаар нэгд нэгэнгүй дэлгэрэнгүй ярьж танилцуулан асууж лавлах зүйл байвал тодорхой хариулт өгч дараа нь гэр бүлийн хүчирхийллийн хор холбогдолыг дээрх маягаар дэлгэрэнгүй танилцуулан тодорхой ойлголт өгсөний дараа эцэг, эх юмуу омгийн ахлагчаар зөвлөгөө, үүрэг, даалгавар өгүүлнэ. Дараа нь гэр бүлийн хүчирхийлэлд өртөгч болон хүчирхийлэл үйлдэгчээр ээлжлэн яриулж өчигийн зөрүүг гарган мэргэжлийн зөвлөгөө өгч эвлэрүүлэх арга хэмжээ авна. Хэрэв хоорондоо тохиролцохгүй бол гэр бүл салснаас болоод хохирол амсаж буй зарим хүний талаар тэдний үр хүүхдүүдэд учирч байгаа хүндрэл бэрхшээл, амьдралын алдаа оноогч иш татаж ярьж өөрсдийн бурууг ухааруулах арга хэмжээ авна.

Танайд гэр бүлийн хүчирхийлэл гарахад нөлөөлж байгаа зүйл байвал түүнийг таслан зогсоох арга хэмжээ авахад би бэлэн гэдгээ ч хэлж санал хүсэлтийг нь асууна. Хэрэв хүсэлт тавьвал түүнийг биелүүлэхийн төлөө идэвхитэй ажиллах ч шаардлага гарна. Ингэхдээ цаг хугацааг хязгаарлаж болохгүй. Учир нь нэг гэр бүл ч гэсэн эвлэрч цаашид зөв замаар амьдрах юм бол бидний ажлын үр дүн гарлаа л гэсэн үг. Үүний тулд тэдэнтэй тулж ажиллах хэрэгтэй байдаг. Тэгж байж тэд энэ өмгөөлөгч зөвхөн бидний гэр бүлийн асуудалд онцгой анхаарч хүндэтгэлтэй хандаж бидний ахуй амьдрал сайн сайхны төлөө уяггүй ажиллаж байгаа юм байна. Энэ хүний зөвлөгөөг би хүндэтгэн хүлээж авахаас өөр ямар ч аргагүй юм байна гэж хүлээн зөвшөөрдөг. Эцэг, эх юмуу омгийн ахлагчийн өгсөн зөвлөгөөг ч тэд ахмадын сургаал алт гэж хүлээж авах болно. Ингэсэн нөхцөлд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчээр цаашид хэрхэн амьдрах талаар баталгаа гаргуулан авч зөвлөгөөнд оролцсон хүмүүсээр гарын үсэг зуруулж баталгааг хавсаргаж энэхүү баталгааны хэрэгжилтийг хэрхэн хянах талаар хэлж өгч зөвлөгөөнөө хааж урилгаар хүрэлцэн ирж үнэтэй зөвлөгөө өгсөн хүнд баярласан талархсанаа илэрхийлж тарцгаана. Баталгаа гаргуулж авсанаас 10 хоногын дараа гэр бүлийн хүчирхийлэлд өртөгч юмуу эцэг, эх, омгийн ахлагчийн аль нэгээс байдал ямар байгаа, засрал авсан эсхийг асууж лавлана. Шаардлагатай гэж үзвэл гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчтэй биечлэн уулзаж ярилцана. Зөвлөгөө өгөхөд ч илүүдэхгүй юм. Түүний хүсэлтийг биелүүлэх талаар арга хэмжээ авна. Тухайлбал, ажил хиймээр байна гэвэл ажил төрөлд ороход нь тус дэм болох зорилгоор зуучлана. Хэрэв ажилд оруулж чадвал миний чамд гэсэн өндөр итгэл найдварыг алдаваа гэдгээ аминчлан захиана.

Иймэрхүү байдлаар хэд хэдэн удаа тэдэнтэй тус тусдаа уулзан

ярилцаж хэрэв бүрэн засарч чадлаа гэж үзвэл «Ариун гэр бүлийн тангараг» өргүүлэн нэг хувийг нь гардуулан өгч амжилт хүсч эвлэрүүлэн зуучлах ажиллагааг эцэс болгоно. Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны явцад зохиосон ажил болгоныг товчхон тэмдэглэж авна.

Хэрэв та нэг гэр бүлийн хүчирхийлэлийг уйгагүй ажиллаж байж бүрэн таслан зогсоож, тэдэнд сайн сайхан амьдрал бэлэглэж чадвал энэ бол бахархууштай том гавьяа. Таны ажлын үр дүн гарлаа гэсэн үг. Тэднийг хараад өөрийн эрхгүй баярлаж ажиллах урам зориг эрч хүчийг авахаас илүү жаргал байхгүй мэт санагдах тохиолдол ч гарна. Энэ бол зөвхөн гэр бүлийн хүчирхийлэлд өртөгдөгчийг өмгөөлөн хамгаалж байгаа асуудал биш бүхэл бүтэн гэр бүл, үр хүүхэд, худ ургийн холбоотой болсон 2 талын хамаатан садангуудад болон улс, нийгэмд ч тус хүргэж байгаа асар их ач холбогдолтой бүтээлч ажил гэж их л хариуцлагатай хандах хэрэгтэй байдаг.

Манай аймгийн иргэдийн ихэнх нь монгол хэл мэддэггүй тул тэдний энэ талын эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор би гэр бүлийн хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх гарын авлага гарган, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг казах хэл дээр орчуулан гарын авлага болгон бэлтгэн тус тус тараалаа.

2008 оноос хойш аймгийн үндэсний радио, телевиз, казах хэл дээр хэвлэгдэн гардаг «Жана дауир» сонин, «Шугыла», «Инабат» сэтгүүлүүд зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслэлүүдээр гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүн хүмүүжүүлэх талаар жил болгон сурталчилгааны материал нийтлүүлж, албан байгууллага, баг, хорооны иргэд хөдөлмөрчдэд яриа таниулга хийх, хичээл заах зэргээр ажилласаны үр дүнд манай аймагт гэр бүлийн хүчирхийлэл жилээс жилд багасаж байна. Үүний нэг яруу тод жишээ нь 2007 онд манай аймагт 56 гэр бүл шүүхээр гэрлэлтээ цуцлуулж байсан бол 2008 онд 31 болж 25-аар буюу 44,7%-иар буурсан бол, 2009 онд 23 болж урьд оныхоос 8-аар буюу 25,9 хувиар буурсан сайхан үзүүлэлттэй байна.

Эвлэрүүлэн зуучлах явцад миний гаргасан алдаа. Би нэг удаа гэр бүлийн хүчирхийлэлийг эвлэрүүлэн зуучлах явцад тэдний амнаас гарсан болгоныг нэг бүрчлэн бичиж аваад тэд хоорондоо хэлэлцэн тохироогүй тул ахыг нь байлцуулан яриа хийж яригдсан бүх асуудлыг шүүх хурлын тэмдэглэл шиг болгон маш дэлгэрэнгүй тохуу хийнэ шүү дээ, та заавал бичих ёстой гэж үзвэл товчхон бүрхэгдүүлж бичээрэй гэсэн юм. Энэ асуудлыг бид бас бодолцож ерөнхий юм бичиж тэдний гэр бүлийн нууцыг хамгаалах нь зүйтэй юм байна. Энэ надад том сургамж болсон юм. Түүнээс хойш би тэмдэглэлээ маш товчилж бүрхэгдүү бичдэг болсон юм.

Хууль зүйн албаны 100 жилийн ойд

**Шүүх яамнаас бусдын нохойг санаатай болоод санамсаргүйгээр
алсан хүнийг хэрхэн шийтгэх тухай бичиг**

Манай ард түмний маань эх орноо хэмээх сэтгэл оюуны идэвх өнөө цагт хүчээ аван, үндэснийхээ уламжлалт соёл, түүх, ёс заншлыг танин мэдэж, мэдрэх гэсэн чин эрмэлзэл дүүрэн болжээ. Оюуны энэхүү хандлага, шаардлагыг хангахын тулд хүмүүст монгол хууль, түүний агуулга, үзэл санааг сурталчлан таниулах явдал нэн чухал гэдгийг манай хуульчид онцлон тэмдэглэж байгаа нь сайшаалтай билээ.

Монгол хуулийн талаарх төсөөллийг олж авсанаар: нэгдүгээрт, төр нь түмнээ, түмэн нь төрөө хэрхэн дээдэлж ирснийг, хоёрдугаарт, өвөг дээдэс маань хууль дүрмийг ямагт дээдлэн сахиж байсныг, гуравдугаарт, монгол хуулиуд нь өөрсдийнх нь ахуй, оюун санааны хэрэгцээ шаардлагаас үндэслэн буй болж, зан заншилтай нь хослон үйлчилж, амьдралынх нь жирийн хэв зуршил болсныг, дөрөвдүгээрт, монгол хууль нь хүмүүнлэг болоод, цээрлүүлэх, хүмүүжүүлэх үзлийг өөртөө бат шингээсэн байдаг зэргийг олж харж болно хэмээн Э.Авирмэд, Д.Дашцэдэн, Г.Совд нар "Монгол хууль" Улаанбаатар., 1997 он бүтээлийнхээ оршилд өгүүлсэн нь монгол хуулийн түүхэн ач холбогдол, үнэ цэнэ, хамрах хүрээг товч, ончтой илэрхийлэн гаргасан хэрэг юм. Энэ ч үүднээс монгол хуулиа олон түмэндээ таниулан хүргэх үүднээс зарим нэг хэргийг хэрхэн шийдэж байсан талаар архивт хадгалагдан үлдсэн сонирхол татахуйц баримтуудаас нийтлэж, нийтийн хүртээл болгох нь дээр өгүүлсэн монгол хуулийн төсөөллийг олж авахад дусал нэмэр болох бизээ хэмээн санаж Шүүх яамнаас нэгэн иргэний хэргийг хэрхэн шийдсэн талаар дор сийрүүлэн хүргэж байна.

Хүн бүр хууль цаазаа эс зөрчин, чандлан сахиж, амьдралын салшгүй нэгэн хэсгээ хэмээн ухамсарлаж байх болтугай.

* * * * *

Шүүх, Таслах Хэргийг Бүгд Захиран Шийтгэгч Яамны бичиг.

Хууль зүйлийг зохион бүхий сайдуудад илгээв.

Явуулах учир.

Түшээт хан аймгийн чуулганы даргыг газраас Түшээт ханы хошууны Хар Содномын үнэг, чоно агнахаар тавьсан хорыг идэн үхсэн Дэндэв нарын нохойны төлбөр ба цаазалсныг зөрчиж явсан төлөв их Хар Содномыг хэрхэн шийтгэхийг тогтоон заахыг эрж бидний хоёр яаманд нэгэн адил мэдүүлэн ирсэн дагалтаар Дотоод яамнаас уг хэргийг түүгээр гүйцэтгэн шийтгэж, хариу ирүүлмүй хэмээн

хүргэж ирсэн. Хууль зүйлд байцааваас монгол цаазын бичигт тусгай заасан зүйл үгүй, шүүх цаазны бичигт гахай, хонь зэрэг тэжээврийг ташааран алах ба хор хийх болвоос ял унагах үгүй, хорогдуулсан үнийн төдий хөөн төлүүлэгтүн хэмээжүхүй.

Үүнд энэ хэргийн Хар Содномыг цаазалсан зөрчсөн, цаазын бичгийн ёсоор шүүхээс гадна гагцхүү нохой хэдий зориуд заасан зүйл үгүй боловч манай монголчууд болвоос их төлөв хөдөө тал газар гэр хөрөнгө, мал үнээнд итгэж мануулан сахиулах нь ер хоосон болгон шийтгэхэд татгалзалтай зүйл буй бөгөөд үнийг хэрхэн төлүүлэх явдлыг эдүгээгээс нэг болгон тогтоож, үүрд дагаж явуулваас зохихын тул газар орны аж ахуйн байдал төлөвт нийлүүлэн хааяа энэ мэтийг хувьсган шийтгэж бүхий хэргийн ёсоор үүнээс хойш бусдын нохойг зорилгоор алах ба ташааран алах нь болвоос тухайд учир барьж, цаазын бичгийн ёсоор ялган салгаж шийтгүүлэн, үхсэний өрийг гурван насны үхрээр төлүүлвээс болох эсэх, хэрвээ үл нийлэлцвээс хэрхэн тогтоовоос зохихыг эрснийг дэсээр цохож, хойш хариу ирүүлээд, гүйцэтгэн шийтгүүлэх ажаамуу хэмээн зохих газар явуулсанд Дотоод яамнаас хойш цохож ирсэн нь энэ хэргийг ийнхүү шийтгэхээр төлөвлөсөн нь зүйтэй амуй хэмээжүхүй.

Иймийн тул энэ хэргийн цаазалсныг зөрчиж, хор тавин нэг хошууны Хар Сэрээнэн, Базар, их шавь өвгөн Дэндэв нарын үнийг өгүүлэхэд хүргүүлсэн хуягаар Содномыг цаазалсныг зөрчсөн цаазын бичгийн ёсоор тавин ташуур жанчих ял оноосугай. Уг үхсэн нохойн үнийг эдүгээгийн зөвлөлдөн тогтоосон ёсоор гурван насны үхэр буюу таацах үнийг түүний нэрийн доороос хөөн гаргуулж зохигчдод төлүүлэн дуусгуулж, үүнээс урагш үүрд журамлан дагаж явуулахаар тогтоон шийтгэсэн явдлыг Түшээт хан аймгийн чуулганы дарга, Нийслэл Хүрээний Эрдэнэ Шанзудбо нарт тус бүр тушаан явуулаад, энэ хэргийн Содномыг унагасан ялын ёсоор харъяат газарт тооны ёсоор ташуур жанчиж шийтгүүлэн баримтлан захируулахаас гадна эдгээр үхсэний үнийн төлбөрийг даруй түргэн түүнээр төлүүлэн олгуулж дуусгуулсугай. Үүнийг бас Ховд, Улиастай, Хиагтын сайдууд, нөгөө гурван аймаг ба Дөрвөдийн хоёр гарын чуулганы дарга жанжид, Хөвсгөл нуурын Урианхай, Ар Илийн гүн Найданжав нарт хуваан явуулан тушаагаад, хянан үзэж, өөр өөрийн харъяат газруудад зарлан тушааж, нэгэн адил дагаж шийтгүүлэхийн учир нэгдүгээр хутагтын зэрэг дөрвөн яамны хууль зүйлийг зохион бүхий сайдуудад явуулаад, байцаан үзүүлсүгүй.

Үүний тул илгээв.

Олноо Өргөгдсөний зургаадугаар он, таван сарын арван хоёрны өдөр.

Үндэсний Төв Архивын ажилтан Л.Хантөгс

**“ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” СЭТГҮҮЛИЙН
НИЙТЛЭЛИЙН ЖАГСААЛТ-2010 ОН**

2010, №1(28)

**Хууль зүйн албаны 100 жилийн ойд
Монгол Оросын 1912 оны найрамдлын гэрээ
ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэн, Түүхийн шинжлэх ухааны
доктор, профессор О.Батсайхан**

**Төрийн байгуулалтын хууль тогтоомж
Үндсэн хуулийг тайлбарлах цорын ганц субъект цэц мөн үү?
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан О.Мөнхцэцэг**

**Монгол Улсын хууль тогтоох байгууллагын түүхэн хөгжил
ШУА-ийн Философи, социологи, эрх зүйн хүрээлэнгийн “Хууль зүйн
судалгааны төв”-ийн эрдэм шинжилгээний ажилтан Б.Батбаяр**

**Ашиг сонирхлын зөрчилд өртсөн төрийн албан хаагчид хүлээлгэх
хариуцлагын асуудал
Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын Албаны дарга, Хууль
зүйн доктор, профессор Л.Батжав**

**Спортын эрх зүй: Төрийн алба ба спорт
Хууль зүйн магистр, Самбо бөхийн олон улсын хэмжээний мастер
Г.Баттулга**

**Шүүх эрх мэдэл
Эрүүгийн хэрэг үүсгэх шатанд байцаан шийтгэх зарим ажиллагааг
хэрэгжүүлэх нь
НЦГ-ын Гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн хэргийн газрын үзлэгийн
чиглэлийн ахлах мэргэжилтэн, Цагдаагийн дэд хурандаа
Б.Жаргалсайхан**

**Шүүх хуралдааны аюулгүй байдал ба шүүх хуралдааныг нээлттэй
явуулах хууль зүйн харилцан хамаарлын зарим асуудал
Цагдаагийн Академийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш
Б.Даваажав
Хүний эрхийг хангах шүүх эрх мэдлийн зарим асуудал
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан М.Мөнхжаргал**

**Үндсэн хуульт ёсны төлөвшилтөд ердийн болон дагнасан шүүхийн
оролцоо**

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан П.Баттулга

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсронгуй болгох зарим асуудал

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш, докторант Д.Хуяг

Прокурорын хяналт

Монгол Улсын Прокурорын байгууллагын 80 жилийн ойд*

Сонгинохайрхан дүүргийн прокурорын газрын түүхэн товчоон

Иргэний хууль тогтоомж

Иргэний эрх зүй дэх эд хөрөнгийн хязгаарлагдмал эрх, түүний эрх зүйн зохицуулалтын зарим асуудал

ОТИС-ийн Хууль зүйн сургуулийн Иргэн, бизнесийн эрх зүйн тэнхимийн багш Г.Жаргал

Эрх зүй ба аж ахуйн нэгжийн үүсэл хөгжил

"Harvard Law Review" сэтгүүлээс орчуулсан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Ц.Одмаа

Гэр бүл ба хөрөнгө

Пагдаагийн Академийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш О.Отгонтуяа

Хамтран амьдрагчийн эрх зүйн зохицуулалтын асуудал

МУБИС-ийн Түүх, нийгмийн ухааны сургуулийн Философи, дидактикийн тэнхимийн эрх зүйн тэнхимийн багш Э.Чулуунцэцэг

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Б.Солонго

Олон улсын эрх зүй, харьцуулсан эрх зүй

Цэвэр абстракт хяналт ба Монгол Улсын Үндсэн хуулийн хяналтын систем: харьцуулсан судалгаа

Японы хүүхдийг ивээх сангийн ажилтан, судлаач Н.Энхцэцэг

Төр, түүний өмчийн дархан эрхийн онол: Албадлагын арга хэмжээ авагдахаас ангид байх улсын дархан эрх

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Олон улсын эрх зүйн багш Б.Тамир

Криминологи

Монгол Улсад цаазаар авах ялыг халах уу, аль эсвэл...

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан Г.Оюунболд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Захиргаа, хүмүүнлэгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр А.Түвшинтулга

Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх гэмт хэргийн шалтгаан, нөхцөл

Тагнуулын Ерөнхий газрын Дорнод аймаг дахь газрын дарга, хурандаа, докторант Ц.Доржняма

ШШҮХ-ийн Шүүх-ДНХ шинжилгээний зарим үр дүнгээс

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн лабораторийн дарга, биологийн ухааны доктор С.Ганболд, магистрант Р.Баярмаа

Эрх зүйн үйлчилгээ

Орон нутаг дахь “Эрх зүйн туслалцааны төв”-ийн одоо ба ирээдүй Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн Эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн, магистр Д.Ёндонжамц

Нэр томъёо

Хууль зүйн англи нэр томъёо

2010, №2(29)

Төрийн байгуулалтын хууль тогтоомж

Парламентын хяналт шалгалтыг төгөлдөржүүлэх нь (Цаас үйлдвэрлэж мөнгө тараахаас цааш юу харагдана вэ?)

Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, ардын багш, гавъяат хуульч, доктор, профессор Б.Чимид

Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд бэлэг буюу үйлчилгээ хүлээн авахтай холбогдсон хоригийн тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын Албаны дарга, Хууль зүйн доктор, профессор Л.Батжав

Боловсролын харилцаан дахь хүүхдийн эрхийн асуудал

Монгол Улсын боловсролын их сургуулийн багш О.Өнөрцэцэг

Төрийн байгууллагаас иргэнд учруулсан сэтгэл санааны хохирлыг

нөхөн төлүүлэх зохицуулалт: Монгол Улсын хууль тогтоомжид тусгагдсан байдал

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан Л.Батчимэг

Шүүх эрх мэдэл

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, докторант Д.Хуяг

Прокурорын хяналт

Монгол Улсын Прокурорын байгууллагын 80 жилийн ойд*
Багануур дүүргийн прокурорын газрын түүхэн товчоон

Иргэний хууль тогтоомж

Үнэт цаасны зах зээлийн хуулийн хэрэгжилтийн зарим асуудал
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны баг

Иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүндийг хамгаалах иргэний эрх зүйн зохицуулалт
Докторант Ш.Сүхбаатар

Эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх асуудал
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Д.Тамир

Орчин тойрондоо аюултай зүйлс, аюултай үйл ажиллагаанаас учруулсан гэм хорыг арилгах, түүний эрх зүйн зохицуулалтын асуудал
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Б.Наранцацрал

Олон улсын эрх зүй ба харьцуулсан эрх зүй
ХБНГУ-ын захиргааны шүүхийн Үндсэн хуулийн болон энгийн хуулийн эрх зүйн үндсүүд (II хэсэг)
МУИС-ийн ХЗС-ийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн доктор Г.Банзрагч

Хууль бусаар ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан иргэнд учирсан хохирлыг арилгуулах талаархи Польш улсын эрх зүйн зохицуулалт
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан Ц.Баттуяа

Криминологи

Бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах эрх зүйн орчин

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн судалгааны секторын эрдэм шинжилгээний ажилтан Г.Оюунболд

Хүн худалдаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн зохицуулалтын асуудал

Цагдаагийн академийн төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш, магистр, цагдаагийн дэслэгч С.Гантулга

Хууль зүйн албаны 100 жилийн ойд

Шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэгч яамны анхны сайд Намсрай

Үндэсний төв архивын эрдэм шинжилгээний ажилтан Т.Билэгсайхан

Нэр томъёо

Хууль зүйн англи нэр томъёо

2010, №3(30)**Эрдэм шинжилгээ, онол, арга зүй**

Үндсэн хуулийн хэм хэмжээг ердийн шүүхээс хэрэглэх онолын зарим асуудал

Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш Р.Очирбал

Монгол Улсын төрийн албан хаагчийн захиргааны эрх зүйн байдлыг тогтоох зарим асуудал

Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Долгорсүрэн

Хэвлэл мэдээлэл ба эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны нууцлал

ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан, докторант Г.Оюунболд

Олон улсын гэрээнд нэгдэн ороход судалгаатай хандах асуудал

ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Б.Энх-Амгалан

Гадаад орнууд дахь дотоод худалдааны эрх зүйн зохицуулалтын төлөв байдал

ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Ж.Соёлмаа

Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр олон улсын хувийн эрх зүйн хэм хэмжээ болох нь
ХЗҮХ-ийн Олон улсын эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Г.Халиунаа

Судалгааны тайлан

Хил хамгаалах байгууллагад үйлдэгдэж байгаа онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөл
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан

Хуулийн хариуцлагад үндэслэлгүй татагдсан, цагдан хоригдсон, хилс ял шийтгүүлсэн, эдэлсэн хүмүүсийн сэтгэл зүйн хохирлыг нөхөн төлөх төлбөрийн хэмжээ тогтоох
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан

Үзэл бодол, эргэцүүлэл

Өв хүлээн авах эрхийн зарим асуудал
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан Д.Тамир

Баривчлах, цагдан хорихтой холбогдсон ажиллагаанд анхаарах зарим асуудал
Төв аймгийн шүүхийн шүүгч Д.Гансүх

Төрийн алба дахь ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хамрах хүрээ
“Авлигын эсрэг сан”-гийн захирал, хууль зүйн доктор, профессор Л.Батжав

Залуу судлаачийн индэр

Парламентийн гишүүний ёс зүй ба түүний эрх зүйн зохицуулалт
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн V ангийн оюутан Б.Төрболд

Статистик

2010 оны эхний 7 сард улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн статистикийн мэдээлэл

Хууль зүйн албаны 100 жилийн ойд

Богдын хишиг тараах зарлиг

Нэр томъёо

Хууль зүйн англи нэр томъёо

Эрдэм шинжилгээ, онол, арга зүй

Хуулийн этгээд эрүүгийн гэмт хэргийн субъект болох нь: Харьцуулсан эрх зүйн зарим асуудал

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Эрүүгийн эрх зүйн тэнхимийн багш, Хууль зүйн доктор Д.Баярсайхан

Сонгуулийн компанит ажил дахь зохион байгуулалттай гэмт бүлэглэлийн оролцоо

ОХУ-ын Сонгуулийн эрх зүйн институтын шинжээч, хууль зүйн доктор Красинский Владислав Вячеславович

Давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь

ХЗҮХ-ийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан, докторант Г.Оюунболд

Төрийн бус тэтгэврийн сангийн эрх зүйн зохицуулалт

Голомт банкны Хууль зүйн зөвлөх, магистр П.Өнөрмаа

Хорих байгууллагын аюулгүй байдлыг хангах арга хэмжээний тухай

ППШГЕГ-ын Тогтоол гүйцэтгэх газрын Ялтны сургалт, хүмүүжлийн хэлтсийн дарга, хошууч, докторант Ц.Очгэрэл

Судалгааны тайлан

Бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах гэмт хэрэг ба иргэний хуулиар зохицуулсан үүргийн гүйцэтгэлээс үүссэн хэрэг маргааныг зааглан ялгах аргачлал боловсруулах судалгааны тайлан

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны тайлан

Үзэл бодол, эргэцүүлэл

Ашиг сонирхлын зөрчлийн талаархи гадаад орнуудын эрх зүйн зохицуулалтыг бүтээлчээр ашиглая

УИХ-ын тамгын газрын ажилтан, хууль зүйн доктор, профессор Л.Батжав

Ашиг сонирхлын зөрчлийн нийгмийн ёс суртахуунаас үүдэлтэй шалтгаан

Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх, магистр Г.Ганзориг

Хорих анги ба Гяндангийн практик ойлголт

Нийслэлийн прокурорын газрын Ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга, хууль цаазын итгэмжит зөвлөх Ц.Мөнхбат

Австрийн Үндсэн хуулийн шүүхийн тухай

Үндсэн хуулийн цэцийн референт, магистр Ё.Өнөборгил

Монгол Улсын эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэрэглэсэн “мөрдөн байцаах, хэрэг бүртгэх албаны дарга” нэр томъёог өөрчлөх тухай асуудал

ОХУ-ын ДЯЯ-ны Удирдлагын академийн адъюнкт, цагдаагийн дэд хурандаа Б.Одбаатар

Гэр бүлийн эргэн тойронд..

Цагдаагийн академийн Иргэний эрх зүйн тэнхимийн багш, магистр, цагдаагийн дэслэгч О.Отгонтуяа

Монгол Улсын Иргэний хуулийн зарчмын түүхэн хөгжил

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Иргэн, эдийн засгийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ажилтан, магистр Р.Болормаа

Монгол Улс дахь эрүүдэн шүүхийн өнөөгийн байдал ба түүний шинэчлэл

Г.Төмөрбаатар

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааны аргачлал

Баян-Өлгий аймгийн Эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч Т.Костёр

Хууль зүйн албаны 100 жилийн ойд

Шүүх яамнаас бусдын нохойг санаатай болоод санамсаргүйгээр алсан хүнийг хэрхэн шийтгэх тухай бичиг

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Өндөр хурдны интернет бүхий
компьютерийн лаборатори
иргэдэд үйлчилж байна.
1 цаг интернет ашиглахад 400 төгрөг.

Мөн та манай танхимыг түрээслэн
сургалт, уулзалт-зохион байгуулах боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл
315735 дугаарын утсаар лавлана уу.

Хаяг Улаанбаатар 210646, Чингэлтэй дүүрэг,
Сүхбаатарын талбай 7, Хууль зүйн үндэсний хүрээлэн,
205 тоот танхим